



- Төслийн нэр:** “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төсөл
- Зөвлөх үйлчилгээний нэр:** *“Дорнод, Сүхбаатар аймгийн ус, ой, газрын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллагыг бэхжүүлэх, хамтын менежментийн гэрээг боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээ*
- Гэрээний дугаар:** № 22/59. 2022.04.08.

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТАЙЛАН

**Гүйцэтгэгч:** Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо ТББ.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо,

Токиогийн гудамж, 26-р байр, 6-606 тоот.

Утас: (+976) 9811 3747, 99060647

И-мэйл: [info@greenmongolia.mn](mailto:info@greenmongolia.mn)

Веб хаяг: [www.greenmongolia.mn](http://www.greenmongolia.mn)

2022.10.14.

## ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

“Дорнод, Сүхбаатар аймгийн ус, ой, газрын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллагыг бэхжүүлэх, хамтын менежментийн гэрээг боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээний зөвлөх багийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч .....Н.Тогтохбаяр (Sc.D)

Багийн гишүүн.....М.Сувд (Ph.D)

Багийн гишүүн.....Н.Ганхуяг

Багийн гишүүн.....Л.Ганцогт

Багийн гишүүн.....Б.Мэнджаргал

Орон нутгаас оролцож ажилласан зөвлөх нар:

Сүхбаатар аймгийн орон нутгийн зөвлөх: Б.Лхамдулам

Сүхбаатар аймгийн иргэний нийгмийн байгууллагын зөвлөх: Д.Батхүрэл

Дорнод аймгийн орон нутгийн зөвлөх: Ч.Гэрэл

Сүхбаатар аймгийн иргэний нийгмийн байгууллагын зөвлөх: Д.Отгонбаатар

# ГАРЧИГ

ХУРААНГУЙ .....	9
1. СУДАЛГААНЫ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	13
1.1 Судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага:.....	13
1.2. Судалгааны арга зүй: .....	15
Ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөл, хоршооны тооллого, бүртгэл хийх, бүртгэлийн мэдээллийн санг шинэчлэхэд баримталсан арга зүй, аргачлал.....	15
Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг даван туулах боломж, нөхцөлийг хангасан, малчдын оролцоотой байгууллага (БНХМБ)-ын хэлбэрээр ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын менежментийг хэрэгжүүлэх хамтын менежментийн гэрээний загварыг боловсруулах арга зүй .....	17
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ : .....	20
ДОРНОД, СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТ СУМЫН ХЭМЖЭЭНД УС, ОЙ, ГАЗАР (ХАДЛАН, БЭЛЧЭЭР)-ЫН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ, ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БҮЛЭГ, НӨХӨРЛӨЛ, ХОРШООНЫ ТООЛЛОГО ХИЙЖ, БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ ШИНЭЧЛЭН ГАРГАСАН ТУХАЙ.....	20
1.1. Малчдын оролцоотой БНХМБ-ын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, хүний нөөц, хамрагдаж буй малчин өрхийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхын бүртгэл тооллогын талаар: .....	20
1.1.1. Дорнод аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, хүний нөөц, хамрагдаж буй малчин өрхийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхын бүртгэл тооллого	
21	
Дорнод аймгийн сумдад бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ ( <b>малчдын бүлэг</b> )-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр: .....	21
Дорнод аймгийн сумдад байгалийн нөөцийн /ус, ой, амьтан/ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ ( <b>нөхөрлөл</b> )-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:.....	23
Дорнод аймгийн сумдад хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ ( <b>хоршоо</b> )-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр: .....	24
Дорнод аймгийн сумдын малчдын оролцоотой БНХМБ-ын хүний нөөцийн мэдээлэл:	
25	
Дорнод аймгийн сумдын БНХМБ (бүлэг, хоршоо)-ын хөрөнгө, санхүүгийн чадавхын мэдээлэл:.....	27
1.1.2. Сүхбаатар аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, хүний нөөц, хамрагдаж буй	

малчин өрхийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхын бүртгэл тооллого

28

Сүхбаатар аймгийн сумдад бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (**малчдын бүлэг**)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр: .....28

Сүхбаатар аймгийн сумдад байгалийн нөөцийн /ус, ой, амьтан/ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (**нөхөрлөл**)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр: .....30

Сүхбаатар аймгийн сумдад хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (**хоршоо**)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр: .....31

Сүхбаатар аймгийн сумдын малчдын оролцоотой БНХМБ-ын хүний нөөцийн мэдээлэл:.....32

Сүхбаатар аймгийн сумдын БНХМБ /бүлэг, хоршоо/-ын хөрөнгө, санхүүгийн чадавхын мэдээлэл: .....33

1.2. Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны чиглэл, хэрэгжилт, хууль, эрх зүйн орчны талаар:.....35

1.3. Малчдын оролцоотой БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн арга барил, мал аж ахуй, ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлт, хяналт, үнэлгээний мэдээлэл, гэрээний хэрэгжилт, сайн туршлага, сургамжийн талаар: .....47

1.3.1.Дорнод аймгийн БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн арга барил, гэрээний хэрэгжилт, сайн туршлагын тухай:.....47

1.3.2 Сүхбаатар аймгийн БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн арга барил, гэрээний хэрэгжилт, сайн туршлагын талаар:.....50

1.3.3.Дорнод, Сүхбаатар аймгийн малчдын бэлчээр ашиглагчдын бүлэг,хэсгийн дундын мөнгөн хуримтлалын тухай /сайн туршлага/ .....52

1.4. Малчдын оролцоотой БНХМБ-ын нэгдсэн бүртгэлийг одоо ашиглагдаж буй холбогдох мэдээллийн сан, бүртгэлтэй харьцуулсны үндсэн дээр мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай .....55

1.4.1.Дорнод аймгийн одоо ашиглагдаж буй малчдын оролцоотой БНХМБ-ын мэдээллийн санг шинэчлэн гаргасан талаар .....55

1.4.2.Сүхбаатар аймгийн одоо ашиглагдаж буй малчдын оролцоотой БНХМБ-ын мэдээллийн санг шинэчлэн гаргасан талаар .....58

**ХОЁРДУГААР БҮЛЭГ:** .....61

**ДОРНОД, СҮХБААТАР АЙМГИЙН СУМДЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ МАЛЧДЫН ОРОЛЦООТОЙ БНХМБ-ЫН УС, ОЙ, ГАЗАР (ХАДЛАН, БЭЛЧЭЭР)-ЫН НӨӨЦИЙН**

<b>ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ ХИЙСЭН ТУХАЙ .....</b>	<b>61</b>
2.1. Дорнод, Сүхбаатар аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замуудын талаар : .....	61
2.1.1. Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд:.....	61
2.1.2 Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд:.....	64
2.1.3. Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны биелэлт, хамтын менежментийн гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн талаар:.....	68
2.2. Гэрээнд малын тооны өсөлт, малын ашиг шим, үүлдэрлэг байдал, сүргийн бүтэцтэй уялдуулан хадлан, бэлчээрийн нөөцийн менежментийн зохицуулалт тусгагдсан эсэх талаарх үнэлгээ: .....	70
2.2.1.Малчдын оролцоотой БНХМБ-ууд нь “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалыг ашиглан бэлчээрийн даац тооцож байгаа эсэх тухай:.....	75
2.3. Гэрээнд байгалийн гамшигт үзэгдэл, онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан эсэхэд үнэлгээ хийсэн талаар: .....	79
2.4. Дорнод, Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны түвшнээр нь үнэлсэн талаар:.....	82
2.5. Талуудын гэрээгээр хүлээж буй үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг хэрхэн үнэлж, дүгнэж, гэрээг хэрхэн сунгадаг болон цуцалдаг талаар хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтийн талаар:.....	83
2.6. Байгалийн нөөц (ой, ойн сан) эзэмших, ашиглах гэрээнд хийсэн дүн шинжилгээ: 92	
2.7. Ус ашиглалтын гэрээнд хийсэн дүн шинжилгээ:.....	99
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ:.....</b>	<b>101</b>
<b>МАЛЧДЫН ОРОЛЦООТОЙ БНХМБ-ЫН ХЭЛБЭРЭЭР УС, ОЙ, ГАЗАР (ХАДЛАН, БЭЛЧЭЭР)-ЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАРЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ, ТҮҮНИЙГ АЛБАЖУУЛАХ ЗӨВЛӨМЖИЙН ХАМТ ТАЛУУДАД ТАНИЛЦУУЛЖ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТУХАЙ .....</b>	<b>101</b>
3.1. Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, хадлан, бэлчээрийн нөөцийн ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааны хамтын менежментийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулсан болон тэдгээрийг албажуулах зөвлөмжийн талаар: .....	101
3.1.1.Малчдын оролцоотой БНХМБ-ын усны нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын гэрээний талаар: .....	101

3.1.2.Малчдын оролцоотой БНХМБ-ын ойн нөөцийг зохистой ашиглах, эзэмших, хамгаалах гэрээний загварыг шинээр боловсруулсан талаар:.....	107
Загвар-1: Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх тухай сумын ИТХ-ын тогтоолын төсөл:.....	113
Загвар-2: Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулах тухай сумын Засаг даргын захирамжийн төсөл: .....	113
Загвар-3: Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх тухай гэрээний загварын төсөл: .....	114
3.1.3.Малчдын оролцоотой БНХМБ-ын газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын гэрээний загварыг шинээр боловсруулсан талаар: .....	118
Загвар-4: “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам” батлах тухай аймгийн ИТХ-ын тогтоолын төсөл:.....	120
Загвар-5: Суманд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутаг тогтоох тухай сумын ИТХ-ын тогтоолын загварын төсөл: .....	130
Загвар-6: Сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам батлах тухай сумын ИТХ-ын тогтоол болон журмын төсөл: .....	131
Загвар-7: Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах тухай сумын Засаг даргын захирамжийн төсөл:.....	140
Загвар-8: Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний загварын төсөл (Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх) .....	140
Загвар-9: Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээ (Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх)	148
3.1.4. Бэлчээрийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд оролцогч Талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой болгож, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлуудыг гэрээнд тусгах тухай: .....	151
Талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх талаар: .....	151
3.1.5. Бэлчээрийн газрын төлөв байдалтай уялдсан ашиглалт, богино хугацааны сэлгээний хуваарь, урт хугацааны мониторингийн төлөвлөгөө, бэлчээрийн даац, болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг тооцсон сүргийн эргэлтийн төлөвлөгөө зэргийг төр - малчид - хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах үүрэг, хариуцлагыг тусгах талаар:.....	156
Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах. ....	157
3.1.6. Малчдын оролцоотой БНХМБ-тай бэлчээрийн нөөц ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамж, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулсан талаар:.....	158
Малчдын оролцоотой БНХМБ-тай байгуулсан “Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамж болон Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтүүдийг загвар 10 болон 11-т үзүүлэв.....	158
Загвар-10. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамжийн төсөл:....	158
Загвар-11. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтүүд. /Удирдамжийн хавсралт/ .....	159

<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:</b> .....	165
ГЭРЭЭНИЙ ШИНЭЧИЛСЭН ЗАГВАРЫГ ОРОН НУТАГТ ТАНИЛЦУУЛАХ, ШИНЭ ЗАГВАРЫН ДАГУУ БНХМБ-ЫГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ЧАДАВХЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ .....	165
<b>ДҮГНЭЛТ</b> .....	<b>169</b>

Хүснэгт 1. Дорнод аймгийн малчдын оролцоотой БНХМБ (бүлэг)-ын тооллого, бүртгэл	21
Хүснэгт 2. Дорнод аймгийн малчдын оролцоотой БНХМБ (нөхөрлөл)-ын тооллого, бүртгэл .....	24
Хүснэгт 3. Дорнод аймгийн малчдын оролцоотой БНХМБ (хоршоо)-ын тооллого, бүртгэл .....	25
Хүснэгт 4. БНХМБ (бүлэг, нөхөрлөл)-ын хүний нөөц, гишүүнчлэл .....	25
Хүснэгт 5. Малчдын оролцоотой хоршооны хүний нөөц, гишүүнчлэл.....	26
Хүснэгт 6. Малчдын бүлгийн хөрөнгө, санхүүгийн чадавх .....	27
Хүснэгт 7. ХАА-н хоршооны хөрөнгө, санхүүгийн чадавх.....	27
Хүснэгт 8. Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ (бүлэг)-ын тооллого, бүртгэл .....	29
Хүснэгт 9. Сүхбаатар аймаг дахь малчдын оролцоотой БНХМБ (нөхөрлөл)-ын тооллого, бүртгэл .....	31
Хүснэгт 10. Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ (хоршоо)-ын тооллого, бүртгэл .....	32
Хүснэгт 11. БНХМБ (бүлэг, нөхөрлөл)-ын хүний нөөц, гишүүнчлэл.....	32
Хүснэгт 12. Малчдын оролцоотой хоршооны хүний нөөц, гишүүнчлэл .....	33
Хүснэгт 13. Малчдын бүлэг, хэсгийн хөрөнгө, санхүүгийн чадавх.....	34
Хүснэгт 14. ХАА-н хоршооны хөрөнгө, санхүүгийн чадавх.....	34
Хүснэгт 15. Нөхөрлөл, бүлгийн эрх зүйн статус, ижил төстэй ба ялгаатай талууд.....	35
Хүснэгт 16. БАХ-ийн гишүүн малчдын дундын сангийн хуримтлал.....	52
Хүснэгт 17. Дундын сангийн гишүүн өрхийн тоо, аймгаар /2017-2021/.....	53
Хүснэгт 18. Дундын сангаас олгосон зээл болон эргэн төлөлт /аймгаар/.....	53
Хүснэгт 19. Дорнод аймгийн дундын сангийн хуримтлал, ашиг, сангийн нийт дүн /сумаар/ .....	53
Хүснэгт 20. Сүхбаатар аймгийн дундын сангийн тайлан /сумаар/.....	54
Хүснэгт 20. Малчдын оролцоотой хоршооны тооллого. ....	56
Хүснэгт 21. Малчдын оролцоотой бүлэг, хэсгийн тооллого. ....	57
Хүснэгт 22. Малчдын оролцоотой хоршооны тооллого. ....	58
Хүснэгт 23. Малчдын оролцоотой БАХ, бүлгийн тооллого. ....	59
Хүснэгт 21. Дорнод аймагт газар, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд.....	61
Хүснэгт 22. Дорнод аймагт ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд: .....	62

Хүснэгт 23. Дорнод аймагт усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд: .....	63
Хүснэгт 24. Сүхбаатар аймагт газар, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд:.....	64
Хүснэгт 25. Сүхбаатар аймагт ойн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд:           65	
Хүснэгт 26. Сүхбаатар аймагт усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд : / Ундны болон ХАА-н усны талаар / .....	66
Хүснэгт 27. Сүхбаатар аймагт усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд: /Уул уурхайн усны талаар/ .....	67
Хүснэгт 28. Сүхбаатар аймагт усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд : /Артезийн усны талаар/.....	67
Хүснэгт 29. Дорнод болон Сүхбаатар аймгийн малын тооны өсөлт .....	70
Хүснэгт 30. Дорнод болон Сүхбаатар аймгуудын малын төрөл хоорондын харьцаа .....	71
Хүснэгт 31. Дорнод болон Сүхбаатар аймагт үржүүлж буй малын үүлдрүүд, малын төрлөөр .....	72
Хүснэгт 32. Дорнод, Сүхбаатар аймгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлт .....	73
Хүснэгт 33. Дорнод аймгийн сумуудын өвөл, хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн.....	75
Хүснэгт 34. Дорнод аймгийн сумуудын зун намрын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн.....	76
Хүснэгт 35. Сүхбаатар аймгийн сумдын өвөл-хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн.....	77
Хүснэгт 36. Сүхбаатар аймгийн сумдын зун намрын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн.....	78
Хүснэгт 37. Дорнод аймгийн гамшигт үзэгдэл, онцгой байдлаас сэргийлэх ажлын бэлтгэлд үнэлгээ хийсэн тухай.....	80
Хүснэгт 38. Сүхбаатар аймгийн сумдын усан хангамжийн мэдээлэл .....	81



## ХУРААНГУЙ

“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд “Дорнод, Сүхбаатар аймгийн ус, ой, газрын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллагыг бэхжүүлэх, хамтын менежментийн гэрээг боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээний “Ажлын даалгавар”-ын 3 дахь хэсэг буюу хүрэх Үр дүн 1-ийн 4, Үр дүн 2-ын 5, Үр дүн 3-ийн 4, Үр дүн 4-ийн 4 бүгд 17 чиглэлийн ажлуудыг Дорнод аймгийн 14, Сүхбаатар аймгийн 13, нийт 27 сумыг хамруулан гүйцэтгэв.

Дорнод, Сүхбаатар аймгийн 17 сумын хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөл, хоршооны тооллого, бүртгэл хийхэд дараах тоот үзүүлэлт бүхий судалгааны үр дүн гарлаа.

Дорнод аймгийн нийт 9 суманд 2427 малчин өрх оролцсон, 123 бүлэг, 7 суманд Байгаль орчны чиглэлтэй 40 нөхөрлөл, 14 суманд малчдын оролцоотой хөдөө аж ахуйн 54 хоршоо бүртгэгдлээ. Малчдын бүлэг 3230 малчидтай 67.1 хувь нь эрэгтэй, 32.9 хувь нь эмэгтэй бөгөөд бүлэг, хэсгийн ахлагч нарын 63 хувь нь эрэгтэй, 37 хувь нь эмэгтэй байна. 40 нөхөрлөл нь 40 ахлагч, 709 гишүүнтэй, тэдгээрийн 53 хувь нь эрэгтэй, 47 хувь нь эмэгтэй байна. Ахлагчдын 51 хувь эрэгтэй, 49 хувь нь эмэгтэй, дундаж нас 55 байна. Нөхөрлөлүүд нь Удирдах зөвлөлийн 137 Хяналтын зөвлөлийн 107 гишүүнтэй бөгөөд 48 идэвхтэн байгаль хамгаалагчтай ажиллаж байна. ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын гишүүдийн тоо 2310 хүрсэн байна.

Сүхбаатар аймгийн 13 сумыг хамруулан хийхэд 8 суманд 1465 малчин өрх оролцсон 43 бүлэг бүртгэгдсэн бөгөөд нийт малчдын 2474 буюу 50.2 хувь нь эрэгтэй, 2554 буюу 49.8 хувь нь эмэгтэй, бүлэг, хэсгийн ахлагчдын 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэй байна. Аймгийн 4 суманд нийт 5 нөхөрлөл, 5 ахлагч, 71 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Дорнод аймагт нэг сая толгой мал бүхий малчдын бүлэг, хэсгүүд 5.5 сая га бэлчээрийг ашиглахаар гэрээ байгуулсан бол 14 суманд ХАА-н чиглэлээр 54 малчдын оролцоотой хоршоо 32,9 сая төгрөгийн дүрмийн сантай, 614,8 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Сүхбаатар аймгийн бэлчээр ашиглагч бүлэг, хэсгүүд 0,75 сая толгой мал сүрэгтэй, 1,2 сая га бэлчээрийг 5 жилийн хугацаатайгаар ашиглахаар гэрээ байгуулан ажиллаж байгаа бол 11 суманд 2859 гишүүнтэй 33 хоршоо хөдөө аж ахуйн чиглэлээр 118,3 сая төгрөгийн дүрмийн сантай, 181,0 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Дорнод аймгийн 14, Сүхбаатар аймгийн 13, нийт 27 сумын хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөл, хөдөө аж ахуйн хоршооны тооллого, бүртгэл, судалгааг аймаг, сумдын ХАА, БО, Газрын харилцааны асуудал

хариуцсан мэргэжилтэн нартай хамтран хийлээ. Дээрх судалгааны бүртгэл мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /ГЗБГЗЗГ/, Улсын бүртгэлийн ерөнхий газар /УБЕГ/, Байгаль орчны яам, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо зэрэг газруудын мэдээллийн сангуудтай харьцуулан шинэчилсэн байдлаар гаргасан болно.

Дорнод, Сүхбаатар аймгийн 17 сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, гэрээний хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж судлахад дараах үр дүн гарлаа.

Байгалийн нөөцийн зарчим, зохистой ашиглалт, хамгаалалтыг хууль зүйн талаас онол, практикийг харьцуулан судалснаар холбогдох хуулийн эрх зүйн зохицуулалтад үндэслэн малчдын оролцоотой БНХМН, Бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлгийн эрх зүйн статус, тэдний ижил төстэй ба ялгаатай талуудыг тодорхойлж, малчдын хамтын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, экологийн харилцаан дахь хүний эрх, байгалийн нөөц баялаг ашиглах, хамгаалах гэрээний эрх, үүрэг, хариуцлагын талаар системчлэн дүгнэлт хийсэн болно.

Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааны биелэлт, хамтын менежментийн гэрээний заалтууд болон хэрэгжилтэд хууль зүйн дүн шинжилгээ хийхдээ байгалийн нөөц баялгийн ашиглалтын төрөлжсөн объектын ангилал тогтоож гэрээ тус бүрд үнэлгээ хийсэн болно.

Малчид оролцсон Байгалийн нөөцийн хамтын менежментийн бүлэг, нөхөрлөлүүдтэй хийсэн гэрээнд бэлчээрийн хэмжээ, байршил, экологийн чадавхын зураглалаас гадна зуны дээд ургацыг олон жилийн дунджаар оруулан даацыг хонин толгойгоор тооцсон байна. Харин малын тооны өсөлт, үүлдэрлэг байдал болон чанар, сүргийн бүтцийг мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй хэрхэн зохицуулах, малын бэлчээрийн даацыг тооцох, талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа гэх мэт гэрээний нөхцөлүүдийг практикт хэрэгжүүлэх боломжтой, хуульд нийцсэн нөхцөл бүхий гэрээний шинэ загварыг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлов.

Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохдоо зорилтот 2 аймгийн ХААГ, БОГ, ГХБХБГ болон сумдын ХААТ, БО, Газрын даамал зэрэг холбогдох мэргэжилтэн, малчдын төлөөлөл оролцсон чанарын судалгаагаар байгалийн баялаг ашиглалт, хамгаалалтад тулгарч буй хүндрэлтэй асуудлуудын талаар санал солилцон хэлэлцэж, тэмдэглэл үйлдэж, цаашид шийдвэрлэх арга замуудыг тодорхойлсны зэрэгцээ бусад хамаарал бүхий оролцогчдын саналыг авч тайлангийн холбогдох хэсгүүдэд тусгасан болно.

Байгалийн тодорхой төрлийн баялгийг гэрээ байгуулах замаар эзэмшүүлж, ашиглуулах нь байгалийн нөөц баялгийн зохистой ашиглалт, хамгаалалтын хамгийн оновчтой хэлбэр гэдгийг олон улсын практикт хүлээн зөвшөөрсөөр байна.

Байгаль орчныг хамгаалах тухай улс орнуудын хөгжлийн энэхүү чиг хандлагыг Монгол Улсад хөгжүүлэх, боловсронгуй болгоход төрийн бодлого, эрх зүйн таатай орчин шууд хамааралтай. Ийм учраас одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын байгаль орчны салбарын болон газрын харилцааны багц хуулиудын холбогдох эрх зүйн зохицуулалтын хүрээнд ус, ой, бэлчээр, хадлангийн талбайг гэрээ байгуулан эзэмшүүлэх, ашиглуулах хууль зүйн үндэслэл, боломж байгаа эсэх талаар судлан, хууль зүйн дүн шинжилгээ хийсэн болно.

Монгол Улсын байгаль орчныг хамгаалах тухай хууль, газрын тухай хууль, ойн тухай хууль, усны тухай хууль болон холбогдох эрх зүйн актуудын зохицуулалтад үндэслэн дээр дурдсан баялгийг хэрхэн зүй зохистой ашиглах, хамгаалах асуудлын талаар тусгав.

Ус, ой, бэлчээр, хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах асуудлыг дараах агуулгаар илэрхийлсэн болно. Үүнд:

1. Малчдын оролцоотой БНХМБ нь ямар нэгэн ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчныг ашигладаг ус хэрэглэгч субъект болохын хувьд усны тухай хуульд заасан үндэслэл, журмаар усыг гэрээгээр ашиглах эрх зүйн зохицуулалтгүй болохыг тодотгосон. Гэсэн хэдий ч худаг гаргах, худаг засварлах, булаг, шандын ус, эхийг хаших, хамгаалах гэх зэрэг асуудлыг гэрээгээр ашиглах, эзэмших боломжтойг харгалзан ийм төрлийн гэрээний загварыг гаргах боловсруулах боломжтой гэж үзсэн тул орон нутаг, төслийн нэгжтэй санал солилцсоны үндсэн дээр малчдын оролцоотой БНХМБ-д “Худаг эзэмшүүлэх гэрээний шинэчилсэн загварын төслийг бэлтгэсэн.

2. Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлд эзэмшүүлэх эрх зүйн үндэслэлээр:

- Ойн нөхөрлөлд ойн санг эзэмшүүлэх тухай Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол,
- Ойн нөхөрлөлд ойн санг эзэмшүүлэх гэрээ байгуулах тухай Сумын Засаг даргын захирамж,
- Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээний загварыг тус тус шинээр боловсруулав.

3. Бэлчээрийн газрын зохистой ашиглалт, хамгаалалтын асуудлыг зөвхөн гэрээний загварыг бус, уг гэрээтэй холбогдох эрх зүйн баримт бичгүүд тухайлбал: Аймгийн “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг батлах тухай аймгийн ИТХ-ын тогтоол болон уг журмын төсөл, Суманд бэлчээрийн болон суурин /эрчимжсэн мал аж ахуйн/ мал маллагааны бүс нутгийг тогтоох тухай сумын ИТХ-ын төсөл, Сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын болон журмын төсөл, Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээ байгуулах тухай сумын Засаг даргын захирамж, Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний загвар, хавсралт хүснэгтүүдийн хамт (уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зорилгоор сумын Засаг дарга, малчдын оролцоотой БНХМБ хооронд байгуулах), Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний загвар (эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зорилгоор сумын Засаг дарга, иргэн, хуулийн этгээд хооронд байгуулах) зэрэг багтсан төслийг цогцоор нь боловсруулсан болно.

4. Судалгааны явцад сумын Засаг дарга болон бүлэг, хэсэг болсон малчдын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах, биелэлтийг дүгнэх асуудал орон нутагт тун хангалтгүй байгаа нь ажиглагдсан. Бид малчдын оролцоотой БНХМБ буюу малчдын бүлэг, хэсэг холбогдох талуудтай гэрээ байгуулан бэлчээрийн газрын менежментийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудын холбогдох зүйл, заалтад үндэслэн гэрээг боловсруулан ашиглах нь зүйтэй гэсэн чиглэлийг баримталж ажилласан. Энэ шинэчилсэн гэрээний загварт талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, тодорхой болгох, гэрээний биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж оруулсан болно.

5. Зорилтот аймаг, сумдыг “бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-тай болгох буюу эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэрээний талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, дүгнэх шалгуур үзүүлэлттэй болгох асуудлыг тусгаж байгаагаас гадна бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх Малын тоо толгойн албан татварын хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтуудыг ашиглан ажиллах боломж байгааг талаар тусгаж өгөв.

6. Малчдын оролцоотой БНХМБ-ын гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэх үе шатыг тайланд бүдүүвч хэлбэрээр тусгаснаас гадна албажуулах ажлын зөвлөмжийг тайланд оруулсан болно.

7. Гэрээний шинэчилсэн загварын төслийг Сүхбаатар, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт албан бичгээр хүргүүлж санал авсан бол Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Түвшинширээ, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул зэрэг сумдын удирдлага, малчдын төлөөлөл нийт 46 хүнд танилцуулж, санал авсан ба хэрхэн албажуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх ажлыг гүйцэтгэж ажилласан байна.

8. Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага /БНХМБ/-ын гэрээний шинэ загварын дагуу малчдын оролцоотой бүлэг үүсгэн байгуулах талаар Сүхбаатар аймгийн Дарьганга, Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага, мэргэжилтэн, холбогдох багийн Засаг дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр Дарьганга сумын 1 дүгээр багийн “Хөөврийн булаг” орчмын 18 малчин өрх, Түвшинширээ сумын 3 дугаар багийн “Замтын булаг” орчмын 20 малчин өрхийг тус тус оролцуулсан хоёр малчдын бүлэг шинээр байгуулах хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон. Үүний дагуу дээрх хоёр сумын багийн дарга, мэргэжилтэн, малчдын төлөөлөлтэй газар дээр нь уулзаж энэ ондоо багтааж бүлэг байгуулах ажлыг зохион байгуулах, Дорнод аймгийн Баян-Уул сумын “Заяат” болон “Улз”, Чойбалсан сумын “Энгэр шанд” бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар зөвлөх багийн зүгээс сургалт-мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахаар тогтсон болно.

9. Төслийн хөрөнгө оруулалтаар булгийн эх болон ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хамгаалсан хашааг цаашид хариуцан ажиллах малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөлийг тодорхой болгож, гэрээний шинэчилсэн загварын талуудын хүлээх эрх, үүргийн хэсэгт төслийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан булаг шандын эх болон ой нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хамгаалах зорилгоор барьсан хашааг

хамгаалах, арчлан тордох, ашиглах асуудлыг тусгах талаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Түвшинширээ, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул сумдын ЗДТГ-ын удирдлага, мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт зөвлөгөө өгөв. Мөн бэлчээр ашиглалтын болон ойн нөхөрлөлийн гэрээний загвар, гарын авлага материалыг танилцуулж хэлэлцүүлэн хүлээлгэн өгсөн болно.

## 1. СУДАЛГААНЫ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.1 Судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага:

“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн хамтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг малчдын оролцоотой байгууллага (бүлэг, нөхөрлөл, хамтлаг, хоршоо)-тай хамтран олон цогц арга хэмжээг хэрэгжүүлэх тул тэдгээрийг удирдлага, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, албажуулах, үндэсний хэмжээний мэдээллийн санд суурилан нэгдсэн бүртгэлийг нь сайжруулах, үнэлгээ хийх шаардлагатай болсон байна.

Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай “Дорнод, Сүхбаатар аймгийн ус, ой, газрын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллагыг бэхжүүлэх, хамтын менежментийн гэрээг боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан болно.

Зөвлөх үйлчилгээний ажлын зорилго нь Дорнод, Сүхбаатар аймгийн хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллага (бүлэг, нөхөрлөл, хоршоо)-ын үйл ажиллагаанд үнэлгээ хийж тулгамдсан асуудлыг илрүүлэн, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчин, хамтын менежментийн гэрээ, байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагааны хэрэгжилт, ашиглалт болон хариуцан ажиллуулах үе шатуудад малчдын оролцоотой байгууллагууд хэрхэн оролцох, сумын засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах хамтын ажиллагааны болон хариуцлагын зарчмыг сайжруулах гэрээний санал боловсруулахад орших юм.

Зөвлөх үйлчилгээг үндсэн 5, орон нутаг үйл ажиллагааг дэмжин туслах 4 ажилтны бүрэлдэхүүнтэй гүйцэтгэв (Хүснэгт 1)

## Судалгааны багийн бүрэлдэхүүн, хариуцсан ажил

№	Судлаачдын овог нэр	Албан тушаал	Хариуцсан ажил
Судалгааны үндсэн ажилтан			
1	Н.Тогтохбаяр Зооинженер, Доктор ( Sc.D )	Багийн ахлагч	Судалгааны багийг зохион байгуулалт, удирдлагаар хангах
2	М.Сувд Эрх зүйч, хуульч, Доктор ( Ph.D )	Багийн гишүүн	Гэрээний эрх зүйн харилцааг судлах, үнэлэх, зөвлөмж боловсруулах
3	Н.Ганхуяг Мал зүйч, хүрээлэн буй орчны хамгаалал, магистр	Багийн гишүүн	ХАА, бэлчээрийн харилцаа, БНХМБ-ын нийгэм, эдийн засгийн асуудал
4	Л.Ганцогт Газар зохион байгуулагч, мэргэшсэн инженер	Багийн гишүүн	Газар ашиглалт, төлөвлөлт, мэдээллийн сан
5	Б.Мэнджаргал Ургамал хамгаалагч-агроном, магистр	Багийн гишүүн	ХАА, бэлчээрийн харилцаа, малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл, хоршооны судалгаа, бүртгэл, зохион байгуулалт
Судалгааны туслах ажилтан			
1	Д.Отгонбаатар Агрономич Дорнод аймгийн орон нутгийн зөвлөх	Багийн гишүүн	Ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Дорнод аймагт гүйцэтгэхэд оролцож ажиллана.
2	Ч.Гэрэл Дорнод аймгийн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	Багийн гишүүн	Ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Дорнод аймагт гүйцэтгэхэд оролцож ажиллана.
3	Б.Лхамдулам, Газар зохион байгуулагч Сүхбаатар аймгийн орон нутгийн зөвлөх	Багийн гишүүн	Ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Сүхбаатар аймагт гүйцэтгэхэд оролцож ажиллана.
4	Д.Батхүрэл Экологич-байгаль хамгаалал	Багийн гишүүн	Ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Сүхбаатар аймагт гүйцэтгэхэд оролцож ажиллана.

Судалгааг ажлын даалгаварт тусгагдсан 4 үр дүнг гүйцэтгэх төлөвлөгөө гарган (**Хавсралт 1**) хэрэгжүүлсэн бөгөөд тайланг уг зөвлөх үйлчилгээний үр дүнгүүдийн дагуу бүлэглэн .... хуудсанд багтаан бичсэн болно.

## 1.2. Судалгааны арга зүй:

Ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөл, хоршооны тооллого, бүртгэл хийх, бүртгэлийн мэдээллийн санг шинэчлэхэд баримталсан арга зүй, аргачлал

- Тооллого судалгааг төрийн болон иргэний нийгмийн байгууллагын мэдээллийн сан, цахим сүлжээг ашиглах, малчдаас бүлгийн ярилцлага, санал асуулга авах, баримтын шинжилгээ хийх аргуудыг ашиглан гүйцэтгэв. Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавартай холбоотой мэдээлэл цуглуулах зорилгоор Дорнод, Сүхбаатар аймгуудын бүх сумдын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн болон байгаль орчин, газрын асуудал хариуцсан нийт 81 мэргэжилтнүүд, аймаг тус бүрийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2, Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2, бүгд 12, нийт 93 хүнийг цуглуулан Чойбалсан, Баруун-Урт хотуудад 2022 оны 5 дугаар сарын 16-17 болон 5 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд тус бүр хоёр өдрийн уулзалт-семинарыг зохион байгуулав. Тус семинараар сум тус бүрд үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (бүлэг, хэсэг, нөхөрлөл, хоршоо)-ны талаар мэдээлэл авах, холбогдох баримт бичигтэй танилцах, асуулга асууж бөглүүлэх, ус, ой, газрын нөөцийн ашиглалтын өнөөгийн тулгамдсан болон шийдвэрлэх асуудлуудыг бүлгээр хэлэлцүүлэн санал бодлыг нь сонсох зэргээр мэдээлэл бүрдүүлэн, тооллого, бүртгэл хийх ажлыг гүйцэтгэсэн.
- Мөн Дорнод аймгийн орон нутгийн зөвлөх Ч.Гэрэл, Д.Отгонбаатар нар 5-6 дугаар сард Баянтүмэн, Баян-Уул, Халхгол, Дашбалбар, Цагаан-Овоо зэрэг 5 сум, Сүхбаатар аймгийн орон нутгийн зөвлөх Д.Батхүрэл, Б.Лхамдулам нар Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан, Баруун-Урт зэрэг 4 суманд ажиллаж бүрдүүлсэн мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаатай нь биечлэн танилцах, зарим тоо, баримтыг баталгаажуулан холбогдох мэдээлэл, бичиг баримтыг бүрдүүлсэн болно.
- Тооллого, бүртгэл хийх явцад байгалийн нөөцийг ашиглаж, хамгаалж байгаа байдлаар нь малчдын оролцоотой БНХМБ-ыг бүлэг, нөхөрлөл, хоршоо гэж 3 ангилан бүртгэж, бүрдүүлсэн судалгааны материалыг ашиглан мэдээллийн санг шинэчлэн ажиллаж, аймаг тус бүрээр нэгтгэн, дүгнэлт гаргасан болно.
- Өгөгдлийн чанарын түргэвчилсэн үнэлгээ хийх, өгөгдлийн эх сурвалж бүрийг шалгуур тус бүрээр 1-4 оноогоор үнэлэн, малчдын оролцоотой байгууллагыг оноогоор эрэмбэлж үйл ажиллагааны түвшнээр нь сайн, дунд, сайжруулах шаардлагатай гэж ангилна. Мөн талуудын гэрээгээр хүлээж буй үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг дүгнэж, гэрээг сунгадаг болон цуцалдаг эсэхэд хяналт тавив.

**Дорнод, Сүхбаатар аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллагын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийн гэрээний хэрэгжилтийг үнэлсэн аргачлал**

- БНХМБүлгүүдийн гэрээнд тусгасан мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажлын хэрэгжилтийг ХХААХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тушаалаар батлагдсан “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх” заавар, бэлчээрийн даацын тооцоог Үндэсний статистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 сарын 05-ны өдрийн А/113, А/250, А/422 тоот тушаалаар батлагдсан “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал”-ыг баримтлан хянав. Бэлчээрийн биологийн дундаж ургацыг тооцсоны дараа зуны дээд ургацыг намар 0,77 болон өвөл, хавар 0,52 гэсэн итгэлцүүрээр үржүүлэн 100-д хуваан малд идэгдэх бодит ургацыг тодорхойлох, малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээг тооцохдоо нийт малыг адуу 7, үхэр 6, тэмээ 5, хонь 1, ямаа 0.9 гэсэн илтгэлцүүрийг ашиглан хонин толгойд шилжүүлсэн бөгөөд хээрийн бүсэд хонь зун намар 1.8, өвөл хавар 1.4 кг өвс иддэг хэмжээ болон бэлчээрлэх хугацааг зун намрын улиралд хээрийн бүсэд 169, өвөл хаврыг 196 хоног байна гэдгийг баримтлав. Бэлчээрийн даацыг 1 га бэлчээрийн бодит ургацыг малын бэлчээрлэх хугацаа болон 1 толгой малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээний үржвэрт харьцуулж тооцсон болно. Малын тоог 1212.mn сайтаас авч бэлчээрийн даацыг хонь/га-аар тодорхойлов.

Бэлчээрийн даацыг үнэлэхдээ тухайн бэлчээрт байгаа малын тоог бэлчээрийн даацад харьцуулан хувиар илэрхийлэв. Энэхүү үзүүлэлтийн утга 0-50.0 бол бэлчээрийн нөөцтэй, 50.1-100.0 бол бэлчээр хүрэлцээтэй, 100.1-300.0 бол даац 1-3 дахин хэтэрсэн, 300.1-500.0 бол даац 3-5 дахин хэтэрсэн, 500.1- ээс дээш бол даац олон дахин хэтэрсэн гэсэн ангилалд оруулав.

- Гэрээнд сүргийн эргэлтийн тооцоог оруулсан эсэхийг хянаснаас гадна судалгаанд хамрагдсан аймгуудаас Сүхбаатар аймгийн өнгөрсөн оны эцэст тоологдсон малчин өрх, аж ахуйн нэгжийн малын тоо, нас, хүйс (мал тооллогын “А” данснаас авах), Нас гүйцсэн үржлийн малын заазлалтын хувь, Төлөвлөгөөт онд гаднаас худалдаж авахаар төлөвлөсөн малын тоо, гадагш борлуулахаар төлөвлөсөн малын тоо, Малын зүй бусын хорогдлын хувь, төлөвлөгөөт оны эцэст байх нийт малын дотор эх малын эзлэх хувь, хээлтүүлэг, төллөлтийн төлөвлөгөө, хээлтүүлэгч, хээлтэгч малын зохистой харьцаа хээлтэгчийн хээл тээх хугацаа, үржлийн малын заазлалтын хувийг тус тус авч “Сүргийн нөхөн үйлдвэрлэлийн төлөвлөлт, сүргийн бүтэц эргэлтийг тооцох заавар”, программыг ашиглан боловсруулалт хийв.
- Сүргийн эргэлтийг төлөвлөхдөө оны эхэнд ба эцэст байх малын тоо, орлого, зарлага гэсэн хэсгээс бүрдүүлж орлого талд тухайн жилд эх сүргээс бойжуулах төл, худалдан авах, нас дэвшиж ирэх, бусдаас бэлэглэсэн, шилжиж ирсэн малын тоог, зарлага талд зах зээлд борлуулсан, маханд борлуулсан, үржилд худалдсан, нас дэвшсэн, зүй бусаар хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн малын тоог оруулав. Нас



дэвшилтийн орлого, зарлага тэнцүү байна. Тухайн төрлийн малыг төллөх насанд нь нас гүйцсэнд тооцно.

- Нийт малаас бойжуулахаар тооцсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн төл бойжилтын хувийг тодорхойлов. Тухайн жилд хүлээн авсан төлийн эр, эмийн харьцааг 50:50 хувиар тооцсон.
- Оны эхний 100 хээлтэгчээс бойжуулах төлийн доод хэмжээ тал хээрийн бүсэд ингэнээс 38, гүүнээс 65, монгол үнээнээс 70, хониноос 85, ямаанаас 82 байна.
- Нас дэвших мал: Оны эхний малаас үржилд худалдах, зүй бус хорогдол, зах зээлд амьдаар болон маханд борлуулах, дотоодын хэрэгцээнд нийлүүлэх мал зэрэг зарлагыг хасаад үлдсэн хэсгээс малын тоог өсгөх шаардлагад нийцүүлэн сүрэг сэлбэхээр авч үлдсэн малыг тооцов.
- Зарлагын дүн: Тухайн төрлийн малаас үржилд худалдах, зүй бусаар хорогдох, зах зээлд амьдаар болон маханд борлуулах, дотоодын хэрэгцээнд нийлүүлэхээр тооцсон нас хүйсийн малын нийт дүн нь зарлагын дүн болно.
- Оны эцсийн малын тоог гаргахдаа оны эхний малын тоон дээр малын нийт орлогыг нэмж нийт зарлагыг хасан оны эцэст үлдэх малын тоог малын нас хүйс тус бүрээр гаргав.
- Ган, зуд, гал түймэр, үер, халалт, салхи шүүрганаас хамгаалах арга ажиллагааг тооцоолохдоо хүн, малын ундны ус, малын нэмэгдэл тэжээл, хашаа, хороо, харилцаа холбооны хангамжийг судлав. ХХААХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тушаалаар батлагдсан “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх зааврын дагуу нэмэгдэл тэжээлээр дунд ба дундаас дээш тарга хүчтэй тэмээ, адууны 5 хувь, үхэр, хонь, ямааны 20 хувь, ирэх онд гарах тугал, хурга, ишигний 30 хувийг оруулж хангайн бүсэд 120 хоног, хээрийн бүсэд 90 хоног, говийн бүсэд 60 хоног тус тус тэжээхээр тооцов.Тэжээх малыг хонин толгойд шилжүүлэхдээ бодын төлийг нэг, богийн төлийг 0.2 гэсэн илтгэлцүүрийг ашиглав.
- Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг үнэлэхдээ хонин толгойд шилжүүлсэн нийт малын 30 хувийг нэг хонинд хоногт 1.0 кг өвс, түүнтэй тэнцэх үйлдвэрийн, гар, ногоон, даршин зэрэг тэжээлээр тус бүр 3 хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх нөөц байна гэдгийг үндэслэсэн болно.
- Усны хэрэгцээг тооцохдоо өвөл, хаврын улиралд нэг хоногт тэмээ 40-50 л, адуу 20-30 л, үхэр 30-40 л, хонь, ямаа 2-3 л, бодын төл 10-20 л, богийн төл 1-2 л ус хэрэглэхээр бодов.

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг даван туулах боломж, нөхцөлийг хангасан, малчдын оролцоотой байгууллага (БНХМБ)-ын хэлбэрээр ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын менежментийг хэрэгжүүлэх хамтын менежментийн гэрээний загварыг боловсруулах арга зүй**

- Монгол Улсын төрөөс байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр баримталж буй бодлого, үзэл баримтлалыг судалж, дүн шинжилгээ хийх,
- Ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын ашиглалт, хамгаалалттай холбогдох хууль тогтоомжийг судалж, хууль зүйн дүн шинжилгээ хийх,

- Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагатай холбогдох хууль тогтоомжийг судалж, хууль зүйн дүн шинжилгээ хийх,
- Олон улсын гэрээ, конвенц, хэрэгжилтийн байдалд хийх дүн шинжилгээ,
- Малчдын оролцоотой байгууллага (БНХМБ)-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын гэрээнүүдэд хууль зүйн дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд үнэлгээ өгөх, үнэлгээнд үндэслэн малчдын оролцоотой байгууллага (БНХМБ)-ын гэрээний шинэ загвар боловсруулах,
- Шинээр боловсруулах гэрээнд гэрээний зорилго, өмчлөл, ус, ой, хадлан, бэлчээрийн зориулалт, хэмжээ, байршил, ашиглалтын хугацаа, талуудын эдлэх эрх, талуудын ашиглах эрх дуусгавар болох ба ашиглагч өөрчлөгдөх нөхцөл байдал, гэрээг цуцлах үндэслэл, журам, давагдашгүй хүчин зүйл, хориглох зүйлс, талуудын хүлээх хариуцлага, ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх зэрэг нөхцөлүүдийг тусгах,
- Гэрээг хэрэгжүүлэхэд хамаарал бүхий оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоо, бэлчээр ашиглалтын богино болон үрт хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх нөхцөл, үүнтэй холбогдуулан оролцогч талуудын хариуцлагыг тусгах,
- Хадлангийн болон нөөц бэлчээрийн газар бий болгох, тэжээлийн агуулах барих боломж, нөхцөл, ус ашиглалт, хамгаалалтын гэрээнд булаг хаших, усны эх, худаг засварлах, хөв цөөрөм байгуулах, усан хангамж нэмэгдүүлэх, ой ашиглалт, хамгаалалтын гэрээнд татмын ойн нөхөн сэргээлт хийх, ус, ой, бэлчээр, хадлан ашиглалт, хамгаалалтын гэрээнд байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагааны хэрэгжилт, ашиглалт болон хариуцан ажиллуулах үе шатуудад малчдын оролцоотой байгууллага (БНХМБ)-уудын оролцоо, сумын засаг захиргаа, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтран ажиллах арга, хэлбэр, оролцоо зэрэг талуудын статусыг тусгах,
- Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг гэж тодорхойлогдсон газрууд болон малчдын оролцоотой байгууллага (БНХМБ) байгуулагдаагүй сумдын жагсаалтыг гаргах, зорилтот бүлгийн ярилцлага хийх,
- Үндэсний болон орон нутгийн хамтрагч нарыг хамруулсан уулзалт, хэлэлцүүлгийг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулах,

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг даван туулах боломж, нөхцөлийг хангасан, малчдын оролцоотой БНХМБ-ын хэлбэрээр ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн менежментийг хэрэгжүүлэх гэрээний шинэ загварын дагуу малчдын оролцоотой байгууллага (БНХМБ)-ыг үүсгэн байгуулах, хүний нөөцийг чадавхжуулах хэрэгцээ, шаардлагын арга хэмжээний төлөвлөгөөг талуудын оролцоотой боловсруулах аргачлал**

- Төсөл хэрэгжүүлэх нэгж болон оролцогч талуудын саналыг үндэслэн шинэчилсэн гэрээний загварын дагуу ... аймаг ... сумдад малчдын оролцоотой байгууллагыг (БНХМБ) холбогдох хууль, журмын хүрээнд дараах үе шатаар зохион байгуулна. Үүнд:

- БНХМБ-ыг байгуулах боломжтойг хэлэлцэн зөвшилцөж, гишүүдээ тодорхойлох, Бэлчээр нутгийн хэмжээ байршил, хил заагийг БИНХ-аар хэлэлцэх,
- Эрхэм зорилго, хамтран ажиллах дүрмээ тогтох,
- Ахлагчаа сонгох, Хамтын ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтээ хэлэлцэх,
- Шинэ гэрээний загварын хүрээнд гэрээ байгуулах,

БАХ байгалийн нөөцөө доройтуулахгүй соргог байдал, нөөц чадавхыг нь хадгалах чиглэлээрх ажлыг 10 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Нөөцийн хил заагийг зөвшилцөн тогтоох, улирлын ашиглалтын заагийг тогтоох,
2. Улирлаар сэлгэн ашиглах хуваарь гаргах, хэрэгжүүлэх,
3. Сэргэх чадавхад суурилсан ашиглалтын зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх,
4. Бэлчээрийн даацад мал, амьтдын тоо толгойг тохируулах, сүргийн эргэлтийн төлөвлөгөөг дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
5. Шинээр хадлангийн талбай гаргах, үсжуулах, хашиж хамгаалах шийдвэр гаргах, 6. Шинээр өвөлжөө, хаваржаа барих шийдвэр гаргах,
6. Өөр газар шилжин явагсдын ашиглаж байсан байгалийн баялаг, бэлчээр, хадлангийн талбайн талаар шийдвэр гаргах,
7. Гэрээг сумын Засаг даргатай байгуулж эрхээ баталгаажуулах,
8. Байгалийн баялаг, Бэлчээр, хадлангийн хуваарь, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зөв зохистой ашиглах журам тогтоож мөрдөх,
9. БНХМБ-ын гишүүд усны хомсдол, ойн бүтээмж буурах, бэлчээрээ доройтож буй эсэхэд хяналт тавьж, ажиглалт, судалгаа хийж байх.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ :

ДОРНОД, СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТ СУМЫН ХЭМЖЭЭНД УС, ОЙ, ГАЗАР (ХАДЛАН, БЭЛЧЭЭР)-ЫН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ, ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ БҮЛЭГ, НӨХӨРЛӨЛ, ХОРШООНЫ ТООЛЛОГО ХИЙЖ, БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ ШИНЭЧЛЭН ГАРГАСАН ТУХАЙ

---

### 1.1. Малчдын оролцоотой БНХМБ-ын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, хүний нөөц, хамрагдаж буй малчин өрхийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхын бүртгэл тооллогын талаар:

Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын зорилго нь: Дорнод, Сүхбаатар аймгийн хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллага (бүлэг, нөхөрлөл, хоршоо)-ын бүртгэл судалгаа хийсний үндсэн дээр хамтын менежментийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл байгуулахад Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчин хангалттай эсэх талаар үнэлгээ хийж, малчдын оролцоотой байгууллагууд нь орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн болон бусад холбогдох байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах хамтын ажиллагааны болон хариуцлагын зарчмыг сайжруулсан гэрээний шинэ загвар боловсруулж, гэрээ байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх гол зорилготой юм. Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага (бүлэг, нөхөрлөл, хоршоо)-ыг тайланд цаашид “БНХМБ” гэж товчлон нэрлэнэ.

Ажлын даалгаврын Үр дүн 1-ийн хүрээнд: Дорнод аймгийн 14, Сүхбаатар аймгийн 13, нийт 2 аймгийн 27 сумын хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (бүлэг, нөхөрлөл, хоршоо)-ын тооллого, бүртгэл, судалгаа хийх, бүртгэлийн санг шинэчлэн гаргах ажлуудыг төсөл хэрэгжиж буй хоёр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, 27 сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага, мэргэжилтэн, малчдын төлөөллийн оролцоотой хийж гүйцэтгэв. Үүнд:

**1.1.1. Дорнод аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, хүний нөөц, хамрагдаж буй малчин өрхийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхын бүртгэл тооллого**

- Дорнод аймгийн сумдад бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (малчдын бүлэг)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:

Дорнод аймгийн нийт 14 суманд бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (малчдын бүлэг)-ын тооллого, бүртгэлийг аймаг, сумдын холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн нартай хамтран судалгаа авч хийхэд тус аймгийн нийт 9 суманд 2427 малчин өрхийг хамруулсан 123 малчдын бүлэг тооллогод хамрагдаж бүртгэгдсэн. Эдгээр бүлгүүдээс 122 бүлэг нь 9 сумын Засаг даргатай “Бэлчээр ашиглах гэрээ” байгуулсан ба үүнээс 21 нь газрын мэдээллийн санд бүртгүүлсэн байна. Харин Баяндун, Гурванзагал, Дашбалбар, Матад, Чулуунхороот гэсэн 5 суманд ямар нэгэн малчдын бүлэг байгуулагдаагүй байна.

**Хүснэгт 1. Дорнод аймгийн малчдын оролцоотой БНХМБ (бүлэг)-ын тооллого, бүртгэл**

№	Сумын нэр	Бүлгийн тоо	Бүлгийн гишүүн малчин өрхийн тоо	Бэлчээр ашиглах гэрээний тоо	Газрын мэдээллийн санд бүртгүүлсэн гэрээний тоо
1.	Хэрлэн	14	32	14	-
2.	Баяндун	-	-	-	-
3.	Баянтүмэн	27	328	27	6
4.	Баян-Уул	14	538	14	10
5.	Булган	17	169	17	-
6.	Гурванзагал	-	-	-	-
7.	Дашбалбар	-	-	-	-
8.	Матад	-	-	-	-
9.	Сэргэлэн	13	276	13	-
10.	Халхгол	9	210	9	-
11.	Хөлөнбуйр	5	236	5	-
12.	Цагаан-Овоо	6	342	5	5
13.	Чойбалсан	18	296	18	-
14.	Чулуунхороот	-	-	-	-
<b>ДҮН:</b>		<b>123</b>	<b>2427</b>	<b>122</b>	<b>21</b>

Дээрх 9 сумын малчдын бүлгүүд нь тус аймагт хэрэгжиж байсан олон улсын байгууллага, хөтөлбөр, төслийн хүрээнд байгуулагдсан байна. Үүнд:

1. 2010-2013 онд: Мянганы сорилтын сангийн санхүүжилт бүхий “Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийн хүрээнд Хэрлэн суманд 14, Баянтүмэн суманд 21, Булган

суманд 10, Сэргэлэн суманд 4, Чойбалсан суманд 11, нийт аймгийн төвтэй хил залгаа, ойр байршилтай 5 суманд 165 малчин өрхийг нэгтгэсэн 60 малчдын бүлэг байгуулсан байна.

Эдгээр бүлгүүдэд цөөн буюу 2-5 малчин өрхүүд хамрагдаж, анх удаа нийт 61320 га бэлчээр ашиглах гэрээг 15 жилийн хугацаатай байгуулсан байна.

Харин эдгээр 60 малчдын бүлгийн байгуулсан гэрээнээс нэг ч гэрээ газрын мэдээллийн санд бүртгэгдээгүй байна. Төсөл хэрэгжиж байсан тухайн үед төслийн санаачилга, зөвлөмжийн дагуу бэлчээрийн менежментийн чиглэлээр “Хамтын ажиллагааны гэрээ”-г төсөлд хамрагдсан малчдын бүлэг тус бүртэй байгуулан малын хашаа байр барих материалын дэмжлэг үзүүлэх, гүн өрмийн худаг гаргах зэрэг үйл ажиллагаанд урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох, уг зээлийг зориулалтаар нь зарцуулж, эргэн төлөлтийг орон нутгийн санд төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлж байсан ба энэ гэрээний дагуу эргэн төлөлтийн ажил одоо хүртэл явагдаж байгаа талаар Баянтүмэн сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон газрын даамал нар танилцуулж, мэдээлэл өгсөн.

2. 2016-2021 онд: Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилт бүхий “Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд Баянтүмэн суманд 6, Баян-Уул суманд 14, Булган суманд 7, Цагаан-Овоо суманд 6, Чойбалсан суманд 7, нийт 5 суманд 40 бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийг байгуулж, 39 БАХ нь Газрын тухай хуулийн 52.2-ыг үндэслэн тухайн сумдын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээг байгуулж, үүнээс 21 БАХ нь байгуулсан гэрээгээ газрын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

Дээрх БАХ-үүд нь нэг нутаг бэлчээр бүхий 20-50 малчин өрхүүдийг нэгтгэн “бэлчээрээс ашиг хүртэгч нь хамгаалагч байна” гэсэн үзэл баримтлалтай ажиллаж байна. Төслийн хүрээнд БАХ-ийн гишүүн малчдыг дэмжих зорилгоор төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “**малчдын дундын сан**”-г үүсгэн байгуулах ажлыг анх удаа үр дүнтэй зохион байгуулсан нь төслийн сайн туршлага болсон байна. Мөн тус аймгийн нийт сумдын газрын даамал нарыг бэлчээрийн фото-мониторингийн судалгаа хийх, дүгнэх чиглэлээр чадавхжуулах ажлыг хийж, шаардагдах гарын авлага, тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан байна. Энэ ажлын үр дүнд төсөл хэрэгжиж байсан сумдын БАХ-үүдийг хамруулан улирлын бэлчээр тус бүрд бэлчээрийн тухайн жилийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор фото-мониторингийн судалгааг жил бүрийн 8 дугаар сарын эхний 15 хоногт хийж, тухайн жилийн бэлчээрийн ургацын байдлыг БАХ, баг, сум, аймгийн түвшинд нэгтгэн дүгнэн гаргаж, орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, малчдыг мэдээллээр хангах, малчдын бүлгийн бэлчээр ашиглах гэрээний хэрэгжилтийг дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгох ажлыг хэвшүүлэн ажиллаж байна.

3. 2019-2022 онд: НҮБ болон Олон улсын хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн санхүүжилт бүхий “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд

Халх гол суманд 9, Хөлөнбуйр суманд 5, Сэргэлэн суманд 9, нийт 3 суманд 23 бэлчээр ашиглагч малчдын бүлэг (БАМБ)-ийг байгуулж, БАМБ тус бүрийн **“2019-2021 оны бэлчээрийн менежментийн төлөвлөгөө”**-г сумын удирдлага, мэргэжилтэн, малчдын оролцоотой боловсруулж, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлж ажилласан байна. Мөн тус төслийн хүрээнд БАМБ-ийн гишүүн малчдыг дэмжих зорилгоор сум, багийн түвшинд тэжээлийн агуулах болон мал угаах төхөөрөмж барьж өгөх, инженерийн хийцтэй худаг гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх багаж хэрэгсэл олгох зэрэг хөрөнгө оруулалтыг хийжээ. Одоогийн байдлаар эдгээр бүлгүүдийн гэрээ газрын мэдээллийн санд бүртгүүлээгүй бөгөөд энэ ондоо багтаан бүртгүүлж дуусгана гэсэн мэдээллийг төслийн аймаг, сумд хариуцсан ажилтан нар өгсөн болно.

- Дорнод аймгийн сумдад байгалийн нөөцийн /ус, ой, амьтан/ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (нөхөрлөл)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:

Судалгааны үеэр тус аймгийн 7 суманд 40 нөхөрлөл тооллого, бүртгэлд хамрагдсан байна. Сум тус бүрийн байгаль, цаг уур, газар нутгийн онцлог байдлаас хамаарч нөхөрлөлийн үйл ажиллагааны чиглэлүүд өөр өөр байна. Тухайлбал Баян-Уул сумын 26 нөхөрлөл нь бүгд ойн санг эзэмшиж ашиглах, хамгаалах талаар гэрээ байгуулснаас 21 нөхөрлөл нь гэрчилгээтэй байна. Халхгол сумын нөхөрлөл нь Буйр нуурыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Нуурын орчимд малын тоо ихсэж байгаатай холбогдон эрэг орчмын бэлчээр доройтож, сэргээх шаардлага байна гэж орон нутгийн мэргэжилтэн нар мэдээлсэн. Дашбалбар сумын нөхөрлөлийн үйл ажиллагаа идэвхгүй, нэр төдий байгаа тул сумын удирдлага, мэргэжилтэн гэрээг цуцлах саналтай байгаа юм байна. Мөн нөхөрлөлүүд сумын Засаг даргатай гэрээ байгуулсан боловч, цаашид бүртгүүлж гэрчилгээ авах ажил хангалтгүй байна гэж дүгнэсэн. Эдгээр нөхөрлөл нь нийт 337352 га талбайг хамгаалж, ус, ой, амьтан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах эрхийн гэрээ болон гэрчилгээ нь тухайн хамгаалж буй газар нутагт тархсан тарвага, зээр, нүүдлийн шувууд, загас, эмийн ургамал, ой мод зэрэг нь нөхөрлөлийн гишүүдийн хайрлан хамгаалж ашиг шимийг нь хүртэх баялгийн эх сурвалж болж байна.

Хүснэгт 2. Дорнод аймгийн малчдын оролцоотой БНХМБ (нөхөрлөл)-ын тооллого, бүртгэл

№	Сумын нэр	Нөхөр лөлийн тоо	Гишүү дийн тоо	Хамрагдсан малчин өрхийн тоо	Гэрээний тоо	Гэрчилгээн ий тоо	Хамгаалж байгаа газрын хэмжээ /га/
1	Хэрлэн	-	-	-	-	-	-
2	Баяндун	4	69	34	4	4	39989
3	Баянтүмэн	1	21	13	1	1	10000
4	Баян-Уул	26	425	283	24	21	211015
5	Булган	-	-	-	-	-	-
6	Гурванзагал	-	-	-	-	-	-
7	Дашбалбар	2	31	9	2	2	20000
8	Матад	-	-	-	-	-	-
9	Сэргэлэн	-	-	-	-	-	-
10	Халхгол	1	20	10	1	1	20
11	Хөлөнбуйр	2	39	18	2	1	10000
12	Цагаан-Овоо	4	104	43	4	-	36328
13	Чойбалсан	-	-	-	-	-	-
14	Чулуунхороот	-	-	-	-	-	-
<b>ДҮН:</b>		<b>40</b>	<b>709</b>	<b>410</b>	<b>38</b>	<b>30</b>	<b>337352</b>

- Дорнод аймгийн сумдад хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (хоршоо)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:

Аймгийн хэмжээнд 14 суманд хөдөө аж ахуй, нийтийн үйлчилгээ, тээвэр зуучлал, хадгаламж зээл гэсэн төрөл, чиглэлээр нийт 84 хоршоо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс малчдын оролцоотой малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлдэг, мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг, газар тариалан, хадлан бэлтгэх зэргээр хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 13 сумын 2310 гишүүнтэй 54 хоршоог тооллогод хамруулж бүртгэсэн. Бүртгэлийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны хоршооны бүртгэлтэй тулгаж нийцүүлсэн болно.

Сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн нарын танилцуулга, мэдээллээс үзэхэд нийт хоршоодын үйл ажиллагаа идэвхтэй бус, улирлын чанартай буюу ноос, ноолуур, мал, мах, арьс, шир бэлтгэх үед идэвхжиж ажилладаг нийтлэг дутагдалтай тал байна. Харин Засгийн газраас 2022 оныг Хоршооны жил болгосон, мөн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санг өөрчлөн Хоршоог дэмжих сан болгож байгаатай холбогдуулж хоршоод идэвхжих, зарим сумдад шинээр хоршоо байгуулах хандлага харагдаж байна.



### Хүснэгт 3. Дорнод аймгийн малчдын оролцоотой БНХМБ (хоршоо)-ын тооллого, бүртгэл

№	Сумын нэр	Нийт хоршооны тоо	Гишүүдийн тоо	Үүнээс: малчдын оролцоотой ХАА-н хоршооны тоо	ХАА-н хоршооны гишүүдийн тоо
1.	Хэрлэн	18	570	6	327
2.	Баяндун	6	880	4	312
3.	Баянтүмэн	8	226	6	129
4.	Баян-Уул	6	757	4	213
5.	Булган	3	102	3	102
6.	Гурванзагал	5	66	5	66
7.	Дашбалбар	7	428	5	367
8.	Матад	2	112	-	-
9.	Сэргэлэн	8	119	4	76
10.	Халхгол	3	33	2	18
11.	Хөлөнбуйр	3	39	1	20
12.	Цагаан-Овоо	5	773	4	447
13.	Чойбалсан	4	130	4	130
14.	Чулуунхороот	6	103	6	103
	<b>ДҮН:</b>	<b>84</b>	<b>4338</b>	<b>54</b>	<b>2310</b>

- Дорнод аймгийн сумдын малчдын оролцоотой БНХМБ-ын хүний нөөцийн мэдээлэл:

Төсөл хэрэгжиж байгаа Дорнод аймгийн нийт сумдын малчдын оролцоотой БНХМБ (бүлэг, нөхөрлөл, хоршоо)-ын тооллого, бүртгэл, мэдээлэлд үндэслэн тэдгээрийн байршил, ахлагч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гишүүдийг тодорхойлов. Үүнд:

### Хүснэгт 4. БНХМБ (бүлэг, нөхөрлөл)-ын хүний нөөц, гишүүнчлэл

Сумын нэр	Бүлэг Үүнээс:	Гишүүн өрхийн тоо	ИТХ-д сонгогдсон БАХ-ийн ахлагч	Нөхөрлөл Үүнээс:	Гишүүд	УЗ-ийн гишүүдийн тоо	Хяналтын зөвлөлийн гишүүдийн тоо
Баяндун	-	-	-	4	69	11	11
Баян-Уул	14	538	1	26	425	96	64
Баянтүмэн	27	328	3	1	21	3	5
Булган	17	169	1	-	-	-	-
Гурванзагал	-	-	-	-	-	-	-
Дашбалбар	-	-	-	2	31	6	6
Матад	-	-	-	-	-	-	-
Хөлөнбуйр	5	236	-	2	39	6	6
Хэрлэн	14	32	-	-	-	-	-
Халхгол	9	210	-	1	20	3	3
Сэргэлэн	13	276	-	-	-	-	-
Цагаан-Овоо	6	342	1	4	104	12	12
Чойбалсан	18	296	-	-	-	-	-
Чулуунхороот	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>123</b>	<b>2427</b>	<b>6</b>	<b>40</b>	<b>709</b>	<b>137</b>	<b>107</b>

Дорнод аймаг 123 малчдын бүлэг, хэсэгтэй бөгөөд нийт гишүүн малчин өрх 2427, малчид 3230 байгаа бөгөөд, нийт малчдын 2168 буюу 67.1 хувь нь эрэгтэй, 1062 буюу 32.9 хувь нь эмэгтэй малчид байна. Нийт 123 бүлэг, хэсгийн ахлагч нараас 63 хувь нь эрэгтэй, 37 хувь нь эмэгтэй малчин юм. Бүлэг, хэсгийн ахлагч нараас 6 ахлагч сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Тус аймгийн 7 сумын 40 нөхөрлөл нь 40 ахлагч, 709 гишүүнтэй. Эрэгтэй гишүүд 53 хувь, эмэгтэй гишүүд 47 хувийг эзэлдэг. Нөхөрлөлүүдийн дийлэнх нь дотоод дүрэм, журам, богино хугацааны ажлын төлөвлөгөөтэй ба ойн болон бэлчээрийн менежмент, аялал жуулчлал, ан амьтан хамгаалах, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх зэрэг чиглэлээр голчлон үйл ажиллагаа явуулж байна, Ахлагчдын 20 буюу 51 хувь эрэгтэй, 19 буюу 49 хувь нь эмэгтэй, дундаж нас 55 юм. Нөхөрлөлийн гишүүн өрхүүдэд 447 хүүхэд байгаа ба үүний 225 буюу 50.3 хувь нь эрэгтэй, 222 буюу 47,7 хувь эмэгтэй болно. Нөхөрлөлүүд нь Удирдах зөвлөлийн 137, Хяналтын зөвлөлийн 107 гишүүнтэй бөгөөд 48 идэвхтэн байгаль хамгаалагчтай ажилладаг.

#### Хүснэгт 5. Малчдын оролцоотой хоршооны хүний нөөц, гишүүнчлэл

Д/д	Сумын нэр	Хоршооны тоо		Үүнээс: ХАА-н хоршоо
		Нийт хоршоо	ХЗХ, бусад	
1	Хэрлэн	18	12	6
2	Баяндун	6	2	4
3	Баянтүмэн	8	2	6
4	Баян-Уул	6	2	4
5	Булган	3	0	3
6	Гурванзагал	5	0	5
7	Дашбалбар	7	2	5
8	Матад	2	2	
9	Сэргэлэн	8	4	4
10	Халхгол	3	1	2
11	Хөлөнбуйр	3	2	1
12	Цагаан-Овоо	5	1	4
13	Чойбалсан	4	0	4
14	Чулунхороот	6	0	6
	<b>ДҮН:</b>	<b>84</b>	<b>30</b>	<b>54</b>

Тус аймгийн хэмжээнд 84 хоршоо байгаагаас 54 нь хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хоршоод дүрэмдээ заасан чиглэлээр олон талт үйл ажиллагаа явуулж байгаа ба газар тариалан, малын тэжээл үйлдвэрлэл, мал аж ахуй, малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, фермерийн чиглэлээр голчлон ажиллаж байна. ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын гишүүдийн тоо 2310 хүрсэн байна. Хадгаламж зээлийн чиглэлээр 2 сумын 6

хоршоо 575 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба бусад хоршоод нь хөдөө аж ахуйгаас өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

- Дорнод аймгийн сумдын БНХМБ (бүлэг, хоршоо)-ын хөрөнгө, санхүүгийн чадавхын мэдээлэл:

Дорнод аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа малчдын оролцоотой бүлэг, хоршооны хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхыг тэдгээрийн хариуцаж байгаа бэлчээр, байгалийн нөөц, нутаг дэвсгэрийн хэмжээ, сумын Засаг даргатай байгуулсан гэрээ, үргэлжлэх хугацаа, гишүүдийн малын тоо, хувь нийлүүлсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт зэрэг мэдээллийг үндэслэн тогтоож 6, 7 дугаар хүснэгтүүдэд үзүүлэв.

#### Хүснэгт 6. Малчдын бүлгийн хөрөнгө, санхүүгийн чадавх

Сумын нэр	Бэлчээрийн хэмжээ, га	Гэрээний хугацаа, жил	Малын тоо					
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Нийт
Баяндун	-	-	-	-	-	-	-	-
Баян-Уул	308,987	15	331	13052	14163	43171	27875	98,592
Баянтүмэн	801,183	15	744	28,319	22,043	87,683	59,631	198,420
Булган	-	-	198	6,674	3,932	23,058	14,675	48,537
Гурванзагал	-	-	-	-	-	-	-	-
Дашбалбар	-	-	-	-	-	-	-	-
Матад	-	-	-	-	-	-	-	-
Хөлөнбуйр	377,995	15	2573	34578	10017	55396	28328	130892
Хэрлэн	-	-	-	-	-	-	-	-
Халхгол	-	-	225	11131	10491	22227	24361	68,435
Сэргэлэн	395,696	15	768	15715	12279	81921	45751	156,434
Цагаан-овоо	578,584	15	548	24217	20494	103435	84352	233,046
Чойбалсан	883,304	15	379	17,239	14,493	48,614	39,677	120,402
Чулуухороот	1,516,138	15	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>3,345,749</b>	<b>15</b>	<b>5,766</b>	<b>150,925</b>	<b>107,912</b>	<b>465,505</b>	<b>324,650</b>	<b>1,054,758</b>

Тус аймгийн малчдын бүлгүүд 3.3 сая га бэлчээрийг сумын Засаг даргатай 15 жилийн хугацаатайгаар ашиглахаар гэрээ байгуулсан байна. Бэлчээр ашиглах урт хугацаатай гэрээ байгуулсан нь нэг сая толгой мал сүрэгтэй гишүүн малчдыг цаашид тогтвортой үйлдвэрлэл эрхэлж орлого олох улмаар төрийн байгууллага, төсөл хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас аливаа хөрөнгө оруулалт татахад таатай нөхцөлийг бий болгож байна.

#### Хүснэгт 7. ХАА-н хоршооны хөрөнгө, санхүүгийн чадавх

Д/д	Сумын нэр	ХАА-н хоршоо	Дүрмийн сан	Зээлд хамрагдсан эсэх мөнгөн дүн сая,төг
1	Баяндун	4	1,990,000	60.0
2	Баянтүмэн	6	3,600,000	50.0

3	Баян-Уул	4	2,520,000	145.0
4	Булган	3	-	60.0
5	Гурванзагал	5	900,000	5.0
6	Дашбалбар	5	8,715,000	76.0
7	Матад		-	
8	Сэргэлэн	4	650,000	30.0
9	Халхгол	2	600,000	15.0
10	Хөлөнбуйр	1	810,000	-
11	Хэрлэн	6	1,730,000	109.80
12	Цагаан-Овоо	4	9,300,000	30.0
13	Чойбалсан	4	-	-
14	Чулуунхороот	6	2,100,000	-
	<b>Дүн</b>	<b>54</b>	<b>32,915,000</b>	<b>580.8</b>

Аймгийн хэмжээнд ХАА-н чиглэлээр 13 суманд 54 малчдын оролцоотой хоршоо ажилладаг. Эдгээр хоршоод нь 32,9 сая төгрөгийн дүрмийн сантай байгаа ба сум хөгжүүлэх сан (одоо хоршоо хөгжүүлэх сан болсон), жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, 2014 онд Хөдөлмөрийн яамнаас хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй дэмжлэг, 2015 онд Хөдөлмөрийн яамнаас хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй дэмжлэг зэрэг эх үүсвэрээс авсан 580,8 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа мэдээлэл байна.

### 1.1.2. Сүхбаатар аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр, хүний нөөц, хамрагдаж буй малчин өрхийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхын бүртгэл тооллого

- Сүхбаатар аймгийн сумдад бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (малчдын бүлэг)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:

Сүхбаатар аймгийн нийт 13 суманд бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг малчдын оролцоотой БНХМБ (малчдын бүлэг)-ын тооллого, бүртгэлийг аймаг, сумдын холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн нартай хамтран судалгаа авч хийхэд тус аймгийн нийт 8 суманд 1465 малчин өрхийг хамруулсан 43 малчдын бүлэг тооллогонд хамрагдаж бүртгэгдсэн. Эдгээр бүлгүүдээс 28 бүлэг нь 8 сумын Засаг даргатай “бэлчээр ашиглах гэрээ” байгуулж, бүгд газрын мэдээллийн санд бүртгүүлсэн байна. Харин Баруун-Урт, Асгат, Дарьганга, Наран, Онгон зэрэг 5 суманд ямар нэгэн малчдын бүлэг байгуулагдаагүй байна.

Хүснэгт 8. Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ (бүлэг)-ын тооллого, бүртгэл

№	Сумын нэр	Бүлгийн тоо	Бүлгийн гишүүн малчин өрхийн тоо	Бэлчээр ашиглах гэрээний тоо	Гэрээг газрын нэгдмэл санд бүртгүүлсэн тоо
1.	Баруун-Урт	-	-	-	-
2.	Асгат	-	-	-	-
3.	Баяндэлгэр	5	209	5	5
4.	Дарьганга	-	-	-	-
5.	Мөнххаан	5	-	-	-
6.	Наран	-	-	-	-
7.	Онгон	-	-	-	-
8.	Сүхбаатар	9	346	-	-
9.	Түвшинширээ	6	231	6	6
10.	Түмэнцогт	4	144	4	4
11.	Уулбаян	1	-	-	-
12.	Халзан	4	188	4	4
13.	Эрдэнэцагаан	9	347	9	9
<b>ДҮН:</b>		<b>43</b>	<b>1465</b>	<b>28</b>	<b>28</b>

Дээрх 8 сумын малчдын бүлэг, хэсэг нь тус аймагт хэрэгжиж байсан олон улсын байгууллага, хөтөлбөр, төслийн хүрээнд байгуулжээ. Үүнд:

1. 2016-2021 онд: Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилт бүхий “Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд Баяндэлгэр суманд 5, Сүхбаатар суманд 9, Түвшинширээ суманд 6, Түмэнцогт суманд 4, Халзан суманд 4, Эрдэнэцагаан суманд 9, нийт 6 суманд 37 бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийг байгуулж, үүнээс 28 БАХ нь Газрын тухай хуулийн 52.2-ыг үндэслэн тухайн сумдын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээг байгуулж, улмаар газрын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

Дээрх БАХ-үүд нь нэг нутаг бэлчээр бүхий 30-60 малчин өрхүүдийг нэгтгэн “бэлчээрээс ашиг хүртэгч нь хамгаалагч байна” гэсэн үзэл баримтлалтай ажиллаж байна. Энэ төслийн хүрээнд БАХ-ийн гишүүн малчдыг дэмжих зорилгоор төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “малчдын дундын сан”-г үүсгэн байгуулах ажлыг анх удаа үр дүнтэй зохион байгуулсан сайн туршлага байна. Мөн тус аймгийн нийт сумдын газрын даамал нарыг бэлчээрийн фото-мониторингийн судалгаа хийх, дүгнэх чиглэлээр чадавхжуулах ажлыг хийж, шаардагдах гарын авлага, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллажээ. Энэ ажлын үр дүнд төсөл хэрэгжиж байсан сумдын БАХ-үүдийг хамруулан улирлын бэлчээр тус бүрд тухайн жилийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор бэлчээрийн фото-мониторингийн судалгааг жил бүрийн 8 дугаар сарын эхний 15 хоногт хийж, ургацын байдлыг БАХ, баг, сум, аймгийн түвшинд нэгтгэн дүгнэн гаргаж, орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, малчдыг мэдээллээр хангах, малчдын бүлгийн бэлчээр ашиглах гэрээний

хэрэгжилтийг дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгох ажлыг хэвшүүлэн ажиллаж байгаа ололттой тал байна.

2. 2019-2022 онд: НҮБ болон Олон улсын хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн санхүүжилт бүхий “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн хүрээнд өмнө нь “Ногоон алт, малын эрүүл мэнд” төслөөр Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан суманд байгуулсан 20 БАХ-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжин ажилласан байна.

Энэ төслийн хүрээнд 20 БАХ тус бүрийн “2019-2021 оны бэлчээрийн менежментийн төлөвлөгөө”-г сумын удирдлага, мэргэжилтэн, малчдын оролцоотой боловсруулж, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлж ажилласан байна. Мөн тус төслөөс БАХ-ийн гишүүн малчдыг дэмжих зорилгоор сүм, багийн түвшинд тэжээлийн агуулах болон мал угаах төхөөрөмж барьж өгөх, инженерийн хийцтэй худаг гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх багаж хэрэгсэл олгох зэрэг хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

3. Сүхбаатар аймгийн 3 суманд хэрэгжиж байсан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Нидерландын Вант Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж байсан “Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент” төслийн хүрээнд малчдын бүлэг үүсгэн байгуулж байсан хэвлэлийн мэдээлэл байдаг боловч, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэдээлэл байхгүй байна.

Харин сумдын өгсөн мэдээллээс үзэхэд Уулбаян, Мөнххаан сумд нь малчдын үүсгэл санаачилгаар малчдын бүлгүүдийг багийн түвшинд загвар байдлаар байгуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байгаа сайн жишээ байна.

- Сүхбаатар аймгийн сумдад байгалийн нөөцийн /ус, ой, амьтан/ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (нөхөрлөл)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:

Тус аймгийн нийт 13 сумаас 4 суманд 5 нөхөрлөл тооллого, бүртгэлд хамрагдсан. Аймаг, сумдын байгаль, цаг уур, газар нутгийн онцлог байдлаас хамаарч нөхөрлөлийн үйл ажиллагаа нь ашиглах гэхээс илүү хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажилладаг онцлогтой байна. Эдгээр нөхөрлөл нь нийт 53494 га талбайг хамгаалж, амьтан хамгаалах, усны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг юм байна. Тухайлбал: Дарьганга сумын хоёр нөхөрлөлийн нэг нь Нарт уулын аргаль, нөгөө нь Холбоо нуурын бургасыг хамгаалах, Түвшинширээ сумын нэг нөхөрлөл Маргал ууланд байдаг аргаль, Мөнххаан сумын нөхөрлөл Баян ууланд байдаг аргаль хамгаалах зорилготой байна. Харин Түмэнцогт сумын нөхөрлөл бол байгаль орчныг /гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, Хар ямаатын ууланд ойжуулалт хийх гэх мэт/ хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Хүснэгт 9. Сүхбаатар аймаг дахь малчдын оролцоотой БНХМБ (нөхөрлөл)-ын тооллого, бүртгэл

№	Сумын нэр	Нөхөр- лөлийн тоо	Гишүүдийн тоо	Хамрагд- сан малчин өрхийн тоо	Гэрээний тоо	Гэрчилгээ- ний тоо	Хамгаалж байгаа газрын хэмжээ /га/
1.	Баруун-Урт	-	-	-	-	-	-
2.	Асгат	-	-	-	-	-	-
3.	Баяндэлгэр	-	-	-	-	-	-
4.	Дарьганга	2	36	-	2	-	30000
5.	Мөнххаан	1	10	-	1	-	11857
6.	Наран	-	-	-	-	-	-
7.	Онгон	-	-	-	-	-	-
8.	Сүхбаатар	-	-	-	-	-	-
9.	Түвшинширээ	1	15	-	1	-	7637
10.	Түмэнцогт	1	10	-	1	-	4000
11.	Уулбаян	-	-	-	-	-	-
12.	Халзан	-	-	-	-	-	-
13.	Эрдэнэцагаан	-	-	-	-	-	-
<b>ДҮН:</b>		<b>5</b>	<b>71</b>		<b>5</b>		<b>53494</b>

- Сүхбаатар аймгийн сумдад хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ (хоршоо)-ын тоо, байршил, бүтэц, зохион байгуулалт, засаглалын хэлбэр:

Сүхбаатар аймгийн хэмжээнд хөдөө аж ахуй, нийтийн үйлчилгээ, тээвэр зүүчлал, хадгаламж зээл гэсэн чиглэлээр нийт 83 хоршоо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 11 суманд малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлдэг, мал эмнэлгийн ажил үйлчилгээ, газар тариалан, хадлан бэлтгэх зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг малчдын оролцоотой хөдөө аж ахуйн чиглэлийн 2859 гишүүнтэй 33 хоршоог тоолж бүртгэсэн. Бүртгэлийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны хоршооны бүртгэлтэй тулгаж нийцүүлсэн болно. Тооллог, бүртгэлийн дүнгээс үзэхэд тус аймгийн Халзан суманд ямар нэгэн хоршоо бүртгэгдээгүй байна.

Сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн нарын мэдээлснээр нийт хоршоодын үйл ажиллагаа идэвхтэй бус, улирлын чанартай буюу ноос, ноолуур, мал, мах, арьс, шир бэлтгэх үед идэвхжиж ажилладаг нийтлэг дутагдал байна. Харин Засгийн газраас 2022 оныг Хоршооны жил болгосон, мөн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санг өөрчлөн Хоршоог дэмжих сан болж байгаатай холбогдуулж хоршоод идэвхжих, зарим сумдад шинээр хоршоо байгуулах хандлага харагдаж байна.

Хүснэгт 10. Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ (хоршоо)-ын тооллого, бүртгэл

№	Сумын нэр	Нийт хоршооны тоо	Гишүүдийн тоо	Үүнээс: малчдын оролцоотой ХАА-Хоршооны тоо	ХАА-н хоршооны гишүүдийн тоо
1.	Баруун-Урт	34	1423	9	726
2.	Асгат	5	59	1	10
3.	Баяндэлгэр	7	1016	7	1016
4.	Дарьганга	5	390	3	207
5.	Мөнххаан	3	354	1	210
6.	Наран	1	221	-	-
7.	Онгон	2	183	1	9
8.	Сүхбаатар	4	67	2	19
9.	Түвшинширээ	6	376	3	343
10.	Түмэнцогт	6	169	4	80
11.	Уулбаян	3	257	1	230
12.	Халзан	0	0	-	-
13.	Эрдэнэцагаан	7	153	1	9
<b>ДҮН:</b>		<b>83</b>	<b>4687</b>	<b>33</b>	<b>2859</b>

- Сүхбаатар аймгийн сумдын малчдын оролцоотой БНХМБ-ын хүний нөөцийн мэдээлэл:

Төсөл хэрэгжиж байгаа Сүхбаатар аймгийн нийт сумдын малчдын оролцоотой БНХМБ (бүлэг, нөхөрлөл, хоршоо)-ын тооллого, бүртгэлд үндэслэн тэдгээрийн байршил, ахлагч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гишүүдийн мэдээллийг 11-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11 БНХМБ (бүлэг, нөхөрлөл)-ын хүний нөөц, гишүүнчлэл

Сумын нэр	Бүлэг Үүнээс:	Гишүүн ерхийн тоо	ИТХ-д сонгогдсон бүлгийн ахлагч	Нөхөрлөл Үүнээс:	Гишүүд	УЗ-ийн гишүүдийн тоо	Хяналтын зөвлөлийн гишүүдийн тоо
Асгат	-	-	-	-	-	-	-
Баруун урт	-	-	-	-	-	-	-
Дарьганга	-	-	-	2	36	-	-
Мөнххаан	5	-	-	1	10	-	-
Сүхбаатар	9	346	-	-	-	-	-
Түвшинширээ	6	231	2	1	15	-	-
Түмэнцогт	4	144	1	1	10	-	-
Уулбаян	1	-	-	-	-	-	-
Халзан	4	188	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	9	347	2	-	-	-	-
Баяндэлгэр	5	209	3	-	-	-	-



Наран	-	-	-	-	-	-	-
Онгон	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>43</b>	<b>1465</b>	<b>8</b>	<b>5</b>	<b>71</b>	<b>-</b>	<b>-</b>

Сүхбаатар аймгийн 8 суманд нийт 43 малчдын бүлэг, хэсэгтэй бөгөөд гишүүн малчин өрхийн тоо 1465, малчин 5028, малчдын 2474 буюу 50.2 хувь нь эрэгтэй, 2554 буюу 49.8 хувь нь эмэгтэй байна. Нийтдээ 43 бүлэг, хэсгийн ахлагчаас 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэй малчин байна. БАХ-ийн 8 ахлагч сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна. БАХ-ийн гишүүдийн хамтран ажиллах дотоод дүрэмдээ тусгасан “дундын бэлчээр нутгаа хайрлан хамгаалах, даацад нь тохируулан мал аж ахуйгаа эрхлэх” гэсэн чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тус аймгийн 4 суманд нийт 5 нөхөрлөл, 5 ахлагч, 71 гишүүнтэйгээр “байгаль орчны” чиглэлээр буюу амьтан, ургамлыг хамгаалах үйл ажиллагаа явуулж байна.

#### Хүснэгт 12. Малчдын оролцоотой хоршооны хүний нөөц, гишүүнчлэл

Д/д	Сумын нэр	ХАА-н хоршооны тоо	Гишүүдийн тоо	Үүнээс: Тэргүүлэгчдийн тоо
1	Баруун-Урт	9	726	3
2	Асгат	1	10	45
3	Баяндэлгэр	7	1016	15
4	Дарьганга	3	207	9
5	Мөнххаан	1	210	9
6	Наран	-	-	7
7	Онгон	1	9	6
8	Сүхбаатар	2	19	9
9	Түвшинширээ	3	343	
10	Түмэнцогт	4	80	3
11	Уулбаян	1	230	23
12	Халзан	-	-	
13	Эрдэнэцагаан	1	9	3
	<b>Дүн</b>	<b>33</b>	<b>2859</b>	<b>132</b>

Тус аймгийн хэмжээнд 11 суманд 33 хоршоо хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын гишүүдийн тоо 2859, тэргүүлэгчдийн тоо 132 байна. Эдгээр хоршоод дүрэмдээ заасан чиглэлээр олон талт үйл ажиллагаа явуулж байгаа ба газар тариалан, малын тэжээл үйлдвэрлэл, мал эмнэлэг, мал аж ахуй, малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, фермерийн чиглэлээр голчлон ажиллаж байна.

- Сүхбаатар аймгийн сумдын БНХМБ /бүлэг, хоршоо/-ын хөрөнгө, санхүүгийн чадавхын мэдээлэл:

Төсөл хэрэгжиж буй Сүхбаатар аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа малчдын оролцоотой бүлэг, хэсэг, хоршооны хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхыг тэдгээрийн

хариуцаж байгаа бэлчээр, байгалийн нөөц, нутаг дэвсгэрийн хэмжээ, сумын Засаг даргатай байгуулсан гэрээ, түүний хугацаа, гишүүдийн малын тоо, хувь нийлүүлсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт зэрэг сумдаас авсан мэдээллийг үндэслэн үнэлж 13,14-р хүснэгтэд үзүүлэв.

### Хүснэгт 13. Малчдын бүлэг, хэсгийн хөрөнгө, санхүүгийн чадавх

Сумын нэр	Бэлчээрийн хэмжээ, га	Гэрээний хугацаа, жил	Хашаалсан хадлан, тэжээлийн талбай, га	Малын тоо					
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Нийт
Асгат	-	-	-	-	-	-	-	-	-
Баруун урт	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	-	-	-	-	-	-	-	-	-
Мөнххаан	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	-	5	-	1,098	23,773	16,414	138,757	79,034	259,076
Түвшинширээ	203,085	5	-	489	6064	4578	56793	40078	108,002
Түмэнцогт	149,799	5	-	220	8,710	6,264	34,291	26,808	76,293
Уулбаян	160,274	5	-	153	4,450	2861	28,429	13,396	49,289
Халзан	-	5	-	159	7,811	4,710	48,102	23,307	84,089
Эрдэнэцагаан	818,137	5	-	372	14485	8241	47053	51261	121,412
Баяндэлгэр	249,828	5	50	161	3980	4477	55608	33916	98,142
Наран	-	-	-	-	-	-	-	-	-
Онгон	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>1,581,123</b>	<b>5</b>	<b>50</b>	<b>2,652</b>	<b>69,273</b>	<b>47,545</b>	<b>409,033</b>	<b>267,800</b>	<b>796,303</b>

Тус аймгийн бэлчээр ашиглагч бүлэг, хэсгүүд 1,5 сая га бэлчээрийг сумын Засаг даргатай 5 жилийн хугацаатай ашиглахаар гэрээ байгуулсан байна. Бэлчээр ашиглах урт хугацааны гэрээ байгуулсан нь гишүүн малчдыг цаашид тогтвортой үйлдвэрлэл эрхэлж орлого олох улмаар төрийн байгууллага, төсөл хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас аливаа хөрөнгө оруулалт татах таатай нөхцөлийг бий болгож байна. Урт хугацаатай ашиглах гэрээтэй бэлчээр нутаг, 0,79 сая толгой мал сүрэг нь малчдын тогтвортой үйлдвэрлэлийн гол эх үүсвэр болсон байна.

### Хүснэгт 14. ХАА-н хоршооны хөрөнгө, санхүүгийн чадавх

Д/д	Сумын нэр	ХАА-н хоршоо	Дүрмийн сан мөнгөн дүн	Зээлд хамрагдсан эсэх мөнгөн дүн
1	Асгат	1	-	-
2	Баруун урт	9	-	-
3	Дарьганга	3	-	-
4	Мөнххаан	1	20.000.000	114.000.000
5	Сүхбаатар	2	-	-
6	Түвшинширээ	3	16.400	-
7	Түмэнцогт	4	2.500.000	67.000.000
8	Уулбаян	1	-	-

9	Халзан		-	-
10	Эрдэнэцагаан	1	-	-
11	Баяндэлгэр	7	60.500.000	-
12	Наран	-	-	-
13	Онгон	1	-	-
<b>Дүн</b>		<b>33</b>	<b>83,016,400</b>	<b>181,000,000</b>

Аймгийн хэмжээнд ХАА-н чиглэлээр 11 суманд 33 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хоршоод нь 83,0 сая төгрөгийн дүрмийн сантай байгаа ба сүм хөгжүүлэх сан (одоо хоршоо хөгжүүлэх сан болсон), жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, технологийн парк зэрэг эх үүсвэрээс авсан 181,0 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### 1.2. Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны чиглэл, хэрэгжилт, хууль, эрх зүйн орчны талаар:

Малчдын оролцоотой БНХМБ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **нөхөрлөл**, бэлчээр ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **малчдын бүлэг**, хэсгийн эрх зүйн статус, тэдний ижил төстэй ба ялгаатай асуудлуудыг хууль зүйн талаас нь харьцуулан авч үзэх шаардлагатай юм.

#### Хүснэгт 15. Нөхөрлөл, бүлгийн эрх зүйн статус, ижил төстэй ба ялгаатай талууд

№	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл /цаашид нөхөрлөл гэх/	Бэлчээр ашиглагчдын бүлэг, хэсэг /цаашид бүлэг гэх/	Хууль зүйн тайлбар, дүгнэлт
1.	Иргэний хуулийн 481-д нөхөрлөлийг хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2.8-д нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа ил	Бүлэг бол бэлчээрийг ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулах талаар сайн дураараа нэгдсэн, өөрийн дүрэм, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, ахлагчтай, ахлагчаараа дамжуулж нийгмийн харилцаанд оролцдог, улсын эрхийн бүртгэлийн газарт бүртгүүлээгүй, малчдын байгууллагын анхан шатны бие даасан бүтцийн нэгж юм.	Нөхөрлөл нь улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй, бөгөөд түүний эрх зүйн статусыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар шууд тодорхойлон зохицуулсан тул тухайн газар нутагтаа тодорхой төрлийн баялгийг гэрээний үндсэн дээр эзэмших хэлбэрээр ашиглаж, хамгаалах хууль зүйн зохицуулалттай байгалийн баялгийг зохистой ашиглах, хамгаалах зорилгоор гэрээ байгуулж бий болсон бүтцийн нэгж. Харин бүлгийн эрх зүйн байдлыг

тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой бүтцийн хэлбэрийг тус тус хуульчилсан.

холбогдох хуульд тодорхой хуульчлаагүй боловч байгалийн нөөц баялгийг ашиглах, эзэмших харилцаанд хязгаарлагдмал хүрээнд буюу Газрын тухай хуулийн 52.2-ын дагуу өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг хэсэг бүлэг болсон малчдад гэрээний дагуу ашиглуулах эрх сумын Засаг даргад бий гэж үзэж болно.

### Байгалийн баялаг ашиглах эрх /онолын хувьд/

**Байгалийн баялаг ашиглах тусгайлсан эрх эдэлнэ.** Өөрөөр хэлбэл, иргэдийн нөхөрлөлийн эдийн засгийн ашиг сонирхлыг байгалийн тодорхой төрлийн баялгаар хангах зорилготой байдаг учраас төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийн тусгай журамтай байж, түүний дагуу байгалийн баялгаас тодорхой хэсгийг салгаж буюу тасалж ашиглахыг зайлшгүй шаарддаг.

**Байгалийн баялаг ашиглах нийтийн эрх эдлэх боловч өвөлжөө, хаваржааны бэлчээрийг гэрээгээр ашиглах тусгайлсан эрх эдэлж болно.** **Гэхдээ байгалийн баялаг ашиглах тусгайлсан эрхийг сонгодог утгаараа эдлэнэ гэж шууд дүгнэхэд онолын хувьд бэрхшээлтэй.** Төрийн захиргааны аль нэгэн байгууллага, албан тушаалтан болон хуулийн этгээдээс **тусгайлан зөвшөөрөл авахыг шаардахгүй** бүх нийтэд хүртээлтэй байдаг байгалийн баялаг болох бэлчээрээс зөвхөн хоёр улирлын бэлчээрийг ашиглах эрх эдлэх тухай хэм хэмжээ юм.

Нөхөрлөл бол хуульд заасан үндэслэл, журмаар баялгийг эзэмших тусгай зохицуулалттай учраас байгалийн баялгийг ашиглах тусгайлсан эрх эдэлдэг субъект. Харин бүлэг бол зөвхөн өвөл, хаврын бэлчээрийг хэрэв хүсвэл сайн дураараа гэрээгээр хамтран ашиглах эрх зүйн зохицуулалттай. Гэхдээ бүлэг, нөхөрлөл гэсэн субъектүүдийн үүсгэн байгуулагдсан хэлбэр, бүтэц, зохион байгуулалт төстэй боловч БОХТухай хуульд нөхөрлөл гэсэн нэрээр шууд хуульчилснаараа уг субъект байгалийн нөөц баялгийг эзэмшин ашиглагч субъект болж байна. Мөн нөхөрлөлийн эзэмших, ашиглах баялгийн үндсэн объект нь нэг дор, харин бүлгийн зохион байгуулалт бол 4 улирлын бэлчээрт түшиглэн байгуулагдсан тул ялгаатай. Харин бүлэг нь ойн нөөц сан бүхий газарт нутагладаг тохиолдолд нөхөрлөл гэсэн нэртэй дүрмээ батлаад, тухайн нөөц баялаг бүхий бэлчээрийн газрын БОХТухай хуульд заасан үндэслэл, журмаар хугацаатай

гэрээ байгуулан эзэмшиж болох юм.

#### **Байгалийн баялаг ашиглах, эзэмших харилцааны субъект болох байдал**

Нөхөрлөл нь байгалийн баялаг ашиглаж байгаа бөгөөд хуульд заасан тодорхой эрх, үүрэг хүлээсэн субъект болно. Бүлэг бол хуулиар байгалийн баялгийг ашиглах эрх эдлэх боломж бүхий субъектэд хамаарна. Байгалийн баялаг ашиглаж буй зориулалтаасаа хамаарч нөхөрлөл, бүлэг нь ялгаатай субъект болох тул Бүлэг нь байгалийн баялгийг нийтээр ашиглагч субъект, Нөхөрлөл нь дангаараа байгалийн баялгийг эзэмшигч, ашиглагч субъект болно.

#### **Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын хэмжээ**

**БОХТХ. 24 дүгээр зүйл. Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ**

1. Байгалийн баялгийн нөөцийг түүний даац, нөхөн сэргэх чадварыг харгалзан тодорхой хугацаанд ашиглаж болох хэмжээг байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын хэмжээ гэнэ.

2. Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно.

Газрын тухай хууль 52.6. Энэ хуулийн 52.1-д заасан ерөнхий хуваарь, 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Нөхөрлөлийн ашиглах байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын хэмжээг тогтоох асуудлыг хуульчилсан бол газрын тухай хуулийн 52.2-д заасан малчдын хэсэг, бүлэг, өөрөөр хэлбэл Бүлгийн ашиглах бэлчээрийн даацыг тогтоож гэрээ байгуулах асуудлыг шүүд тусгасан тодорхой зохицуулалтгүй орхисон нь эдгээр хоёр субъектийн ашиглах баялгийн нөөцийн талаарх ялгааг илэрхийлж байна.


<p>1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>Газрын тухай хуулийн 52 дугаар зүйл 52.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог,</p>	<p>Нөхөрлөлийн тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг хуулиар шат шатны төрийн эрх бүхий байгууллага тогтоохоор хуульчилсан. Харин Бүлгийн</p>
<p><b>2. Нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг</b> энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;</p>	<p>бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.</p>	<p>ашиглах бэлчээр болон байгалийн бусад төрлийн баялгийн хэмжээг нарийвчлан тогтоох талаар хуульчлаагүй, зөвхөн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах асуудлыг ерөнхийлөн хуульчилсан байна.</p>

#### Бэлчээр ашиглалтын эрх зүйн үндэс

<p><b>45 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежмент</b></p>	<p>52.3.Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно.</p>	<p>Бүлэг нь ойн сан бүхий газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжтой боловч тухайн газрыг эзэмших эрхтэйгээр ашиглах хүсэлтэй тохиолдолд зайлшгүй БОХТухай хуульд заасан бүтцийн зохион байгуулалтад орж, Нөхөрлөл болж болно.</p>
<p>1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ.</p>		

50 дугаар зүйл. Байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөл	Бүлгийн хамтын журам	Бүлгийн дотоод дүрэм, Нөхөрлөлийн эрх зүйн статусыг шууд тогтоосон хэм хэмжээгээр зохицуулсан бол Бүлгийн эрх зүйн статусыг тухайн малчид өөрсдөө бие даан бий болгосон.
---	----------------------	--

Байгалийн баялаг ашиглах эрх өөрийн гэсэн тусгай зарчимтай. Түүнийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч субъектүүдийн аль аль нь заавал дагаж баримтлах бөгөөд зарчмуудыг үндэслэн малчдын оролцоотой БНХМБ-ын байгалийн баялгийн зохистой ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох нь ихээхэн ач холбогдолтой.



**Ашиглах эрх нь тухайн баялгийг өмчлөх эрхээс үүсмэл байх зарчим** бол манай улсад байгалийн баялаг үндсэндээ төрийн өмч учраас аль ч субъект түүнийг ашиглахдаа төрийн зохих байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр ашиглах эрх эдэлнэ. Харин нийтээр ашиглах эрх үүнд хамаарахгүй онцлогтой. Үүнд бэлчээр, бэлчээр дэх хужир мараа бүхий газар ашиглалт хамаарна. Байгалийн баялгийг өмчлөгч төр нь ашиглагч субъектүүдийн эрх, үүрэг, ашиглалтын нөхцөл, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хуульчлан тогтоож, тэдгээрийн хэрэгжилтийг хангах арга ажиллагааг зохион байгуулан удирдана. Энэ нь ашиглах эрх өмчлөх эрхээс үүсмэл байхын бас нэгэн тодорхой жишээ юм.

**Зүй зохистой, үр ашигтай ашиглах зарчим** бол монголчуудын уламжлалт үзэл баримтлал, дадлага түршлага мөн. Монголчууд байгалийн аливаа баялгийг энэрэнгүй, ариг гамтай, хэрэгцээнийхээ шаардлагад тохируулан, хаягдал үрэгдэлгүй ашиглаж ирсэн уламжлалтай. Энэхүү зарчмыг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл байгальд эдийн засаг, соёл, хүмүүнлэг сэтгэлгээний үүднээс хандах ухагдахууныг агуулна.

**Экосистемийн зүй тогтлыг харгалзан экологийн тэнцлийг хангах зарчим** бол байгалийн баялгийг зохистой ашиглах зарчимтай уялдаатай. Энэ зарчмыг эрдэмтэд, судлаачид байгалийн жам ёс, харилцан уялдааг заавал харгалзан үзэж ашиглалт хийх үзэл баримтлал гэж үздэг. Байгалийн баялгийг бүрэн дүүрэн ашиглана гэдэг бол хууль

зүйн утгаараа “шавхаж ашиглана” гэсэн үг огт биш юм. Баялгаас ашиглахыгаа үрэгдэл хорогдолгүй авч, үлдэхийг байгалийнхаа аясаар төлжин сэргэх чадвартай нь байлгана гэсэн агуулгатай. Иймд дээр дурдсан хоёр зарчим нь харилцан уялдаатайгаар байгаль орчныг хамгаалах шаардлагаас урган гардаг. Экологийн тэнцлийг хангах зарчмын бас нэгэн чухал шинж нь нэг төрлийн баялгийг ашиглахдаа бусад баялагт хор хохирол, эвдрэл сүйрэл, бохирдол учруулахгүйгээр хүрээлэн байгаа орчныг бүхэлд нь хамгаалах асуудалд чиглэгдэнэ. Уг зарчмыг байгаль орчны хуулиудад мөн л ашиглагч субъектийн үүргийн хэлбэрээр тодорхойлон бэхжүүлсэн байдаг.

**Ашиглалт сонгон оноосон зориулалттай байх, ашиглалт тогтвортой байх зарчим** бол ихэвчлэн газар, газрын хэвлий, ой. Ургамал, амьтны аймаг зэрэг байгалийн баялгийн ашиглалтад илүү хамаарна. Газар, ой, ус, ургамлыг ашиглалтад олгох зөвшөөрөл, газрын хэвлий, ашигт малтмал ашиглах лицензэд тус тусын ашиглах зориулалтыг тодорхой зааж, үг зориулалтаас өөрөөр ашиглавал ашиглах эрхийг зогсоох хүртэл хууль зүйн үр дагавар үүснэ. Зориулалт тус бүрийг ашиглагч өөрөө сонгон тогтоох эрх эдэлдэг учраас “**сонгон оноосон**” гэсэн тодотгол хэрэглэдэг. Энэ нь байгалийн баялгийн дүр зоргын ашиглалт байхгүй гэсэн агуулга бүхий хууль зүйн ухагдахуун юм.

**Ашиглалт тогтвортой байх зарчим** бол байгалийн баялгийг урт хугацаатай ашиглуулж ашиглагчийн эрх, ашиг сонирхол, итгэл найдварыг баталгаажуулах үзэл баримтлал юм. Энэ зарчим газар, ус, ашигт малтмал, ашиглах үйл ажиллагаанд илүүтэй хэрэгжиж байхаар хуульчилсан. Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд төрийн өмчийн газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 15-60 жил хүртэл хугацаагаар эзэмшүүлэн ашиглуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад нэг удаад 40 жилээс илүүгүй хугацаагаар сунгаж болохоор зохицуулсан нь тогтвортой ашиглалтыг хуульчлан баталгаажуулсан баримт юм. Усны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2-т ус ашиглах гэрээг 20 хүртэл жилийн хугацаатайгаар байгуулж, нэг удаа сунгах хугацааг 5 хүртэл жил байхаар заасан нь мөн л тогтвортой ашиглалтын зарчмыг хуульчилсан хэрэг мөн.

**Байгалийн баялгийн ашиглалт төлбөртэй байх зарчим** бол байгалийн баялаг ашиглах аливаа субъект үг ашиглалтын төлөө зохих төлбөр, хураамж төлөх шаардлагатайг хуулиар баталгаажуулсан явдал юм. Харин нийтийн ашиглалт үүнд хамаарахгүй байдгаараа төлбөргүй байна. Энэ зарчмын утга агуулга нь ашиглагдсан баялгийн үлдсэнийг хэвийн тааламжтай байдалд нь байлгах, нөхөн сэргээх эдийн засгийн хөшүүргийг хэрэглэхэд оршино. Төлбөр дан ганц ашиглалтын төлөө бус, байгаль орчныг бохирдуулсны төлөө бас төлбөр төлдөг үндэсний төдийгүй олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурладаг. Байгаль орчныг бохирдуулсан бол түүний төлбөрийг бохирдуулсан этгээд өөрөө хариуцдаг түгээмэл зарчим дэлхийн бүх оронд хэрэгждэг байна. Төлбөрийн хэмжээ, журмыг зөвхөн хуулиар тогтооно. Монгол Улсад өнөөгийн байдлаар газрын, ус, рашаан ашигласны, ойгоос хэрэглээний мод, бүлээ бэлтгэж ашигласны, байгалийн ургамал ашигласны, агнуурын нөөц ашигласны болон ан амьтан агнах, барих зөвшөөрлийн төлбөр, хураамжийн тухай тус тусын төрөлжсөн хууль үйлчилж байна.



Байгалийн баялаг ашигласны төлбөрийн эрх зүйн зохицуулалт нь байгаль ашиглах, байгаль орчныг хамгаалах эдийн засаг, эрх зүйн нэгэн чухал механизм болдог.

Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны чиглэлээр ангилахын тулд байгалийн нөөц баялгийг өмлөх, эзэмших, ашиглах эрх, ялангуяа ашиглах эрхийн талаарх хууль зүйн онолын ойлголтод үндэслэн илэрхийлэх нь зохистой.

Байгалийн баялаг эзэмших эрх нь уг баялгийг өмчлөх эрхээс үүсмэл байх бөгөөд ашиглах эрхийн хамт эдэлж байдаг. Эзэмших эрхийн онцлог нь тодорхой хугацаатай, байгалийн баялгийг эзэмших талаар төрөөс тогтоосон буюу зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээний нийлбэрээс бүрдэнэ.

Байгалийн баялаг ашиглах харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний тогтолцоог **байгалийн баялаг ашиглах эрх** гэж нэрлэдэг. Эрх зүйн тийм хэм хэмжээнүүд газар, газрын хэвлий, ашигт малтмал, ой, ус, ургамал, амьтны аймгийн тухай хуульд тодорхойлогдсоноос гадна зарим нийтлэг эрх зүйн хэм хэмжээ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хуульд хуульчлагдсан байна.

Байгалийн баялаг ашиглах харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний нийлбэр нь бүхэлдээ байгаль ашиглах эрх зүйн иж бүрдэл бүхий институтийг бүрдүүлнэ. Энэхүү институт газар, ус гэх мэт байгалийн тодорхой төрөл зүйлсийг ашиглаж байгаа талуудад /субъектүүдэд/ зохих эрх, үүрэг бий болгохын хамт байгалийн баялаг ашиглагч нийт субъектэд байгалийн баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах субъектив эрх олгож, тэдний эрхийн чадвар, чадамжийг тодорхойлдог байна.


Байгалийн баялаг ашиглах эрхийг дагаж мөрдөж байгаа хууль, байгалийн баялгийн төрөл зүйлсийг /объект/ түшиглүүлэн хэд хэдэн төрөлд ангилан авч үздэг. Тухайлбал:

- Газар ашиглах эрх,
- Газрын хэвлий, ашигт малтмал ашиглах эрх,
- Тусгай хамгаалалттай газар нутаг ашиглах эрх,
- Ус ашиглах эрх,
- Ой ашиглах эрх,
- Байгалийн ургамал ашиглах эрх,
- Амьтны аймгийг ашиглах эрх,
- Хийн мандлын агаар ашиглах эрх гэж ангилна.

Дээрх ангилал тус бүр өөрийн зориулалт бүхий эрх зүйн өөр өөр дэглэмтэй. Тэр нь тухайн баялгийн нийгмийн хэрэгцээ, өөрийнх нь өвөрмөц онцлог шинж байдлаас урган гардаг байна. Эдгээрийг төрөлжсөн хуулиар тодорхойлон тогтоож, зохицуулдаг.

**Байгалийн баялаг ашиглах эрхийн төрөл тус бүрийн онцлог, нэг нь нөгөөгөөсөө ялгагдах эрх зүйн зохицуулалтын шинж чанартай** болно.

Байгалийн баялаг ашиглах эрхийг байгаль ашиглах эрх үүсэх үндэслэлийг гол шалгуур болгон дараах үндсэн хоёр ангилалд хуваадаг. Үүнд:



**Байгалийн баялаг ашиглах нийтийн эрх** гэж төрийн захиргааны аль нэгэн байгууллага, албан тушаалтан болон хуулийн этгээдээс тусгайлан зөвшөөрөл авахыг шаарддаггүй, бүх нийтэд хүртээлтэй байдаг байгалийн тийм баялаг ашиглах эрхийг хэлнэ. Байгаль ашиглах нийтийн эрх бол хүрээлэн байгаа орчинд хэн ч гэсэн тааламжтайгаар оршин байх заяагдмал эрх юм. Ийм эрхийг дэлхийн аливаа улс орон хуулиар баталгаажуулдаг зарчимтай, практиктай байдаг.


Харин Монгол Улсад газрын тухай хуулиас бусад байгаль орчны хуулиудад дурдсан нийтийн эрхийг ил тод зориуд хуульчлан баталгаажуулсан зохицуулалт үндсэндээ байхгүй байгаа нь байгалийн баялаг ашиглах эрхийн тулгамдсан асуудлуудын нэг мөн гэж болно. Хуулийн зохицуулалт хэдийгээр дутмаг ч гэсэн манай орны байгалийн баялаг ашиглагч иргэн, хуулийн этгээд байгалийн баялаг ашиглах нийтийн эрхийг амьдрал дээр өөрийн үзэмжээр зохих ёсны дагуу эдэлсээр байна.

Байгалийн баялаг ашиглах нийтийн эрхийн хүрээнд Иргэний хууль зарим шинэлэг хэм хэмжээ тогтоосон онцлогтой. Тухайлбал, иргэний хуулийн 134-141 дүгээр зүйлд заасан хөршийн эрх, 150 дугаар зүйлд заасан Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх, 151 дүгээр зүйлд заасан Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх /сервитут/ хамаарна.

*Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглаж болох газар, байгалийн зарим баялгийг шинээр нэрлэн зохицуулсан билээ. Тийм баялагт **бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа, хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар, зам, шугам сүлжээний газар, ойн болон усны сан бүхий газрыг хамруулсан юм.***

**Байгалийн баялаг ашиглах тусгайлсан эрх** гэж нийгэм, иргэн, хуулийн этгээдийн эдийн засгийн ашиг сонирхлыг газар, ус, ой, ургамал, амьтны аймаг зэрэг байгалийн тодорхой төрлийн баялгаар хангахтай холбогдсон эрх зүйн дэг журмыг хэлнэ. Энэ нь байгальд үзүүлэх нөлөөллөөрөө нийтийн ашиглалтаас илүү өргөн хүрээтэй байдаг. Тийм учраас зөвшөөрлийн тусгай журамтай байж, түүний дагуу байгалийн баялгаас тодорхой хэсгийг салгаж буюу тасалж ашиглахыг зайлшгүй шаарддаг байна.

Байгалийн баялгийг тусгайлан ашиглах эрх нь дараах хоёр хэлбэрээр хэрэгждэг. Үүнд:




**Байгалийн баялгийг иж бүрдлээр ашиглах** гэдэг нь байгалийн нэг төрлийн баялгийг ашиглахдаа аж ахуйн үйл ажиллагаагаар буюу хүний нөлөөллөөр байгалийн бусад баялагт болон хүрээлэн буй орчинд бүхэлд нь аль болох бага хохирол, зохисгүй нөлөө үзүүлж, тухайн баялгийг байгалийнх нь даац чадавхад нийцүүлэн ашиглах ажиллагааг хэлдэг. Байгалийн баялгийг иж бүрдлээр болон тусгайлан ашиглахад

ашиглах нөөцийн дээд хэмжээг заавал тогтооно. Эрх зүйн тийм үндэслэлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлд тодорхойлсон байна. Энэ зохицуулалтаар ашиглалтын дээд хэмжээг тухайн баялгийн даац, нөхөн сэргэх чадварыг харгалзан тодорхой хугацаагаар, баялаг тус бүрийн хуульд заасны дагуу тогтоодог.

**Байгалийн баялгийг сонгосон зориулалтаар ашиглах** гэдэг нь аль ч төрлийн баялаг ашиглалтад хэрэглэгдэх бөгөөд иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн аль нэг хэрэгцээг хангахад шууд чиглэгддэг хэлбэр юм. Тухайлбал, газрыг бэлчээр, тариалан, орон сууц, барилга байгууламж барих аль нэг зориулалтаар, газрын хэвлийг стратегийн болон тусгай, ердийн аль нэгэн ашигт малтмал ашиглах болон газрын хэвлийд цахилгаан, дулаан, уур, ус дамжуулах шугам, хоолой барих, хог хаягдал булах зэрэг аль нэг зориулалтаар, усыг услалтын систем барьж байгуулах, тээвэр хийх, спорт, эрүүл ахуйн гэх мэт зориулалтын аль нэгээр, ан амьтныг үйлдвэрлэлийн буюу ахуйн хэрэгцээнд олдворыг нь ашиглах, судалгаа шинжилгээ, соёл, урлагийн хэрэгцээнд агнах, барих аль нэг зориулалтаар зэргээр тусгайлсан хэрэгцээнд ашиглах асуудал хамаарна.

Малчдын оролцоотой БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлийн судалгааг хийхэд экологийн харилцаан дахь хүний эрх, тэр дундаа малчдын эрхийн талаарх хууль зүйн шинжлэх ухааны онолын ойлголтыг үндэслэх нь чухал ач холбогдолтой.

Экологийн харилцаан дахь хүний эрх гэдэг бол өргөн утгаараа байгальтай харилцан нягт бий болдог хүний төрөл бүрийн хэрэгцээг хангах, хамгаалах боломжуудыг үндэсний болон олон улсын эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрч эрх зүйн хэм хэмжээнд баталгаажуулсан шинж байдлыг хэлдэг.



Экологийн харилцаан дахь хүний үндсэн эрхэд дээр дурдсанаар хүний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах ийм хоёр тулгуур эрх хамаарна. Ийм эрхийг хамгаалах эрх зүйн үндэслэлийг аливаа улс орны Үндсэн хууль, хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн баримт бичигт тусган баталгаажуулсан байдаг. Дурдсан хоёр эрхээс бусад эрхийг бусад эрх гэх бөгөөд тэдгээр эрхийг олгох, хамгаалах эрх зүйн үндэслэлийг үндэсний хуулиуд болон олон улсын гэрээ, конвенцод тодорхойлсон байдаг. Энэхүү хоёр эрх нь тусгаарлагдмал бус хоорондоо харилцан уялдаатай юм.

Үндсэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Хүн амьд явах эрхтэй”, мөн зүйлийн 2-т “Хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй” гэж тус баталгаажуулсан. Энэ бол хүний жам ёсны эрх төдийгүй хүний ураг бүрэлдэх үеэс эхлээд төрөх, амьд явах, хэвийн ажиллаж амьдрах, сүрч боловсрох, амарч зугаалах аливаа тааламжтай нөхцөл орчноос нь бүрэн хамааран шалтгаалж байх тухай өргөн хүрээтэй ойлголт бөгөөд үүнийг орчин цагийн экологийн эрх зүйд “**тааламжтай хүрээлэн буй орчинд амьдрах эрх**” гэж нэрлэдэг.

Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэдийн хэд хэдэн үндсэн эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах асуудлыг малчдын хувьд шийдвэрлэхэд малчдыг бэлчээрийн харилцааны субъект гэсэн ганц талаас нь илүүтэй харгалзан үзэх биш, харин малчдыг мал, бэлчээр хоёртой холбож авч үзэх нь чухал.

Уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжилтэй холбоотойгоор малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох<sup>1</sup> үндсэн эрх сүүлийн жилүүдэд ихээхэн хязгаарлагдах болж, тэдний аж төрөх уламжлалт арга алдагдахад хүрч буй ноцтой байдал нийгэмд илт боллоо.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д **Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй** гэж заасан.

Эрүүл, аюулгүй орчин хэмээх ойлголт агуулгын өргөн утгаараа байгалийн ба үүсмэл орчны элементийг хамруулан авч үздэг. Эдгээр нь хүний амьдрах болон ажил хөдөлмөр эрхлэх орчин болдог бөгөөд уг эрхийг тааламжтай хүрээлэн буй орчинд амьдрах эрх хэмээн томъёолсон байдаг.

Экологийн харилцаан дахь хүний эрхийг Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээнд баталгаажуулсан байдаг нь малчдын экологийн эрхтэй шууд хамааралтай гэж үзэх нь зохистой.

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг дотоодын хууль тогтоомжид баталгаажуулснаар тэдгээр эрхийг эдлэх боломж үүсдэгт л практик ач холбогдол нь байдаг, гэвч тодорхой нөхцөл бүрдсэн тохиолдолд л энэ боломж бодитой болдог<sup>2</sup> гэж үзсэн үзэл баримтлалыг малчдын эрхтэй уялдуулан авч үзвэл малчдын эрхийг Үндсэн хуульд баталгаажуулсан эрхээ эдлэх хууль зүйн нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гагцхүү малчид Үндсэн хуульд тусгагдсан эрхээ эдлэх тодорхой нөхцөл хангалттай бүрдээгүйтэй холбогдон эрхээ эдлэх боломж бодитойгоор хэрэгжихэд бэрхшээлтэй гэх үндэслэл байна.

**Малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг** Үндсэн хуулиар төдийгүй хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тодорхойлон баталгаажуулсан байна.

- НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршил хэсэгт *"...айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл..."* хэмээн үзэж байгааг цохон тэмдэглээд 25 дугаар зүйлд *"хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгмийн ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй..."* гэж тунхаглажээ. Энэ нь дурдсан

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 16.2, 16.4, 16.18

<sup>2</sup>Ж.Амарсанаа, Хүний эрх, Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал, УБ., 2000, х.75

эрхийг шууд томьёолоогүй ч шууд бусаар хүн тааламжтай хүрээлэн буй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж буй олон улсын эрх зүйн зарчим мөн.

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Фактад оролцогч улсууд бие бялдрын болон оюуны талаар дээд зэргийн эрүүл байх хүн бүрийн эрхийг хүлээн зөвшөөрч, орчны болон үйлдвэрийн, хөдөлмөрийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах, байгалийн нөөцийг хамгийн үр ашигтай эзэмших, ашиглах зорилгоор техник, технологи, шинжлэх ухааны мэдлэгийг өргөн ашиглах<sup>3</sup> заалт тусгагдсаныг Монгол улс биелүүлэх үүрэг хүлээсэн.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Фактын 6 дугаар зүйлд **“Амьдрах эрх бол хүн бүрийн салшгүй эрх мөн, энэ эрхийг хуулиар хамгаална”**, 1 дүгээр зүйлд **“Бүх улс түмэн ... олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүрэгтээ хохирол учруулахгүйгээр байгалийн баялаг, нөөцөө өөрийнхөө зорилгод чөлөөтэй ашиглана”** гэж заасан байдаг.

Түүнчлэн дурдсан хоёр Фактад **“байгалийнхаа баялаг, нөөцийг бүрэн чөлөөтэй эзэмших, ашиглах бүх ард түмний салшгүй эрхийг хязгаарласан мэтээр энэхүү Фактын аль ч заалтыг тайлбарлаж болохгүй”**<sup>4</sup> гэж заасан нь улс үндэстэнд бүхэлд нь төдийгүй, хувь хүнд экологийн эрхээ саадгүй эдлэх улс төр, хууль зүйн баталгаа олгосны илрэл мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд **“байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”** гэж заасан нь эрх, үүргийн нэгдлийг хангах онолын үндэслэлийг давхар баталгаажуулсан хэрэг мөн.

Уул уурхайн үйлдвэрлэл малын бэлчээрт эдийн засаг, аж ахуйн хүндрэл учруулж байгаагийн зэрэгцээ малчдын **“эрүүл, аюулгүй орчинд амьдрах”** эрхийг ноцтой зөрчиж байгаа байдалд онцлон анхаарах нь нэг тулгамдсан чиглэл мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.18-д **“Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох...”** эрхийг өөрийн орны иргэдэд баталгаатай эдлүүлэхээр заасан нь малчдын хувьд мөн л анхаарал татсан асуудлын нэг болж байна. Малчид бэлчээрээ сонгон нутаглах эрхээ уул уурхайн компаниудаар жолоодуулж, нүүдлээ тэднээр заалгадаг болсныг “оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх” гэхэд хэцүү болж байна. Монгол Улсын иргэд өөрийн улсынхаа нутаг дэвсгэрт оршин суух газраа чөлөөтэй сонгоход бусад хүмүүсийн эрх ашиг, хот суурин байгуулалтын шаардлага, бэлчээр нутгийн даацын зохицуулалтаас шалтгаалж хуулиар тогтоосон зарим зохицуулалтаас гадуур ямар нэг хязгаарлалт байж болохгүй<sup>5</sup> гэж тайлбарласан байдаг. Энэ бол малчдын хувьд бүр ч илүү ач холбогдолтой. Малчдын түр буюу байнга оршин суух газар нутгаа сонгох эрх Үндсэн хуулийн дээрх хэм хэмжээнд үндэслэх нь ойлгомжтой учир малчид, түүний хамтын байгууллага нүүдлийн мал аж

<sup>3</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 11, 12 дугаар зүйлд заасантай дэлгэрүүлж танилцана уу.

<sup>4</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 25 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 6

<sup>5</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2009, х.103

ахуйн уламжлалыг хадгалах, бэлчээрийг ээлж хуваарьтай, тогтвортой ашиглах эрх, ашиг сонирхлоо хамгаалж байх ёстой.

**Экологийн харилцаан дахь хүний бусад эрх** гэдэг бол аливаа хувь хүн эрх зүйн этгээд байж, байгалийн нөөц баялгийг эзэмших, ашиглах, өмчлөх, байгаль орчны бохирдол, бусад хортой нөлөөнөөс хамгаалуулах, эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг аливаа эрх зүйн харилцааны хүрээнд эдэлж байх ёстой гэсэн ухагдахуун юм.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд Монгол Улсын иргэн экологийн харилцаанд дор дурдсан эрх эдлэхээр заасан байна.

- Байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах. Энэ эрх нь экологийн харилцаанаас үүсэх бөгөөд түүнийг шүүх, төрийн захиргааны болон холбогдох байгууллагад хандах эрх гэж нэрлэдэг.
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх, байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах. Энэ эрх нь мөн л экологийн эрх зүйн харилцаанаас үүсэх бөгөөд түүнийг салбарын буюу мэргэжлийн байгууллага, албан тушаалтанд хандах эрх гэж нэрлэдэг.
- Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх, нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний үр шимийг хүртэх. Энэ эрхийг хүрээлэн буй орчны салбарт эвлэлдэн нэгдэх эрх буюу улс төрийн эрх гэж нэрлэдэг.
- Байгаль орчны тухай мэдээллийг холбогдох байгууллагаас авах. Үүнийг мэдээллээр хангагдах эрх гэж нэрлэдэг.
- Байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, тийм үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллага байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг шаардах эрх. Үүнийг төр, захиргааны байгууллагад хандах эрх гэж нэрлэдэг.
- Сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, хуульд заасан журмаар иргэдийн нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, гэрээгээр ашиглах, эзэмших. Энэ эрхийг нутгийн хүн амын эвлэлдэн нэгдэж байгалиа эзэмших, ашиглах хамгаалах эрх гэж нэрлэдэг. Ийм эрхийг 2005 онд хуульчлан баталгаажуулсан.

Дээр дурдсан 6 үндсэн эрх нь хүний экологийн бусад эрхийн суурь гэж тооцогддог. Энэхүү суурь дээр үндэслэн

- Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлд газар эзэмшигчийн эрх,
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан газар газар өмчилж авах иргэний эрх,
- Усны тухай хуулийн 23 дугаар зүйлд ус ашиглагчийн эрх,
- Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйлд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, 27 дугаар зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн

эрх зэрэг байгалийн нөөц баялгийн төрөлжсөн хуулиудад заасан хүний эрх бий. Ийм эрхүүдийг бүхэлд нь **байгаль ашиглах хувийн эрх** гэж томъёолсон байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилго бүхий өнөө үед хүрээлэн буй орчны салбарт иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн ач холбогдол өсөн нэмэгдсээр байна. Энэ эрх нь агуулгаараа хэдийгээр улс төрийн эрх боловч түүнийг байгаль орчны салбарт эдлэх талаар хуульчилсан нь экологийн харилцаан дахь хүний эрхийг чухалчилсан хэрэг мөн. Үүний эрх зүйн үндсийг байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.8, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д тусгасан билээ.

### **1.3. Малчдын оролцоотой БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн арга барил, мал аж ахуй, ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлт, хяналт, үнэлгээний мэдээлэл, гэрээний хэрэгжилт, сайн туршлага, сургамжийн талаар:**

#### **1.3.1. Дорнод аймгийн БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн арга барил, гэрээний хэрэгжилт, сайн туршлагын тухай:**

##### **-Дорнод аймгийн Халхгол сумын бэлчээр ашиглагчдын бүлэг:**

Халхгол сумын бэлчээр ашиглагч малчдын бүлгүүд нь Цогтсүмбэр, Ялалт, Ташгай зэрэг 3 багийн бэлчээр ашиглагч малчдын 9 бүлэгт 210 өрх бүхий 90 мянга орчим мал хамрагдаж байна.


Энэ бүлгүүдэд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” /ЗЗББУХ/ төслийн зүгээс 2019, 2020, 2021 онуудад гүн өрмийн худаг, үлийн цагаан оготно устгах тоног төхөөрөмж, мал угаалгын ванн, өвс тэжээлийн агуулах саравч зэргийг шинээр хөрөнгө оруулалтаар олгож, аймгийн жижиг дунд үйлдвэрлэл дэмжих төвийг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах бусад оролцогч, дэмжигчдийн үйл ажиллагааг үялдуулах зорилгоор бэлчээр ашиглагч малчдын бүлэг нэгдэж Халхгол сумын “ЭНХ ХАЛХ ШИМТ” бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-ыг байгуулан ажиллаж байна.





Халхгол сумын Ялалт Ташгай багийн нутаг дэвсгэрт бэлчээр ашиглагчдын малчны бүлэг байгуулах газрын байршил, хил заагийн зураглал



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000230845

2021.09.30 / Бүртгэсэн өгсөвдөр / 0771002075 / Хувийн хэргийн буцаар /  
3391159 / Регистрийн буцаар /

Дорнод аймгийн Халхгол сумын энх халх шимт бэлчээр ашиглагчдын холбоо / Холбоо /НҮТББ/

Дүрэм / Тусгай байгуулах баримат бичиг /

Тогтоол / 01 / 2021.09.16 /

94990 / Код / Бэлчээрийн газрыг зохиистой ашиглах, хамгаалах бусад зорилгоор дэмжигчийн уял ажиллагааг уялдуули, малчдын амжилтад дэмжигчид уял ажиллагааг олгох. / Уял ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / Хугацаа / 5 / Хугацаагүй хэмжээ, мөнгөн гажирал / 0.00

Дорнод, Халхгол, 3-р баг, Ташгай, Төвшги нуурын улс, Утас1: 88066121, Утас2: 88572151, Факс: / Хуулийн этгээдийн албан ёсын хаяг /

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС  
УЛСЫН БҮРТГЭГЧ / Б.БОГОРГОРДЭНО /





ЗЗБУХТөсөл хэрэгжсэнээр малчид болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдэд үр өгөөжөө өгч, малчид бүлгийн зохион байгуулалтад орсноор хамтран хадлан тэжээлээ бэлтгэх, бэлчээрээ үр ашигтай ашиглах, хамгаалах, төлөвлөх зэрэг үйл ажиллагааг үр дүнтэй явуулж байна.

ЗЗБУХ төслийн шугамаар 2019-2020 онд Халхгол суманд малын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Цогтсүмбэр багт 1, Ялалт багт 2, Ташгай багт 2 нийт 5 бог мал угаалгын ванн барьж ашиглалтад оруулснаар 2020 онд 10.5 мянган бог мал, 2021 онд 29.6 мянган бог малыг эрүүлжүүлэх зорилгоор угаалгад хамруулсан. Эдгээр мал угаалгын ваннуудыг Бэлчээр ашиглагч малчдын бүлэг/БАМБ/-үүд нэгдсэн зохион байгуулалттайгаар хөдөлмөрөө хорших хэлбэрээр ашиглан мал угаалгын ажлыг мал эмнэлгийн үйлчилгээний “Гангийн нуруу” ХХК нэгжтэй хамтран зохион байгуулж байна. Мал угаалгын ванныг барихдаа ванны хэмжээ, хийцийн талаар малчдын саналыг авснаар тэдний ажлыг хөнгөвчилсөн, таашаалд нийцсэн байгууламж болж чадсан сайн туршлага байна.

**-Дорнод аймгийн Сэргэлэн сумын бэлчээр ашиглагчдын бүлэг:**

Сэргэлэн сум нь нийт 3 багт 329 малчин өрхтэй, үүний 267 малчин өрх буюу нийт малчин өрхийн 81 хувь нь 9 бэлчээр ашиглагчдын малчдын бүлэгт хамрагдаж тус сумын нутаг, бэлчээрийн 97,4 хувийг ашиглаж байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2019 оноос хойш 7 инженерийн хийцтэй худгийг төсөл болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэнээр 4500 га бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж 40 малчин өрхийн 18000 толгой мал үр шимийг хүртсэн. 2019 онд 1-р багт 2500 га, 2-р багт 3000 га нийт 5500 га талбайд оготно устгалын ажил хийж бэлчээрээ хамгаалсан байна.

**-Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын бэлчээр ашиглагчдын бүлэг:**

Хөлөнбуйр сумын 3 багт 267 малчин өрхтэйгөөс 64 хувь нь 5 бэлчээр ашиглагч малчдын бүлэгт хамрагдсан. Тус сум 377308 га газар нутагтайгаас 241294 га талбайг малчдын бүлэгт ашиглуулж Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах бусад БАМБ-ийн үйл ажиллагааг уялдуулж, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор БАМБ-үүд нэгдэж Хөлөнбуйр сумын “Хөлөн өлзийт” бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-г байгуулжээ.

Малчид бүлгийн зохион байгуулалтад орж, хамтран хадлан тэжээлээ бэлтгэх, бог малаа угаалгад хамруулах, худаг засварлах зэрэг ажлуудыг хийсэн ба нийт 8000 га талбайд оготно устгалын ажил хийж бэлчээрээ хамгаалж байна.



2021 онд Дорнод аймгийн Хөлөнбуйр сум, зөвхөн өөрийн сумын байгууллага, хувь хүмүүстэй хадлан хадах гэрээ байгуулан хадлангийн 9 салаа, Бэлчээр ашиглалтын бүлгийн зохион байгуулалтаар хамтран ажиллаж, нийт 1800 га талбайн өвсийг хадаж, салаа бүр 750 боодол өвсийг сумын өвс тэжээлийн агуулахад хандивлав. Уг нөөцийн өвснөөс 50 боодлыг зэрлэг ан амьтанд нөөцөлж, үлдэгдлийг нь 400.0-450.0 төгрөгөөр борлуулахаар гэрээ байгуулан ажилласан байна.

**1.3.2 Сүхбаатар аймгийн БНХМБ-ын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засаг, байгалийн нөөцийн хамтын менежментийн арга барил, гэрээний хэрэгжилт, сайн туршлагын талаар:**

**-Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын бэлчээр ашиглагчдын бүлэг:**

Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу жил бүр зун, намрын улиралд ургамал ургалтын үед малчид өвөлжөө, хаваржааныхаа газрыг чөлөөлж байна. Тухайлбал 2020 онд 10 га бэлчээрийг чөлөөлж малын хөлийн талхагдлаас хамгаалж нөхөн сэргээх боломжийг бүрдүүлжээ.

Малчид малаа борлуулан эргэлтэд оруулж тоо толгойг багасгах, чанарыг сайжруулахад анхаарч байна. Тус суманд 2012 оноос хойш Мянгат малчдын тоо жил ирэх бүр буурч байгаа ажээ

**-Сүхбаатар Эрдэнэцагаан сумын бэлчээр ашиглагчдын бүлэг:**

Бэлчээрийг өнжөөж амраахад тулгамдаж байгаа асуудал бол худаг, усны хомсдол юм. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулахын тулд 9 булаг шанд, хуучин худгийг сэргээн засварлаж ойр орчмын малчин өрхүүд, тэдгээрийн мал сүргийг усаар хангаж байна.



Арвижих БАМБ “Гахай шандын” булгийг 7х8 хэмжээтэй мал орохооргүй хашажуулсан байна.



Бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, зохион байгуулалтын хүрээнд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын газрын даамал, төслийн зохицуулагч нар хамтран бэлчээрийн фото мониторингийн судалгаа хийхэд бэлчээрийн ургац нэмэгдсэн байна.

### **Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум**

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд 15-16 микрон голч бүхий 40 мм – ээс богино, жигд ойрхон атираатай цайвар өнгөтэй ноолууртай, амьдын жин, махан ашиг шимээр жирийн монгол ямаанаас илүү “Баяндэлгэрийн улаан” үүлдрийн ямааг үржүүлдэг.





Тус сумын ХАА-н тасаг, Цагаан шанд, Уртын нуруу, Тоост, Төгрөг, Уул БАМБ-ын бүлгүүдтэйгээ хамтран улаан ямаанд шилэн сонголт явуулж, ноолуурын чанарыг нь судалж, гарвал, ашиг шимийн гэрчилгээтэй ухна, эм ямааг бойжуулан үржлийн үйлчилгээ явуулахаас гадна бусад аймаг, сумын аж ахуйн нэгж, малчдад борлуулан малын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна. Тухайлбал 2019 – 2021 онд цөм сүргийн сууриасаа 426 шүдлэн ухна худалдан борлуулжээ.

### 1.3.3. Дорнод, Сүхбаатар аймгийн малчдын бэлчээр ашиглагчдын бүлэг, хэсгийн дундын мөнгөн хуримтлалын тухай /сайн түршлага/

Аймаг, сумдын бэлчээр ашиглагчдын холбоод болон бэлчээр ашиглагчдын бүлэг, хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хамтын ажиллагааны үр ашгийг сайжруулах, бие даасан байдлыг нь бэхжүүлэх, малчдын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/-ийн гишүүдийн санаачилга, “Ногоон алт” төслийн дэмжлэгээр малчдын мөнгөн хуримтлал буюу дундын санг бий болгож ажилласан сайн түршлага байна. Судалгаагаар 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дээрх 2 аймгийн 11 сумын хэмжээнд нийт 63 БАХ, 11 дундын сангийн тусгай тохиргоотой данс дээр 1946 малчин өрхийн 175.8 сая төгрөгийн хуримтлалтай болжээ (Хүснэгт 16).

**Хүснэгт 16 БАХ-ийн гишүүн малчдын дундын сангийн хуримтлал**


№	Аймаг	Шилэн данс	БАХ-ийн тоо	Гишүүн өрхийн тоо	Хуримтлал /өссөн дүнгээр/		Ашиг алдагдал	Нийт дундын сангийн хөрөнгө
					Өрхөөс	Төслөөс		
1	Дорнод	5	44	1025	37,745,000	52,337,000	120,910,765	120,910,765
2	Сүхбаатар	6	34	921	29,725,000	24,217,000	54,905,775	54,905,775
<b>Дүн</b>		11	78	1946	67,470,000	76,554,000	175,816,540	175,816,540

Малчдын БАХ-ийн дундын санд жил бүр гишүүн өрх шинээр нэмэгдэж нийт гишүүдийн тоо 1946 болсон байна.

Хүснэгт 17 Дундын сангийн гишүүн өрхийн тоо, аймгаар /2017-2021/

№	Аймаг	2017	2018	2019	2020	2021
1	Дорнод	817	923	947	1,025	1,025
2	Сүхбаатар	-	365	858	921	921
	<b>Дүн</b>	<b>817</b>	<b>1288</b>	<b>1805</b>	<b>1,946</b>	<b>1,946</b>

Тахирмаг Дундын сангийн гишүүн өрхийн тоо /2017-2021 аймаг болон нийт дүнгээр/



БАХ-ийн дундын сангийн зээл олголтын талаар:

Зорилтот хоёр аймаг, сумдын БАХ-үүд өнгөрсөн онд 372 зээлдэгчид 582,7 сая төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт 18. Дундын сангаас олгосон зээл болон эргэн төлөлт /аймгаар/

№	Аймаг	Олгосон зээл			Төлөгдсөн зээл		Хугацаа хэтэрсэн зээл	
		Зээлийн тоо	Зээлдэг чийн тоо	Мөнгөн дүн /сая/	Зээлдэг чийн тоо	Мөнгөн дүн /сая/	Зээлдэг чийн тоо	Мөнгөн дүн /сая/
1	Дорнод	362	362	561.90	161	174.96	171	328.77
2	Сүхбаатар	10	10	20.81	0	-	10	20.81
	<b>Нийт дүн</b>	<b>372</b>	<b>372</b>	<b>582.71</b>	<b>161</b>	<b>174.96</b>	<b>181</b>	<b>349.58</b>

Дорнод болон Сүхбаатар аймгийн БАХ-ийн дундын сангийн хуримтлал, ашиг, сангийн нийт дүнг 2022 оны 7 дугаар 7-ны байдлаар авч 19, 20-р хүснэгтэд тус тус үзүүлэв.

Хүснэгт 19 Дорнод аймгийн дундын сангийн хуримтлал, ашиг, сангийн нийт дүн /сумаар/

Сумд	Хуримтлал		Хуримтлагдсан ашиг	Дундын сангийн Нийт дүн
	Өрхөөс	Төслөөс		
Баян-Уул	9,330,000.00	18,887,500.00	13,701,865.00	41,919,365.00
Баянтүмэн	4,200,000.00	3,857,500.00	222,900.00	8,280,400.00
Булган	3,925,000.00	3,981,500.00	-359,600.00	7,546,900.00
Цагаан Овоо	11,490,000.00	20,108,000.00	14,587,300.00	46,185,300.00


Чойбалсан	8,800,000.00	5,652,500.00	2,676,300.00	17,128,800.00
<b>Нийт дүн</b>	<b>37,745,000.00</b>	<b>52,487,000.00</b>	<b>30,828,765.00</b>	<b>121,060,765.00</b>

### Хүснэгт 20. Сүхбаатар аймгийн дундын сангийн тайлан /сумаар/

Сумд	Хуримтлал		Хуримтлагдсан ашиг	Дундын сангийн Нийт дүн
	Өрхөөс	Төслөөс		
Баяндэлгэр	2,250,000.00	2,200,000.00	163,400.00	4,613,400.00
Сүхбаатар	6,775,000.00	6,834,000.00	-22,100.00	13,586,900.00
Түвшинширээ	5,650,000.00	4,014,000.00	36,050.00	9,700,050.00
Түмэнцогт	4,550,000.00	2,481,500.00	-22,500.00	7,009,000.00
Халзан	5,150,000.00	3,274,500.00	106,900.00	8,531,400.00
Эрдэнэцагаан	5,350,000.00	4,025,000.00	722,025.00	10,097,025.00
<b>Нийт дүн</b>	<b>29,725,000.00</b>	<b>22,829,000.00</b>	<b>983,775.00</b>	<b>53,537,775.00</b>

Дундын сангаас авсан зээлийн 24.2 хувийг хадлан тэжээлд, 30.2 хувийг мал сүргийн чанарыг сайжруулах, малын тарилга эм, малчны эрүүл мэнд зэрэгт зориулалтын дагуу ашигладаг байна. Малчдын дундын сангаас авч буй зээлийн зориулалтад баяр ёслол, бензин шатахуун, хадлан тэжээлийн зардал ихэнх хувийг эзэлж байна. Доорх бүдүүвчээс үзэхэд 2020-2021 онд ихэнх аймгуудад хадлан тэжээл бэлтгэх зориулалтаар авсан зээлийн эзлэх хувийн жин илүү байна.

#### Бүдүүвч 1 Дундын сангийн зээлийн зарцуулалт, хувиар



Дундын сан нь БАХ-ийн гишүүдийн санхүүгийн зарим асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж эхэлсэн ба гишүүд уулзалтаа тодорхой давтамжтай хийх, хамтын шийдвэр гаргах, хариуцлагатай байх, санхүүгийн сахилга баттай байх зэрэг нийгэм, эдийн засгийн шинэ харилцаанд оролцоход нь малчдад туслах үүргийг гүйцэтгэж байгаа нь шинэлэг ажил, бөгөөд цаашид өргөжүүлэн хөгжүүлэх тэргүүн туршлага болсон гэж үзэж байна.

Дөрвөн улирлын бэлчээр, хадлан, ус, байгалийн нөөцөө хамтаараа ашиглаж ирсэн малчид хамтран дундын бэлчээр, хадлан, ус, байгалийн нөөцөө ашиглах төлөвлөгөө гаргах, харилцан зөвшилцөх, хэрэгжүүлэх орон нутгийн онцлогт тохирсон арга замуудыг

санаачлан хэрэгжүүлж, төрийн зүгээс малчидтай бэлчээр, хадлан, ус, байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалтыг хангах гэрээ байгуулж байна. Туршлагаас үзэхэд байгалийн нөөцийн хамтын менежментийн зохион байгуулалтыг хийх нь хэд хэдэн үндсэн зарчмуудыг хангах хэрэгтэй болж байна. Үүнд: тухайн сум багт байгаа бүхий л малчдын оролцоог хангах, малчдын анхан шатны зохион байгуулалтын нэгж болох бүлэг, хэсгийн эрх үүрэг тодорхой байх, малчдын уламжлалт зохицуулах арга хэмжээг төрийн хууль, журам дүрмийн уялдааг хангах, үүний үндсэн дээр бүлэг болон орон нутгийн удирдлагын хооронд бэлчээр, хадлан, ус, байгалийн нөөц ашиглалтын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх механизмыг мөн малчдын өөрсдийн сайн дурын болон төрийн хууль, тогтоомж, журам, дүрэмтэй уялдуулах нь үр дүнтэй нь харагдаж байна.

#### **1.4. Малчдын оролцоотой БНХМБ-ын нэгдсэн бүртгэлийг одоо ашиглагдаж буй холбогдох мэдээллийн сан, бүртгэлтэй харьцуулсны үндсэн дээр мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай**

##### **1.4.1. Дорнод аймгийн одоо ашиглагдаж буй малчдын оролцоотой БНХМБ-ын мэдээллийн санг шинэчлэн гаргасан талаар**

#### **1. Хоршоодын мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай**

Дорнод аймгийн 14 сумын хэмжээнд хөдөө аж ахуй, нийтийн үйлчилгээ, тээвэр зуучлал, хадгаламж зээл гэсэн төрөл, чиглэлээр нийт 84 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 13 суманд нь малчдын оролцоотой (малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлдэг, мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг, газар тариалан, хадлан бэлтгэн нийлүүлэх) хөдөө аж ахуйн чиглэл үйл ажиллагаа явуулдаг 60 хоршоог тооллогод хамруулж “Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан (<http://opendata.burtgel.gov.mn/les>), Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны хоршооны бүртгэлтэй тулгаж мэдээллийн санг (хавсралт хүснэгт 1) шинэчлэн бүртгэсэн. МБАНХ-ны зүгээс сумдад хийсэн хоршооны тооллого бүртгэлээр 60 хоршоо тоологдсон бөгөөд хоршоодын мэдээллийн санг “Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан”-тай харьцуулахад ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 хоршоо татан буугдсан байсныг хасаж 54 хоршоодын мэдээллийн санг шинэчлэн гаргав. Хавсралт-1 Зарим хоршоодын гишүүдийн тоо баг зэрэг зөрж байсан тул улсын бүртгэлд бүртгэсэн гишүүдийн тоог нь авч ашиглав. Харин үйл ажиллагааны чиглэл, нэр, хаяг байршил нь тохирч байлаа. Хоршоо тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хүснэгт 1-ээс харах боломжтой.

**Хүснэгт 21. Малчдын оролцоотой хоршооны тооллого.**

Д/д	Сумын нэр	Хоршооны тоо		Үүнээс: ХАА-н хоршоо
		Нийт хоршоо	ХЗХ, бусад	
1	Хэрлэн	18	12	6
2	Баяндун	6	2	4
3	Баянтүмэн	8	2	6
4	Баян-Уул	6	2	4
5	Булган	3	0	3
6	Гурванзагал	5	0	5
7	Дашбалбар	7	2	5
8	Матад	2	2	
9	Сэргэлэн	8	4	4
10	Халхгол	3	1	2
11	Хөлөнбуйр	3	2	1
12	Цагаан-Овоо	5	1	4
13	Чойбалсан	4	0	4
14	Чулуунхороот	6	0	6
	<b>ДҮН:</b>	<b>84</b>	<b>30</b>	<b>54</b>

**2. Малчдын бүлэг, хэсгийн мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай**

Дорнод аймгийн нийт 14 суманд малчдын оролцоотой бүлэг, хэсгийн тооллогыг явуулсан ба нийт 9 суманд 123 бүлэг тоологдов. Эдгээр бүлгүүд нь бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. 9 сумын 115 бүлэг нь 4,6 сая га бэлчээрийг сумын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр сумын засаг даргатай байгуулсан гэрээний 18 нь газрын мэдээллийн санд бүртгэгдсэн байна. Харин Баяндун, Гурванзагал, Дашбалбар, Матад, Чулуунхороот гэсэн 5 суманд ямар нэгэн малчдын бүлэг, хэсэг байгуулагдаагүй байна.



Хүснэгт 22. Малчдын оролцоотой бүлэг, хэсгийн тооллого.

№	Сумын нэр	Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн хүрээнд байгуулагдсан БАХ-ийн тоо				ЗЗБУХТөслийн хүрээнд байгуулагдсан БАХ-ийн тоо				“Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийн хүрээнд байгуулагдсан БАХ-ийн тоо				Гэрээт бэлчээрийн талбайн хэмжээ
		БАХ-ийн тоо	Гэрээний тоо	ГМС-д бүртгэгдсэн гэрээний тоо	Гишүүн өрхийн тоо	БАХ-ийн тоо	Гэрээний тоо	ГМС-д бүртгэгдсэн гэрээний тоо	Гишүүн өрхийн тоо	Булгийн тоо	Гэрээний тоо	ГМС-д бүртгэгдсэн гэрээний тоо	Гишүүн өрхийн тоо	
1	Хэрлэн	-	-	-	-	-	-	-	-	14	<b>14</b>	-	32	-
2	Баяндун	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Баянтүмэн	6	6	6	254	-	-	-	-	21	21	-	74	723,991
4	Баян-Уул	14	14	7	538	-	-	-	-	-	0	-	-	316,217
5	Булган	7			145					10	10	-	24	-
6	Гурванзагал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Дашбалбар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Матад	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Сэргэлэн	-	-	-	-	9	9		267	4	4	-	9	403,991
10	Халхгол	-	-	-	-	9	9	-	210	-	0	-	-	1,292,105
11	Хөлөнбуйр	-	-	-	-	5	5		236	-	0	-	-	377,995
12	Цагаан-Овоо	6	5	5	342	-	-	-	-	-	0	-	-	624,186
13	Чойбалсан	7	7		270	-	-	-	-	11	11	-	26	957,269
14	Чулуунхороот	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	<b>40</b>	<b>32</b>	<b>18</b>	<b>1,549</b>	<b>23</b>	<b>23</b>	<b>-</b>	<b>713</b>	<b>60</b>	<b>60</b>	<b>-</b>	<b>165</b>	<b>4,695,755</b>

Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн мэдээллийн санг шинэчлэн боловсруулахдаа аймаг сумдын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран тооллого бүртгэлийг хийж МБАНХ, АБАХ, ЗЗБУХ төсөл, Хот орчмын бэлчээр төслийн малчдын бүлэг, хэсгийн мэдээллийн сантай харьцуулан гаргасан. Хавсралт-2

#### 1.4.2. Сүхбаатар аймгийн одоо ашиглагдаж буй малчдын оролцоотой БНХМБ-ын мэдээллийн санг шинэчлэн гаргасан талаар

##### 1. Хоршоодын мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай

Сүхбаатар аймгийн 13 сумын хэмжээнд 83 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Үүнээс 11 суманд нь малчдын оролцоотой (малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлдэг, мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг, газар тариалан, хадлан бэлтгэн нийлүүлэх) хөдөө аж ахуйн чиглэл үйл ажиллагаа явуулдаг 37 хоршоог тооллогод хамруулж “Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан, Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны хоршооны бүртгэлтэй тулгаж мэдээллийн санг шинэчлэн бүртгэсэн. Сумдад хийсэн хоршооны тооллого бүртгэл, мэдээллийн санг “Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан”-тай харьцуулахад ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 хоршоо татан буугдсан байсныг хасаж 33 хоршоодын мэдээллийн санг шинэчлэн гаргав. Хавсралт-1 Тооллого бүртгэлд хамрагдсан зарим хоршоодын гишүүдийн тоо бага зэрэг зөрж байсан тул улсын бүртгэлд бүртгэсэн гишүүдийн тоог нь авч ашиглав. Харин үйл ажиллагааны чиглэл, нэр, хаяг байршил зэрэг бусад мэдээлэл нь тохирч байлаа.

##### Хүснэгт 23. Малчдын оролцоотой хоршооны тооллого.

Д/д	Сумын нэр	Хоршооны тоо		Үүнээс: ХАА-н хоршоо
		Нийт хоршоо	ХЗХ, бусад	
1	Баруун-Урт	34	25	9
2	Асгат	5	4	1
3	Баяндэлгэр	7	0	7
4	Дарьганга	5	2	3
5	Мөнххаан	3	2	1
6	Наран	1	1	-
7	Онгон	2	1	1
8	Сүхбаатар	4	2	2
9	Түвшинширээ	6	3	3
10	Түмэнцогт	6	2	4
11	Уулбаян	3	2	1
12	Халзан	-	-	-
13	Эрдэнэцагаан	7	6	1
<b>ДҮН:</b>		<b>83</b>	<b>50</b>	<b>33</b>

Бусад 50 хоршоод нь дэлгүүр, үсчин, зочид буудал, зоогийн газар, болон ХЗХ-ны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

## 2. Малчдын БАХ, бүлгийн мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай

Сүхбаатар аймгийн нийт 13 суманд малчдын оролцоотой БАХ, бүлгийн тооллогыг явуулсан ба нийт 8 суманд 43 бүлэг тоологдов. Эдгээр БАХ, бүлгүүд нь бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. 8 сумын 28 бүлэг нь 1,8 сая га бэлчээрийг сумын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр сумын засаг даргатай байгуулсан гэрээний 24 нь газрын мэдээллийн санд бүртгэгдсэн байна. Хавсралт-2 Харин Баруун-Урт, Асгат, Дарьганга, Наран, Онгон гэсэн 5 суманд ямар нэгэн малчдын БАХ, бүлэг байгуулагдаагүй байна.

### Хүснэгт 24. Малчдын оролцоотой БАХ, бүлгийн тооллого.

№	Сумын нэр	БАХ-ийн тоо				Гэрээт бэлчээрийн талбайн хэмжээ /га/
		БАХ-ийн тоо	Гэрээний тоо	ГМС-д бүртгэгдсэн гэрээний тоо	Гишүүн өрхийн тоо	
1	Баруун-Урт	-	-	-	-	-
2	Асгат	-	-	-	-	-
3	Баяндэлгэр	5	5	5	209	247489.3
4	Дарьганга	-	-	-	-	-
5	Мөнххаан	5	-	-	-	-
6	Наран	-	-	-	-	-
7	Онгон	-	-	-	-	-
8	Сүхбаатар	9	-	-	346	-
9	Түвшинширээ	6	6	4	231	275289.7
10	Түмэнцогт	4	4	4	144	149799.8
11	Уулбаян	1	-	-	-	-
12	Халзан	4	4	2	188	335457.3
13	Эрдэнэцагаан	9	9	9	347	790764.3
<b>ДҮН:</b>		<b>43</b>	<b>28</b>	<b>24</b>	<b>1,465</b>	<b>1,798,801</b>

Үүнээс гадна Уулбаян, Мөнххаан сумд нь малчдын үүсгэл санаачилгаар малчдын бүлгүүдийг багийн түвшинд загвар байдлаар байгуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байгаа сайн жишээ байна.

Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн мэдээллийн санг шинэчлэн боловсруулахдаа аймаг сумдын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран тооллого бүртгэлийг хийж МБАНХ, АБАХ, ЗЗБУХ төсөл, Хот орчмын бэлчээр төслийн малчдын бүлэг, хэсгийн мэдээллийн сантай харьцуулан гаргасан.

### **3. Нөхөрлөлийн мэдээллийн санг шинэчлэн гаргасан тухай**

Сүхбаатар, Дорнод аймагт нийт 45 нөхөрлөлийн бүртгэл мэдээллийн санг шинэчлэн гаргасан ба эдгээр нөхөрлөл нь нийт 390846.2 га талбайг хамгаалж, ус, ой, амьтан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Дорнод аймгийн 7 суманд малчдын оролцоотой, байгаль орчны менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 нөхөрлөл бүртгэгдсэн. Эдгээрээс 38 нөхөрлөл сумын Засаг даргатай гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

Сүхбаатар аймгийн 4 суманд малчдын оролцоотой, байгаль орчны менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 нөхөрлөл бүртгэгдсэн. Эдгээр 5 нөхөрлөл нь сумын засаг даргатай гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

МБАНХ-ны зүгээс аймаг сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн бүртгэл, мэдээллийн санг БОАЖЯ-ны мэдээллийн сантай харьцуулан шинэчлэн боловсруулав. Нөхөрлөл бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хүснэгт 3-аас харах боломжтой.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ:

ДОРНОД, СҮХБААТАР АЙМГИЙН СУМДЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ МАЛЧДЫН ОРОЛЦООТОЙ БНХМБ-ЫН УС, ОЙ, ГАЗАР (ХАДЛАН, БЭЛЧЭЭР)-ЫН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ ХИЙСЭН ТУХАЙ

**2.1. Дорнод, Сүхбаатар аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замуудын талаар :**

Дорнод, Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг тус хоёр аймгийн төвүүдэд 2022 оны 5 дугаар сарын 16-17 болон 5 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан уулзалт-семинар дээр хэлэлцэж шийдвэрлэх арга замуудыг тодорхойлсон болно. Семинарт оролцогсдыг бүлэглэн хувааж “Газар, бэлчээрийн тогтвортой менежмент”, “Ойн тогтвортой менежмент”, “Усны тогтвортой менежмент” гэсэн багууд болгон ажиллуулж газар, бэлчээр, ой, усны менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлсэн ба бусад оролцогчдын саналыг авч тайланд тусган ажилласан юм.

**2.1.1. Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд:**

Дорнод аймгийн БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлсныг 21-23-р хүснэгтүүдэд үзүүлэв.

**Хүснэгт 25. Дорнод аймагт газар, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
Ашиглалт	-Жилийн 4 улиралд хуваарьтай ашиглах -Бэлчээрийн даац тодорхойлох	-Жилийн 4 улиралд хуваарьтай ашиглахгүй байна -Малын чанар сайжрахгүй	-Багийн ИНХ-р хэлэлцүүлж, сумын ИТХ-ын тогтоол гаргах -Малын тоо толгойн албан

	-Сүргийн бүтэц тодорхойлох -Алсын бэлчээр усжуулах -Хадлангийн талбайг тогтоох	-Худаг гаргах -Хадлангийн талбайг сэргээж ашиглах -Сарлаг, ямаатай хүмүүс гаднаас их ирж байна	татвараар олсон орлогоор холбогдох үйл ажиллагааг санхүүжүүлэх
<b>Хамгаалалт</b>	-Гэрээ байгуулагдсан /Ногоон алт төсөл хэрэгжсэн сумдад /	-Малын чанар сайжруулах -Үлийн цагаан оготной тэмцэх -Уул уурхайн зөвшөөрлийг замбараагүй олгох	-Олон нийтийн цахим орчинд сурталчлах -МТТАТ санхүүжүүлэх -Бэлчээрээ сэлгэн ашигласан малчдын бүлэг, нөхөрлөл урамшуулах -Сургалт мэдээллээр хангах
<b>Нөхөн сэргээлт</b>	Байхгүй	-Олон салаа зам үүсэх -Зуслан намаржааны газрыг цэвэрлэхгүй -Бэлчээрийг цэвэрлэх малын сэг зэм х/хаягдал	-Булаг шанд хаших -Алсын бэлчээр усжуулах -Элсний нүүдлээс сэргийлж мод тарих -Олон наст ургамлын үр цацах -Даац хэтэрсэн газар, бэлчээрийг өнжөөх -1 га газар хашиж хамгаалж ногдох хонин толгойг оруулж туршилт явуулж үзэх

Хүснэгт 26. Дорнод аймагт ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд:

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
<b>Ашиглалт</b>		-Эрхийн бичгийн олголт бага -Малчдын өрхийн хэрэгцээнд мод олгодоггүй -Ойн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөлүүдэд дэмжлэг бага -Нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа зогсонги байна -Хууль бус мод бэлтгэл ан агнуур -Мэргэжлийн боловсон хүчин дутуу дулимаг орон тоо цөөн	-Эрхийн бичгийн олголт нэмэгдүүлж хяналт сайжруулж ойн инженерийн орон тоо нэмэгдүүлж, бодлогоор боловсон хүчнийг нэмэгдүүлэх -Санхүүжилтийн дэмжлэг -Идэвхтэй байгаль хамгаалагч нарыг урамшуулж идэвхжүүлэх -Нөхөрлөлүүдийн үйл

	-Гал түймэр -Нөхөрлөлийн гишүүнээр элссэнээр үүрэг хариуцлага их. /морин эргүүл хийнэ, бага төсвөөр их талбайг ойжуулах/	ажиллагааг идэвхжүүлж чадавхжуулах -Байгаль хамгаалагч нарын цалин хөлс, нийгмийн асуудал, ажиллах нөхцөл техник тоног төхөөрөмж багаж хэрэгслээр бүрэн хангах -Гал түймрийн үед морин эргүүл байнга хийх, -Иргэдэд сэрэмжлүүлэг өгч гарын үсгийн баталгааг авах
<b>Хамгаалалт</b>		-Дрон нисгэх, дэвшилтэд технологи ашиглах -Ойг бүртгэлжүүлж мэдээллийн сантай болох -Иргэдэд сургалт мэдээлэл өгөх -Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх
<b>Нөхөн сэргээлт</b>	-Хортон мэрэгчдийг устгах	-Төсөв санхүүжилт нэмэгдүүлэх -Тарьц суулгац тарих -Ойгоос орсон гоожингийн орлогыг нөхөн сэргээх ажилд оруулах

**Хүснэгт 27. Дорнод аймагт усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд:**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
<b>Ашиглалт</b>	Уул, уурхайн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулдаг	-Гол цөөрмийн дагуу малчин өрхүүд ихээр бууж бэлчээрийн даац хэтэрсэн /малын хөлд талхагддаг/. -Уур амьсгалын өөрчлөлтөөс нөлөөлж усны урсац багасаж байна -Гол нуурын эрэг, газар тариалан эрхэлж суваг татаж голын голдирол түвшин багассан.	-Цас, борооны ус цуглуулах -Үүлэнд зориудаар нөлөөлөх ажилд төсөв тавих -Уул уурхайн литр тутамд ногдох мөнгөн төлбөр нэмэгдүүлэх -Уриалга гаргах
<b>Хамгаалалт</b>	Үгүй	-Хашаажуулаагүй булаг шанд ширгэж байна	-Булгийн эхийг хашаад ногоон байгууламж байгуулах

		-Хашаажуулахдаа дов сондуулыг оруулж хашаажуулахгүй байна -Худаг уст цэгийг төлөвлөлтгүй гаргаж байна -Хөв цөөрөм хийх судалгаа хийх хэрэгтэй байна -Усны мэргэжилтэн аймаг, орон нутагт дутмаг байна.	-Бүлэг, нөхөрлөл хоршооны оролцоотой нөлөөллийн ажил зохион байгуулах -Иргэдийн оролцоо дутмаг байна -Идэвхжүүлэх сургалтад хамруулах -Малын тоо толгойн албан татвараас санхүүжилт авах -БИНХ-р хэлэлцэж санал авах
<b>Нөхөн сэргээлт</b>	Үгүй	-Биологийн нөхөн сэргээлт дутмаг байдгаас гадаргын доорх усны нөөцөд нөлөөлж байна. -Байгалийн тэнцвэрт байдал алдагдах -Уул уурхайн үйл ажиллагаанд усыг замбараагүй ашиглаж байна	-Уул уурхайн биологийн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлэх -Усны чанар нөөцөд нөлөөлөх биологийн төрөл зүйлийг нутагшуулах

2.1.2 Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд:

Сүхбаатар аймгийн БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлсныг 24-28 –р хүснэгтүүдэд үзүүлэв.

**Хүснэгт 28. Сүхбаатар аймагт газар, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд:**

Үйл ажиллагааны төрөл	Газар, бэлчээр	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
<b>Ашиглалт</b>	Гэрээтэй	-Бэлчээрийн даац хэтэрсэн -Бэлчээрийн тухай хуульгүй -Малын тоо толгой ихэссэн -Усан хангамж муутай -Гэрээнд заагдсан хэмжээ талбай заах -Газрын төлбөрийн асуудал -Хадлангийн ир тавилтад хяналт тавьж байх -Байгалийн хүчин зүйл -Гал унтраах бүрэн хэрэгсэлтэй	-Бэлчээр ашиглах журамтай болох -Бэлчээрийн хуультай болох -Малын тоо толгойг цөөрүүлэх /ашиг шимийг нэмэгдүүлэх/ -Усан хангамжийг нэмэгдүүлэх -Төлбөрийн хэмжээ, итгэлцүүрийг нэмэх



		байх -Хадлангийн гэрээний нөхцөлөө биелүүлэх -Ургамлын төлбөрийн эрхзүйн зохицуулалт муу	-Барьцаа авдаг байх -Журам гаргах, талбайг хүлээн авах
<b>Хамгаалалт</b>	Төлөвлөгөөтэй	-Бэлчээр сэлгэх -Өвөлжөө, хаваржааны газар гэрчилгээгүй -Малын үүлдэр угсааг сайжруулах -Малын тоо толгойг бууруулах -Отроор малчид ирэх  -Гаднын малчид суурьших -Байгалийн хүчин зүйлс	-Усан хангамжийг нэмэгдүүлэх -Гэрчилгээтэй болох -Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх -Малын гаралтай бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах -Иргэн болон төрийн зохицуулалт -Айл, малчин өрхийг зохион байгуулалтад оруулж хадлангийн бүсээс чөлөөлөх
<b>Нөхөн сэргээлт</b>	Төлөвлөгөөтэй	-Бэлчээрийг чөлөөлөх -Талбайг хүлээлгэн өгдөггүй -Заасан хугацаанд хадлан бүүхгүйд арга хэмжээ авах -Хэмжилт хийдэггүй -Гал, усны аюулгүйн талаас хамгаалах арга хэрэгсэл, шаардлага муу тавьдаг	-Бэлчээрийг хаших /хэсэгчлэн/ -Малын тэжээл тарих -Эрчимжсэн МАА хөгжүүлэх -Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх -Худаг гаргах /усан хангамжийг нэмэгдүүлэх/ -Хятад тармуур ашиглуулахгүй байх -Ажлын хэсэг байгуулж нөхөн сэргээлт хийх -Хугацаа заах, талбайг бүрэн чөлөөлүүлэх, цэвэрлүүлэх

**Хүснэгт 29. Сүхбаатар аймагт ойн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд:**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
<b>Ашиглалт</b>	Тийм	-Ойн нөөц бага  -Ой, хээрийн түймэр	-Нөхөн тарилт, талбайн хэмжээг нэмэгдүүлэх -Сургалт, сурталчилгаа, харуул хамгаалалт, ухуулах самбар байршуулах

<b>Хамгаалалт</b>	Тийм	Хөрөнгө санхүүжилт	-Хуваарийн дагуу харуул хамгаалалт хийх -Төрийн байгууллагатай хамтрах Нөхөрлөлийн гишүүдэд сургалт хийж, мэдлэг олгох -Дундын сан үүсгэх -Гадна зээл тусламж, төсөлд хамрагдах -Төрөөс дэмжлэг туслалцаа авах
<b>Нөхөн сэргээлт</b>	Тийм	-Хөрөнгө санхүүжилт -Мэргэшсэн боловсон хүчин -Мод суулгацын нөөцгүй -Мал аж ахуй	-Нөхөрлөлийн гишүүдийг мэргэшүүлэх -Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх -Мод үржүүлгийн газар байгуулах -Туршлага судлах -Малын тоог цөөрүүлэх -Ойн сангаас малыг гаргах -Нөхөрлөл мал аж ахуйгаас өөр орлогын эх үүсвэртэй болох

**Хүснэгт 30. Сүхбаатар аймагт усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд : / Ундны болон ХАА-н усны талаар /**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
<b>Ашиглалт</b>	Үгүй	-Малчид шинжилгээгүй хэрэглэх -Элс шороонд дарагдах -Усны хүрэлцээ хангамж муу, хэрэглэгч их -Усны эх дээр мал их хэмжээгээр ундаалснаас гадаргын усны эх дарагдах	-Мэргэжлийн лабораторид шинжлэх -Худгийн ойролцоох бэлчээрийг хамгаалах -Гадаргын усны эхийг тогтоож хамгаалалтын бүс хийх
<b>Хамгаалалт</b>	Төлөвлөгөөтэй	-Ил задгай уст цэгүүд хамгаалалтын хашаа хайс байхгүй -Хамгаалалтын багаж, техник хэрэгсэл, төсөв санхүү хүрэлцээгүй -Хамгаалагдсан бүсийг хариуцах эзэнгүй орхигдуулах -Хог хаягдлыг цэвэрлэх	-Хашаа хамгаалалт татах /хамгаалалтын бүс тогтоох/ -Нөхөрлөлийн гишүүд санхүүжилт олох, улсын болон олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргах -Гадаргын усыг ойролцоох хот айлд хариуцуулах
<b>Нөхөн сэргээлт</b>	Төлөвлөгөөтэй	-Худгийг лайдах  -Ойролцоох хот айлын мал ихэдсэн, айлууд сэлгэн	-Худгийг нөхөрлөлийн гишүүд лайдаж ундаргыг сэргээх -Багийн ИНХ-д энэ талаар

**Хүснэгт 31. Сүхбаатар аймагт усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд: /Уул уурхайн усны талаар/**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
Ашиглалт	Тийм	-Гүний усыг их хэмжээгээр ашиглах -Саарал усыг ашиглахгүй байна -Бохирдолтой усыг байгальд шууд хаях -Ус ашиглалтын төлбөр заасан хугацаанд хийхгүй	-Уул уурхайн ус ашиглалтад нөхөрлөлийн зүгээс хяналт тавих, зөрчлийг мэргэжлийн байгууллагад тавьж арилгуулах -Саарал усыг ашиглах технологи нэвтрүүлж ажиллах -Уурхайн бохирдолтой усыг ус шүүх стандартын технологи нэвтрүүлэх -Ус ашигласны төлбөр хаана төлөгдөх, ямар үйл ажиллагаанд зарцуулж буйг тодруулж тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулах
Хамгаалалт	Тийм	-Уурхай ашигласан бохирдолтой усыг хамгаалсан зурвас хашаа байхгүй -Бохирдолтой усыг цэвэршүүлэхгүй байгальд асгах	
Нөхөн сэргээлт		-Нөхөн сэргээлт хангалгүй хийдэг	-Нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэд хийлгэдэг байх

**Хүснэгт 32. Сүхбаатар аймагт усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх арга замууд : /Артезийн усны талаар/**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээнд тусгагдсан эсэх	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам
Ашиглалт	Үгүй	-Байгалийн даралтаар ундарч хаах боломжгүй	-Байнгын урсцыг дагасан ногооны талбай, ойн зурвас, мод үржүүлгийн газар байгуулах
Хамгаалалт	Үгүй	-Хамгаалалт	-Хашаа хамгаалалт хийх


		хангалтгүй
<b>Нөхөн сэргээлт</b>	Үгүй	-Нөхөн сэргээх талаар ямар ч арга хэмжээ авдаггүй

Хэлэлцүүлэгт оролцогчид Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй 4 сав газрын захиргаа орон нутагтай хамтран ажиллах, зөвлөн туслах үйлчилгээ дутмаг, хамтын менежмент алдагдсан гэж дүгнэсэн байна.

### 2.1.3. Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны биелэлт, хамтын менежментийн гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн талаар:

Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны биелэлт, хамтын менежментийн гэрээний хэрэгжилтэд хууль зүйн дүн шинжилгээ хийхдээ дараах байдлаар байгалийн нөөц баялгийн ашиглалтын төрөлжсөн объектын ангилал тогтоож гэрээ тус бүрд үнэлгээ хийхийг зорив.

Байгалийн нөөц баялгийн ашиглалтын төрөлжсөн объектын ангиллаар нь:



Байгалийн баялаг ашиглах эрхийн объект нь байгаль бүхэлдээ гэж үздэг. Байгалийн аль нэгэн тодорхой төрөл зүйлсийг ашиглах явдал мөн чанартаа байгалийн баялгийг л ашиглаж байгаа юм.

Байгалийг ашиглахад түүний баялгийн төрөл зүйлсээр нь нарийвчлан зохицуулах эрх зүйн хэм хэмжээг хуулиар тогтоож, газар ашиглах, ус ашиглах, ой ашиглах гэх мэтээр ашиглалтын төрөлжсөн объектыг заасан байдаг. Гэхдээ энэ нь харьцангуй ойлголт бөгөөд объект тус бүр нь салангид, дагнан туйлширсан байдалд байдаггүй, нэг нэгэндээ харилцан уялдаатай байдаг. Жишээ нь, ой ашиглах эрх хөрс, ус, байгалийн ургамал, амьтны аймаг гэх мэт төрөлжсөн объектоор холбоотойгоор хэрэгждэг. Ийнхүү харилцан холбоотой байх нь зүй зохист хэрэг мөн бөгөөд үр дүн нь байгаль ашиглах явцад байгаль орчныг хамгаалах арга ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд нөлөө үзүүлнэ.

Байгалийн нөөц баялгийн ашиглалтын төрөлжсөн объектын ангилал тогтоосон гэрээнүүдэд үнэлгээ хийхээс өмнө тухайн гэрээний нэг талын субъект болон орон нутгийн төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас гарсан эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзсэн болно.

Зорилтот 2 аймгийн 27 сумаас эрх зүйн баримт бичгийн санал асуулгын судалгаа авч шинжилгээ хийхэд дараах тоон судалгаа гарсан байна.

№	Эрх зүйн баримт бичгийн төрөл	Сүхбаатар	Дорнод
1	Ус ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан сумын Засаг даргын захирамж	3	5
2	Ой ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан сумын Засаг даргын захирамж	1	3
3	Хадлан, бэлчээр ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан сумын Засаг даргын захирамж	3	9
4	Ус ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан сумын ИТХ-ын тогтоол	2	7
5	Ой ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан сумын ИТХ-ын тогтоол	-	2
6	Хадлан, бэлчээр ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан сумын ИТХ-ын тогтоол	7	9
7	Ус ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан багийн ИНХ-ын тогтоол	1	-
8	Ой ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан багийн ИНХ-ын тогтоол	-	-
9	Хадлан, бэлчээр ашиглалт, хамгаалалттай холбоотой гаргасан багийн ИНХ-ын тогтоол	2	1
10	Ус ашиглалт, хамгаалалттай холбоотой журам	1	3
11	Ой ашиглалт, хамгаалалттай холбоотой журам	-	-
12	Хадлан, бэлчээр ашиглалт, хамгаалалттай холбоотой журам	4	5
13	Малчдын хэсэг, бүлэг, нөхөрлөл байгуулсан талаарх ямар нэгэн баримт бичиг (Багийн Засаг даргын санал болон малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөлийн саналд үндэслэн гаргасан шийдвэр гэх мэт)	2	8
14	Малчин, малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөлтэй байгуулсан ус ашиглалт, хамгаалалтын гэрээ	2	1
15	Малчин, малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөлтэй байгуулсан ой ашиглалт, хамгаалалтын гэрээ	1	1
16	Малчин, малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөлтэй байгуулсан хадлан, бэлчээрийн газар ашиглалт, хамгаалалтын гэрээ	3	8
<b>Нийт</b>		<b>32</b>	<b>62</b>

Дорнод аймгийн сумдад байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр дараах төрлийн гэрээг байгуулсан байна. Үүнд:

1. Бэлчээр ашиглуулах гэрээ
2. Хөдөө аж ахуйн зориулалтаар газар ашиглах гэрээ
3. Иргэн, хуулийн этгээдэд хадлангийн зориулалтаар газар ашиглуулах гэрээ
4. Нөхөрлөлийн ойн санг эзэмших гэрээ
5. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн байгаль, ан амьтан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ
6. Өвс, тэжээлийн агуулах, саравчийг ашиглах, хяналт тавих гэрээ
7. Бог мал угаалгын банныг эзэмших, ашиглах, хяналт тавих гэрээ

8. Худаг эзэмшүүлэх гэрээ
9. Хамтын ажиллагааны гэрээ (Сумын Засаг дарга, малчдын бүлэг, Монголын Мянганы Сорилтын сан хамтран гэрээ байгуулсан) багтаж байна.

Сүхбаатар аймгийн сумдад байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр дараах төрлийн гэрээг байгуулсан байна. Үүнд:

1. Бэлчээр ашиглуулах гэрээ
2. Ус ашиглах гэрээ

Зорилтот 2 аймгийн дээр дурдсан гэрээний нийтлэг шинж, агуулга, нөхцөлүүдийн талаар дүн шинжилгээ хийхдээ байгалийн баялгийн ашиглалтын төрөлжсөн объектын ангиллаар бүлэглэн үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан болно.

## 2.2. Гэрээнд малын тооны өсөлт, малын ашиг шим, үүлдэрлэг байдал, сүргийн бүтэцтэй үялдуулан хадлан, бэлчээрийн нөөцийн менежментийн зохицуулалт тусгагдсан эсэх талаарх үнэлгээ:

Гэрээнд ихэвчлэн дараах нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:


- Малын тоо,
- Дөрвөн улирлын бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоог улирал тус бүрээр тогтоосон,
- Бэлчээр ашиглуулах хүрээнд худгийг малчдын бүлэгт эзэмшүүлэх, хэрэглүүлэх, холбогдох хэсгийг өмчлүүлэх нөхцөл.

Гэрээнд бэлчээрийн хэмжээ, байршил, экологийн чадавхын зураглалаас гадна зуны дээд ургацыг олон жилийн дунджаар оруулан даацыг хонин толгойгоор тооцож тусгасан байна. Харин малын тооны өсөлт, үүлдэрлэг байдал болон чанар, сүргийн бүтцийг мал аж ахуйн бүтээгдэхүүнийх үйлдвэрлэлтэй хэрхэн зохицуулахыг тусгаагүй байна. Иймээс эдгээр аймгуудын малчдын бүлэг, нөхөрлөлтэй хийх гэрээнд малын тооны өсөлтөөс гадна чанарыг сайжруулах заалт оруулах нь зүйтэй байна.

### Хүснэгт 33. Дорнод болон Сүхбаатар аймгийн малын тооны өсөлт

Аймгийн нэр	Малын төрөл	2019	2020	2021
Дорнод	Адуу	297.37	324.45	368.5
	Үхэр	277.42	305.11	353.22
	Тэмээ	6.3	6.22	6.49
	Хонь	1,262.35	1,303.06	1,470.18
	Ямаа	786.17	810.85	852.68
	<b>Хонин толгойд шилжүүлснээр</b>	<b>5747.513</b>	<b>6165.735</b>	<b>6968.862</b>
Сүхбаатар	Адуу	321.89	330.96	364,57
	Үхэр	268.55	280.91	308.23
	Тэмээ	7.93	7.61	7.75
	Хонь	1,971.23	1,993.91	2,179.01
	Ямаа	1,247.42	1,280.24	1,343.38
	<b>Хонин толгойд шилжүүлснээр</b>	<b>6998.088</b>	<b>7186.356</b>	<b>7828.172</b>

Дорнод аймгийн мал сүрэг 2021 онд 2019-2020 оныхтой харьцуулбал тэмээ 2020 онд 1.3 хувь буурч цаашид нэмэгдсэн бол бусад төрлийн мал 3.1-15.7 хувиар харин нийт малын тоо хонин толгойд шилжүүлснээр 7.3- 13.0 хувиар өсчээ.



Сүхбаатар аймгийн мал сүргээс тэмээ 2020 онд 4.0 хувь буурч 2021 онд нэмэгдсэн бол бусад төрлийн малын тоо 2021 онд 2019-2020 оныхтой харьцуулбал 1.1-10.2 хувиар харин хонин толгойд шилжүүлснээр 2.7- 8.9 хувиар өссөн байна.

Дорнод аймагт адууны тоо Сүхбаатар аймгаас 2019-2020 онд дутуу байсан бол 2021 онд 1,0 хувиар илүү болжээ. Харин үхрийн тоогоор Сүхбаатар аймгаас 3.1-12.7 хувиар илүү харин тэмээ болон бог малын тоогоор дутуу байна.

Монгол улсын мал аж ахуйн салбарт малын тооны өсөлтөөс гадна төрөл хоорондын харьцаанд томоохон өөрчлөлт гарч байна. Олон жилийн дунджаар нийт мал сүргийн бүтцийн 21.7 хувийг бод мал, 78.3 хувийг бог мал эзэлж байсан бол өнөөгийн байдлаар бод малын эзлэх хувь буурч 13.2 хувь, бог малын эзлэх хувь өсөж 86.8 хувьд хүрчээ.

#### Хүснэгт 34. Дорнод болон Сүхбаатар аймгуудын малын төрөл хоорондын харьцаа

Аймгуудын нэр	Малын төрөл	2019	2020	2021
Дорнод	Адуу	11.3	11.8	12.1
	Үхэр	10.5	11.1	11.6
	Тэмээ	0.3	0.23	0.2
	Хонь	48.0	47.4	48.2
	Ямаа	29.9	29.5	27.9
Сүхбаатар	Адуу	8.4	8.5	8.7
	Үхэр	7.0	7.2	7.3
	Тэмээ	0.2	0.2	0.2
	Хонь	51.6	51.2	51.8
	Ямаа	32.7	32.9	32.0

Дорнод аймагт нийт сүрэгт эзлэх бод малын хувь 2019 онд 22.1 хувь байсан бол 2021 онд 23.9 хувь болж 1.8 хувиар нэмэгдсэн бол Сүхбаатар аймагт энэ үзүүлэлт дээрх дарааллаар 15.6, 16.2 болж 0.6 хувиар нэмэгдсэн байна.

Цаашид малын нөхөн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэстэй, бүс нутгийн онцлог, эдийн засгийн зорилго, чиглэлтэй уялдуулан зохион байгуулах хэрэгтэй. Малын тооны өсөлтөөс чанарт шилжих, үржүүлэг, тэжээллэг, арчилгаа, маллагааны технологид хяналт тавих, түүний үр дүнг бүх шатанд үнэлж дүгнэх зорилгоор боловсруулан, баталсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги”-ийг хэрэгжүүлэхийн тулд, бэлчээр, тэжээлийн нөөц сайтай, хээрийн бүсийн эдгээр аймгуудад бог малын тоог бууруулж, үхэр, тэмээний тоог өсгөж, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулах, бэлчээрийн даац, тэжээлийн хүрэлцээ хангамжид тохируулах ажлыг гэрээнд нь тусгах хэрэгтэй. Бог малд 2 хонь, 1 ямаа гэсэн харьцааг баримталбал сайн юм.

Эдгээр аймгуудын экологийн нөхцөлд, ардын сонгон үржүүлгийн үр дүнд бий болсон Монгол үүлдрийн малаас гадна Дорнод аймагт Барга үүлдэр, Буриад омгийн хонь, Галбын говийн улаан үүлдрийн тэмээ, Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр харин Сүхбаатар аймагт Үзэмчин үүлдрийн хонь, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямаа, Ханын хэцийн хүрэн үүлдрийн тэмээ байна.

Эдгээрээс гадна гадаад орнуудаас авчирсан, арвин ашиг шимт сүүний чиглэлийн Хар тарлан, Талын улаан, мах сүүний хосолмол ашиг шимт Симменталь, Алатау, Монтебеллярд, Абонданс, махны чиглэлийн Казакын цагаан толгойт Ангус, Лимузин Герефорд үүлдрийн үхэр, Англи цэвэр, Араб, Буддэный үүлдрийн адуу, Өвөр байгаль, Каракул, Сүффолк, Эдельбай үүлдрийн хонийг мөн Монгол орны байгаль, эдийн засгийн өөр бүсэд зохицсон Дархад хонь, Алтайн улаан, Залаа жинст эдрэн, Завханы буурал үүлдрийн ямааг цэврээр болон монгол малтай эрлийзжүүлэн үржүүлж байна. Баруун болон бусад бүсүүдээс шилжин ирсэн малчдыг дагалдан эдгээр аймгуудад сарлаг бий болсныг харж болно.

### Хүснэгт 35. Дорнод болон Сүхбаатар аймагт үржүүлж буй малын үүлдүүд, малын төрлөөр

№	Малын төрөл	Дорнод	Сүхбаатар
1	Адуу	Галшар, Англи цэвэр, Араб, Буддэный, Барга	Нутгийн, Анли цэвэр, Буддэный, Араб, Дархад, Тэс, Галшар, Оросын хатирч
2	Тэмээ	Галбын говийн улаан,	Нутгийн, Ханын хэцийн хүрэн
3	Үхэр	Дорнод Монголын улаан, Хар тарлан, Сарлаг, Симменталь, Казакын цагаан толгойт, Талын улаан, Монтебеллярд, Абонданс, Ангус, Лимузин Герефорд, Алатау	Симменталь, Сэлэнгэ, Дорнод монголын улаан, Казахын цагаан толгойт, Талын улаан, Хар тарлан, Ангус, Алатау, Монтебелиард, Герефорд, Лимузин, Халимаг, Сарлаг,
4	Хонь	Үзэмчин, Барга, Дархад, Өвөр байгаль, Алтанбулаг, Каракул, <b>Буриад</b> , Сүффолк, Эдельбай	Үзэмчин, Барга, Сайн цагаан, Сүффолк, Эдельбай
5	Ямаа	Нутгийн хар ямаа, Баяндэлгэрийн, Говь гурван сайхан, Залаа жинстийн цагаан, Тулман хөхт	Баян дэлгэрийн улаан, Говь 3 сайхан, Алтайн улаан, Залаа жинст эдрэн, Завханы буурал



Тухайн аймаг, сумдын экологийн онцлогт тохироогүй малыг өөр улс болон бүс нутгаас дураар авчрах, тэжээл, байр, усан хангамжийг тооцохгүй, зохих бэлтгэлгүй, мэргэжилтний оролцоогүйгээр аж ахуй эрхлэх нь эрсдэлийг дагуулж байна.


Иймээс ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги”-ийг баримтлан малчдын бүлгүүд, нөхөрлөлүүд нь зонхилох төрлийн малын уламжлалт зохистой байршил болон зорилтод зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан тухайн төрлийн малаа ашиг шимийн ямар чиглэлээр үржүүлэх зорилтоо зөв тодорхойлсон байх,


Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мал сүргийг “тооноос–чанарт” шилжүүлж, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэхийн тулд ямар үүлдэр, омгийн малаар сайжруулахыг сумынхаа хэмжээнд шийдвэрлэсэн байх хэрэгтэй.

#### Хүснэгт 36. Дорнод, Сүхбаатар аймгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлт

№	Малын төрөл	Ашиг шимийн төрөл	Дорнод	Сүхбаатар
1	Адуу	Амьдын жин, кг		386.9
2	Тэмээ	Амьдын жин, кг		482.2
		Ноосны гарц кг		5.5
3	Үхэр	Амьдын жин, кг		369.2
		Сүүний гарц /кг /		721.5
4	Хонь	Амьдын жин, кг		64.8
		Ноосны гарц кг		1.2
5	Ямаа	Амьдын жин, кг		54.6
		Ноолуурын гарц /кг/	290.0	361.5

Нэг төрлийн малын доторх нас, хүйс тус бүрийн эзлэх харьцааг сүргийн бүтэц гэнэ. Тухайн өрх, аж ахуйн нэгж жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо, хэмжээ, чанар, хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний өөрийн өртөг, үйлдвэрлэлийн үе шат, хөрөнгийн эргэлт, ашигт ажиллагаа зэрэг нь сүргийн бүтцээс ихээхэн хамаардаг. Сүргийн бүтцийг бодит болон зохистой гэж хоёр ангилж үздэг.





Малчдын оролцоотой Байгалийн нөөцийн хамтын менежментийн бүлэг, нөхөрлөлүүд нь мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын тоо, сүргийн бүтцийг зохистой хэмжээнд барих, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөлт, малын тоо толгойн өөрчлөлт, орлого, зарлагыг тооцох сүргийн эргэлтийг программыг нэвтрүүлж, сүргийн эргэлт, ашиг шимийн үзүүлэлтийг тооцох хэрэгтэй бөгөөд дээрх асуудлуудыг орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн талуудын байгуулах гэрээнд тусгах, хэрэгжилтийг жил бүр тогтмол дүгнэж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлон, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой болгон хэрэгжүүлж ажиллахад хариуцлагатай ханддаг хэрэгтэй байна.

2.2.1. Малчдын оролцоотой БНХМБ-ууд нь “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалыг ашиглан бэлчээрийн даац тооцож байгаа эсэх тухай:

Малчдын оролцоотой БНХМБ-уудын гэрээнд бэлчээрийн даацыг тусгасан боловч гэрээ байгуулсан талууд болох сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал, малчдын бүлэг, хэсгүүд нь гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, дүгнэх үедээ “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалыг” ашигладаг эсэх нь тодорхойгүй байна. Иймд зорилтот хоёр аймгийн өвөл-хавар, зун-намрын бэлчээрийн даацыг сүүлийн 3 жилийн /2019,2020,2021 он/ байдлаар нэгтгэн гаргасан болно. Үүнд:

2.2.1.1. Бэлчээрийн даацыг Дорнод аймгийн сумдаар тооцоолон гаргаж 33, 34-р хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 37. Дорнод аймгийн сумуудын өвөл, хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн**

Сумдын нэр	Өвөл-хаврын	Нэг га бэлчээрийн ургац, кг	Нийт ургац /кг/	Жилд нэг хонин толгойн идэх өвс. кг	Бодит даац	2019		2020		2021	
						Даацын үнэлгээ	Хэтрэлт	Даацын үнэлгээ	Хэтрэлт	Даацын үнэлгээ	Хэтрэлт
1 Баяндун	190,794	462	88,151,107	317	278,255	151	2	157	2	181	2
2 Баянтүмэн	338,228	396	133,935,013	274	488,101	102	1	116	1	129	1
3 Баян-Уул	273,017	381	103,934,249	317	328,075	104	1	108	1	134	1
4 Булган	454,652	359	163,153,686	274	594,583	77	1	84	1	95	1
5 Гурванзагал	87,622	334	29,237,703	274	106,551	334	3	344	3	397	4
6 Дашбалбар	271,692	1,142	310,181,415	274	1,130,399	49	0	51	1	58	1
7 Матад	811,293	756	613,269,905	274	2,234,949	22	0	26	0	30	0
8 Сэргэлэн	49,582	320	15,876,112	274	57,858	765	8	766	8	852	9
9 Халхгол	157,858	1,727	272,567,712	274	993,323	312	3	313	3	347	3
10 Хөлөнбуйр	78,293	268	20,971,339	274	76,426	446	4	462	5	531	5
11 Цагаан-Овоо	141,219	295	41,604,355	274	151,619	338	3	381	4	435	4
12 Чойбалсан	239,322	121	28,983,962	274	105,627	354	4	397	4	468	5
13 Чулуунхороот	287,101	214	61,412,288	274	223,806	108	1	118	1	131	1

Дорнод аймгийн сумдын бэлчээрийн өвөл, хаврын бэлчээрийн даацыг 2019-2021 он буюу сүүлийн 3 жилийн байдлаар тодорхойлсон дүнгээс үзэхэд:, Булган, Дашбалбар, Матад сумын бэлчээр тэжээлийн нөөцтэй, Баян түмэн, Баян-Уул, Чулуунхороот сумынх 1.3-1.8, Халхгол, Цагаан-Овоо, Гурванзагал сумынх 3-4, Чойбалсан, Хөлөнбуйр сумынх 5, Сэргэлэн сумынх 9 дахин хэтэрсэн бол харин зуны бэлчээрийн хувьд Баяндун, Баянтүмэн, Булган, Гурванзагал, Дашбалбар, Матад сумдынх нөөцтэй, Сэргэлэн, Халхгол сумдынх дөнгөж хүрэлцээтэй, Баян-Уулынх 1.9 дахин хэтрэлттэй байна.

Хүснэгт 38. Дорнод аймгийн сумуудын зун намрын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн

Сумдын нэр	Зун-намрын	Нэг га бэлчээрийн ургац, кг	Нийт ургац /кг/	Жилд нэг хонин толгойн идэх өвс, кг	Бодит даац	2019		2020		2021	
						Даацын үнэлгээ	Хэтрэлт дахин	Даацын үнэлгээ	Хэтрэлт дахин	Даацын үнэлгээ	Хэтрэлт дахин
1 Баяндун	233,702.4	1,490.0	348,216,623.4	300.6	1,158,405.3	36.2	0.4	37.6	0.4	43.6	0.4
2 Баянтүмэн	214,356.6	990.0	212,207,802.6	304.2	697,593.0	71.5	0.7	81.4	0.8	90.5	0.9
3 Баян-Уул	72,793.6	951.7	69,278,967.3	300.6	230,469.0	147.5	1.5	153.6	1.5	191.0	1.9
4 Булган	217,300.0	897.1	194,947,554.3	304.2	640,853.2	71.0	0.7	78.3	0.8	88.4	0.9
5 Гурванзагал	228,496.0	834.2	190,611,839.2	300.6	634,104.6	56.1	0.6	57.8	0.6	66.7	0.7
6 Дашбалбар	468,026.1	2,854.2	1,335,824,412.9	300.6	4,443,860.3	12.5	0.1	12.9	0.1	14.8	0.1
7 Матад	896,675.3	1,889.8	1,694,529,472.9	300.6	5,637,157.3	8.8	0.1	10.1	0.1	11.8	0.1
8 Сэргэлэн	191,474.5	800.5	153,274,285.8	300.6	509,894.5	86.8	0.9	87.0	0.9	96.7	1.0
9 Халхгол	248,151.3	4,316.7	1,071,186,254.1	300.6	3,563,493.9	86.9	0.9	87.1	0.9	96.9	1.0
10 Хөлөнбуйр	163,001.1	669.6	109,152,542.0	300.6	363,115.6	93.8	0.9	97.2	1.0	111.8	1.1
11 Цагаан-Овоо	211,079.1	736.5	155,463,918.5	300.6	517,178.7	99.2	1.0	127.7	1.3	127.7	1.3
12 Чойбалсан	357,960.1	302.8	108,379,976.8	300.6	360,545.5	103.8	1.0	137.0	1.4	137.0	1.4
13 Чулуунхороот	114,035.2	534.8	60,981,700.4	300.6	202,866.6	118.9	11.9	130.2	1.3	144.4	1.4

2.2.1.2. Сүхбаатар аймгийн өвөл, хаврын бэлчээрийн даацыг сумдаар тооцоолон гаргаж 35-р хүснэгтэд үзүүлэв. Хүснэгтээс үзэхэд бэлчээрийн даац өвөл, хаврын улиралд Түмэнцогт, Онгон, Наран, Мөнххаан сумдад 2019-2021 онуудад 1.3- 1.9 дахин хэтрэлттэй, Асгат, Түвшинширээ сумдад 2.2- 2.8, Дарьганга, Халзан, Эрдэнэцагаан сумдад 3.1-3.6 Баяндэлгэр, Сүхбаатар+Баруун-Урт, Уулбаян сумдад 4.5- 5.6 буюу олон дахин хэтэрсэн байна. Харин зуны улиралд Асгат суманд тэжээлийн нөөц хүрэлцээтэй, Мөнххаан, Наран, Эрдэнэцагаан,

Сүхбаатар, Онгон, Халзан сумд 1.1-1.6 дахин, Уул баян, Баяндэлгэр сумдад 4.0- 4.8 буюу олон дахин, бусад сумдад 105.1-161.2 хувиар хэтэрчээ.

Тус аймгийн сүргийн эргэлтийн төлөвлөлтийг бэлчээрийн бодит даацад тохируулах зорилгоор 10 жилийн хугацаатайгаар тооцоолж төлөвлөгөөт хугацааны дараа хонь 50, ямаа 25, үхэр 14.5, адуу 10, тэмээ 0.5 хувийг эзэлж байхаар боловсруулан хавсралтад оруулав.

Хүснэгт 39. Сүхбаатар аймгийн сумдын өвөл-хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн

№	Сумын нэр	Өвөл, хаврын бэлчээрийн талбайн хэмжээ /га/	Өвөл, хаврын бэлчээрийн 1 га-гийн дундаж ургац /кг/	Нийт ургац /кг/	Жилд нэг хонин толгойн идэх өвс, кг	Бодит даац	2019			2020			2021		
							Даацын үнэлгээ	Хэтрэлт	Хэтрэлт	Даацын үнэлгээ	Хэтрэлт	Хэтрэлт	Даацын үнэлгээ	Хэтрэлт	Хэтрэлт
1	Асгат	189952	270	51287038.1	274.4	186906.1	202.2	2.0	213.3	2.1	224.7	2.2			
2	Баяндэлгэр	341399.5	100	34139948.5	205.7	165969.6	463.7	4.6	462.8	4.6	486.5	4.9			
3	Дарьганга	106694	430	45878412.5	274.4	167195.4	284.7	2.8	287.0	2.9	316.8	3.2			
4	Мөнххаан	346330.9	480	166238813	274.4	605826.6	129.0	1.3	134.2	1.3	142.2	1.4			
5	Наран	71339.9	400	28535959	205.7	138726.1	185.4	1.9	170.8	1.7	187.4	1.9			
6	Онгон	270194	170	45932985.7	205.7	223300.9	123.9	1.2	129.1	1.3	136.5	1.4			
7	Сүхбаатар+Баруун-	330	4E+08	578.6	274.4		365.3	3.7	337.7	3.4	446.5	4.5			
(8)	Урт														
9	Түвшинширээ	180932.3	300	54279696	274.4	197812.3	250.2	2.5	245.1	2.5	282.3	2.8			
10	Түмэнцогт	109124.6	580	63292268	274.4	230657.0	127.9	1.3	125.4	1.3	127.5	1.3			
11	Уулбаян	253933.8	90	22854040.8	274.4	83287.3	495.0	5.0	498.5	5.0	564.7	5.6			
12	Халзан	127367.4	210	26747143.7	274.4	97475.0	325.8	3.3	332.1	3.3	358.5	3.6			
13	Эрдэнэцагаан	371387.5	180	66849747	274.4	243621.5	325.3	3.3	336.5	3.4	359.1	3.6			

Хүснэгт 40. Сүхбаатар аймгийн сумдын зун намрын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн

№	Сумын нэр	Зун намрын бэлчээрийн талбайн хэмжээ /га/	Зун намрын бэлчээрийн 1 га-гийн дундаж ургац /кг/	Нийт ургац /кг/	Зун, намар нэг хонин толгойн идэх өвс, кг	Бодит даац	2019		2020		2021	
							Даацын үнэлгээ	Хэтрэлт	Даацын үнэлгээ	Хэтрэлт	Даацын үнэлгээ	Хэтрэлт
1	Асгат	513573.9	378	194130936.8	304.2	638168.8	59.2	0.6	62.5	0.6	65.8	0.7
2	Баяндэлгэр	384982.4	140	53897535.72	267	201863.4	380.5	3.8	380.5	3.8	400.0	4.0
3	Дарьганга	211795.5	602	127500901.5	304.2	419135.1	113.6	1.1	114.5	1.1	126.4	1.3
4	Мөнххаан	369228.8	672	248121733.1	304.2	815653.3	95.8	1.0	99.7	1.0	105.6	1.1
5	Наран	117890.6	560	66018735.9	267	247261.2	104.0	1.0	95.8	1.0	105.1	1.1
6	Онгон	272364.3	238	64822695.45	267	242781.6	113.9	1.1	118.8	1.2	125.6	1.3
7 (8)	Сүхбаатар+Баруун- Урт						105.4	1.1	97.4	1.0	128.8	1.3
9	Түвшинширээ	250887.1	420	105372565	304.2	346392.4	142.9	1.4	139.9	1.4	161.2	1.6
10	Түмэнцогт	69475.4	812	56414024.8	304.2	185450.4	159.1	1.6	156.0	1.6	158.5	1.6
11	Уулбаян	236285.9	126	29772020.69	304.2	97869.89	421.3	4.2	424.3	4.2	480.6	4.8
12	Халзан	248347.5	294	73014179.38	304.2	240020.3	132.3	1.3	134.9	1.3	145.6	1.5
13	Эрдэнэцагаан	922645.6	252	232506681	304.2	764321.8	103.7	1.0	107.2	1.1	114.5	1.1

### 2.3. Гэрээнд байгалийн гамшигт үзэгдэл, онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан эсэхэд үнэлгээ хийсэн талаар:

Байгалийн гамшиг бол хүний оролцоогүйгээр, гэнэт тохиолддог, хүн, малын амьдралд сөрөг нөлөөтэй, уршиг ихтэй үйл явдлыг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас манай оронд ган, зудын давтамж нэмэгдэн, улам их хохирол учруулах болоод байна. Иймээс малчид, аж ахуйн нэгжүүд зохих бэлтгэлийг хийж, эдгээр гамшгийн үед тохиолдох уршгаас сэргийлж байх хэрэгтэй юм.

Бидний судалгаагаар малчдын оролцоотой БНХМБ-ын гэрээнд байгалийн гамшигт үзэгдэл, онцгой байдлын үед хэрэгжүүлэх дараах нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

- Урьдчилан мэдээлэх, мэдэх боломжгүй зуд, ган, үер зэрэг байгалийн аюултай үзэгдэл, түймэр, мал амьтны гоц халдварт өвчний тархалт, эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгааны улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд тусгасан нөхцөлийн талаар харилцан үүрэг хүлээхгүй,
- Талуудын хүсэл сонирхлоос гадуур, гэнэтийн бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй үйл явдал, тэр дундаа ган зуд, усны үер, байгалийн аюултай үзэгдэл, гал түймэр, мал амьтны гоц халдварт өвчин, эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгаа гэх мэт нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөлийг талууд хүлээн зөвшөөрсөн,
- Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичиг, эсхүл нийтэд зарласан бөгөөд ойлгомжтой, олон нийтээр мэдэх нөхцөл байдал нь давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тухай болон түүний үргэлжилсэн хугацааны талаарх хангалттай нотолгоо болно,
- Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр олгосон газрыг түр ашиглах боломжгүй тохиолдолд малчдын бүлэг, хэсэг нь тухайн баг, сумын Засаг даргын дэмжлэгтэйгээр зэргэлдээ бэлчээрийн газарт бэлчээрийн даацад нь тохируулан өөрийн малыг оруулна,
- Давагдашгүй хүчин зүйл учирсан тохиолдолд сумын Засаг даргын шийдвэрээр Малчдын бүлэг, хэсгийн зүгээс хөрш аймаг, сумын болон тусгай хамгаалалттай газрын бэлчээр, отрын бэлчээр, нөөц бэлчээрийг түр ашиглахад нь туслалцаа үзүүлж болох бөгөөд холбогдох этгээдтэй энэ талаар зохих гэрээ байгуулна зэрэг онцлог нөхцөлүүдийг тусгажээ.

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр” 2001 онд батлагдан өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ. Энэ хөтөлбөрийн 8.1-т Малчид Байгалийн болзошгүй ган, зудын аюулаас хамгаалах зорилгоор нэг хонин толгойд ойт хээрт 30 кг, өндөр уул, тал хээрийн бүсэд 10 кг, говийн бүсэд 3 кг-аас доошгүй нэмэгдэл тэжээлээр тэжээх өвс, түүнчлэн гар тэжээл, хужрын нөөцийг өөрсдийн хүч, хөрөнгөөр заавал бүрдүүлэх; 8.3-т Мал сүргээ зохих хууль тогтоомжийн дагуу даатгалд хамруулах; 9.1-т сум бүр нэг хонин толгойд хоногт 1 кг-аас доошгүй өвсөөр тооцон нийт малыг 3-аас

доошгүй хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх, сумын аюулаас хамгаалах өвс, тэжээлийн нөөцийг энэ жилээс эхлэн үе шаттайгаар хангаж, 2004 он гэхэд бүрэн бүрдүүлсэн байх; 10.1-т Бэлчээрийн эдэлбэр газрын эзэмшилт, ашиглалтыг сайжруулан, хадлангийн хэмжээг нэмэгдүүлж, нэг хонин толгойд хоногт 1 кг өвсөөр тооцож нийт малыг 3-аас доошгүй хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх өвс, тэжээлийн аймгийн аюулгүйн нөөцийг жил бүр заавал бүрдүүлсэн байх, 11.7-д Улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг, салбаруудын тоог нэмэгдүүлэн зөв байршуулах, хүчин чадлыг сайжруулах асуудлыг боловсруулан шийдвэрлүүлж 1 хонин толгойд 1 кг өвсөөр тооцон нийт малын 25 хувийг 3-аас доошгүй хоног тэжээх өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх; 11.8-д Улсын нөөцөд удаан хадгалах боломжтой, овор багатай, уураг, энергийн агууламж ихтэй тэжээлийн ургамал (шар буурцаг, вандуй, эрдэнэ шиш, овьёос, царгас гэх мэт)-ыг улсын захиалга даалгавраар тариалах, түүнд шаардагдах хөрөнгийг зээл, төсөл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих ажлыг хэрэгжүүлэх; 11.9. Тухайн жилийн байгаль, цаг уурын урьдчилсан тойм, бэлчээрийн даацыг харгалзан зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан мал сүргийн зохих хэсгийг бэлтгэж бүтээгдэхүүн хэлбэрээр дотоод, гадаадын зах зээлд борлуулах асуудлыг зохицуулахаар заасан байдаг.

Энэ хөтөлбөрийн 8.1, 9.1-т заасан нэмэгдэл өвс, тэжээл бэлтгэх чиг үүргийг гэрээнд тусгаж өгөх нь байгалийн гамшигт үзэгдэл, онцгой байдлын үед талуудын хариуцлагыг өндөржүүлэх, бэлэн байдлыг хангах, цаг агаарын хүндэрсэн нөхцөлд хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

### 2.3.1. Дорнод аймгийн гамшигт үзэгдэл, онцгой байдлаас сэргийлэх ажлын бэлтгэлд үнэлгээ хийсэн тухай:

Дорнод аймгийн өвөл, хаврын бэлтгэл хангасан үзүүлэлтийг 37-р хүснэгтэд үзүүлэв. Нийт малд шаардлагатай өвс болон тэжээлийн тооцоог холбогдох журмын дагуу зөв тооцоолсон боловч, бэлтгэж нөөцөлсөн хэмжээ сумдад харилцан адилгүй байна.

#### Хүснэгт 41. Дорнод аймгийн гамшигт үзэгдэл, онцгой байдлаас сэргийлэх ажлын бэлтгэлд үнэлгээ хийсэн тухай

Сумын нэр	Усны хангамж		Бэлтгэсэн нэмэгдэл тэжээлийн хэмжээ, т			Хашаа хорооны хангамж		
	Худгийн тоо	Хүн, малын усан хангамж, %	Өвс	Хүчит тэжээл	Хангамж, %	Бодын	Богийн	Хашаа, хорооны хангамж, %
Баяндун	418	86.7	6807.1	10.0	75.0	354	295	95.1
Баянтүмэн	520	100.6	8228.6	5.0	73.7	264	240	73.9
Булган	225	92.0	7720.0	10.0	66.3	248	250	80.5
Гурванзагал	307	56.4	8950.0	40.0	100.1	74	162	94.8
Дашбалбар	531	105.2	4170.0	0.0	66.7	266	328	94.3
Матад	414	50.7	6075.5	4.3	50.3	154	328	95.1
Халхгол	183	63.0	7799.8	14.5	68.7	168	168	96.0



Хөлөнбуйр	80	106.3	4746.0	39.0	109.4	75	148	91.1
Сэргэлэн	256	86.3	7025.9	47.3	138.4	182	252	94.4
Цагаан-Овоо	411	106.3	8356.1	40.0	100.0	315	328	93.6
Баян-Уул	651	106.9	13370.0	52.0	194.4	293	368	98.1
Чойбалсан	422	89.0	5380.0	0.0	41.6	105	234	94.5
Чулуунхороот	203	92.8	5511.0	1.0	56.3	84	131	91.8
Хэрлэн	571	96.2	4160.0	40.0	96.0	557	394	97.9
<b>Дүн</b>	<b>5192</b>	<b>88.5</b>	<b>98300.0</b>	<b>303.1</b>	<b>88.2</b>	<b>3139</b>	<b>3626</b>	<b>92.2</b>

Тухайлбал Дорнод аймгийн Гурванзагал, Хөлөнбуйр, Сэргэлэн, Цагаан-овоо, Баян-уул сумд төлөвлөгдсөн өвс тэжээлийг 100—194,4 хувь бэлтгэн нөөцөлсөн байхад Чойбалсан, Булган, Чулуунхороот, Хэрлэн, Халхгол, Дашбалбар, Баяндун, Баянтүмэн сумд төлөвлөгөөг биелүүлээгүй байв. Усан хангамж Баянтүмэн, Дашбалбар, Хөлөнбуйр, Цагаан-овоо, Баян-уул сумдад сайн, бусад ялангуяа Гурванзагал, Матад, Халхгол сумдад ихээхэн дутагдалтай бол хашаа, хорооны хангамж Дорнод аймагт 73.9-98.1 хувьтай байв.

### 2.3.2 Сүхбаатар аймгийн гамшигт үзэгдэл, онцгой байдлаас сэргийлэх ажлын бэлтгэлд үнэлгээ хийсэн тухай:

Сүхбаатар аймгийн өвөл, хаврын бэлтгэл хангасан үзүүлэлтийг авч 38–р хүснэгтэд үзүүлэв. Нийт малд шаардлагатай өвс болон тэжээлийн тооцоог холбогдох журмын дагуу зөв тооцоолсон боловч бэлтгэж нөөцөлсөн хэмжээ сумдад харилцан адилгүй байна.

#### Хүснэгт 42. Сүхбаатар аймгийн сумдын усан хангамжийн мэдээлэл

Сумын нэр	Усны хангамж		Бэлтгэсэн нэмэгдэл тэжээлийн хэмжээ, т			Хашаа хорооны хангамж		
	Хүдгийн тоо	Хүн, малын усан хангамж, %	Өвс	Хүчит тэжээл	Хангамж, %	Бодын	Богийн	Хашаа, хорооны хангамж, %
Асгат	286	100.0	660	0	71.8	53	175	96
Баруун-Урт	289	100.0	1,090	40	68.5	63	581	76
Баяндэлгэр	134	78.4	2,060	20	68.5	72	335	100
Дарьганга	300	100.0	1,150	7	84.4	145	532	100
Мөнххаан	137	100.0	2,571	30	65.7	30	165	92
Наран	252	88.1	820	30	65.8	61	255	97
Онгон	396	100.0	1,100	54	51.5	53	456	87
Сүхбаатар	147	100.0	950	25	41.8	72	520	89
Түвшинширээ	219	100.0	1,280	50	95.1	75	250	100
Түмэнцогт	259	100.0	750	116	63.0	50	185	100
Уулбаян	447	97.7	1,263	25	49.6	95	411	100
Халзан	157	100.0	790	30	76.0	85	123	96
Эрдэнэцагаан	252	100.0	1,600	40	35.0	152	700	95
<b>Бүгд</b>	<b>3275</b>	<b>97.2</b>	<b>16,084</b>	<b>472</b>	<b>68.7</b>	<b>1006</b>	<b>4688</b>	<b>95</b>

Сүхбаатар аймгийн хувьд малчид шаардагдах тэжээлийн 42,6-100, дунджаар 67.4 хувийг, аймаг сумын нөөцөд бэлтгэх тэжээлийн 70 хувийг тус тус бэлтгэсэн байна. Тэжээлийн нөөц бэлдэлгүй дан ганц бэлчээрт найдах нь эрсдэлтэй бөгөөд ялангуяа арвин ашиг шимт мал үржүүлэн, бизнес хийх боломжгүй юм.

2021 оны судалгаагаар Сүхбаатар аймагт мал **97.2** хувь усаар хангагдсан байгаа боловч усаар хангагдсан өрх 50 хувь байжээ. Малын усны хэрэгцээг тооцохдоо өвөл, хаврын улиралд нэг хоногт тэмээ 40-50 л, адуу 20-30 л, үхэр 30-40 л, хонь, ямаа 2-3 л, бодын төл 10-20 л, богийн төл 1-2 л ус хэрэглэнэ гэдгийг баримталдаг боловч усны нөөц, ундаргыг хэрхэн тооцож хангамжийн хувийг гаргасан нь тодорхойгүй юм. Сүхбаатар аймагт малд зориулсан худагнаас малчид ус авч хүнсэнд ашигладаг. Ус нь хатуулаг ихтэй, хүний эрүүл мэндэд муу байдаг тухай судалгаанд оролцогчид ярьж байсан юм.

Монголын ард түмэн дундуур идэш, дулаан хэвтэр гэж дулаан хашаа, хорооны ач холбогдлыг өндөр үнэлдэг билээ. Гамшгаас урьдчилан сэргийлэхэд мал сүргийг хашаа, хороогоор хангах нь чухал ач холбогдолтой. Сүхбаатар аймагт бод малын хашааны хангамж 86.4, бог малынх 100.0, дунджаар 93.2 хувь байна.

Цаашид нутгийн үүлдрийн үхэр, бог малыг өвөлжүүлэх дулаалгатай, саравчтай хашааны багтаамжийг нэг үхэрт 3.0, адуунд 3.0, тэмээнд 4.0, бог малд 0.8, тугал, унаганд 1.0, ботгонд 1.5 ам дөрвөлжин метр талбай тус тус оногдохоор тооцон хангах хэрэгтэй. Дорнод, Сүхбаатар аймгуудад тэжээл, ус, хашаа, саравчны хангамжаас гадна хээрийн түймэр, малын гоц халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, чадварыг малчдад олгоход анхаарах нь чухал байна.

#### **2.4. Дорнод, Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны түвшнээр нь үнэлсэн талаар:**

Дорнод аймгийн БНХМБ-ын үйл ажиллагаа:

Малчдын бүлгүүд нь нийт 3230 малчидтай 67.1 хувь нь эрэгтэй, 32.9 хувь нь эмэгтэй бөгөөд бүлэг, хэсгийн ахлагч нарын 63 хувь нь эрэгтэй, 37 хувь нь эмэгтэй байна. Дорнод аймагт нэг сая толгой мал бүхий малчдын бүлэг, хэсгүүд 5.5 сая га бэлчээрийг ашиглахаар гэрээ байгуулсан. **Малчдын бүлгүүдийн 39 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.**

Нийт 40 нөхөрлөл нь 40 ахлагч, 709 гишүүнтэй, тэдгээрийн 53 хувь нь эрэгтэй, 47 хувь нь эмэгтэй байна. Ахлагчдын 51 хувь эрэгтэй, 49 хувь нь эмэгтэй, дундаж нас 55 байна. Нөхөрлөлүүд нь Удирдах зөвлөлийн 137 Хяналтын зөвлөлийн 107 гишүүнтэй бөгөөд 48 идэвхтэн байгаль хамгаалагчтай ажиллаж байна. Эдгээрээс 38 нөхөрлөл сумын Засаг даргатай гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна. **Нөхөрлөлүүдийн 72 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.**

ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын гишүүдийн тоо 2310 хүрсэн байна. Малчдын оролцоотой 54 хоршоо нь 32,9 сая төгрөгийн дүрмийн сантай, 614,8 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

**Хоршоодын 29 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.**

Сүхбаатар аймгийн БНХМБ-ын үйл ажиллагаа:

Тооллогод хамрагдсан малчдын бүлэг, хэсгүүд нь нийт 5028 гишүүдийн 2554 буюу 50.2 хувь нь эрэгтэй, 2474 буюу 49.8 хувь нь эмэгтэй, бүлэг, хэсгийн ахлагчдын 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэй байна. Сүхбаатар аймгийн бэлчээр ашиглагч бүлэг, хэсгүүд 0,75 сая толгой мал сүрэгтэй, 1,7 сая га бэлчээрийг 5 жилийн хугацаатайгаар ашиглахаар гэрээ байгуулан ажиллаж байна. **Малчдын бүлгүүдийн 52 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна.**

Нийт 5 нөхөрлөл, 5 ахлагч, 71 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 5 нөхөрлөл нь сумын засаг даргатай гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна. **Нөхөрлөлүүдийн 60 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна.**

11 суманд 2859 гишүүнтэй 33 хоршоо хөдөө аж ахуйн чиглэлээр 118,3 сая төгрөгийн дүрмийн сантай, 181,0 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. **Хоршоодын 24 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.**

## 2.5. Талуудын гэрээгээр хүлээж буй үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг хэрхэн үнэлж, дүгнэж, гэрээг хэрхэн сунгадаг болон цуцалдаг талаар хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтийн талаар:

Гэрээнд ихэвчлэн дараах нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

- Малчдын хэсэг, бүлгийн эрх, үүрэг,
- Засаг даргын эрх, үүрэг,
- Малчдын бүлэг солигдох,
- Бэлчээр ашиглах эрх дуусгавар болох,
- Гэрээг цуцлах,
- Хариуцлага,
- Талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх нөхцөлүүдийг тусгасан байна.
- Хавсралтад: бэлчээр ашиглагч малчдын хэсэг, бүлгийн гишүүн өрх, мэдээлэл,
- Гэрээт бэлчээрийн хэмжээ, байршил, улирлын хуваарийн зураглал,
- бэлчээрийн газрын экологийн чадавхын зураглал, бэлчээрийн төлөв байдал, шилжилтийн загвар (экологийн бүлгүүдээр)
- бэлчээр ашиглуулах гэрээний биелэлтийг фото мониторингийн аргаар үнэлэх суурь мэдээлэл

Газар (хадлан, бэлчээр)-ын гэрээгээр хүлээж буй талуудын үүрэг, хариуцлага, хугацааны

талаарх нийтлэг нөхцөлүүдийг бүлэглэн судалж үзэхэд:

Хөдөө аж ахуйн зориулалтаар газар ашиглах гэрээ /Засаг дарга, малчдын бүлэгтэй байгуулсан гэрээ/	
1	<b>Өмчлөгчийг төлөөлж буй ашиглуулагч (Засаг дарга)-ийн үүрэг</b> <ul style="list-style-type: none"><li>- Холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний шаардлагыг хангасан Малчдын бүлэгт бэлчээрийн зориулалтаар газар олгох, холбогдох захирамж гаргах</li><li>- Малчдын бүлэг нь тухайн газрыг ашиглах эрхтэй ба хэрэв бусад малчид энэ эрхийг хөндвөл Засаг дарга гэрээний болон холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн малчдад хариуцлага хүлээлгэнэ.</li><li>- Бэлчээрийн болон худгийн зориулалтаар Малчдын бүлэг олгосон газрыг бусдад олгохгүй байх, Малчдын бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, худгийг</li></ul>

---

малчдын бүлгээс бусад этгээд олгохгүй, ашиглуулахгүй байх, ус ашиглуулах гэрээгээр бусдад шилжүүлэхгүй байх (Үүнд бэлчээрийн хилээс гадагш хоёр (2) километр дотор усны эх үүсвэрийг бохирдуулах үйл ажиллагаа явуулах уул уурхайн компани болон бусад иргэн, аж ахуйн нэгжид ашиглуулахгүй байх нөхцөл орно)

- Малчдын бүлэгт Бэлчээрийн зориулалтаар ашиглах газрыг Хавсралт 2-т заасан Малчдын бүлэгт холбогдох газрын зургийн дагуу хүлээлгэн өгөх
- Малчдын бүлэгт малын хашаа, саравчны материал олгох, худаг гаргахад дэмжлэг үзүүлэх
- Бэлчээр нь бусдад ашиглагдаагүй, барьцаалагдаагүй, битүүмжлэгдээгүй, түүнийг хөлслүүлээгүй, түрээслүүлээгүй, өмчийн ямар нэгэн маргаангүй гэх зэрэг нөхцөлийг Засаг даргын Тамгын газар, холбогдох албан тушаалтнаар хангуулах
- Худгийн ус өргөх тоног төхөөрөмж, худгийн байшин, ус дамжуулах дотор, гаднах сүлжээ, мал услах онгоц, мал услах талбайн ажиллагааг зохих түвшинд хангаж байгаа эсэхэд хяналт тавих
- Энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүргээ биелүүлнэ.

## **2 Бэлчээр ашиглагч (Малчдын бүлэг)-ийн үүрэг**

- Холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлчээрийг зориулалтаар нь ашиглах, байгаль орчны болон бусад хууль тогтоомжийг даган мөрдөх, бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, бэлчээрийн чанарыг сайжруулах, бүрэн бүтэн байдлыг хангах, мал сүргээ эрүүлжүүлэх
  - Бэлчээр болон худгийг бусдад дамжуулахгүй, ашиглуулахгүй байх
  - Хөрсний үржил шим, ургамлын бүрхэвч, бүрэлдэхүүн алдагдахаас хамгаалах, хөрс элэгдэх, хатах хэт усархаг буюу шүлтлэг болох, хөрс бохирдох, хордох зэрэгт нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх
  - Ашиглаж буй бэлчээрийн хилийн дагуу 200 м тутамд энгийн аргаар тэмдэглэгээ хийх. Энэ тэмдэглэгээ нь малчдын бүлэг тухайн бэлчээрийг ашиглаж байгааг илэрхийлсэн байх
  - Худгийн ашиглалт хамгаалалтыг хариуцах, худгийг зохистойгоор, зориулалтын дагуу хэрэглэх, бохирдуулахгүй байх, ус, газар, байгаль орчныг хамгаалах, худгийн орчин тойрныг байгаль орчинд хор нөлөөгүйгээр хэрэглэх, худгийн усны чанарыг эрсдэлд учруулахаас хамгаалах
  - Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний төлбөр зэрэг худгийн байнгын ажиллагааны зардлыг хариуцах
  - Худгийн операторчныг малчдын бүлгийн гишүүдээс томилох, худгийн операторчин нь Малчдын бүлгийг төлөөлж тухайн худгийг гардан ажиллуулах, худаг хэрэгслийн бүртгэл хөтлөх, шаардлагатай засвар, үйлчилгээ хийлгэхээр Малчдын бүлэгт мэдэгдэх, жижиг засварыг өөрөө хийж байх
  - Худгийн ердийн элэгдэл, хорогдлоос бусад эвдрэл, гэмтэл, хулгайд тоногдох зэргийг Засаг дарга болон Засаг Даргын Газрын холбогдох албан хаагчид мэдэгдэж байх
  - Малчдын бүлгийн үйл ажиллагаатай холбоотой бүртгэл хөтлөх, шаардлагатай бол төрийн эрх бүхий албан тушаалтанд уг мэдээллийг өгөх
  - Энэхүү гэрээний дагуу хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг хариуцан Сум хөгжүүлэх санд шилжүүлэх.
  - Гэрээнд заасан хугацаанд эргэн төлөх төлбөрөө хугацаанд нь төлөх, эргэн төлөх төлбөрөө төлөөгүй бол дутуу төлсөн төлбөрийн үнийн дүнгээс бодож хоног тутамд 0,3 хувийн алданги төлөх Тайлбар: Алданги төлөх нь энэ гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх болон зөрчлийг арилгахаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
  - Малчдын бүлэг гэрээгээр ашиглаж буй талбайгаа бүхэлд нь хашихгүй байх
  - Энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүргээ биелүүлнэ.
-

### 3 Талуудын хариуцлага

Гэрээнд талуудын хариуцлага гэж тусгайлсан нөхцөл болгож тусгаагүй ч гэрээний бусад гэсэн хэсэгт хариуцлагын агуулгатай дараах нөхцөлүүд байна. Үүнд:

- Засаг даргаас даалгасны дагуу даргын тамгын газраас томилсон төрийн эрх бүхий албан хаагч болон малчдын бүлгээс сонгогдсон төлөөлөгч нар бэлчээр, худаг ашиглалт, хөрөнгө оруулалтын эргэн төлбөрийн хэрэгжилтийг хангаж, хянаж, зохион байгуулна. Засаг даргаас даалгасны дагуу гэрээний хэрэгжилтэд холбогдох төрийн албан хаагчид хяналт тавина.
- Гэрээний хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа Малчдын бүлгээр хэлэлцэж, талууд дүгнэж байна.
- Талууд харилцан бие биедээ санал, хүсэлт, гомдлын шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор хянан шийдвэрлэж, хариу өгнө. Талууд албан бичгээр харьцсаныг албан ёсны мэдэгдэл гэж үзнэ.
- Засаг дарга солигдсон нь гэрээг цуцлах, дуусгавар болгох, түүний нөхцөлийг өөрчлөх үндэслэл болохгүй.
- Аль ч тал нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг нөгөө талдаа урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлж болохгүй.

### 4 Гэрээний хугацаа, гэрээг сунгах, цуцлах

#### Гэрээг цуцлах талаар:

- Гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.
- Гэрээнд заасан бэлчээр болон худгийг гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй, дахин сэргэшгүйгээр эвдэж гэмтээсэн, бусдад худалдсан.
- Гэрээнд заасан нөхцөлийг биелүүлээгүй нь баримтаар нотлогдсон
- Гэрээний дагуу оруулсан хөрөнгийг Малчдын бүлэг гэрээнд заасны дагуу төлөх ёстой эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөөгүй, эсхүл төлөхөөс татгалзсан
- Засаг дарга нь Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу олон нийтийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа болон хууль ёсны эрх бүхий лицензтэй уул уурхайн ашиглалтын үйл ажиллагааг тухайн газарт явуулах зорилгоор гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд Засаг дарга 6 сарын өмнөөс албан ёсны мэдэгдлийг Малчдын бүлэгт мэдэгдэж, Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу малчдын бүлэгт оруулсан бүх хөрөнгө оруулалт болон алдсан орлогод нь нөхөн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгуулна.
- Ашиглаж буй газраа доройтолд хүргэж, энэхүү гэрээ болон төлөвлөгөөг зөрчиж малын тоо толгойг хэтрүүлсэн
- Гэрээнд заасан үндэслэлээс бусад тохиолдолд Засаг дарга нь гэрээг өөрийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцалж болохгүй.
- Малчдын бүлэг нь Иргэний хуулийн 288.2.3-т зааснаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахаар бол энэ тухайгаа 1 сараас доошгүй хугацааны өмнө Засаг даргад мэдэгдэнэ.

#### Гэрээний хугацаа сунгах талаар:

- Малчдын бүлэг нь гэрээг сунгах хүсэлтэй байгаа бол гэрээний хугацаа дуусахаас 2 сарын өмнө Иргэний хуулийн 296.2-т зааснаар өргөдлөө Засаг даргад бичгээр гаргана. Засаг дарга уг өргөдлийг хүлээн зөвшөөрсөн бол энэ тухайгаа өргөдөл хүлээн авснаас хойш 3 сарын дотор бичгээр мэдэгдэнэ. Ингэсэн тохиолдолд гэрээг 15 жилийн хугацаагаар сунгасанд тооцно.

### **Засаг дарга, бэлчээр ашиглагчдын хэсэгтэй байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээ**

#### 1 Өмчлөгчийг төлөөлж буй ашиглуулагч (Засаг дарга)-ийн эрх, үүрэг

- Бэлчээр ашиглалт, бэлчээрийн төлөв байдалд тогтмол хяналт тавьж, цаг үеийн байдал хүндэрсэн үед бэлчээр ашиглагчийн бэлчээрийн даацад тохируулан отор

- нүүдлийг зохион байгуулах;
- Ашиглагч болон бусад этгээд гэрээт бэлчээрийн төлөв байдлыг доройтуулах, хохирол учруулсан, даац хэтрүүлсэн тохиолдолд буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, хохирлыг арилгуулах талаар шийдвэр гаргах, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах ;
- Энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол бэлчээрт хөрөнгө оруулалт (худаг, уст цэг гаргах, хороо засах) хийхийг ашиглагчаас шаардах ;
- Ашиглагчийн гэрээнд заасан эрхийг бусад этгээд зөрчвөл гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх ;
- Бэлчээрт үзүүлэх нөлөөллийг үндэслэн тогтоосон атлаа нөхөн төлбөрийг тогтоох, хуримтлагдсан санг бэлчээр зохион байгуулалт, мал сүргийн чанар, эрүүл мэндийг сайжруулах эрсдэлээс хамгаалах арга хэмжээнд зарцуулах

## **2 Бэлчээр ашиглагч (Бэлчээр ашиглагчдын хэсэг –БАХ гэх)-ийн эрх, үүрэг**

- Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтаар батлагдсан төлөвлөгөөний дагуу зохистой ашиглах ;
- Гэрээний хугацааг сунгуулахаар ашиглуулагчид хүсэлт гаргах ;
- Бэлчээрт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр шаардах ;
- Гэрээнд заасан бэлчээрийг бусад этгээд дур мэдэн ашигласан бол энэ талаарх үйл ажиллагааг зогсоох талаар шаардлага тавих ;
- Бэлчээрт байлгавал зохих малын тоо (хонин толгойд шилжүүлснээр)-г гэрээнд заасан даацад тохируулах, төлөв байдлыг суурь түвшин (хавсралт №...)-ээс нь доройтуулахгүйгээр ашиглах;
- Бэлчээрт үзүүлэх нөлөөллийг үндэслэн тогтоосон аливаа нөхөн төлбөрийг төлөх, хуримтлалын сангаас ашиг хүртэж, бэлчээр зохион байгуулалт, мал сүргийн чанар, эрүүл мэндийг сайжруулах эрсдэлээс хамгаалах арга хэмжээнд зарцуулах
- Гишүүнчлэл солигдсон нөхцөлд өмчлөгчид мэдэгдэх.
- Малчид хариуцлагатай байх сэлгэх, өнжөөх хариуцлага тооцох журмыг хэлэлцэн батлан мөрдөх

## **3 Талуудын хариуцлага**

- Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хууль болон холбогдох хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээнэ.
- Гэрээний хариуцлагатай холбоотой бусад асуудлыг талууд зөвшилцөн шийдвэрлэж болно.

Гэрээнд хариуцлагын нөхцөлд шууд тусгаагүй боловч хариуцлагын агуулгатай дараах нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

### **Хориглох зүйлийн талаар:**

- Байгаль орчинд хохирол учруулах аливаа үйл ажиллагаа явуулах
- Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтаар гэрээгээр олгогдсон бэлчээрийг бусдын мал бэлчээх, дайран өнгөрөхөд саад болох хэмжээнд хаших
- Хүн, малын үндны усны зориулалтаар худаг гаргахаас өөр зорилгоор бэлчээрийн хэвлийг хөндөх
- Бэлчээрт сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулах
- Өвөлжөө, хаваржааны доорх газрыг болон гэрээгээр ашиглалтад олгогдсон бэлчээрийг барьцаалах, худалдах, бэлэглэх
- Талууд бэлчээр, түүнтэй дагалдах бусад эд хөрөнгө болон тоног төхөөрөмжийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь бусдад шилжүүлэх, түрээслэх, худалдах.

### **Бэлчээр ашиглах эрх дуусгавар болох талаар:**

- Гэрээний хугацаа дүссэн бөгөөд талууд гэрээг сунгах тухай хүсэлт гаргаагүй.
- Бэлчээр ашиглагч гэрээг БАХ-ийн малчдын 60 хувь нь цуцлах хүсэлт гаргасан.

- Бэлчээрийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эрх ашигласан нь тогтоогдсон.
- Гэрээний хугацаа дууссан бөгөөд талууд гэрээг сунгах тухай хүсэлт гаргаагүй.
- Бэлчээр ашиглагч БАХ-ын малчдын 60 хүртэлх хувь нь цуцлах хүсэлт гаргасан.
- Бэлчээрийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан нь тогтоогдсон.

#### **4 Гэрээний хугацаа, гэрээг сунгах, цуцлах**

##### **Гэрээг цуцлах талаар:**

- Гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.
- Бэлчээр ашиглах гэрээний үүргийг бэлчээр ашиглуулагчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх, зориулалтын дагуу ашиглаагүй, худаг зэрэг бэлчээрийн мал маллагааны дагалдах хэрэглэгдэхүүнийг дахин сэргэшгүйгээр эвдэж гэмтээсэн.
- Гэрээний үүргээ биелүүлээгүй, удаа дараа, ноцтой зөрчсөн нь баримт, эрх бүхий байгууллагын эрх зүйн баримт бичгээр нотлогдсон
- Гэрээнд зааснаас бусад тохиолдолд бэлчээр ашиглуулагч нь өөрийн санаачилгаар хугацаанаас нь өмнө гэрээг цуцлахыг хориглоно.

#### **Засаг дарга, нөхөрлөлтэй байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээ**

##### **1 Өмчлөгчийг төлөөлж буй ашиглуулагч (Засаг дарга)-ийн эрх, үүрэг**

- Бэлчээрийн газар ашиглах эрх нь талууд гарын үсэг зурж баталгаажсанаар хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээний Хавсралтаар заасан Газрын зургаар нөхөрлөлд хүлээлгэн өгнө.
- Өмчлөгч нь Нөхөрлөлтэй хамтран тухайн бэлчээрт байх малын тоог хонин толгойгоор жил бүр тогтоож төлөвлөж хэрэгжилтэд хяналт тавина. Нөхөрлөл нь энэ гэрээний 4.1-т заасан журмын дагуу 3 жилийн дараа бэлчээрийн даацад тохирсон малтай байна. Бэлчээрийн даацыг жил бүр тогтоож, гэрээт бэлчээрт байх малын тоог хонин тогойгоор бодож тогтооно. Энэ үйл ажиллагаа нь ургамлын гарц, чанар, хөрс, усны эх үүсвэр, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах болон бэлчээрийг тогтвортой ашиглах зорилготой.
- Өмчлөгч нь тогтоосон хугацаанд нөхөрлөлөөс Менежментийн төлөвлөгөө боловсруулахыг шаардах эрхтэй.
- Энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол Өмчлөгч нь бэлчээр, худаг, хашаанд хийх засвар, үйлчилгээг Нөхөрлөлөөс өөрийн хөрөнгөөр хийхийг шаардах эрхтэй.
- Өмчлөгч нь Нөхөрлөлийн бэлчээрийн газар ашиглах хууль ёсны эрхийг хамгаалж бэлчээрийг гэрээнд зааснаас бусад иргэн, аж ахуйн нэгжид ашиглуулахгүй байх нөхцөлийг хангана. Энэ нөхөрлөлийн хилээс гадагш хоёр (2) километр дотор усны эх үүсвэрийг бохирдуулах үйл ажиллагаа явуулах үүл уурхайн компани болон бусад иргэн, аж ахуйн нэгжид ашиглуулахгүй байх нөхцөл орно.
- Нөхөрлөл нь тухайн бэлчээрийн газрыг ашиглах эрхтэй ба хэрэв бусад малчид энэ эрхийг хөндвөл Өмчлөгч гэрээний болон холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн малчдад хариуцлага хүлээлгэнэ.

##### **2 Бэлчээр ашиглагч (нөхөрлөл)-ийн эрх, үүрэг**

- Нөхөрлөл нь бэлчээрийг энэ гэрээнд заасан нөхцөл болон зориулалтаар ашиглаж, бэлчээрийн даацад малын тоог тохируулан, мал сүргээ эрүүлжүүлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, хүдгийн ашиглалт хамгаалалтыг хариуцах, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулж, бүрэн бүтэн байдлыг хангана. Нөхөрлөл нь гэрээгээр ажиллаж буй бэлчээрт байх малын тоог энэ гэрээний 3.2-т заасан дагуу Өмчлөгчөөс тогтоосон хэмжээнд барих үүрэг хүлээнэ. Бэлчээрийн төлөв байдал сайжрахгүй байгаа нөхцөлд Өмчлөгч нь энэ хэмжээг бууруулах эрхтэй.
- Нөхөрлөл нь бэлчээрийн чанар, хөрсний үржил шим, ургамлын бүрхэвч, бүрэлдэхүүн алдагдах, хөрс элэгдэх, хатах, хэт усархаг буюу шүлтлэг болох, хөрс бохирдох, хордох



---

зэрэгт нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй.

- Нөхөрлөл нь дараах нөхцөлөөс бусад үед ашиглаж буй бэлчээрээс бусад малчдыг өвс, хадлан бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах, мал бэлчээхийг хориглох эрхтэй.
- Мал дайран өнгөрөх
- Өмчлөгчтэй тохиролцсоны дагуу байгалийн гамшгийн үед бэлчээрийн даацад зохицуулан мал оруулах
- Нөхөрлөл нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой шаардлагуудыг дагаж мөрдөнө.
- Нөхөрлөл нь жил бүр менежментийн төлөвлөгөөндөө бэлчээрийн арга хэмжээг тусган боловсруулж хэрэгжүүлнэ.
- Нөхөрлөл нь энэ гэрээгээр хүлээн авсан газар, бусад эд хөрөнгө болон тоног төхөөрөмжийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь нөхөрлөлийн гишүүдийн зөвшөөрөлтэйгөөр бусдад дамжуулан ашиглуулахыг хориглоно.

### **3 Талуудын хариуцлага**

Гэрээнд талуудын хариуцлага гэж тусгайлсан нөхцөл болгож тусгаагүй ч гэрээний бусад гэсэн хэсэгт хариуцлагын агуулгатай дараах нөхцөлүүд байна. Үүнд:

- Талууд харилцан бие биедээ санал, хүсэлт, гомдлын шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор хянан шийдвэрлэж, хариу өгнө.
- Өмчлөгч солигдсон нь гэрээг цуцлах, дуусгавар болгох, түүний нөхцөлийг өөрчлөх үндэслэл болохгүй.
- Аль ч тал нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг нөгөө талдаа урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлж болохгүй.

### **4 Гэрээний хугацаа, гэрээг сунгах, цуцлах**

**Гэрээг цуцлах талаар:**

- Гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.
- Гэрээнд заасан бэлчээр болон худгийг гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй, дахин сэргэшгүйгээр эвдэж гэмтээсэн, бусдад худалдсан.
- Гэрээнд заасан нөхцөлийг биелүүлээгүй нь баримтаар нотлогдсон
- Өмчлөгч нь Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу олон нийтийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа болон хууль ёсны эрх бүхий лицензтэй уул уурхайн ашиглалтын үйл ажиллагааг тухайн газарт явуулах зорилгоор гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд Өмчлөгч 6 сарын өмнөөс албан ёсны мэдэгдлийг нөхөрлөлд мэдэгдэж, Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу оруулсан бүх хөрөнгө оруулалт болон алдсан орлогод нь нөхөн төлбөр олгоно.
- Ашиглаж буй газраа доройтолд хүргэж, энэхүү гэрээний журамд заасан малын тоо толгойг хэтрүүлсэн
- Гэрээнд зааснаас бусад тохиолдолд Өмчлөгч нь гэрээг өөрийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцалж болохгүй.
- Нөхөрлөл нь Иргэний хуулийн 288.2.3-т зааснаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахаар бол энэ тухайгаа 1 сараас доошгүй хугацааны өмнө Өмчлөгчид мэдэгдэнэ.

**Гэрээний хугацаа сунгах талаар:**

Бэлчээрийн газар ашиглагч нөхөрлөл нь гэрээг сунгах хүсэлтэй байгаа бол гэрээний хугацаа дуусахаас 2 сарын өмнө Иргэний хуулийн 296.2-т зааснаар өргөдлөө Өмчлөгчид бичгээр гаргана. Засаг дарга уг өргөдлийг хүлээн зөвшөөрсөн бол энэ тухайгаа өргөдөл хүлээн авснаас хойш 3 сарын дотор бичгээр мэдэгдэнэ. Ингэсэн тохиолдолд гэрээг 3 жилийн хугацаагаар сунгасанд тооцно.

---

**Дүгнэлт 1. Газар (хадлан, бэлчээр)-ын ашиглалт, хамгаалалтын гэрээнд хийсэн үнэлгээ**



№	Шалгуур үзүүлэлт	Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль эрх зүйн орчинд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах эрх зүйн үндэслэл
1	Бэлчээр ашиглах арга, хэлбэр, эрх зүй	<p>Монгол Улсын Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-т <b>“Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ...”</b> гэж заасан нь үндсэн хоёр чиглэлийн хууль зүйн агуулгатай юм. <i>Нэгдүгээрт</i>, Зуслан, намаржаа, отрын бэлчээрийг багаар нь болон хот айлаар тодорхой хуваарьтайгаар ашиглах, <i>хоёрдугаарт</i>, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг тодорхой горим журамтай ашиглах эрх зүйн үндэслэлтэй байна.</p> <p>Монгол Улсын Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т <b>“...Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно”</b> заасан зохицуулалтад үндэслэж, Багийн ИНХурал хэлэлцэж шийдвэрлээд тухайн сумын Засаг дарга нь бэлчээрийг малчдын хэсэг, бүлэгт гэрээгээр ашиглуулж болох асуудлыг Газрын тухай хуульд хуульчилсан байна.</p>
2	Бэлчээр ашиглалтын гэрээ нь хууль ёсны байх	<p>Сумын Засаг дарга, хэсэг бүлэг болсон малчдын хамтын байгууллага нь холбогдох хуульд заасан үндэслэл, журмаар бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар харилцан тохиролцож бичгийн хэлбэрийн гэрээ байгуулах нь хууль ёсны эрх зүйн баримт бичиг болохыг илэрхийлнэ. Иймд хууль ёсны гэрээ байгуулж хэрэгжүүлэх шаардлага үүсэх үндэслэлтэй тул талууд гэрээнд заасан үүргээ биелүүлэх, эс биелүүлсэн нөхцөлд хууль зүйн хариуцлага хүлээх, гэрээнээс үүсэх маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэх, эс шийдвэрлэж чадвал эрх бүхий байгууллагын оролцоотой хянан шийдвэрлэх бололцоотой эрх зүйн баримт бичиг байх нь чухал.</p>
3	Гэрээний субъект	<p>Үндсэн хуульд бэлчээр нь төрийн өмч гэх агуулгаар хуульчилсан тул орон нутагт төрийн өмчийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч үндсэн субъект бол сумын Засаг дарга байна. Үндсэн хууль, Иргэний хуульд зааснаар өмчийн төрөл, хэлбэрээр авч үзвэл мал хувийн өмч тул малчин өрх, малчдын хамтын зохион байгуулалтын нэгж бэлчээрийг ашиглагч субъект болно. Бэлчээрийг хамтран ашиглах тохиолдолд уг субъектийн эрх зүйн статусыг Монгол Улсын Иргэний хуулийн 481-р зүйлийг үндэслэл болгох нь зүйтэй.</p> <p>Харин зорилтот аймгийн сумдад бэлчээр ашиглагч субъектийг дараах хоёр төрлөөр авч үзсэн нь анхаарал татахуйц байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг /БАХ/-т бэлчээр ашиглуулах гэрээ байгуулсан ба энэ нь холбогдох хуульд заасан үндэслэл, журамд нийцсэн байна.</li> <li>- Малчдын оролцоотой нөхөрлөлд бэлчээрийг ашиглуулах гэрээ байгуулсан тохиолдол байгаа бөгөөд энэ нь хууль зүйн талаас үзэхэд нөхөрлөл байгуулах эрх зүйн орчны хүрээнд бэлчээр ашиглалтын үйл ажиллагааг давхар оруулан нөхөрлөлийн хүрээнд бэлчээрийг ашиглах, хамгаалах ажлыг хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр гэж үзсэн.</li> </ul>
4	Бэлчээр	Монгол Улсын Иргэний хуулийн 481.1-т <b>“Хамтран ажиллах гэрээний</b>

ашиглагч субъектийн зохион байгуулалт	<p><b>үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно”</b> гэж заасны дагуу бэлчээр ашиглагч субъектийн эрх зүйн статус нь тодорхойлогдох тул эрх зүйн харилцаанд оролцож эрх эдэлж, үүрэг хүлээх нөхцөл бүрдэнэ. Бэлчээр ашиглагчдын хэсэг, бэлчээр ашиглагчдын бүлэг, малчдын хэсэг, малчдын бүлэг хэмээн янз бүрээр нэрлэгдэж буй малчдын хамтын зохион байгуулалтын хэлбэрүүдийн <b>хамтран ажиллах үйл ажиллагааны үндсэн асуудал нь:</b></p>	
	<ul style="list-style-type: none"> <li>- бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаагаа нэгдсэн зохион байгуулалттайгаар явуулах зорилготой,</li> <li>- улсын эрхийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй,</li> <li>- бүтэц, зохион байгуулалтаа дотоод дүрэм, журмаараа харилцан тохиролцдог зохион байгуулалтын хэлбэр юм.</li> </ul>	
	<p><b>Иргэний хуульд заасан зохицуулалтаар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- малчдын зохион байгуулалтын хэлбэр нь заавал улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж гэрчилгээ, тамга тэмдэгтэй байхыг шаардаагүй,</li> <li>- хэсэг бүлэг малчин өрх, малчид хамтраад бэлчээрээ зүй зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтад орох,</li> <li>- тухайн хамтарсан малчин өрх, малчид нь өөрсдийн бүтэц, зохион байгуулалтаа хийхдээ гишүүд хэлэлцэж дотоод дүрэм, журам боловсруулан хэрэгжүүлэх боломжтой.</li> </ul>	
	<p>Дээрх үндэслэлээр эрх зүйн харилцаанд оролцогч субъект хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байгаа тул хэн нэгэн этгээдтэй гэрээ байгуулж, гэрээнд заасан эрхээ эдлэх, үүргээ хүлээх, мөн хариуцлага хүлээх боломж бүрдэнэ. Иргэний хуулийн энэхүү зохицуулалттай холбогдсон бас нэг чухал асуудал бол мөн хуулийн 481.2-т <b>“Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл нь иргэний эрх зүйн харилцаанд бүрэн эрх бүхий төлөөлөгч буюу гишүүдээр дамжин оролцоно”</b> гэсэн хэм хэмжээ бол тухайн малчдын байгууллага дарга /ахлагч/, гишүүдээрээ дамжуулж эрх зүйн харилцаанд оролцох эрхтэй.</p>	
5	Объект	Бэлчээрийг гэрээгээр ашиглах нь зохистой.
6	Бэлчээр ашиглах гэрээ, түүний агуулга	<p>Гэрээний талууд харилцан тохиролцож хэлэлцсэний үндсэн дээр тухайн <b>бэлчээрийг</b> ашиглахтай холбогдсон харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хууль зүйн хариуцлага, бэлчээрийг ашиглах хугацаа, нөхцөл, арга, хэлбэр гэх зэрэг бэлчээрийг малчдын хамтын байгууллага дундаа хамтран ашиглахтай холбогдох харилцааг гэрээгээр зохицуулах бодит боломж бий.</p>
<b>Бэлчээр ашиглах гэрээний үндсэн нөхцөлүүд</b>		
7	Нийтлэг үндэслэл	<p>Уг гэрээг байгуулахад баримтлах хэм хэмжээ (Монгол Улсын хууль тогтоомж)-нд үндэслэнэ. Үндэслэл хэсгийн хэм хэмжээг зөв тогтоосноор гэрээгээр зохицуулсан харилцаа төдийгүй, зохицуулаагүй орхигдсон харилцааг иш татсан хууль тогтоомжоор зохицуулах нөхцөл бүрддэг тул гэрээний чухал нөхцөл бол нийтлэг үндэслэл хэсэг байдаг. Иймд холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн зүйл, заалтыг зөв тусгах шаардлагатай.</p>
8	Гэрээний зорилго	Гэрээгээр зохицуулагдах харилцааг тодорхойлно.

9	Өмчлөх эрхийн агуулга	Засаг дарга гэрээгээр ашиглалтад олгосон хэмжээтэй бэлчээрийг малчдын хамтын байгууллагад ашиглуулах эрхээр хангана. Гэрээ байгуулах үед гэрээнд заасан бэлчээрийн газар нь бусдын ашиглалтад олгогдоогүй, барьцаалагдаагүй, битүүмжлэгдээгүй, түрээслэгдээгүй байх бөгөөд түүнтэй холбоотой өмчийн ямар нэгэн маргаан байхгүй болохыг Засаг дарга баталгаажуулах нь зүйн хэрэг. Гэрээг байгуулахаас өмнө малчдын хамтын байгууллагын ахлагч нь гишүүдийн хурлаар гэрээний нөхцөлүүдийг танилцуулж энэ талаар хэлэлцэн, гишүүдийн гаргасан саналд үндэслэн өмчлөгчтэй гэрээ байгуулах хэрэгтэй. Учир нь гэрээ байгуулах процесс нь талуудын хүсэл зоригийн илэрхийллийн зарчимд суурилсан байхыг шаарддаг.
10	Бэлчээрийн хэмжээ, нэр, байршил	Тухайн бэлчээрийн газрын оноосон нэр, байршлуудаас гадна ашиглах бэлчээрийн талбайн га-гийн хэмжээг гэрээнд тусгана.
11	Бэлчээрийн зураглал	Гэрээний хавсралтад оруулж уг гэрээний салшгүй хэсэг болохыг гэрээний үндсэн нөхцөл болгож тусгах нь зүйтэй.
12	Бэлчээрийн даац, уг бэлчээрт байх малын тоо	Бэлчээрийг хамгаалах үндсэн хөшүүрэг нь бэлчээрийн даацын асуудлыг гэрээнд тусгах шаардлагатай. Иймд тухайн бэлчээрт адгуулах малын тоог гэрээнд зааж өгөх нь гэрээний үндсэн нөхцөлүүдийн нэг болох юм.
13	Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө	Гэрээгээр малчдын хамтын байгууллагын ашиглалтад олгогдсон бэлчээрийг ашиглаж, үр шимийг нь хүртэхдээ тухайн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг гаргаж ашиглах нөхцөлийг тусгах нь бэлчээрийг эмх цэгцтэй, хуваарьтай, бодлого төлөвлөлттэй ашиглах нөхцөл бүрдэнэ.
14	Байгаль орчны үнэлгээ	Үүнийг гэрээнд тусгах шаардлагатай. Анх ашиглалтад олгогдох бэлчээрт мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг хавсралт болгон тусгах нь чухал юм.
15	Хөршийн эрх, үүрэг	Нэг талаар хөршийн эрхийг зөрчихгүй байх, нөгөө талаар өөрийн эрхийг хязгаарлахгүй байх нөхцөлийг тусгах нь зүйтэй.
16	Малчдын байгууллагын эрх, үүрэг	Бэлчээрийг зохистой ашиглагч, хамгаалагч үндсэн субъект нь малчдын хамтын байгууллага тул бэлчээр ашиглалтын гэрээнд тэдний эдлэх эрх, хүлээх үүргийг зайлшгүй тусгах шаардлагатай.
17	Засаг даргын эдлэх эрх, хүлээх үүрэг	Засаг даргын эрх хэмжээг гэрээнд зааж өгөхдөө түүний албан үүрэгтэй нь холбогдуулан тус суманд хэрэгжүүлэх бэлчээрийн харилцаанд баримтлах бодлогын түвшинд тусгах нь илүү ач холбогдолтой. Засаг даргын бэлчээр ашиглалтад хүлээх үүргийг бас үялдуулан тусгах хэрэгтэй.
18	Бэлчээр ашиглах хугацаа	Газрын хуульд заасан газар эзэмших, ашиглах эрхийн хугацааг жишиг болгохоос гадна тухайн гэрээний талууд харилцан тохиролцож бэлчээр ашиглалтын хугацааг тохиролцоно.
19	Талуудын хүлээх хариуцлага	Бэлчээр ашиглалтын гэрээнд хариуцлагын нөхцөлийн талаар тусгахдаа холбогдох хуульд (Зөрчлийн тухай хууль) заасан үндэслэлээр хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх боломжтой.
20	Газрын даамлын эрх, үүрэг, хариуцлага	Газрын даамлын эрх, үүргийг тусгайлан заах боломжгүй боловч газрын даамалд тухайн гэрээгээр ашиглалтад олгогдсон бэлчээрийн газрын зургийг газрын бүртгэлд оруулах асуудлыг гэрээнд тусгах боломжтой.
21	Форс - мажор	Байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн үлмаас үүсэх нөхцөл байдлыг зайлшгүй тусгах нь эрсдэлээс хамгаалах боломжийг бүрдүүлэх тул гэрээнд тусгах нь зүйтэй.

22	Маргаан шийдвэрлэх механизм	Газрын тухай хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг дарга шийдвэрлэх ба шийдвэрийг эс хүлээн зөвшөөрвөл дээд шатны Засаг дарга шийдвэрлэх зохицуулалтад тулгуурлана. Хэрэв бэлчээр ашиглалтын гэрээтэй холбогдон маргаан гарвал нэн тэргүүнд маргалдагч талууд харилцан тохиролцох, эс тохиролцвол Газрын тухай хуульд заасан үндэслэлээр шийдвэрлэх боломжийг тусгах нь зүйтэй.
24	Бусад	Гэрээг үйлдсэн хувь, гэрээ хүчин төгөлдөр болох, талууд гарын үсэг зурах зэрэг нөхцөлийг тусгах.

## 2.6. Байгалийн нөөц (ой, ойн сан) эзэмших, ашиглах гэрээнд хийсэн дүн шинжилгээ:

Дорнод аймагт 7 сумын 40 нөхөрлөл, Сүхбаатар аймагт 4 сумын 5 нөхөрлөл тус бүр байгуулагдаж, байгалийн нөөц - ой, ойн санг гэрээгээр эзэмших, ашиглах, хамгаалах хууль зүйн нөхцөл бүрдсэн байна.

Эдгээр нөхөрлөлүүдийн байгуулсан ойн санг эзэмших гэрээ, гэрчилгээ, Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл байгуулахыг дэмжсэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон хамаарал бүхий гэрээнд баримт бичгийн дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2009 онд баталсан “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”, БОАЖСайдын Журам, гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай 2010 оны А250 дугаар тушаал (нэгдүгээр хавсралтаар Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийн баримтлах журмыг, хоёрдугаар хавсралтаар иргэдийн нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээний загварыг, гуравдугаар хавсралтаар иргэдийн нөхөрлөлийн гэрчилгээний загварыг, дөрөвдүгээр хавсралтаар Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөлийн талаар авах зарим арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан)-ыг тус тус баримтлан нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсан байх тул дээрх баримт бичгүүдийг тухайн сумын нөхөрлөлүүдэд үндсэндээ ижил загвараар боловсруулагдсан байна. Гэсэн хэдий ч зарим гэрээ, сумын ИТХ-ын тогтоол, сумын Засаг даргын захирамж гэх мэт баримт бичгүүдийн үндэслэл болгосон хуулийн хэм хэмжээ, гэрээний агуулга ялгаатай байх тул цаашид БНХМБ болох нөхөрлөл байгуулагдсан сумдын баримт бичгүүдийг харьцуулан судалж үзэн дараах үнэлгээг хийсэн. Үүнд:

**Гэрээнд ойн нөөцийн менежментийн зохицуулалт тусгагдсан эсэх үнэлгээ хийсэн талаар:**

- Ойн санг эзэмшүүлэх гэрээнд ойн менежментийн төлөвлөгөөг хавсралтаар тусгасан ба уг төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд дараах агуулгатай байна. Үүнд:
- Нөхөрлөлийн байршил,
- Нөхөрлөлийн хүний нөөц,
- Нөхөрлөлийн малын тоо
- Нөхөрлөлийн гэрээт бэлчээрийн газрын хэмжээ,
- Нөхөрлөлийн зохистой ашиглах, хамгаалахаар гэрээ байгуулсан байгалийн нөөцийн төрөл

- Төлөвлөгөөний зорилго,
- Нөхөрлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа: нөхөрлөлийн удирдлага, зохион байгуулалт, хамтын үйл ажиллагаа,
- Нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, шинэ ажил, үйлчилгээ эрхлэх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөрлөлийн бизнес, маркетингийн ур чадварыг сайжруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх, малын эрүүл мэнд, малын тэжээл, хашаа байр бэлтгэх, эрдэл, бизнесийн үйл ажиллагаа, ургамал, ан амьтан хамгаалах, маргаан зөрчил гэх мэт асуудлуудыг багтаажээ.

**Гэрээнд байгалийн гамшигт үзэгдэл, онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан эсэхэд үнэлгээ хийх талаар**

- Судалж үзсэн Гэрээнд тодорхой заалт тусгагдаагүй

**Талуудын гэрээгээр хүлээж буй үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг хэрхэн үнэлж, дүгнэж, гэрээг хэрхэн сунгадаг болон цуцалдаг талаар**

- Нөхөрлөлийн эрх, үүрэг
- Талуудын хүлээх хариуцлага
- Гэрээгээр эзэмших ойн талбайн хилийн цэс, байршил, тархалтын зураг
- Гэрээгээр эзэмших ойн санг хүлээлгэн өгсөн тухай акт.

**Байгалийн нөөц (ой, ойн сан) эзэмших, ашиглах гэрээгээр хүлээж буй талуудын үүрэг, хариуцлага, хугацааны талаарх нийтлэг нөхцөлүүдийг бүлэглэн судлахад:**

<b>I.</b>	<b>Нөхөрлөлийн ойн санг эзэмших гэрээ /Засаг дарга, нөхөрлөлийн ахлагчтай байгуулсан гэрээ/</b>
<b>1</b>	<b>Өмчлөгчийг төлөөлж буй ашиглуулагч (Засаг дарга)-ийн үүрэг</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Засаг дарга нь ойн санг эзэмшигч нөхөрлөлд акт үйлдэн хүлээлгэн өгөх ба уг акт нь гэрээний салшгүй хэсэг болно. Актанд эзэмших ойн сангийн талбайн хэмжээ ба түүнд байгаа ургамал, амьтны аймаг бусад байгалийн баялгийн нөөц, төлөв байдлыг тодорхойлсон байна. Акт нь ойн ацсанг эзэмших үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарч, эзэмшлийн ойн сангийн хэсгийг буцаан хүлээн авах тохиолдолд харьцуулах үндсэн баримт бичиг болно.</li> </ul>
<b>2</b>	<b>Ойн санг эзэмшигч, ашиглагч (нөхөрлөл)-ийн үүрэг</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Нөхөрлөл нь ойн санг эзэмших гэрээ байгуулахдаа байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 8 дугаар бүлгийг удирдлага болгон БНХНМ-ын зарчим, ... гэх мэт нөхөрлөлийн хамаарах асуудлыг зохицуулах дүрэмтэй болсон байх.</li> <li>- Эзэмшлийн талбайдаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах</li> </ul>
<b>3</b>	<b>Талуудын хариуцлага</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээ байгуулсан талуудын хооронд үүссэн маргааныг сум /дүүрэг/-ийн иргэдийн төлөөлөгчдийн хурал шийдвэрлэх ба уг шийдвэрийг үл зөвшөөрвөл шүүхэд хандах эрхтэй.</li> <li>- Нөхөрлөл нь эзэмшиж буй ойн сангаасаа мод болон ойн дагалт нөөцийг хууль бусаар ашигласан нь эрүүгийн болон захиргааны хэргийн шинжгүй, ойн санд хортой нөлөөлөл үзүүлсэн, нөөц баялгийн нөхөн сэргээгдэх боломжийг алдагдуулсан буюу нөхөн сэргээлт хийгээгүй нөхцөлд Засаг дарга гэрээг цуцлах, гарсан хохирлыг нөхөрлөлийн хөрөнгөөр бүрэн арилгуулахын хамт тэдгээрийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авна.</li> </ul>
<b>4</b>	<b>Гэрээний хугацаа, гэрээг сунгах, цуцлах</b>
	<p>Гэрээг 5 жилийн хугацаагаар байгуулсан байна.</p> <p>Гэрээний хугацааг сунгах талаар нөхөрлөлийн эрхэд тусгасан байна.</p>

<b>II.</b>	<b>Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн байгаль, ан амьтан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ</b> <i>/Засаг дарга, нөхөрлөлийн ахлагчтай байгуулсан гэрээ/</i>
<b>1</b>	<b>Өмчлөгчийг төлөөлж буй (Засаг дарга)-ийн эрх, үүрэг</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Нөхөрлөлийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэвийн явуулах нөхцөл, бололцоогоор хангана</li> <li>- Нөхөрлөлийн гэрээт газар дээр гарсан түймэр, байгалийн голомтод халдварт өвчин, бусад аюул гамшгийн хор үршгийг арилгуулах, шаардлагатай гэж үзвэл энэ ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж туслалцуулна.</li> <li>- Бусад аж ахуйн нэгж, байгууллага иргэнд гэрээт газрын нутаг дэвсгэрээс ан амьтан агнах, барих, ургамал түүх цуглуулах зэргээр байгалийн тодорхой нөөц баялгийг ашиглах зөвшөөрөл олгохдоо энэхүү гэрээнд заасны дагуу ирүүлсэн нөхөрлөлийн саналыг иш үндэс болгон үг асуудлыг нөхөрлөлтэй зөвшилцөж тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.</li> <li>- Гэрээнд заасан үүрэг болон менежментийн төлөвлөгөөнд тусгасан ан амьтныг зохистой ашиглах хамгаалах заалттай зөрчилдөхөөр бол гэрээт газрын нутаг дэвсгэрээс бусад аж ахуйн нэгж, байгууллага иргэнд ан амьтан агнуулах, барих, ургамал түүх, цуглуулах зэрэг байгалийн нөөц баялгийг ашиглах зөвшөөрөл олгосноос татгалзвар эрхтэй.</li> <li>- Нөхөрлөлийн гишүүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь олон нийтэд тайлбарлан таниулах чиглэлийн сургалт мэдээлэл, сурталчилгааны ажлыг тодорхой удирдлагаар ханган санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд бодит туслалцаа үзүүлнэ.</li> <li>- Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төслийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль хамгаалах чиглэлийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтад оролцох боломжийг нөхөрлөлд олгож бодлогоор дэмжинэ.</li> <li>- Байгаль орчныг хамгаалах чиглэлийн үүлзалт, ярилцлага, семинар зөвлөгөөн, мэргэжил шинээр олгох болон мэргэжүүлэх сургалтад нөхөрлөлийн гишүүдийг хамруулах асуудлыг бодлогоор хэрэгжүүлнэ.</li> <li>- Энэхүү гэрээнд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд нөхөрлөлд удирдлага, зохион байгуулагтун болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.</li> </ul>
<b>2</b>	<b>БНХМН (нөхөрлөл)-ийн эрх, үүрэг</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Амьтны тухай, Газрын тухай, ан агнуурын тухай, Усны тухай, Байгалийн ургамлын тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, менежментийн төлөвлөгөө, энэхүү гэрээний заалтыг дагаж мөрдөн ажиллана.</li> <li>- Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн нөхцөлд гэрээний хугацааг сунгуулах, гэрээг шинэчлэн байгуулах тухай хүсэлтээ Засаг даргад тавьж, шийдвэрлүүлэх эрхтэй.</li> <li>- Нөхөрлөлийн гишүүд гэрээт газар дээрээ өөрийн хөрөнгөөр ургамал, мод бут тарьж ургуулсан бол түүнээ хуулийн этгээдийн хувиар өмчлөх эрхтэй. Мөн өөрийн хөрөнгөөр сэргээн нутагшуулж, өсгөн үржүүлсэн тарвага зэрэг ан амьтад, хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, цөөрмийг нөхөрлөлийн гишүүдийн хамтаар зохион байгуулна.</li> </ul>
<b>3</b>	<b>Талуудын хариуцлага</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээ байгуулсан талуудын хооронд маргаан үүсвэл харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх ба талууд шийдвэрийг үл зөвшөөрсөн тохиолдолд шүүхийн байгууллагад хандаж болно.</li> <li>- Нөхөрлөл нь гэрээнд заасан үүргээ зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсныг холбогдох байгууллагаас тогтоосон тохиолдолд Засаг дарга гарсан хохирлыг нөхөрлөлийн гишүүдийн хөрөнгөөр бүрэн арилгуулах, нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авна.</li> <li>- Нөхөрлөл нь өөрийн үйл ажиллагааг зогсоох болон гэрээг цуцлах тухай сумын Засаг даргын шийдвэрийг зөвшөөрөхгүй бол гомдлоо аймгийн Засаг даргад, эсвэл шүүхэд</li> </ul>

гаргаж шийдвэрлүүлнэ.

**4 Гэрээний хугацаа, гэрээг сунгах, цуцлах**

- Гэрээг 3 жилийн хугацаатай байгуулдаг байна.
- Гэрээний хугацааг сунгах талаар тусгайлсан нөхцөл тусгаагүй боловч сумын Засаг даргын эрх, үүрэг хэсэгт дараах нөхцөлийг тусгажээ. Үүнд:
- Нөхөрлөлтэй байгуулсан гэрээ, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 12 сарын 25-ны дотор дүгнэнэ. Ингэхдээ сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, багийн засаг дарга, байгаль хамгаалагчдын саналыг авч тусгана. Нөхөрлөл гэрээгээр хүлээсэн үүрэг, менежментийн төлөвлөгөөгөө хангалттай биелүүлсэн тохиолдолд байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаагаар Засаг дарга сунгана.
- Нөхөрлөл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, менежментийн төлөвлөгөө, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байвал нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах буюу цаашид гэрээний хугацааг сунгахгүй байх эрх эдэлнэ гэж тус тус заасан байна.

**Дүгнэлт 2. Байгалийн нөөц (ой, ойн сан) эзэмших, ашиглах гэрээнд хийсэн үнэлгээ**

№	Шалгуур үзүүлэлт	Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль эрх зүйн орчинд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах эрх зүйн үндэслэл
1	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах, нөхөн сэргээх бодлого	<b>БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ</b> <b>19 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр</b> 1. Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий "Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"- тэй байна. 2. Төр, түүний байгууллага, албан тушаалтан дараах нийтлэг арга хэлбэрээр байгаль орчныг хамгаална: 7/нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах.
2	Байгалийн нөөцийн хамтын менежмент	<b>45 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежмент</b> 1. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ.
3	Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагааны субъект	<b>48 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд</b> 1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд дараах талууд оролцоно: 1/энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан хэлбэрээр байгуулагдсан нөхөрлөл: 2/нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга; 3/тухайн суманд ажиллаж байгаа байгаль орчны мэргэжлийн байгууллага. 2. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж оролцогч тал байж болно.
4	Байгалийн нөөц (ой, ойн сан)	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.8-д /"байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл" гэж /цаашид

<p>эзэмшигч, ашиглагч субъектийн зохион байгуулалт</p>	<p>“нөхөрлөл” гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг; Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д “ойн нөхөрлөл” гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг хэлнэ гэж хуульчилсан.</p>
<p>5 <b>Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл</b></p>	<p><b>50 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл</b></p> <p>1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрхтэй байна.</p> <p>2. Иргэдийн нөхөрлөлийн гишүүн нь 18 нас хүрсэн, тухайн сум дүүрэгт байнга оршин суугч Монгол Улсын иргэн байна.</p> <p>3. Тодорхой төрлийн байгалийн нөөцийг гэрээний дагуу нөхөрлөлд хариуцуулахдаа нөхөрлөлийн гишүүдийн тоо, хариуцуулах талбай, баялгийн нөөц, хэмжээ, онцлог зэргийг харгалзана.</p> <p>9. Нөхөрлөл нь энэ хуулийн 31 дүгээр зүйл, тодорхой төрлийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ, тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхэлнэ.</p> <p>10. Нөхөрлөл нь өөрийн дотоод дүрэмтэй байх бөгөөд дүрэмдээ бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ахлагч, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, дундын өмч хөрөнгийн харилцааны асуудлыг хуульд заасны дагуу тусгасан байна.</p> <p>11. Нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийн талаарх тайланг жил бүр тухайн сум, дүүрэг, баг, хорооны Хуралд тайлагнах бөгөөд түүнд байгалийн баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, нөөц баялгийн төлөв байдал, түүний өөрчлөлт зэргийг тусгасан байна.</p> <p>12. Нөхөрлөл нь өөрсдийн эрх ашгаа хамгаалах, хамтын ажиллагаагаа зохицуулах үүрэг бүхий нөхөрлөлүүдийн холбоотой байж болох бөгөөд холбооны дүрэм, үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.</p> <p>13. Нөхөрлөл нь өөрийн эзэмшлийн газар болон байгалийн нөөц бусад эд хөрөнгөд үчруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.</p> <p>14. Нөхөрлөл нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банканд данстай байж болно.</p>
<p>6 Объект</p>	<p><b>47 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежментийн хамрах хүрээ</b></p> <p>1. Нөхөрлөлийн хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх объектод энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгалийн нөөцөөс гадна дэлхийн болон үндэсний байгаль, соёлын өвд хамаарагдах</p>



		<p>газар нутаг орно.</p> <p>3.1.Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:</p> <p>1/газар, түүний хөрс; 2/газрын хэвлий, түүний баялаг; 3/ус; 4/ургамал; 5/амьтан; 6/агаар.</p>
7	БНХМН-тэй байгуулах гэрээ	<p>БОХТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2.Төр, түүний байгууллага, албан тушаалтан дараах нийтлэг арга хэлбэрээр байгаль орчныг хамгаална:</p> <p>7/нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах.</p> <p>- БОХТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.4.Сум дүүргийн Засаг дарга дараах баримт бичгийг үндэслэн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна:</p> <p>1/баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр; 2/нөхөрлөлийн байгалийн нөөцийн менежмент явуулахыг хүссэн өргөдөл; 3/нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах менежментийн төлөвлөгөө; 4/нөхөрлөл байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээ болон иргэний үнэмлэхийн хуулбар.</p> <p>БОХТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.5.Энэ хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан бичиг баримтыг бүрдүүлсэн нөхөрлөлтэй сум, дүүргийн Засаг дарга үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.</p> <p>50.6.Нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>50.7.Нөхөрлөл нь оролцогч талуудтай Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бичгээр гэрээ байгуулж ажиллана.</p>
8	Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө	<p>БОХТХуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.11/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.</p> <p><b>28 дугаар зүйл. Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг</b></p> <p>1.Байгаль хамгаалагч дараах эрхтэй байна:</p> <p>7/хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.</p>

---

## 52 дүгээр зүйл. Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө

1.Нөхөрлөл нь бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан менежментийн төлөвлөгөөтэй байна.

2.Менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

1/хариуцаж байгаа байгалийн нөөц, баялгийн мэдээлэл, нутаг дэвсгэрийн хил хязгаарыг баталгаажуулсан зураг;

2/байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах нөхөрлөлийн ашиглах байгалийн нөөцийн тархцын хил хязгаар, тоо хэмжээ, даац, чанар зэрэг үзүүлэлт;

3/эдийн засаг, нийгмийн хувьд ашиг тусаа одоо, ирээдүйд үзүүлж байх нөхцөл, арга хэмжээ;

4/тухайн төрлийн байгалийн нөөцийн онцлог шинж чанарт тохирсон менежмент явуулах арга, хэлбэр;

5/нөхөрлөлийн ашиглаж, эзэмшиж байгаа байгалийн нөөцийн төлөв байдлыг хянах хяналт-шинжилгээний хөтөлбөр;

6/менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нөхөрлөлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх үүрэг болон оролцогч талтай хамтрах ажил;

7/санхүүгийн төлөвлөгөө;

8/бүх гишүүдийн хурлаас тогтоосон бусад зүйл.

---

9 Байгаль орчны үнэлгээ

## 7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ

1.Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

2.Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хүсэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх буюу үнэлгээг урьд нь тогтоосон бол түүнийг гүйцэтгэсний зардлыг төлнө.

3. Байгаль орчны үнэлгээг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эрх олгосон аж ахуйн нэгж, байгууллага хийж тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4.Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага / цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ олгоно.

*/Энэ хэсэгт 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

5.Дараах шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно:

1/үнэлгээний багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх;

2/хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног

---

	төхөөрөмжтэй байх; 3/магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас батлагдсан байгаль орчны үнэлгээ хийх арга зүйтэй байх;
10 Гэрээг цуцлах	БОХТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.8.Нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр явуулах үйл ажиллагааг дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга зогсоож, гэрээг цуцална: 1/нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан; 2/гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, гэрээ байгуулснаас хойш зургаан сар байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй; 3/бүх гишүүдийн хурлаар нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гарсан; 4/энэ хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

## 2.7. Ус ашиглалтын гэрээнд хийсэн дүн шинжилгээ:

Усны тухай хуульд ус ашиглагч<sup>6</sup>, ус хэрэглэгч<sup>7</sup> гэсэн субъектийг ангилсан ба эдгээр субъектийн эрх, үүрэг, хариуцлагыг ялгаа заагтай тодорхой хуульчилсан онцлогтой.

Хуулийн энэхүү зохицуулалтаар бидний судалж буй малчдын оролцоотой байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага бол ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчныг ашигладаг учраас зөвхөн ус хэрэглэгч субъектэд хамаарна. Иймд уг хуулиар сум, дүүргийн Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулах, **Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь** ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх, **Сум, дүүргийн байгаль хамгаалагч** ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх зохицуулалттай.

Иймд ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулах эрх зүйн зохицуулалттай тул малчдын оролцоотой байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага нь усыг гэрээгээр ашиглах эрх зүйн үндэслэлгүй юм. Гэсэн хэдий ч байгалийн нөөц баялгийн зохистой ашиглалт, хамгаалалтын асуудал нь экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэгдэх агуулгаар зорилтот 2 аймгийн сумдад үйл

<sup>6</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.27.“ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

<sup>7</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.28.“ус хэрэглэгч” гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг;

ажиллагаа явуулж буй хуулийн этгээдтэй ус ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байгаа судалгааг авсан тул гэрээнд үнэлгээ өгч, энэ талаар хууль зүйн дүгнэлт хийх нь зүйтэй гэж үзсэн. Мөн газрын түрэмгийлэл - Land grabbing тухайн аймгуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаатай уялдуулан судлах хэрэгцээ шаардлага бий гэж дүгнэв.

Малчид, малчдын оролцоотой БНХМБ-ын худаг эзэмших, ашиглах эрхийн баталгааны талаарх эрх зүйн зохицуулалтыг тодотговол усны тухай хуульд<sup>8</sup> усны барилга байгууламжийг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулж болох тухай хэм хэмжээ үйлчилж байгаа. Энэхүү байгууламжид энгийн болон инженерийн хийцтэй худаг хамаарах агуулгатай<sup>9</sup> гэж дүгнэв.

---

<sup>8</sup> Усны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3

<sup>9</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.13 "усны барилга байгууламж" гэж усны түрэлт, урсцыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг;

**ГУРАВДУГААР БҮЛЭГ:**  
**МАЛЧДЫН ОРОЛЦООТОЙ БНХМБ-ЫН ХЭЛБЭРЭЭР УС, ОЙ, ГАЗАР**  
**(ХАДЛАН, БЭЛЧЭЭР)-ЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**  
**ГЭРЭЭНИЙ ЗАГВАРЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ, ТҮҮНИЙГ**  
**АЛБАЖУУЛАХ ЗӨВЛӨМЖИЙН ХАМТ ТАЛУУДАД ТАНИЛЦУУЛЖ**  
**ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТУХАЙ**

---

**3.1. Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, хадлан, бэлчээрийн нөөцийн ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааны хамтын менежментийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулсан болон тэдгээрийг албажуулах зөвлөмжийн талаар:**

Малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, хадлан, бэлчээрийн газрын нөөц баялгийн зохистой ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны биелэлт, хамтын менежментийн гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ байгалийн нөөц баялгийн объектын ангиллаар заагласан ба түүнд үндэслэн гэрээнүүдийн загварыг шинэчлэн боловсруулсан болно. Ингэхдээ дан ганц гэрээнүүдийн загвар боловсруулахыг чухалд үзээгүй ба хамаарал бүхий хууль тогтоомжийг судлан, холбогдох эрх зүйн хэм хэмжээг баримтлан баримт бичгийг цогцоор нь боловсруулах нь ач холбогдолтой гэж үзсэн болно. Иймд БНХМБ-ын оролцоотой байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалтын гэрээ болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гарах албажуулах эрх зүйн баримт бичгүүдийн төслийг хамтад нь зөвлөмж байдлаар боловсруулав. Үүнд:

**3.1.1. Малчдын оролцоотой БНХМБ-ын усны нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын гэрээний талаар:**

Усны тухай хуульд ус ашиглагч<sup>10</sup>, ус хэрэглэгч<sup>11</sup> гэсэн субъектийг ангилсан ба эдгээр субъектийн эрх, үүрэг, хариуцлагыг ялгаа заагтай тодорхой хуульчилсан онцлогийн талаар өмнө дурдсан билээ. Мөн хуулийн энэхүү зохицуулалтаар бидний судалж буй малчдын оролцоотой БНХМБ бол ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчныг ашигладаг учраас зөвхөн ус хэрэглэгч субъектэд хамаарна. Иймд уг хуулиар сум, дүүргийн Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулах, **Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь** ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх, **Сум, дүүргийн байгаль хамгаалагч** ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх зохицуулалттай.

---

<sup>10</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.27. “ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

<sup>11</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.28. “ус хэрэглэгч” гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчныг ашигладаг хэрэглэгчийг;

Иймд ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулах эрх зүйн зохицуулалттай тул малчдын оролцоотой БНХМБ нь усыг гэрээгээр ашиглах эрх зүйн үндэслэлгүй байна.

#### **Малчдын оролцоотой БНХМБ-ын булаг, шанд ашиглах, хамгаалах талаар:**

Малчид, малчдын оролцоотой хамтын байгууллага усны сан бүхий газар болон худаг эзэмших, ашиглах асуудлыг авч үзэхдээ эдгээр харилцааг зохицуулсан төрөлжсөн хууль болох усны тухай хуулийн холбогдох хэм хэмжээг үндэслэл болгов.

Усны тухай хуульд нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг “усны сан бүхий газар” гэж тодорхойлсны<sup>12</sup> зэрэгцээ уг асуудлын талаар баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд зарим шийдвэр гаргах талаар хуульчилсан. Тухайлбал, сум, дүүргийн Засаг дарга булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, улмаар байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх<sup>13</sup>, баг, хорооны Засаг дарга усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж хангах, мөн гол, горхи, булаг, шанд, рашааны эхийг хамгаалах, тохижуулах, мод тарих, ургамалжуулах, ундаргыг нэмэгдүүлэх, бохирдлоос сэргийлэх арга хэмжээнд иргэдийг татан оролцуулах<sup>14</sup> асуудлыг тус тус хуульчилсан билээ.

Эдгээр зохицуулалтын агуулга багийн болон сумын Засаг дарга малчид, малчдын оролцоотой БНХМБ-тай булаг, шанд, худгийг зохистой ашиглах, хамгаалах талаар хамтран ажиллахад чиглэсэн байна гэж дүгнэж болохоор байна. Хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд сумын Засаг дарга малчдын оролцоотой БНХМБ-тай гэрээ байгуулах замаар тухайн сум, орон нутгийн булаг, шанд, худгийг зохистой ашиглах, хамгаалах асуудлыг шууд заасан зохицуулсан хэм хэмжээ байхгүй ч практикт малчдын оролцоотой БНХМБ өөрсдийн санаачилгаар тухайн бүс нутагт буй булаг, шандыг хамгаалах талаар хэлэлцэн, зарим сумдад хэрэгжүүлсэн олон туршлага байна. Тухайлбал, Дорнод аймгийн Баянтүмэн сумын Баянбулаг БАХ нь булгийн эхийг хамгаалах зорилгоор булгийн эхийн 300 м<sup>2</sup> талбайг хашаалах, булгийн эхийн лаг шаврыг ковшоор цэвэрлэх, шон, труба, материалыг татан авах чиглэлийн үйл ажиллагааг хамтран гүйцэтгэх зорилгоор жижиг төсөл бичиж МБАНХ-ноос санхүүжилт авч хэрэгжүүлсэн байна.

<sup>12</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4

<sup>13</sup> Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3

<sup>14</sup> Усны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2

## Малчдын оролцоотой БНХМБ-ын худаг ашиглах, хамгаалах талаар:

Худаг нь ус хангамжийн эх үүсвэр<sup>15</sup> болохыг хуульчлан томъёолсны зэрэгцээ худагтай холбогдох асуудлаар Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, хамаарал бүхий төрийн байгууллагын бүрэн эрхийг хуульд тусгасан. Үүнд:

- Багийн иргэдийн Нийтийн Хурал Багийн нутаг дэвсгэрт байгаа худаг, усан сан, услалтын системийн ашиглалт, эзэмшлийг зохицуулах, бэлчээр, хадлан, тариаланг усжуулах зорилгоор худаг гаргах, хөв, усан сан, услалтын систем байгуулах талаар Засаг даргын саналыг саналыг хэлэлцэн шийдвэрлэх<sup>16</sup>,
- Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулах<sup>17</sup> бүрэн эрхтэй байна.
- Сав газрын захиргаа ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх, худаг гаргах, суваг хоолой татах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг үндэслэн уг хуульд<sup>18</sup> заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргах, улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ-сувилгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах талаар дүгнэлт гаргах, мэдээллийн санд оруулж бүртгэх гэх мэт бүрэн эрхүүд багтана.

Усны тухай хуулийн дурдсан зохицуулалтуудыг үндэслэн малчдын оролцоотой БНХМБ-ын оролцоотойгоор усан сан, услалтын системийн ашиглалт, эзэмшлийг хэрхэн зохицуулах, бэлчээр, хадлан, тариаланг усжуулах зорилгоор худаг шинээр гаргах шаардлага бүхий газрыг тогтоох, хөв, усан сан, услалтын систем байгуулах гэх мэт тухайн сум, орон нутагт усны асуудлын талаар Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд санал гаргах, хэрэгжүүлэх, уг саналыг БИНХ-аар хэлэлцэн шийдвэр гаргах хууль зүйн үндэслэлтэй. Энэхүү асуудалтай уялдаж хэрэв бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажил гүйцэтгэхээр бол төрийн эрх бүхий байгууллагын оролцоотойгоор шийдвэрлэх хууль зүйн боломж бий. Тэрчлэн малчин, малчдын хамтын байгууллага ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх, худаг гаргах, суваг хоолой татах хүсэлттэй бол төрийн холбогдох байгууллагад хүсэлтээ гаргахын зэрэгцээ усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, бүртгүүлэх, хэрэв 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах бол тухайн Аймгийн байгаль орчны албаны дүгнэлтийг авах шаардлагатай.

<sup>15</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15

<sup>16</sup> Усны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2

<sup>17</sup> Усны тухай хуулийн 16<sup>1</sup> зүйлийн 16<sup>1</sup>.4.14.

<sup>18</sup> Усны тухай хуулийн 28.4.Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

Малчид, малчдын оролцоотой БНХМБ-ын худаг эзэмших, ашиглах эрхийн баталгааны талаарх эрх зүйн зохицуулалтыг тодотговол усны тухай хуульд<sup>19</sup> усны барилга байгууламжийг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулж болох тухай хэм хэмжээ үйлчилж байгаа. Энэхүү байгууламжид энгийн болон инженерийн хийцтэй худаг хамаарах агуулгатай<sup>20</sup> гэж дүгнэв.

Дээр дурдсан хэм хэмжээнүүдийг үндэслэл болгон малчин, малчдын оролцоотой БНХМБ-д худаг эзэмшүүлэх гэрээний загварыг дараах байдлаар боловсрууллаа.

Худаг эзэмшүүлэх гэрээний загварын төсөл:

### Худаг эзэмшүүлэх гэрээ

Нэг талаас ..... аймгийн ..... сумын эзэмшүүлэгчийг төлөөлөн ..... албан тушаалтай ..... овогтой ....., эзэмшигчийг төлөөлөн ..... сумын ..... багийн малчин ..... овогтой ....., БНХМБ-ыг төлөөлөн ахлагч ..... овогтой ..... (аль тохирохыг бөглөх) нар харилцан тохиролцож, Усны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 16<sup>1</sup>.4.14, 28.4, 32.3-д заасныг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

#### 1. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээний зорилго нь сумын ..... багийн ..... /газрын нэр/ /...../ байрлах худгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

#### 2. Өмчлөл

- 2.1. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд зааснаар ус, усны нөөц төрийн өмч мөн бөгөөд энэхүү гэрээгээр зөвхөн худгийг тоног төхөөрөмж, байгууламжийн ашиглалт, эзэмшилт хамаарна.
- 2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бүтээн байгуулсан, сэргээн засварласан тоног төхөөрөмж, байшин барилга нь төрийн өмч байна.
- 2.3. Малчин, малчдын байгууллагын оролцоотой БНХМБ-ын санхүүжилтээр бүтээн байгуулсан, сэргээн засварласан тоног төхөөрөмж, байшин барилга нь эзэмшигчийн өмч, харин усны нөөц нь нийтийн ашиглалтад байна.

#### 3. Эзэмшлийн зориулалт

3.1. Худгийг мал услах /үндны усны, тариа ногоо услах гэх мэт/ хэрэгцээг хангах зориулалтаар эзэмшүүлэв.

<sup>19</sup> Усны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3

<sup>20</sup> Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.13 "усны барилга байгууламж" гэж усны түрэлт, урсцыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг;



- 3.2. Худгийн усыг нутаг ойролцоо хөрш малчин өрхүүдийн мал услах, үндны усны хэрэгцээнд хэрэглүүлнэ.
- 3.3. Онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

#### **4. Эзэмшүүлэх хугацаа**

- 4.1. Худгийг ..... жилийн хугацаатай эзэмшүүлэв.

#### **5. Эзэмшигчийн эрх, үүрэг**

Эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

- 5.1. Худгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах
- 5.2. Худагт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр нэхэмжлэх
- 5.3. Жил бүр хүн ам, малын тооллогоор худгийг бүртгэлд хамруулах
- 5.4. Гэрээний хугацааг сунгуулах хүсэлт гаргах
- 5.5. Худгийг засварлах, тохижуулах талаар хөрөнгө оруулалт хийх  
Эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ.
- 5.6. Энэхүү гэрээнд заасан үүргийг биелүүлэх
- 5.7. Худгийн тоног төхөөрөмж, байшин барилгыг өөрийн зардлаар арчилж, хамгаалах
- 5.8. Худгийн орчмын газар, байгаль орчныг зохих хууль тогтоомжийн дагуу зохистой ашиглах, хамгаалах
- 5.9. Худгийн ус, орчмын газрыг бохирдол, талхлагдахаас хамгаалах арга хэмжээ авах
- 5.10. Эзэмшигчийн хариуцлагагүйгээс худагт аливаа хохирол учирсан, орчмын газар талхлагдсан тохиолдолд өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах
- 5.11. Байгаль орчинд болон бусдын эзэмшил, ашиглалтын газарт хохирол учруулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх
- 5.12. Худаг, ойр орчмын газрыг хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу зүй зохистой ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих
- 5.13. Худгийг зүй зохистой эзэмшиж, ашиглахтай холбоотой бөгөөд эзэмшигчийн эрх мэдэл, хүч бололцоо хүрэхгүй аливаа асуудлаар эзэмшигчид дэмжлэг туслалцаа үзүүлэх
- 5.14. Худгийн ойр орчим эзэмшигч болон бусад этгээд 500 метрт хашаа, саравч барихгүй байх

#### **6. Худгийг онцгой хэрэгцээнд ашиглах**

- 6.1. Эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр үүссэн онцгой хэрэгцээг хангах үүднээс өмчлөгчийн зүгээс худгийг тухай хэрэгцээ шаардлагагүй болох хүртэл төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно.

#### **7. Эзэмших эрх дуусгавар болох**

Худгийг эзэмших эрх доор тохиолдолд дуусгавар болно.

- 7.1. Эзэмших гэрээт хугацаа дууссан бөгөөд эзэмшигч гэрээг сунгуулах хүсэлт гаргаагүй.
- 7.2. Гэрээ байгуулсан хуулийн этгээд нас барсан, сураггүй алга болсон, байгууллага татан буугдсан бөгөөд хууль ёсны эрх залгамжлагч байхгүй.
- 7.3. Эзэмшигч гэрээг цуцлах хүсэлт гаргасан

- 7.4. Эзэмшигч зохих хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ удаа дараа ноцтойгоор зөрчсөн.
- 7.5. Худгийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан болох нь тогтоогдсон.
- 7.6. Худгийн ойр орчим нутаглаж буй малчдын малын болон үнд хэрэгцээнд ашиглуулаагүй бол.

**8. Худгийн ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх**

- 8.1. Худгийн ашиглалтын талаар ашиглагчдын хооронд гарсан маргааныг багийн нийт гишүүдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
- 8.2. Худгийн ашиглалтын талаар ашиглагчид болон бусад этгээдийн хооронд гарсан маргааныг тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.
- 8.3. Худгийн ашиглалтын талаар ашиглагчид болон Засаг даргын хороонд гарсан маргааныг дээд шатны Засаг дарга шийдвэрлэнэ.
- 8.4. Энэхүү зүйлийн 1,2,3-д заасан маргаанд оролцсон аливаа тал маргаан тасалсан шийдвэрийн талаар гомдолтой бол дээд шатны Засаг дарга болон шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЭЗЭМШҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....  
 .....овогтой.....

овогтой

.....

Гарын үсэг

Гарын үсэг

Утас:

Утас:

### 3.1.2. Малчдын оролцоотой БНХМБ-ын ойн нөөцийг зохистой ашиглах, эзэмших, хамгаалах гэрээний загварыг шинээр боловсруулсан талаар:

- Ойн нөөц баялгийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, малчид, малчдын хамтын байгууллага, БНХМБ, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, үүрэг, хариуцлагыг тусгах талаар:

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг нэрлэн зааж<sup>21</sup> хуульчилсан онцлогтой. Иймд эдгээр оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг тухайн орон нутгийн онцлогт тохируулан ойг хамгаалах, эзэмших, ашиглах гэрээнд тухайлан зааж тусгах хууль зүйн үндэслэлтэй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-250 дугаар тушаалаар “Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам”, “Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ”-ны загварыг тус тус баталж, 2022 он хүртэлх хугацаанд 12 дахь жилдээ орон нутагт хэрэгжүүлэн мөрдөж байсан нь малчдын оролцоотой байгуулагдсан нөхөрлөлийн байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, эзэмшихтэй холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт хангалттай гэх үндэслэл болж байв. Гэвч 2022 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/146 дугаар тушаалаар “Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам”-ыг хүчингүй болгож, “Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээний загвар”-ыг хэвээр үлдээсэн тул нөхөрлөлийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах үйл ажиллагаанд загвар гэрээг ашиглаж хэвшсэн байна. Гэсэн хэдий ч малчдын оролцоотой БНХМБ-ын эрх зүйн статус, хууль болон гэрээний харилцаанд оролцох эрх зүйн чадамжийг гэрээний шинэчилсэн загварт тусгахыг чухалчлав.

Байгаль орчныг хамгаалах тухай суурь хуульд хуульчилсан зохицуулалтаар Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн /цаашид “БНХМН” гэх/ байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулах үе шатыг схемчлэн харуулав.

---

<sup>21</sup> Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 48 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд

1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд дараах талууд оролцоно:

1/энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан хэлбэрээр байгуулагдсан нөхөрлөл;

2/нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга;


3/тухайн суманд ажиллаж байгаа байгаль орчны мэргэжлийн байгууллага.

2. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж оролцогч тал байж болно.


Засаг дарга БНХМН-тэй гэрээ байгуулах, гэрчилгээ олгох. БОХТХ-ийн 50.5

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-250 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээний загвар”-аар гэрээ байгуулж байна. БОХТХ-ийн 50.6

Малчдын оролцоотой нөхөрлөлийн үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг нь нөхөрлөлийн дотоод дүрэм байх бөгөөд дүрэмд заавал тусгах асуудлыг хуульчилсан онцлогтой. Үүнийг бүдүүвчээр илэрхийлбэл:



Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батлах бас нэгэн чухал баримт бичиг бол нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө бөгөөд энэхүү төлөвлөгөөнд зайлшгүй багтаах шаардлагатай асуудлыг дараах агуулгаар хуульчлан баталгаажуулсан.



Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д "ойн нөхөрлөл" гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг хэлнэ гэж хуульчилсан зохицуулалтад үндэслэн ойн нөхөрлөлүүд байгуулагдсан байна.

2009 онд Монгол Улсын Засгийн газрын 227 тоот тогтоолоор “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх тухай журам” батлан мөрдөж байна. Уг тогтоолоор ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон билээ.

Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэхэд дээр дурсан журмыг дагаж мөрдөж байгаа тул ойн нөөц баялгийг эзэмшүүлэн ашиглуулах эрх зүйн орчин бүрдсэн гэх үндэслэлтэй. Учир нь журамд хэд хэдэн онцлог зохицуулалтыг тусгасан ба үүнийг товч дурдвал:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түшиглэсэн хамтын эзэмшлийн ойн менежментийг хөгжүүлэх, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагааг дэмжих зорилготой,
- Ойн санг гэрээгээр эзэмших аж ахуйн нэгж, байгууллагад ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгж, сургалт, эрдэм шинжилгээний болон ойн чиглэлийн төрийн бус байгууллага хамаарахыг тодотгосон,
- Эзэмшүүлэх ойн сангийн талбайн хэмжээг тогтоохдоо нөхөрлөлийн гишүүдийн болон аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын тоо, чадавх, хүчин чадал, дундын мөнгөн сангийн хэмжээ, тухайн ойн төлөв байдал, ойн талбай, нөөц, экологийн онцлогийг харгалзахын зэрэгцээ нөхөрлөлийн нэг гишүүнд ногдох талбай 500 га-гаас, аж ахуйн нэгж, байгууллагад ногдох талбай 15000 га-гаас ихгүй байх хэмээн ойн талбайн хэмжээг үндэслэл бүхий хязгаарыг тогтоосон,
- Эзэмшүүлэх ойн талбай нь зөвхөн тухайн сумын хэмжээнд байх байршлын объектыг заасан ба нөхөрлөлийн ахлагч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байнгын оршин суугч байхыг чухалчилсан нь суурьшмал, ойг хамгаалах, зохистой ашиглахад тогтмол үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн,
- Журамд ойн санг гэрээгээр эзэмших нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээ болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад батлах эрхийг олгосны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/58 дугаар тушаалаар 1998 онд баталсан “ойн санг эзэмших гэрээний загвар”-ыг хүчингүй болгосон.
- Ойн санг эзэмших тухай хүсэлтээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргах, шийдвэрлэх
- Ойн санг эзэмшүүлэх гэрээ байгуулах, сунгах нөхцөлийг заасан,
- Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх,
- Гэрээг цуцлах журмыг тогтоосон гэх мэт харилцааг журамлан зохицуулах агуулгатай эрх зүйн ач холбогдол бүхий акт үйлчилж байгаа нь ойн санг гэрээгээр эзэмшүүлэх харилцаанд дагаж мөрдөх чухал эх сурвалж болж байна.

Байгалийн тодорхой төрлийн баялгуудаас ой, ойн сангийн нөөц илүү нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг шаарддагтай уялдаж энэхүү баялгийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбогдсон дараах захиргааны хэм хэмжээний актууд үйлчилж байна. Үүнд:

- Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам, Ойн арчилгааны огтлолтын технологийн картын загвар, Ойд цэвэрлэгээ хийх технологийн картын загвар<sup>22</sup>.
- Ойгоос мод бэлтгэх журам, Бэлтгэх модны санал ирүүлэх хүснэгтийн загвар, Мод бэлтгэх гэрээний загвар, Мод тээвэрлэх хяналтын хуудасны загвар, Ойгоос мод бэлтгэх эхлэл, төгсгөлийн актын загвар, Мод бэлтгэх технологийн картын загвар<sup>23</sup>.
- "Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам, "Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын гүйцэтгэлийн актын загвар, "Ургуулсан тарьц, суулгацад тооллого хийж, хүлээн авах актын загвар"<sup>24</sup>.
- "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам", Ойн дагалт баялаг ашиглах эрхийн бичгийн загвар<sup>25</sup>.
- "Ойн мэдээллийн сангийн бүртгэл тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам"<sup>26</sup>
- "Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах журам"<sup>27</sup>
- "Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам"<sup>28</sup>
- "Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам", "Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ"-ний загвар, "Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг"-ийн загвар<sup>29</sup>-ыг дурдаж болохоор байна.

Хууль зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор 2017 онд анх удаа Монгол Улсад Зөрчлийн тухай бие даасан хууль баталсан нь эрх зүйн ач холбогдол бүхий шинэчлэл болсон билээ. Үүнийг судалгаатай холбон авч үзвэл уг хуулиар ойн тухай хууль зөрчсөн тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулсан ба ой, ойн санг эзэмших, ашиглах, хамгаалах гэрээнд энэхүү хэм хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийг тусгахад ач холбогдолтой. Мөн 2022 оны 3 дугаар сард ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсныг дурдах нь зүйтэй.

Ойн нөхөрлөл нь ой, ойн санг эзэмших, ашиглах гэрээгээ зөрчсөн нөхцөлд зөрчлийн тухай хуульд заасан хууль зүйн хариуцлага хүлээлгэх, тэдний хариуцлагыг хуульд заасан арга, хэлбэрээр нэмэгдүүлэх асуудал чухал учраас энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг судлан дүгнэлт хийсэн болно.

Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг түймэр, Хөнөөлт шавж, Өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун

---

<sup>22</sup> БОАЖС-ын 2020.12.15-ны өдрийн А/684 дүгээр тушаал

<sup>23</sup> БОАЖС-ын 2016.12.13-ны өдрийн А/133 дугаар тушаал

<sup>24</sup> БОАЖС-ын 2015.03.31-ний өдрийн А/140/63 дугаар хамтарсан тушаал

<sup>25</sup> БОАЖС-ын 2014.05.12-ны өдрийн А/166 дугаар тушаал

<sup>26</sup> БОАЖС-ын 2013.02.19-ний өдрийн А/53 дугаар тушаал

<sup>27</sup> БОАЖС-ын 2013.05.01-ний өдрийн А/134 дүгээр тушаал

<sup>28</sup> БОАЖС-ын 2013.08.07-ны өдрийн А/223 дугаар тушаал

<sup>29</sup> 2013.05.15-ны өдрийн А/153 дугаар тушаал

нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно<sup>30</sup>.

Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно<sup>31</sup>.

Ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хэмжээнээс хэтрүүлэн бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно<sup>32</sup>.

Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно<sup>33</sup> гэсэн хэм хэмжээг үндэслэн хариуцлага хүлээлгэх бодит нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ой, ойн санг эзэмшүүлэх гэрээнд эдгээр заалтын агуулгыг тусгах боломжтой учраас шинээр боловсруулсан гэрээний загварт эзэмшигч талын үүрэгт тусгав.

Дорнод аймгийн 7 суманд 40 нөхөрлөл байгуулагдсан нь байгалийн тодорхой төрлийн баялгаас ой, ойн санг зохистой ашиглах, хамгаалах асуудлаар тусгайлан ойн нөхөрлөл байгуулсан байх тул эдгээр нөхөрлөлтэй байгуулсан гэрээнд хийсэн үнэлгээнд үндэслэн гэрээний шинэ загвар боловсруулах ажлын даалгаврын дагуу уг гэрээнд зайлшгүй тусгах шаардлага бүхий нөхцөлүүд, ойг хамгаалахад талуудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлд эзэмшүүлэх тухай гэрээний загварт тусгасан ба уг гэрээг байгуулахтай холбогдох эрх зүйн баримт бичгийн төслүүдийг хамтад нь боловсруулсан болно.

<sup>30</sup> Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7.9.2

<sup>31</sup> Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7.9.5

<sup>32</sup> Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7.9.6

<sup>33</sup> Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7.9.9



Загвар-1: Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх тухай сумын ИТХ-ын тогтоолын төсөл:

**Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол**

20... оны ... дугаар  
сарын ... ны өдөр

№ ...

.....

**Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. “.....” ойн нөхөрлөлд ..... хэмжээ, байршил бүхий ойн сангийн хэсгийг эзэмшүүлсүгэй.

Хоёр. “.....” ойн нөхөрлөлд ойн сангийн ... хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг хангуулж хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга ..... овогтой ..... -нд даалгасугай.

**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ДАРГА**

.....

Дээрх тогтоолд үндэслэн тухайн сумын Засаг дарга захирамж үйлдэн ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх бөгөөд энэхүү захирамжийн загварыг дараах байдлаар боловсруулав.

Загвар-2: Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулах тухай сумын Засаг даргын захирамжийн төсөл:

**..... СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20... оны ... дугаар  
сарын ... ны өдөр

№ ...

.....

**“.....” Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.17 дугаар заалт, Ойн тухай хуулийн 4.4 дүгээр зүйлийн 4.4.2 дах заалт, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6 дах заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ... тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Суманд зохион байгуулагдсан “...” ойн нөхөрлөлд ойн сангийн ... хэсгийг гэрээгээр эзэмшүүлсүгэй.

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 тоот тогтоолоор баталсан “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх тухай журам”-д нийцүүлэн ойн санг эзэмшүүлэх тухай гэрээний загварыг хавсралт ёсоор баталсугай.

#### ЗАСАГ ДАРГА

.....

Сумын Засаг даргын захирамжийн дагуу ойн нөхөрлөлтэй байгуулах гэрээний загварыг дараах байдлаар боловсруулав.

Загвар-3: Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх тухай гэрээний загварын төсөл:

№

#### “.....” ОЙН НӨХӨРЛӨЛД ОЙН САНГИЙН ТОДОРХОЙ ХЭСГИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Энэ гэрээг..... аймгийн ..... сумын Засаг даргын ..... оны ..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар захирамж, Ойн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.2 дах заалт, 7.4 дүгээр зүйлийн 7.4.3 дах заалт, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4, 18.1.5 дах заалт, 21 дүгээр зүйл, Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 227 тоот тогтоолыг тус тус үндэслэн нэг талаас өмчлөгчийг төлөөлөн сумын Засаг дарга ..... овогтой ..... (цаашид эзэмшүүлэгч гэх), нөгөө талаас ойн нөхөрлөлийг төлөөлөн “.....” Ойн нөхөрлөлийн ахлагч ..... овогтой ..... (цаашид эзэмшигч гэх) нар гэрээгээр олгогдсон ойн санг зохистой эзэмших, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

#### НЭГ. Гэрээний зорилго

1.1. Талуудын хооронд ойн санг эзэмших, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

#### ХОЁР. Өмчлөл

2.1. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар ой нь төрийн өмч байна.

2.2. Эзэмшүүлэгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ энэхүү гэрээнд заасан хэмжээ, байршил бүхий ойн санг эзэмшигчид эзэмшиж ашиглуулах боломжоор хангана.

2.3. Энэхүү гэрээнд заасан ойн сан нь бусдын эзэмшил, ашиглалтад олгосон ойн сангийн газартай давхцаагүй болохыг эзэмшүүлэгч батлав.

2.4. Эзэмшигч нь эзэмшүүлэх ойн сангийн талбайн хэмжээ, байршил, ургамал, амьтны аймаг, бусад байгалийн баялгийн нөөц, төлөв байдлыг тодорхойлсон баримт бичиг үйлдэх бөгөөд энэхүү баримт бичиг нь гэрээний хавсралт салшгүй хэсэг байна.

2.5. Энэхүү гэрээг байгуулахдаа ойн сангийн менежментийн төлөвлөгөөг үндэслэсэн бөгөөд уг төлөвлөгөө нь гэрээний хавсралт салшгүй хэсэг байна.

#### **ГУРАВ. Ойн сангийн хэмжээ, байршил**

3.1. Энэхүү гэрээгээр олгогдсон ойн санг зөвхөн гэрээнд заасан нөхцөлийн дагуу эзэмшүүлнэ.

3.2. “.....” Ойн нөхөрлөлийн эзэмшиж, ашиглах ойн сангийн талбай нь ..... га байна.

3.3. Ойн сангийн талбайн хилийн цэс, байршил

.....

#### **ДӨРӨВ. Ойн санг ашиглуулах хугацаа**

4.1. Энэхүү гэрээг 20... оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн 20.. оны ... сарын ...-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаагаар байгуулав.

4.2. Энэхүү гэрээнд заасан хугацаанд тухайн эзэмшилд олгосон ойн сангийн хэвийн төлөв байдлыг алдагдуулахгүйгээр зохистой ашигласан тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно.

#### **ТАВ. Эзэмшигчийн эрх, үүрэг**

##### **5.1. Эзэмшигч нь дараах эрхтэй**

5.1.1. Ойн нөхөрлөлийн дотоод дүрмээ хэрэгжүүлэх.

5.1.2. Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

5.1.3. Энэхүү гэрээгээр олгогдсон ойн санг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах арга хэмжээ авах.

5.1.4. Дотоод, гадаадын бусад байгууллагатай хамтран ажиллаж ойн санг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр аливаа хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж хэрэгжүүлэх.

5.1.5. Гэрээний хугацааг сунгах хүсэлт гаргах.

5.1.6. Ойн санг нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах, түймэртэй тэмцэх зэрэг асуудлаар холбогдох санал, хүсэлтээ эзэмшүүлэгчид гаргах.

5.1.7. Гэрээгээр олгогдсон ойн талбайд хяналт шалгалт зохион байгуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, учруулсан хохирлыг буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлэх, хор үршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад хандах.

5.1.8. Эзэмшлийн ойд зорчин явагсад, байгалийн тодорхой баялгийг ашиглагчдад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, гаргасан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

5.1.9. Ан амьтан, загас, шувуу зэрэг биологийн төрөл зүйл болон гол горхи, булаг шандны эх, хөвөө, хадлан бэлчээрийн талбайг хамгаалах, нөхөн сэргээх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх.

5.1.10. ....

5.1.11. ....

##### **5.2. Эзэмшигч нь дараах үүрэгтэй**

5.2.1. Гэрээ болон ойн менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх.

- 5.2.2. Гэрээгээр олгогдсон ойн сангийн газар, ус, ургамал, амьтны аймаг, бусад байгалийн баялгийг хамгаалах, төрх байдлыг хадгалах арга хэмжээ авах.
- 5.2.3. Гэрээгээр олгогдсон ойн сангийн өөрчлөлтийг жил бүр гаргаж, байгалийн бусад баялгийн өөрчлөлтөд тогтмол ажиглалт хийж, үнэн зөв мэдээллийг ойн анги эсхүл байгаль хамгаалагчид өгч байх.
- 5.2.4. Гэрээгээр олгогдсон ойн сангийн талбайдаа ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах ажлыг өөрийн хөрөнгөөр болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэх, шаардлага хангасан таримал ойг зохих хугацаанд нь улсын ойн мэдээллийн санд бүртгүүлэх.
- 5.2.5. Хуульд заасан хугацаанд эзэмшиж, ашиглаж байгаа ойн санд ой зохион байгуулалтыг хийлгэсэн байх.
- 5.2.6. Энэхүү гэрээ болон холбогдох хуульд заасан бусад үүргийг биелүүлэх.
- 5.2.7. Мод болон ойн дагалт баялгийг борлуулснаас олсон нийт орлогын 50-иас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлж, энэ орлогыг ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бусаар мод бэлтгэхийг таслан зогсоох, хяналт тавих, ойг нөхөн сэргээх, нутгийн хөгжлийг дэмжихэд зарцуулах.
- 5.2.8. ....
- 5.2.9. ....

#### **ЗУРГАА. Эзэмшүүлэгчийн эрх, үүрэг**

##### **6.1. Эзэмшүүлэгч нь дараах эрхтэй**

- 6.1.1. Гэрээгээр олгогдсон ойн сангийн талбайн зохистой ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах талаар шаардлага тавих.
- 6.1.2. Эзэмшигчийн хүсэлтийг харгалзан ойн тухай хуульд заасны дагуу гэрээний хугацааг сунгах.
- 6.1.3. Эзэмшигчээс гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах.
- 6.1.4. Эзэмшигчийн гаргасан үндэслэл бүхий санал, хүсэлтийн талаар шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах.
- 6.1.5. Эзэмшигч нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах.
- 6.1.6. Эзэмшигчтэй хамтран ойн сангийн менежментийн төлөвлөгөөний биелэлтэд тогтмол хяналт тавих, биелүүлэхийг шаардах.
- 6.1.7. Хэрэв холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх.
- 6.1.8. ....
- 6.1.9. ....

##### **6.2. Эзэмшүүлэгч нь дараах үүрэгтэй**

- 6.2.1. Эзэмшигчийн эзэмшилд олгосон ойн санг энэхүү гэрээний 1 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг хүлээлгэн өгөх.
- 6.2.2. Эзэмшүүлсэн ойн сангийн талбайг нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах талаар хуульд заасан арга хэмжээ авах.
- 6.2.3. Эзэмшүүлсэн ойн сангийн талбайг нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах зорилгоор дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй хамтран ажиллах талаар идэвх, санаачилгатай ажиллах.
- 6.2.4. Эзэмшилд олгосон ойн санг бусдад давхар олгохгүй байх нөхцөлөөр хангаж эзэмшигчийн ойн санг эзэмших, ашиглах хууль ёсны эрхийг хамгаалах.
- 6.2.5. Эзэмшүүлсэн ойн сангийн талбайг нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах аливаа асуудлаар эзэмшигчид дэмжлэг туслалцаа үзүүлэх.

- 6.2.6. ....  
6.2.7. ....

#### **ДОЛОО. Гэрээг цуцлах**

- 7.1. Энэхүү гэрээг ойн тухай хуульд заасны дагуу болон гэрээнд заасан хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно.
- 7.1.1. Эзэмшигч нь ойн санг хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан нь тогтоогдсон.
- 7.1.2. Энэхүү гэрээний 5.2-д заасны дагуу үүргээ биелүүлээгүй болон гэрээний нөхцөлийг удаа дараа ноцтойгоор зөрчсөн.
- 7.1.3. ....
- 7.1.4. ....

#### **НАЙМ. Давагдашгүй хүчин зүйл**

- 8.1. Талуудын хүсэл сонирхлоос гадуур, урьдчилан мэдэх боломжгүй зудган, үер ус зэрэг бусад байгалийн аюултай үзэгдэл, гал түймэр, мал амьтны гоц халдварт өвчин,эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгаа гэх мэт нөхцөл байдлын улмаас талууд гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд тусгасан нөхцөлүүдийн талаар талууд харилцан үүрэг хүлээхгүй.

#### **ЕС. Хариуцлага**

- 9.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээнэ.

#### **АРАВ. Ой ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх**

- 10.1. Ойн санг эзэмших, ашиглах талаар гарсан маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэнэ. Эс тохиролцвол холбогдох тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

#### **АРВАН НЭГ. Бусад**

- 11.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 11.2. Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг мөн.
- 11.3. Талууд бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 11.4. Эзэмшүүлэгч нь Монгол Улсын хуульд заасан үндэслэлээр албан үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, өөр этгээдээр солигдсон нь энэ гэрээг цуцлах, дуусгавар болгох, түүний нөхцөлийг өөрчлөх үндэслэл болохгүй.
- 11.5. Гэрээнд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 11.6. Энэхүү гэрээг нийт .... эх хувь үйлдэж, талууд 20.... оны ....-р сарын ....-ны өдөр ..... сумын ..... -нд гарын үсэг зурав. Тал тус бүр энэ гэрээний нэг хувийг өөртөө хадгалав.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Эзэмшүүлэгчийг төлөөлж сумын Засаг дарга .....овогтой  
.....  
Гарын үсэг .....

Эзэмшигчийг ..... төлөөлж  
“.....” Ойн  
нөхөрлөлийн ахлагч .....  
овогтой  
.....  
Гарын үсэг .....

### **3.1.3.Малчдын оролцоотой БНХМБ-ын газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын гэрээний загварыг шинээр боловсруулсан талаар:**

Ажлын даалгаварт хадлангийн талбай болон бэлчээрийн газрыг хамтад нь газар (хадлан, бэлчээр) гэсэн ухагдахуунаар авч үзэж, эдгээрийг гэрээ байгуулан зохистой ашиглах, хамгаалах асуудлыг судлахыг санал болгосон.

Гэвч Монгол Улсын Газрын тухай хуульд заасан үндэслэлээр хадлангийн талбай ба бэлчээрийн газар нь ашиглах зориулалтаас хамааран ялгаатай эрх зүйн зохицуулалттайг харгалзан эдгээрийг хамтад нь ашиглах, хамгаалах нэг гэрээний загвар боловсруулахад эрх зүйн талаас хүндрэлтэй байсан бөгөөд харин журмаар зохицуулах нь илүү боломжтой байсан гэдгийг дурдах нь зүйтэй.

Бэлчээрийг доройтолд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, талхлагдсан бэлчээрийг сэргээн сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, сайжруулах шаардлага орон нутагт бий болсоор байна. Өнөөдрийн байдлаар бэлчээрийн бие даасан хууль байхгүй учир бэлчээрийн газрын харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Зөрчлийн хууль болон бусад өөр хоорондоо салангид хуулиудын холбогдох заалтуудыг үндэслэн зохицуулж байна.

Газрын тухай хуулийн 52.6-д “Энэ хуулийн 52.1-д заасан ерөнхий хуваарь, 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэсэн заалтыг үндэслэн бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төсөл хэрэгжиж буй зорилтот аймаг, сумдад “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын төслийг боловсруулж батлах, бүлэг, хэсгийн зохион байгуулалтад орсон малчдад бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулж, хамгаалах эрх зүйн боломж байна гэж үзсэн.


Малчдын дундаа хамтран бэлчээрийг гэрээгээр ашиглах эрх зүйн зохицуулалтыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх нь бэлчээрийн газрыг сэргээн сайжруулах, хамгаалах, улмаар хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Бэлчээр ашиглалтын журмын зорилго нь орон нутагт бэлчээрийг нөөц даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, ашиглалтыг зөв төлөвлөх, бэлчээрийн менежментийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Бэлчээрийн газартай холбоотой эрх зүйн орчныг Газрын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн бүрдүүлэхийн тулд эхлээд аймаг, сум болгон бэлчээр ашиглалтын журамтай болох, мөн бэлчээрийн болон суурин маллагааны бүс нутгийг тогтоох, бэлчээр ашиглалтын ерөнхий хуваарийн дагуу бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг бэлтгэн сумын

тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан батлуулах, бүлэг, хэсэг болсон малчдад бэлчээрийг ашиглуулах гэрээ байгуулах, улирлын бэлчээр бүрд мониторингийн хяналт хийх ажлыг хэвшүүлэх, бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, гарал үүсэл нь тодорхой малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нийлүүлэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх ажлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлага байна.

Энэ шаардлагын улмаас болон зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгагдсан малчдын оролцоотой БНХМБ /малчдын бүлэг, хэсэг/-ын бэлчээр ашиглах гэрээний шинэчилсэн загварыг боловсруулахад хэрэгтэй, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр дараах жишиг загваруудыг бэлтгэн танилцуулж байна. Үүнд:



Загвар-4: “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам” батлах тухай аймгийн ИТХ-ын тогтоолын төсөл:

**МОНГОЛ УЛС**  
..... **АЙМГИЙН**  
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**  
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

202... оны ... сарын ... өдөр.  
.....сум

Дугаар ....

Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1,23, 35.1.13, 35.1.14, 48.1, 59.1.13, Газрын тухай хуулийн 52.1, 52.6, Захиргааны ерөнхий хуулийн 64.1, 66.1.1-д заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ... дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж хянуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (.....)-д даалгасугай.

3.Журмын хэрэгжилтийг ханган, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (.....)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөө аж ахуй, байгаль орчин, экологийн асуудал хариуцсан хороонд даалгасугай.

ДАРГА .....ГАРЫН ҮСЭГ



.....аймгийн  
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
202... оны ... дүгээр сарын ... -ны өдрийн  
ээлжит ... -р хуралдааны ... дүгээр  
тогтоолын хавсралт

## БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь аймгийн бэлчээр ашиглалтыг нөөц, даацад нь тохируулах замаар бэлчээрийн ургамлын байгалийн жамаараа сэргэн ургах боломжийг бүрдүүлэх, бэлчээр ашиглалтыг экологийн чадавх болон ашиглагчдад суурилсан аргачлалаар төлөвлөх, уг төлөвлөгөөний дагуу улирлын болон богино хугацааны хуваарьтайгаар ашиглаж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

1.2.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг сумын төсөв, төлөвлөгөөнд жил бүр тусгаж Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасны дагуу санхүүжүүлнэ.

1.3.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч хариуцна.

### ХОЁР. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

2.2. Бэлчээр ашиглалтыг төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнг хянах үнэлэх гэсэн үндсэн 3 түвшинд зохион байгуулна. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд бэлчээрийг улирлаар ашиглах, зун-намрын бэлчээрийг сар, улирал, богино хугацаагаар сэлгэх, ашиглах, өнжөөх хуваарь, отор нүүдэл хийх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хадлангийн талбайг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, доройтсон бэлчээрийг сэргээн сайжруулах зэрэг бэлчээрийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах талууд, шаардлагатай төсвийг эх үүсвэрийн хамт тусгана.

2.3.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална:

2.3.1.Бэлчээрийн экологийн чадавх, сүүлийн 3-аас доошгүй жилийн дунджаар тооцсон даац багтаамжид суурилах,

2.3.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах.

2.4.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид “бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гэх) нь дараах шаардлагыг хангасан байна.

2.4.1.Бэлчээр ашиглалтын нөлөөг хянах фото мониторингийн үр дүн болон бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгаа, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө дээр үндэслэсэн байх,

2.4.2.Бэлчээрийн тухайн жилийн нөөц, даацад тохируулан бэлчээр сэлгэх, өнжөөх хуваарьтай ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх бэлчээр нутаг, үргэлжлэх хугацааг тодорхойлж зурагласан байх,

2.4.3.Бэлчээрийг ашиглалтаас чөлөөлж хамгаалах арга хэмжээг бэлчээрийн ургамлын өсөлт хөгжлийн үе шат болон байгалийн жамаар сэргэн ургах чадавхтай үялдуулсан байх,

2.4.4.Бэлчээрийн ургац сайтай хэсгээс хадлан бэлтгэх, мониторингийн байнгын цэг байгуулснаар мониторингийн дүн мэдээнд үндэслэж хадлангийн талбайг тордож сайжруулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх,

2.4.5.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг тодорхой хуваарь, нөхцөл болзлын дагуу нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх,

2.4.6.Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал, цаг уурын ажилтан нар хамтран тухайн жилийн бэлчээрийн даацад үндэслэн баг тус бүрийн болон бэлчээр ашиглагч малчид, малчдын бүлэг, хэсгийн бэлчээр нутагт өвөлжих, хаваржих малын тоог тооцож жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багийн Засаг даргад хүргүүлнэ.

2.4.7.Багийн Засаг дарга нар тус багийн иргэдийн Нийтийн Хурлаар энэ журмын 2.3.6-д заасан малын тоо, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн саналд тулгуурлан дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэлэлцүүлж сумын Засаг даргад хүргүүлнэ.

2.4.8.Газрын тухай хуулийн 52.1-д заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал нь баг бүрийн иргэдийн Нийтийн Хурлаар дэмжигдсэн бэлчээр ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө (цаашид СГЗБТЖТ гэх)-нд тусган жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

2.4.9.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан СГЗБТЖТ-г тухайн ондоо багтааж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын веб сайтад байршуулна.

2.4.10.Тухайн сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч, ашиглагч нь бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө, хуваарийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллана.

2.4.11.Сумын болон сум дундын отрын нөөц бэлчээрийн тухайн жилийн даац, багтаамжид үндэслэн оруулах малчин өрх болон малын тоог сумын Засаг даргын дэргэдэх бэлчээр, мал аж ахуйн асуудал хариуцсан “Хөдөө аж ахуйн хороо” (хороо) тооцож, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгана.

2.4.12.Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр сумын болон сум дундын отрын нөөц бэлчээрт авсан газрын ашиглалттай холбогдуулан авах арга хэмжээг СГЗБТЖТ-д тусгуулах, хэрэгжилтийг хянаж ажиллана.

## ГУРАВ. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.

3.1.Бэлчээр ашиглалтыг тухайн аймаг, сум, багийн бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт болон мониторингийн тухайн жилийн дүн мэдээлэлд үндэслэн улирлаар, сараар, тодорхой хоног хугацаагаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.2.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний дагуу ашиглах ерөнхий зохицуулалтыг баримтална.

3.3.Зуслан-намаржааны бэлчээрийг СГЗБТЖТ-ний дагуу өрх, хот айл, бүлэг, хэсгээр зүй зохистой ашиглах бөгөөд зөвшөөрөлгүйгээр мал оруулахыг хориглоно.

3.4.Бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулж байгаа болон уламжлалт зохицуулалтаар ашиглаж байгаа бэлчээрээр мал дайран өнгөрөх, тууварлах, түр буудаллах хугацааг тухайн сумын онцлогт тохируулан 2-5 хоногоос илүүгүйгээр тогтооно.

3.5.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг 5 дугаар сарын 15-ны дотор ашиглалтаас бүрэн чөлөөлнө.

3.6. Бэлчээрийн газрыг урт богино хугацаагаар чөлөөлөх, малын тоо, сүргийн бүтцийг бэлчээрийн нөөц, зах зээлийн эрэлтэд нийцүүлэх зорилгын хүрээнд гаднаас мал оруулах, оторлуулах талаар баримталж буй бодлого, арга хэмжээний талаар хөрш зэргэлдээ сумдад албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллана.

3.7.Улирлаар ашиглах бэлчээрээс нүүх, буух хугацааг тухайн бүс нутгийн онцлог ба цаг агаарын тухайн жилийн нөхцөлөөс хамааруулан сум түс бүр өөрчилж болох бөгөөд энэ өөрчлөлт нь зөвхөн тухайн улирал, жилд мөрдөгдөнө.

3.8.Тариалангийн бүс нутгийн бэлчээрийг зөвхөн тухайн оны 10 дугаар сарын 15-аас дараа оны 5 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд ашиглана.

3.9.Зуслан-намаржааны бэлчээрийг тариалангийн талбайн захаас 500 метрээс доошгүй зайд байрлахаар зохион байгуулалт хийж, бэлчээр ашиглалтыг зохицуулна.

3.10.Шилжин ирэхээр хүсэлтээ гаргасан мал бүхий малчин өрхийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.1-т заасны дагуу тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар оруулж, шилжиж ирсэн тохиолдолд багийн иргэдийн Нийтийн Хурлаас өвөлжөө, хаваржааны нутгийг зааж өгөх ба жилийн дөрвөн улиралд нутаглаж аймаг, сум, багаас баталсан журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

3.11. Сумын отрын нөөц бэлчээрт орох, гарах буюу дамжин өнгөрөх маршрутыг сумын Засаг даргын захирамжаар тогтооно.

3.12.Отрын нөөц бэлчээрт орох малд тухайн сумын Мал эмнэлгийн тасаг малын эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

3.13.Зун-намрын бог мал оторлолтыг 7 дугаар сарын 20-оос хожимдуулалгүй эхлүүлэх, адууг өвлийн оторт 12 дугаар сарын дундаас оройтуулалгүй гаргах, бог мал төллөсний дараа отроос буух ажлыг зохион байгуулна.

3.14.Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн зурвас газрын бэлчээрийг ашиглахдаа холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

3.15.Аливаа бэлчээрийн ашиглалтын горим ачааллыг тухайн экосистемийн хэвийн үйл ажиллагаа, экосистем дэх байгалийн баялаг, зэрлэг ан амьтад, тэдгээрийн амьдрах орчин нөхцөлийг цогцоор нь хангах түвшинд тохируулна.

3.16.Бэлчээрийн доройтлыг бууруулах, доройтсон бэлчээрийг сэргээн сайжруулахын тулд орон нутгийн зам болон малын хөлөөс чөлөөлсөн бэлчээрийг тэмдэгжүүлэх, шинэ зам гаргахгүй байх, чөлөөлсөн бэлчээрт мал оруулахгүй байх анхааруулга тэмдгийг тавих ажлыг сүм, багийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлнэ.

3.17. Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд өвөлжөө, хаваржаа барих асуудлыг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, гаргасан саналыг СГЗБТЖТ-д тусган батлуулсны үндсэн дээр сумын Засаг дарга зохицуулж шийдвэрлэнэ.

3.18.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын зардлыг сумын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлнэ.

#### **ДӨРӨВ. Бэлчээрийн төлөв байдал, ашиглалтын нөлөөг хянах.**

4.1.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт болон бэлчээр ашиглалтын нөлөөг фото мониторингийн үр дүнгээр үнэлнэ.

4.2.Бэлчээрийн төлөв байдал, бэлчээр ашиглалтын нөлөөг үнэлж, ургац тогтоохдоо бэлчээр ашиглагчид болон улирлын бэлчээрийг төлөөлөхүйц мониторингийн цэгүүдийг хамруулж үндэсний түвшний нэгдсэн арга аргачлалыг баримтална .

4.3.Бэлчээрийн Фото мониторингийн цэгийг сонгохдоо бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгүүд, түүний дотор улирлын бэлчээрийн ашиглалтын горим ачаалал, сэргэн ургалтыг төлөөлөх чадварыг нь харгалзах бөгөөд энэ ажилд малчид, малчдын бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулна.

4.4.Фото мониторингийн цэгийн байршлыг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж, сумын бэлчээр ашиглалтын зурагт нэг бүрчлэн тэмдэглэнэ.

4.5.Фото мониторингийн анхдагч мэдээлэл болох зурган мэдээлэлд боловсруулалт хийж, бэлчээрийн ургамлыг аж ахуйн бүлгээр ангилан эзлэх хувь хэмжээн дээр тулгуурлан тухайн бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ “Монгол орны бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийн загвар” каталогийг ашиглан сэргэх чадавхыг тодорхойлно.

4.6. Фото мониторингийн хүрээнд Газрын даамал, ХААТ-ийн мэргэжилтэн, цаг уурын ажилтан нар хамтран бэлчээрийн даац, ачааллыг ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 8 сарын 5-ны өдрийн тушаалаар баталсан “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалаар тооцно,

4.7. Малын тоог даацад тохируулах сүргийн эргэлтийн үрт богино хугацааны төлөвлөлтийг бэлчээрийн сүүлийн 3 жилийн даац багтаамжийн дунджаар тооцно.

4.8. Фото мониторингийн байнгын цэгүүдээс гадна тодорхой зорилгоор цэг шинээр нэмж байгуулах, мөн хасах боломжтой.

4.9.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь сумдын бэлчээрийн ургац, даацын мэдээг нэгтгэн холбогдох байгууллага, сумдыг мэдээллээр хангана.

## **ТАВ. Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг.**

5.1. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь бэлчээр ашиглалтын талаар дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

5.1.1. Бэлчээрийн даацад тохирсон тооны малыг өсгөн үржүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх.

5.1.2. Малын тоо толгойг даацад тохируулах сүргийн эргэлтийн урт богино хугацааны төлөвлөлттэй уялдуулан, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх.

5.1.3. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажилд оролцож, бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх, гарсан шийдвэрийг дагаж мөрдөх.

5.1.4. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарьт тусгагдсан, тэмдэг тэмдэглэгээ бүхий бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх, өвөлжөө, хаваржааг зөвшөөрөлгүйгээр шинээр барихгүй байх.

5.1.5. Бэлчээр, байгаль орчин, усны эх үүсвэрийг хог хаягдал, хортой зүйлс, малын шавхай бууц, сэг зэмээр бохирдуулахгүй байх, бохирдуулсан тохиолдолд тухай бүр цэвэрлэдэг байх.

5.1.6. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх, мод тарихаас бусад зорилгоор бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх.

5.2. Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн зохион байгуулалтад орсон малчид нь Газрын тухай хуулийн 52.2-ыг үндэслэн сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулна.

5.3. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх зорилгоор хашсан бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.5 -д заасны дагуу тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.

5.4. Энэ журмын 5.2, 5.3-т зааснаас бусад малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжтэй бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахгүй.

5.5. Өвөлжөө-хаваржаа, зуслан-намаржааны бэлчээр, хашаа хороо, худаг уст цэгт мал оруулах, бусдад дамжуулан ашиглуулах, түрээслүүлэх, шилжүүлэх тохиолдолд сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

5.6. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн санд төслийн санал хүргүүлэх, дэмжигдсэн төслийг хэрэгжүүлнэ,

5.7. Бэлчээрийн менежментийн чиглэлээр улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан болон бусад санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллана.

5.8. Хөдөө аж ахуйн хорооны бүрэлдэхүүнд сумын Бэлчээр ашиглагчдын холбооны төлөөллийг оролцуулна.

**ЗУРГАА. Бэлчээр ашиглалтыг сайжруулах талаар аймаг, сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны болон тухайн шатны Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагаа.**

### **6.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.1.1.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг хэлэлцэх, батлах, хэрэгжилтэд хяналт тавих, өөрчлөлт оруулах, чиглэл өгөх.

6.1.2.Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан аймгийн нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоох.

6.1.3.Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.4-ийг үндэслэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор ашигт малтмалын орд бүхий тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, нөөц бэлчээрийн зориулалтаар ашиглах тухай шийдвэр гаргах.

6.1.4.Байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх чиглэлээр бодлогын баримт бичиг гаргах.

6.1.5.Журмын хэрэгжилтийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, шагнаж урамшуулах.

### **6.2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.2.1.Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан сумын нутагт дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал аж ахуй, зөгийн аж ахуй зэрэг бэлчээр ашиглагч бусад аж ахуйг хөгжүүлэхдээ бэлчээрийн сэргэх экологийн чадавх, тохиромжтой болон хэрэгцээт байдлыг үндэслэн бүсчлэн тогтоох.

6.2.2.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх.

6.2.3.Энэхүү журмыг үндэслэн сумын онцлог байдалд нийцүүлэн “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам” төслийг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

### **6.3.Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.3.1.Жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.

6.3.2.Тухайн жилд хийж гүйцэтгэх бэлчээрийн менежментийн арга хэмжээний санал, шаардагдах зардлыг хэлэлцэж, сумын Засаг даргад уламжлах.

6.3.3.Бэлчээрийн даацыг тодорхойлох болон бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд малчид, малчдын бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулах.

6.3.4.Бэлчээрийн менежментийн зардлын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих.

### **6.4. Аймгийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

6.4.1.Журмын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд холбогдох мэргэжлийн байгууллага, сумын Засаг дарга нартай хамтран зохион байгуулж, гүйцэтгэл, үр дүнг хянах, тайлагнах.

6.4.2.Сумын Засаг даргын ажлын үнэлгээнд тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний биелэлт, энэхүү журмын хэрэгжилтийн үр дүнг харгалзан үзэх,

6.4.3.Эрсдэлийн үнэлгээг үндэслэн ган болсон, өвөлжилт хүндэрсэн сум, багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй сум, багийн нутаг дэвсгэрт айл өрх, мал сүргийг тухайн сумын Засаг дарга нартай зөвшилцөн оруулах.

6.4.4.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг үр дүнтэй хэрэгжүүлсэн, алслагдсан болон ашиглалтгүй бэлчээрийг ашигласан, өвөл, зуны отор нүүдэл хийсэн, хадлангийн талбайг тордож сайжруулсан, бууцны хөлд ногоон тэжээл тариалах зэргээр манлайлан ажилласан малчид, малчдын бүлэг, хэсэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох.

6.4.5.Бэлчээрийн даацаас хэтэрсэн мал болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, малын чанарыг сайжруулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

6.4.6.Улс, аймгийн аварга малчин өрх, аймгийн залуу аварга малчин гэр бүлийг тодорхойлох, шалгаруулахдаа бэлчээр ашиглалтын журам, гэрээний хэрэгжилт, үр дүнг харгалзах.

6.4.7.Сумын болон сум дундын отрын нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх, цаг хүндэрсэн тохиолдолд ашиглах арга хэмжээг бэлчээрийн нөөц, чадавхад тохируулан зохион байгуулах.

6.4.8.Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, нэгдсэн удирдлагаар хангах.

#### **6.5.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

6.5.1.Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох.

6.5.2.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

6.5.3.Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний биелэлт болон энэ журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох.

6.5.4.Энэ журмын хэрэгжилт, бэлчээр ашиглах гэрээний хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй баг, малчдын бүлэг, хэсэг, малчин, мал бүхий өрхийг давуу эрхээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох.

6.5.5.Гол горхи, булаг шандын эх ундаргыг хамгаалах, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, доройтсон бэлчээрийг сайжруулахаас бусдаар бэлчээр хаших тохиолдолд сумын Засаг даргаас зөвшөөрөл авах.

6.5.6.Малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах, бэлчээрийг зохистой ашиглах дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах.

6.5.7.Цаг хүндэрсэн тохиолдолд сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжих, хаваржих малыг оруулахдаа энэ журам болон багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг танилцуулж зөвшилцсөний үндсэн дээр тухайн малчин өрхтэй гэрээ байгуулж, бэлчээр нутгийг зааж өгч нэвтрүүлэх.

6.5.8.Бэлчээрийн даацыг тодорхойлох, суурь судалгааны тогтоогдсон цэгүүдийг хамгаалах, мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

6.5.9.Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, нэгдсэн удирдлагаар хангах.

6.5.10.Сумын төв, суурин газарт мал оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх.

#### **6.6.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.6.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, санал авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

6.6.2.Энэ журамд заасан үйл ажиллагааг зохион байгуулах.

6.6.3.Тухайн жилд хэрэгжүүлэх сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөлд малчин өрх, малчдын бүлэг, хэсгийн саналыг авч тусгах, бэлчээрийн менежментийн холбогдолтой асуудлыг сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах.

6.6.4.Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан санал, шийдвэр, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглах хуваарийг малчин өрхүүдэд танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

6.6.5.Бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн талбай болон бэлчээр, үст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах.

### **ДОЛОО. Журмыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын үйл ажиллагаа.**

#### **7.1.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

7.1.1.Журмын хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах.

7.1.2.Бэлчээрийн зохистой ашиглалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

7.1.3.Бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах ажлыг зохион байгуулах.

7.1.4.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан зохион байгуулах.

7.1.5.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах талаар малчид, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих.

7.1.6.Бэлчээр ашиглагч-малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, бэлчээрийг зөв ашиглах дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах.

#### **7.2.Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

7.2.1.Жил бүр сумдад бэлчээрийн газарт фото мониторинг хийж, дүнг олон жилийн дундажтай харьцуулан аймаг, сумын удирдлагад мэдээлэх.



7.2.2.Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсэг, баг, сумын тухайн жилд бэлчээрийн менежментийн чиглэлээр хийсэн ажлыг дүгнэх, дараа жилийн ажлыг төлөвлөхөд фото мониторингийн дүнг ашигладаг болох ажлыг зохион байгуулж хэвшүүлэх.

7.2.3.Сумын бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхцуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах.

7.2.4. Өвөлжөө, худаг, үст цэгийн байршлыг сумын газрын мэдээллийн санд оруулах, тогтмол шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.

7.2.5.Сумын Засаг даргатай малчдын бүлэг, хэсгийн байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээг бүртгэх, гэрээг сумын газрын мэдээллийн нэгдсэн санд оруулах ажилд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.

7.2.6.Бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах, хэрэгжилт, биелэлтийг дүгнэх чиглэлээр холбогдох албан тушаалтан, байгууллага, малчдыг мэдээллээр хангах.

7.2.7.Газрын тухай хуулийн 58.5 дахь хэсэгт заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, дүнг мэдээлэх.

**7.3.Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

7.3.1Тухайн жилийн аймаг, сум, багийн бэлчээрийн даацыг тодорхойлж, холбогдох байгууллага, албан тушаалтан, малчдад мэдээлэх.

7.3.2.Хур тунадас бага үед үүлэнд болон цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц ажиллуулах, тухайн сумын албан хүсэлтийг үндэслэн газрын генератор байрлуулж, ажиллуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулна.

7.3.3. Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажилд оролцож ажиллана.

### **НАЙМ. Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх.**

8.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг маргалдагч талууд болон багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, тэргүүлэгчид, багийн Засаг дарга, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн ахлагч нарын төлөөллийг байлцуулан зөвшилцөж, журмын хүрээнд эвлэрлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2.Маргалдагч талууд эс тохиролцсон тохиолдолд аймаг, сумын Засаг даргын хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хуулийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

8.3.Бэлчээрт учирсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоолгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлүүлнэ.

8.4.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай болон бусад хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.

### **ЕС. Журам хүчин төгөлдөр болох.**

9.1.Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

-----””-----

Загвар-5: Суманд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутаг тогтоох тухай сумын ИТХ-ын тогтоолын загварын төсөл:

## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны ... дугаар сарын ... ны өдөр № ...

### ..... суманд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутаг тогтоох тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 дэх заалтыг үндэслэн ..... сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан суманд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоож хавсралтаар баталсугай.

Хоёр. Суманд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоосон тухай багийн Засаг дарга нарыг мэдээллээр хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга ..... овогтой ..... -нд даалгасугай.

Гурав. Тогтоосон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн зураглалыг газрын бүртгэлд оруулах ажлыг сумын Газрын даамалд даалгасугай.

### СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

.....

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
20... оны ...-р сарын ...-ны өдрийн  
... хуралдааны ... дугаар  
тогтоолын 01 дүгээр хавсралт

### ..... суманд бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүс нутаг тогтоох тухай

Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг дараах байдлаар тогтоов.

..... (газрын нэр)  
..... (газрын зураглал)  
..... (хэмжээ байршил)

### ..... суманд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутаг тогтоох тухай

Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг дараах байдлаар тогтоов.

..... (газрын нэр)  
..... (газрын зураглал)  
..... (хэмжээ байршил)

Загвар-6: Сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам батлах тухай сумын ИТХ-ын тогтоол болон журмын төсөл:

МОНГОЛ УЛС  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

202.. оны ... сарын ... өдөр. Дугаар ....  
сум

Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.23, 35.1.13, 35.1.14, 48.1, 59.1.13, Газрын тухай хуулийн 52.1, 52.6, Захиргааны ерөнхий хуулийн 64.1, 66.1.1-д заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ... дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд хэрэгжүүлэх “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг ханган, үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /...../-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ..... хороонд үүрэг болгосугай.

ДАРГА ..... /...../

.....сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын

202... оны ... дүгээр сарын ... -ны өдрийн  
ээлжит ... -р хуралдааны ... дүгээр  
тогтоолын хавсралт

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь сумын бэлчээр ашиглалтыг нөөц, даацад нь тохируулах замаар бэлчээрийн ургамлын байгалийн жамаараа сэргэн ургах боломжийг бүрдүүлэх, бэлчээр ашиглалтыг экологийн чадавх болон ашиглагчдад суурилсан аргачлалаар төлөвлөх, уг төлөвлөгөөний дагуу улирлын болон богино хугацааны хуваарьтайгаар ашиглаж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

1.2.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг сумын төсөв, төлөвлөгөөнд жил бүр тусгаж Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасны дагуу санхүүжүүлнэ.

1.3.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч хариуцна.

#### **ХОЁР. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх**

2.1. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

2.2. Бэлчээр ашиглалтыг төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнг хянах үнэлэх гэсэн үндсэн 3 түвшинд зохион байгуулна. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд бэлчээрийг улирлаар ашиглах, зун-намрын бэлчээрийг сар, улирал, богино хугацаагаар сэлгэх, ашиглах, өнжөөх хуваарь, отор нүүдэл хийх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хадлангийн талбайг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, доройтсон бэлчээрийг сэргээн сайжруулах зэрэг бэлчээрийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах талууд, шаардлагатай төсвийг эх үүсвэрийн хамт тусгана.

2.3.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална:

2.3.1.Бэлчээрийн экологийн чадавх, сүүлийн 3-аас доошгүй жилийн дунджаар тооцсон даац багтаамжид суурилах,

2.3.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах.

2.4.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид “бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гэх) нь дараах шаардлагыг хангасан байна.

2.4.1.Бэлчээр ашиглалтын нөлөөг хянах фото мониторингийн үр дүн болон бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгаа, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө дээр үндэслэсэн байх,

2.4.2.Бэлчээрийн тухайн жилийн нөөц, даацад тохируулан бэлчээр сэлгэх, өнжөөх хуваарьтай ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх бэлчээр нутаг, үргэлжлэх хугацааг тодорхойлж зурагласан байх, ,

2.4.3.Бэлчээрийг ашиглалтаас чөлөөлж хамгаалах арга хэмжээг бэлчээрийн ургамлын өсөлт хөгжлийн үе шат болон байгалийн жамаар сэргэн ургах чадавхтай үялдуулсан байх,

2.4.4.Бэлчээрийн ургац сайтай хэсгээс хадлан бэлтгэх, мониторингийн байнгын цэг байгуулснаар мониторингийн дүн мэдээнд үндэслэж хадлангийн талбайг тордож сайжруулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх,

2.4.5.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг тодорхой хуваарь, нөхцөл болзлын дагуу нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх,

2.4.6.Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал, цаг уурын ажилтан нар хамтран тухайн жилийн бэлчээрийн даацад үндэслэн баг тус бүрийн болон бэлчээр ашиглагч малчид, малчдын бүлэг, хэсгийн бэлчээр нутагт өвөлжих, хаваржих малын тоог тооцож жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багийн Засаг даргад хүргүүлнэ.

2.4.7.Багийн Засаг дарга нар тус багийн иргэдийн Нийтийн Хурлаар энэ журмын 2.3.6-д заасан малын тоо, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн саналд тулгуурлан

дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэлэлцүүлж сумын Засаг даргад хүргүүлнэ.

2.4.8.Газрын тухай хуулийн 52.1-д заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал нь баг бүрийн иргэдийн Нийтийн Хурлаар дэмжигдсэн бэлчээр ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө (цаашид СГЗБТЖТ гэх)-нд тусган жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

2.4.9.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан СГЗБТЖТ-г тухайн ондоо багтааж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын веб сайтад байршуулна.

2.4.10.Тухайн сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч, ашиглагч нь бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө, хуваарийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллана.

2.4.11.Сумын болон сум дундын отрын нөөц бэлчээрийн тухайн жилийн даац, багтаамжид үндэслэн оруулах малчин өрх болон малын тоог сумын Засаг даргын дэргэдэх бэлчээр, мал аж ахуйн асуудал хариуцсан “Хөдөө аж ахуйн хороо” (хороо) тооцож, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгана.

#### **ГУРАВ. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах**

3.1.Бэлчээр ашиглалтыг тухайн сум, багийн бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт болон мониторингийн тухайн жилийн дүн мэдээлэлд үндэслэн улирлаар, сараар, тодорхой хоног хугацаагаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.2.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээнд тусгагдсан талуудын хүлээх үүргийн дагуу ашиглах ерөнхий зохицуулалтыг баримтална.

3.3.Зуслан-намаржааны бэлчээрийг СГЗБТЖТ-ний дагуу өрх, хот айл, бүлэг, хэсгээр зүй зохистой ашиглах бөгөөд зөвшөөрөлгүйгээр мал оруулахыг хориглоно.

3.4.Бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулж байгаа болон уламжлалт зохицуулалтаар ашиглаж байгаа бэлчээрээр мал дайран өнгөрөх, тууварлах, түр буудаллах хугацааг тухайн сумын онцлогт тохируулан 2-5 хоногоос илүүгүйгээр тогтооно.

3.5.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг 5 дугаар сарын 15-ны дотор ашиглалтаас бүрэн чөлөөлнө.

3.6. Бэлчээрийн газрыг урт богино хугацаагаар чөлөөлөх, малын тоо, сүргийн бүтцийг бэлчээрийн нөөц, зах зээлийн эрэлтэд нийцүүлэх зорилгын хүрээнд гаднаас мал оруулах, оторлуулах талаар баримталж буй бодлого, арга хэмжээний талаар хөрш зэргэлдээ сумдад албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллана.

3.7.Улирлаар ашиглах бэлчээрээс нүүх, буух хугацааг тухайн бүс нутгийн онцлог ба цаг агаарын тухайн жилийн нөхцөлөөс хамааруулан сум тус бүр өөрчилж болох бөгөөд энэ өөрчлөлт нь зөвхөн тухайн улирал, жилд мөрдөгдөнө.

3.8.Тариалангийн бүс нутгийн бэлчээрийг зөвхөн тухайн оны 10 дугаар сарын 15-аас дараа оны 5 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд ашиглана.

3.9.Зуслан-намаржааны бэлчээрийг тариалангийн талбайн захаас 500 метрээс доошгүй зайд байрлахаар зохион байгуулалт хийж, бэлчээр ашиглалтыг зохицуулна.

3.10. Шилжин ирэхээр хүсэлтээ гаргасан мал бүхий малчин өрхийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.1-т заасны дагуу тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар оруулж, шилжиж ирсэн тохиолдолд багийн иргэдийн Нийтийн Хурлаас өвөлжөө, хаваржааны нутгийг зааж өгөх ба жилийн дөрвөн улиралд нутаглаж сум, багаас баталсан журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

3.11. Сумын отрын нөөц бэлчээрт орох, гарах буюу дамжин өнгөрөх маршрутыг сумын Засаг даргын захирамжаар тогтооно.

3.12. Отрын нөөц бэлчээрт орох малд тухайн сумын Мал эмнэлгийн тасаг малын эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

3.13. Зун-намрын бог мал оторлолтыг 7 дугаар сарын 20-оос хожимдүүлалгүй эхлүүлэх, адууг өвлийн оторт 12 дугаар сарын дундаас оройтуулалгүй гаргах, бог мал төллөсний дараа отроос бүүх ажлыг зохион байгуулна.

3.14. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн зурвас газрын бэлчээрийг ашиглахдаа холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

3.15. Аливаа бэлчээрийн ашиглалтын горим ачааллыг тухайн экосистемийн хэвийн үйл ажиллагаа, экосистем дэх байгалийн баялаг, зэрлэг ан амьтад, тэдгээрийн амьдрах орчин нөхцөлийг цогцоор нь хангах түвшинд тохируулна.

3.16. Бэлчээрийн доройтлыг бүүруулах, доройтсон бэлчээрийг сэргээн сайжруулахын тулд орон нутгийн зам болон малын хөлөөс чөлөөлсөн бэлчээрийг тэмдэгжүүлэх, шинэ зам гаргахгүй байх, чөлөөлсөн бэлчээрт мал оруулахгүй байх анхааруулга тэмдгийг тавих ажлыг сум, багийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлнэ.

3.17. Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд өвөлжөө, хаваржаа барих асуудлыг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, гаргасан саналыг СГЗБТЖТ-д тусган батлуулсны үндсэн дээр сумын Засаг дарга зохицуулж шийдвэрлэнэ.

3.18. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын зардлыг сумын төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлнэ.

3.19. Малын тоо толгойн албан татварын орлогын 70-аас доошгүй хувийг бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг сайжруулахад зарцуулна.

#### **ДӨРӨВ. Бэлчээрийн төлөв байдал, ашиглалтын нөлөөг хянах,**

4.1. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт болон бэлчээр ашиглалтын нөлөөг фото мониторингийн үр дүнгээр үнэлнэ.

4.2. Бэлчээрийн төлөв байдал, бэлчээр ашиглалтын нөлөөг үнэлж, ургац тогтоохдоо бэлчээр ашиглагчид болон улирлын бэлчээрийг төлөөлөхүйц мониторингийн цэгүүдийг хамруулж үндэсний түвшний нэгдсэн арга аргачлалыг баримтална.

4.3. Бэлчээрийн Фото мониторингийн цэгийг сонгохдоо бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгүүд, түүний дотор улирлын бэлчээрийн ашиглалтын горим ачаалал, сэргэн ургалтыг төлөөлөх чадварыг нь харгалзах бөгөөд энэ ажилд малчид, малчдын бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулна.

4.4. Фото мониторингийн цэгийн байршлыг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж, сумын бэлчээр ашиглалтын зурагт нэг бүрчлэн тэмдэглэнэ.

4.5. Фото мониторингийн анхдагч мэдээлэл болох зурган мэдээлэлд боловсруулалт хийж, бэлчээрийн ургамлыг аж ахуйн бүлгээр ангилан эзлэх хувь хэмжээн дээр тулгуурлан тухайн бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ “Монгол орны бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийн загвар” каталогийг ашиглан сэргэх чадавхыг тодорхойлно.

4.6. Фото мониторингийн хүрээнд Газрын даамал, ХААТ-ийн мэргэжилтэн, цаг уурын ажилтан нар хамтран бэлчээрийн даац, ачааллыг ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 8 сарын 5-ны өдрийн тушаалаар батлагдсан “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалаар тооцно,

4.7. Малын тоог даацад тохируулах сүргийн эргэлтийн урт богино хугацааны төлөвлөлтийг бэлчээрийн сүүлийн 3 жилийн даац багтаамжийн дунджаар тооцно.

4.8. Фото мониторингийн байнгын цэгүүдээс гадна тодорхой зорилгоор цэг шинээр нэмж байгуулах, мөн хасах боломжтой.

#### **ТАВ. Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг.**

5.1. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь бэлчээр ашиглалтын талаар дараах нийтлэг эрх, үүрэгтэй.

5.1.1. Бэлчээрийн даацад тохирсон тооны малыг өсгөн үржүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх.

5.1.2. Малын тоо толгойг даацад тохируулах сүргийн эргэлтийн урт богино хугацааны төлөвлөлттэй уялдуулан, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх.

5.1.3. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажилд оролцож, бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх, гарсан шийдвэрийг дагаж мөрдөх.

5.1.4. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарьт тусгагдсан, тэмдэг тэмдэглэгээ бүхий бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх, өвөлжөө, хаваржааг зөвшөөрөлгүйгээр шинээр барихгүй байх.

5.1.5. Бэлчээр, байгаль орчин, усны эх үүсвэрийг хог хаягдал, хортой зүйлс, малын шавхай бууц, сэг зэмээр бохирдуулахгүй байх, бохирдуулсан тохиолдолд тухай бүр цэвэрлэдэг байх.

5.1.6. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх, мод тарихаас бусад зорилгоор бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх.

5.2. Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн зохион байгуулалтад орсон малчид нь Газрын тухай хуулийн 52.2-ыг үндэслэн сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж болно.

5.3. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх зорилгоор хашсан бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.5 -т заасны дагуу тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.

5.4. Энэ журмын 5.2, 5.3-д зааснаас бусад малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжтэй бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахгүй.

5.5. Өвөлжөө-хаваржаа, зуслан-намаржааны бэлчээр, хашаа хороо, худаг уст цэгт мал оруулах, бусдад дамжуулан ашиглуулах, түрээслүүлэх, шилжүүлэх тохиолдолд сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

5.6. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор ОНХС-д төслийн санал хүргүүлэх, дэмжигдсэн төслийг хэрэгжүүлэх,

5.7. Бэлчээрийн менежментийн чиглэлээр улсын төсөв, ОНХС болон бусад санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах.

5.8. Хөдөө аж ахуйн хорооны бүрэлдэхүүнд сумын Бэлчээр ашиглагчдын холбооны төлөөллийг оролцуулна.

**ЗУРГАА. Бэлчээр ашиглалтын талаар сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, тухайн шатны Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагаа.**

**6.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.1.1. Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлыг шаардлагатай төсвийн хамт тусгаж батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх.

6.1.2. Энэхүү Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын төслийг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

6.1.3. Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал аж ахуй, зөгийн аж ахуй зэрэг бэлчээр ашиглагч бусад аж ахуйг хөгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавх, тохиромжтой болон хэрэгцээт байдлыг үндэслэн бүсчлэн тогтоох.

**6.2. Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.2.1. Жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.

6.2.2. Тухайн жилд хийж гүйцэтгэх бэлчээрийн менежментийн арга хэмжээний санал, шаардагдах зардлыг хэлэлцэж, сумын Засаг даргад уламжлах.

6.2.3. Бэлчээрийн даацад малын тоо, нягтралыг тохируулах боломжит хувилбарыг тодорхойлох болон бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд малчид, малчдын бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулах.

6.2.4. Бэлчээрийн менежментийн зардлын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих.

**6.3. Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

6.3.1. Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох.

6.3.2. Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

6.3.3. Багийн Засаг дарга, мэргэжилтнүүдийн ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох.

6.3.4. Энэ журмын хэрэгжилт, бэлчээр ашиглах гэрээний хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй баг, малчдын бүлэг, хэсэг, малчин, мал бүхий өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох.



6.3.5.Гол горхи, булаг шандын эх ундаргыг хамгаалах, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, доройтсон бэлчээрийг сайжруулахаас бусад тохиолдолд бэлчээр хашихыг хориглох.

6.3.6.Малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах, бэлчээрийг зохистой ашиглах дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах.

6.3.7.Цаг хүндэрсэн тохиолдолд сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжих, хаваржих малыг оруулахдаа энэ журам болон багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг танилцуулж зөвшилцсөний үндсэн дээр тухайн малчин өрхтэй гэрээ байгуулж, бэлчээр нутгийг зааж өгч нэвтрүүлэх.

6.3.8. Хөдөө аж ахуйн хороог байгуулах, хорооны үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, нэгдсэн удирдлагаар хангах.

6.3.9. Хороо нь ОНХС-ийн Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны саналыг эрэмбэлэх, санхүүжүүлэх талаар санал дүгнэлт боловсруулах, танилцуулж шийдвэрлүүлэх

6.3.10.Сумын нутаг дэвсгэрт дэх төв, суурин газарт мал оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх.

#### **6.4.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.4.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, санал авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

6.4.2.Энэ журамд заасан үйл ажиллагааг зохион байгуулах.

6.4.3.Тухайн жилд хэрэгжүүлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөлд малчин өрх, малчдын бүлэг, хэсгийн саналыг авч тусгах, сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах.

6.4.4.Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан санал, шийдвэр, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглах хуваарийг малчин өрхүүдэд танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

6.4.5.Бүсдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн талбай болон бэлчээр, үст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах.

#### **ДОЛОО. Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх.**

7.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг маргалдагч талууд болон багийн Засаг дарга, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн ахлагч нарын төлөөллийг байлцуулан зөвшилцөж, журмын хүрээнд эвлэрлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Маргалдагч талууд эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

7.3. Тавиул малын албан татварыг өмчлөгч талын харьяа сум, дүүргийн татварын албанаас нэхэмжилж тухайн тавиул мал байгаа өөрийн сум, дүүргийн ОНХС-д төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.

7.4.Бэлчээрт учирсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлүүлнэ.

7.5.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай болон бусад хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.

-----“”-----

Судалгааны үндсэн чиглэлийн нэг болох бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын гэрээний шинэ загвар боловсруулах ажлын хүрээнд уг гэрээг байгуулахтай холбогдон гарах эрх зүйн акт, баримт бичгүүд (сумын Засаг даргын захирамж, журмын төсөл, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зорилгоор ашиглах бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээ)-ийн төслийг цогцоор нь боловсруулав.
---

Газрын тухай хууль болон холбогдох хуульд заасан эрх зүйн зохицуулалтаар бэлчээрийн газрыг гэрээ байгуулах замаар зохистой ашиглах, хамгаалах хууль зүйн үндэслэл, судалгаанд хамрагдсан зорилтот хоёр аймгийн сумдад байгуулсан малчдын оролцоотой бүлэг, хэсгийн бэлчээр ашиглалтын гэрээнүүдэд үнэлгээ хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан уг гэрээний загварыг шинээр боловсруулах шаардлага байна гэж үзэв. Хууль болон судалгааны үр дүнд бэлчээрийн газрыг малчдын хамтын байгууллагад гэрээгээр ашиглуулах үе шатыг дараах бүдүүвчээр илэрхийлж болохоор байна.

**Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах үе шат БНХМН-тэй Засаг дарга гэрээ байгуулах үе шат БНХМН-тэй Засаг дарга гэрээ байгуулах үе шат**

Малчдын оролцоотой БНХМБ-ын гишүүдийн хурлаар бэлчээрийг гэрээгээр дундаа хамтран ашиглах талаар хэлэлцэж олонхийн саналд үндэслэн шийдвэр гаргах. Иргэний хуулийн 481.1 Малчдын гишүүдийн хурлаар БНХМН байгуулан хамтран ажиллах талаар хэлэлцэн шийдвэрлэх. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (цаашид БОХТХ гэх)-ийн

Малчдын оролцоотой БНХМБ бэлчээрийг гэрээгээр дундаа хамтран ашиглах тухай хүсэлт бүхий хурлын шийдвэрээ баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд уламжлах. Газрын тухай хуулийн 52.2 БНХМН-ийн гишүүн болохоо илэрхийлж иргэний үнэмлэхний хvvлбараа хавсаргаж хамтран ажиллах гэрээ байгуулах. БОХТХ-ийн

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар малчдын хамтын байгууллагын хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх. Газрын тухай хуулийн 52.2 БНХМН-ийн бүх гишүүдийн хурлаар байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах менежментийн төлөвлөгөөг хэлэлцэн

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал Малчдын оролцоотой БНХМБ-д бэлчээрийг гэрээгээр ашиглуулах талаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд дэмжсэн тухай уламжлах. Газрын тухай хуулийн 52.2 БНХМН-ийн бүх гишүүдийн хурлын шийдвэрээ багийн иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж БНХМН-аар хэлэлцэн санал гаргах БОХТХ-ийн 50.4.1

Сумын Засаг Дарга Малчдын оролцоотой БНХМБ-д бэлчээрийг гэрээгээр ашиглуулах талаар захирамж үйлдэх. Газрын тухай хуулийн 52.2 Багийн иргэдийн Нийтийн Хурлаас БНХМН байгуулсан талаарх саналаа Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан СИТХ-

Бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах. Газрын тухай хуулийн 52.2 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас БНХМН байгуулсан шийдвэрийг сумын Засаг даргад уламжлах

Сумын Газрын Даамал тухайн ашиглалтад олгох бэлчээрийн газрын хэмжээ, заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, координатжуулах, кадастрын зургийг үйлдэх. Газрын тухай хуулийн 23.4.3 БНХМН нь байгалийн нөөцийн менежмент явуулахыг хүссэн өргөдлөө сумын Засаг даргад уламжлах. БОХТХ-ийн 50.4.2

БНХМН нь байгалийн нөөцийн менежмент явуулахыг хүссэн өргөдлөө сумын Засаг даргад уламжлах. БОХТХ-ийн 50.4.2

Сумын Газрын даамал гэрээгээр ашиглалтад олгогдсон бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийн зургийг газрын улсын бүртгэлд бүртгэх. Газрын тухай хуулийн 23.4.3

Загвар-7: Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах тухай сумын Засаг даргын захирамжийн төсөл:

..... СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20... оны ... дугаар  
сарын ... ны өдөр

№ ...

.....

**Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.17 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ....сумын .....багийн бүлэг, хэсгийн зохион байгуулалтад орсон бэлчээр ашиглагчид болох малчдын оролцоотой ..... БНХМБ-д бэлчээрийг гэрээгээр ..... жилийн хугацаагаар ашиглуулсугай.

Хоёр. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ... тоот тогтоолоор батлагдсан “Сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-д нийцүүлэн бэлчээр ашиглалтын гэрээний загварыг хавсралт ёсоор баталсугай.

Гурав. Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээ заагийг тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын нэгдмэл сангийн бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг сумын Газрын даамалд үүрэг болгосугай.

Загвар-8: Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний загварын төсөл (Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх)

№

**БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ГЭРЭЭ**

Энэ гэрээг..... аймгийн ..... сумын Засаг даргын .... оны .... дугаар сарын ....-ны өдрийн .... дугаар захирамж, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дугаар заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.6, 8.4.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3, 9 дүгээр зүйлийн 9.8, 15 дугаар зүйлийн 15.2, 21 дугаар зүйлийн 21.3, Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-д заасныг тус тус үндэслэн нэг талаас өмчлөгчийг төлөөлөн сумын Засаг дарга ..... овогтой ..... (цаашид ашиглуулагч гэх), нөгөө талаас бэлчээрийг хамтран ашиглагчийг төлөөлөн “.....” малчдын оролцоотой БНХМБ-ын ахлагч ..... овогтой ..... (цаашид ашиглагч гэх) нар бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. Гэрээний зорилго**

1.2. Талууд хоорондын бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх болон бэлчээртэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

### **ХОЁР. Өмчлөл**

- 2.1. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар бэлчээр нь төрийн өмч байна.
- 2.2. Ашиглуулагч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ энэхүү гэрээнд заасан хэмжээ, байршил бүхий бэлчээрийг ашиглагчид ашиглуулах боломжоор хангана.
- 2.3. Энэхүү гэрээнд заасан бэлчээрийн газар нь бусдын эзэмшил, ашиглалтад олгосон бэлчээр, газартай давхцаагүй болохыг ашиглуулагч батлав.
- 2.4. Энэхүү гэрээг байгуулахаас өмнө ашиглагчийн ахлагч нь ашиглагчийн гишүүдийн хурлаар гэрээний нөхцөлүүдийг танилцуулж энэ талаар хэлэлцэн, гишүүдийн гаргасан саналд үндэслэн ашиглуулагчтай гэрээ байгуулав.

### **ГУРАВ. Бэлчээрийн зориулалт, хэмжээ, байршил, бэлчээрийн даац**

- 3.1 Бэлчээрийг мал, амьтан бэлчээх зориулалтаар зөвхөн гэрээнд заасан нөхцөлийн дагуу ашиглуулна.
- 3.2 Бэлчээр ашиглагчдын өрхийн мэдээлэл (Хавсралт №01), бэлчээрийн хэмжээ, төлөв байдал, даац чадавхын зураглал (Хавсралт №02), бэлчээрийн газрын төлөв байдлын шилжилтийн загвар (Хавсралт №03) болон гэрээний биелэлтийг үнэлэх суурь мэдээллүүд (Хавсралт №04), сүргийн эргэлтийн төлөвлөгөө (Хавсралт №05) зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 3.3 “.....” малчдын оролцоотой БНХМБ-ын гэрээгээр ашиглах бэлчээрийн талбай нь ..... га байна. Тухайн бэлчээрийн зураглалыг энэхүү гэрээнд хавсаргав. (Хавсралт №02)
- 3.4 Бэлчээрийн талбайн хиллэх газар, зааг /эргэлтийн цэгийн солбицол/  
.....  
..
- 3.5 ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн тушаалаар батлагдсан “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалын дагуу тогтоосноор гэрээт бэлчээрийн зуны дээд ургац олон жилийн дунджаар .... кг/га байна.
- 3.6 Энэхүү гэрээний 3.3-д заасан бэлчээрийн даац нь цаг агаарын хэвийн нөхцөлд хонин толгойд шилжүүлснээр:
  - А. Өвлийн бэлчээр нь .....(хонин толгой)
  - Б. Хаврын бэлчээр нь ..... (хонин толгой)
  - В. Өвөл, хаврын бэлчээр нь ..... (хонин толгой) болно.

### **ДӨРӨВ. Бэлчээрийг ашиглуулах хугацаа**

- 4.1. Бэлчээрийг 20..... оны ..... сарын ..... өдрөөс эхлэн ..... жилийн хугацаатай ашиглуулна.
- 4.2. Энэ гэрээнд заасан хугацаанд тухайн ашиглалтад олгосон бэлчээрийн хэвийн төлөв байдлыг алдагдуулахгүйгээр зохистой ашигласан тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгана.

### **ТАВ. Бэлчээр ашиглагчийн эрх, үүрэг**

#### **5.1 Бэлчээр ашиглагч нь дараах эрхтэй.**

- 5.1.1. Бэлчээрийг гэрээнд заасан зориулалтаар ашиглаж үр шимийг хүртэх.

- 5.1.2. Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах,
- 5.1.3. Бусад байгууллагатай хамтран ажиллаж бэлчээрийн зохистой үйл ажиллагааны чиглэлээр аливаа хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх, үр ашигтай хамтран ашиглах
- 5.1.4. Гэрээний хугацааг сунгах хүсэлт гаргах.
- 5.1.5. Ашиглалтад байгаа бэлчээрт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон, анхааруулсан дохио тэмдэг тавих.
- 5.1.6. Бэлчээрт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхийг шаардах.
- 5.1.7. Гэрээнд заасан бэлчээрт бусад этгээд бэлчээрийг дур мэдэн ашигласан бол энэ талаарх үйл ажиллагааг зогсоох шаардлага тавих.
- 5.1.8. Бэлчээр зохион байгуулалтын талаар багийн иргэдийн Нийтийн Хурлаар шийдвэрлүүлэхээр өргөдөл, санал, хүсэлт гаргах.

## **5.2 Бэлчээр ашиглагч нь дараах үүрэгтэй.**

- 5.2.1 Гэрээ болон сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам, бэлчээр зохион байгуулалтын жил бүрийн төлөвлөгөөг дагаж мөрдөх.
- 5.2.2 ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-15 тушаалаар батлагдсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө”-ний дагуу тухайн бүсэд зөвшөөрөгдсөн үүлдрийн малыг өсгөн үржүүлэх, ашиглаж буй бэлчээрийн даацад малын тоог тохируулах, сүргийн зохистой бүтцийг мөрдөх,
- 5.2.3 Гишүүдийн буруутай үйл ажиллагаанаас бэлчээрт учруулсан хохирлыг өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах.
- 5.2.4 Бусдын ашиглалтад олгосон бэлчээрт отор нүүдэл хийх, мал тууварлах, дамжин өнгөрөхдөө бусдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх ба отор нүүдэл болон тууврын малыг саадгүй дамжин өнгөрөх нөхцөл боломжоор хангах.
- 5.2.5 Бэлчээрт байгаа худаг, уст цэгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамгаалах арга хэмжээ авах.
- 5.2.6 Бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээх, байгальд орчинд халгүй аргаар хортон мэрэгчдтэй тэмцэх арга хэмжээ авах,
- 5.2.7 Бэлчээрт байвал зохих малын тоо (хонин толгойд шилжүүлснээр)-г энэхүү гэрээний 3.6-д заасан даацад тохируулах, төлөв байдлыг суурь түвшин (хавсралт №04) – ээс нь доройтуулахгүйгээр ашиглах;
- 5.2.8 Мал сүргээ эрүүлжүүлэх, элдэв төрлийн малын өвчнөөс урьдчилан сэргийлэх,
- 5.2.9 Энэхүү гэрээ болон холбогдох хуульд заасан бусад үүргийг биелүүлэх.
- 5.2.10 Гишүүнчлэл солигдсон, шинээр нэмэгдсэн нөхцөлд өмчлөгчид мэдэгдэж газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлийг нэмэх, хасуулах.

## **ЗУРГАА. Ашиглуулагчийн эрх, үүрэг**

### **6.1 Ашиглуулагч нь дараах эрхтэй.**

- 6.1.1. Гэрээгээр олгогдсон бэлчээрийн газрыг мал аж ахуй эрхлэх зориулалтаар ашиглахыг шаардах.
- 6.1.2. Бэлчээрийн газарт ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-15 тушаалаар батлагдсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөний дагуу тухайн бүсэд зөвшөөрөгдсөн үүлдрийн малыг өсгөн үржүүлэх, ашиглаж буй бэлчээрийн даацад малын тоог тохируулах, сүргийн зохистой бүтцийг мөрдөж буй эсэхэд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах,
- 6.1.3. Бэлчээр ашиглалтын байдалд тогтмол хяналт тавьж, цаг үеийн байдал хүндэрсэн үед отор нүүдэл зохион байгуулах.

- 6.1.4. Буруутай этгээдээр бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах, зөрчлийг арилгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах.
- 6.1.5. Зохих зөвшөөрөлгүй орж ирсэн гадны малчдыг нүүлгэх, хуульд заасан бусад арга хэмжээ авах.
- 6.1.6. Бэлчээрийн төлөв байдлыг доройтуулсан нь эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд хохирлыг арилгуулах арга хэмжээ авах.
- 6.1.7. Холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх.

## **6.2 Ашиглуулагч нь дараах үүрэгтэй.**

- 6.2.1 Ашиглалтад олгосон бэлчээрийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад заасан бэлчээрийн зургаар ашиглагчид хүлээлгэн өгөх.
- 6.2.2 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хэмжээ байршлыг тусгах.
- 6.2.3 Гэрээгээр олгосон бэлчээрийн хэмжээ заагийг тэмдэгжүүлэх, газрын мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд бүртгүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах.
- 6.2.4 Ашиглалтад олгосон бэлчээрийг бусдад давхар олгохгүй байх нөхцөлөөр хангаж ашиглагчийн газар ашиглах хууль ёсны эрхийг хамгаалах.
- 6.2.5 Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалахтай холбоотой аливаа асуудлаар ашиглагчид дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- 6.2.6 Шаардлагатай тохиолдолд ашиглагчид бэлчээрийн дэд бүтцийг хөгжүүлэх, мал сүргийн чанар, эрүүл мэндийг сайжруулах, эрсдэлээс хамгаалахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
- 6.2.7 Бэлчээрийг төлөвлөлт, хуваарьтай ашиглах, хамгаалах, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх,
- 6.2.8 Булгийн эх хашиж хамгаалах, худаг гаргах, засварлах, хөв цөөрөм байгуулах зэрэг бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалах үйл ажиллагааг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, сайн дурын байгууллага, малчдын оролцоотой байгууллагатай хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах,

### **ДОЛОО. Гэрээг цуцлах**

- 7.1 Энэхүү гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно.
- 7.2 Бэлчээрийг зориулалтын дагуу ашиглаагүй, хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан нь тогтоогдсон.
- 7.3 Энэхүү гэрээний 3.6-т зааснаас малын тоог хэтрүүлэн ашиглаж бэлчээрийн төлөв байдлыг доройтуулсан нь эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон.
- 7.4 Ашиглагч нь холбогдох хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй, гэрээний нөхцөлийг удаа дараа ноцтойгоор зөрчсөн.

### **НАЙМ. Гамшгийн бэлэн байдал, Давагдашгүй хүчин зүйл**

- 8.1. ХХААХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тушаалаар батлагдсан “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх зааврын дагуу дунд ба дундаас дээш тарга хүчтэй тэмээ, адууны 5 хувь, үхэр, хонь, ямааны 20 хувь, ирэх онд гарах тугал, хурга, ишигний 30 хувийг нэмэгдэл тэжээлээр 90 хоног тэжээх нөөцийг бэлтгэх,
- 8.2 Бод болон бог малыг хашаа, дулаан саравчаар хангах, шаардлагатай малын эм, тарианы нөөц бэлтгэх,

8.3 Талуудын хүсэл сонирхлоос гадуур, урьдчилан мэдэх боломжгүй зуд, ган, үер ус зэрэг бусад байгалийн аюултай үзэгдэл, гал түймэр, мал амьтны гоц халдварт өвчин, эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгаа гэх мэт нөхцөл байдлын улмаас талууд гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд тусгасан нөхцөлүүдийн талаар талууд харилцан үүрэг хүлээхгүй.

8.4 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас бэлчээрийг түр ашиглах боломжгүй тохиолдолд гэрээний талууд хөрш зэргэлдээх бэлчээр ашиглагчтай харилцан тохиролцож тухайн бэлчээрийн даацад нь тохируулан бусдын бэлчээрийг ашиглаж болно.

8.5 Давагдашгүй хүчин зүйл учирсан тохиолдолд ашиглуулагчийн шийдвэрээр ашиглагч нь хөрш аймаг, сумын болон тусгай хамгаалалттай газрын бэлчээр, отрын бэлчээр, нөөц бэлчээрийг түр ашиглахад нь туслалцаа үзүүлж болох бөгөөд холбогдох этгээдтэй энэ талаар гэрээ, хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэж болно.

### **ЕС. Хариуцлага**

9.1 Ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон, анхааруулсан дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалсан газарт зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээнэ.

9.3. Талууд жил бүр гэрээний хэрэгжилтийг үндэслэн дүгнэнэ.

9.4. Хэрэв талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн холбогдох тал хариуцлага хүлээнэ.

### **АРАВ. Бэлчээр ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх**

10.1 Бэлчээрийн талаар гарсан маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэнэ. Эс тохиролцвол холбогдох хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

### **АРВАН НЭГ. Бусад**

11.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

11.2 Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг мөн.

11.3 Талууд бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

11.4 Ашиглуулагч нь Монгол Улсын хуульд заасан үндэслэлээр албан үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, өөр этгээдээр солигдсон нь энэ гэрээг цуцлах, дуусгавар болгох, түүний нөхцөлийг өөрчлөх үндэслэл болохгүй.

11.5 Гэрээнд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

11.6 Энэхүү гэрээг нийт .... эх хувь үйлдэж, талууд 20.... оны ....-р сарын ....-ны өдөр ..... сумын ..... -нд гарын үсэг зурав. Тал тус бүр энэ гэрээний нэг хувийг өөртөө хадгалав.

### **Гэрээний хавсралт баримт бичгүүд:**

Хавсралт 1. Бэлчээр ашиглагч малчдын хэсэг, бүлгийн гишүүн өрх /гишүүд/-ийн мэдээлэл,

Хавсралт 2. Гэрээт бэлчээрийн хэмжээ байршил, улирлын хуваарийн зураг,

Хавсралт 3. Бэлчээрийн газрын экологийн чадавхын зураглал, бэлчээрийн төлөв байдал, шилжилтийн загвар (экологийн бүлгүүдээр),



Хавсралт 4. Бэлчээр ашиглуулах гэрээний биелэлтийг фото мониторингийн аргаар үнэлэх суурь мэдээлэл,  
Хавсралт 5. Сүргийн эргэлтийн төлөвлөгөө.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ашиглуулагчийг төлөөлж сумын Засаг дарга .....овогтой  
.....  
Гарын үсэг .....

Ашиглагчийг ..... төлөөлж  
“.....” Малчдын  
бүлэг, хэсгийн ахлагч .....  
овогтой  
.....  
Гарын үсэг .....

ХАВСРАЛТУУД:

Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хавсралт № 01

Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээнд гарын үсэг зурсан малчин өрхийн төлөөллийн нэрсийн жагсаалт /20.. оны ... сарын....-ны өдөр/

“.....” малчдын оролцоотой БНХМБ-ын бэлчээр ашиглагч өрхийн мэдээлэл

№	Гарын үсэг зурсан гишүүний овог	Гарын үсэг зурсан гишүүний нэр	Регистр	Харьяа баг (Нэрээр)	Гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					

## Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хавсралт № 02

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын байршил, хэмжээ, улирлын хуваарь, чадавхын зураг

## Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хавсралт № 03

Гэрээт бэлчээрийн газрын төлөв байдал, шилжилтийн загвар,

Малчдын оролцоотой БНХМБ-ын Хаваржаа, бэлчээрийн төлөв байдал нь ШАВРАНЦАР хөрстэй уулын бэл хөндийн ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-АЛАГ ӨВСТ бэлчээр( жишээ)

### 2. ШАВРАНЦАР хөрстэй уулын бэл хөндийн ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-АЛАГ ӨВСТ бэлчээр

**1. Үетэн зонхилсон төлөв байдал**

Ургас: 213-313 кг/га  
Бэлчээрийн давс: 73-83 жонин толгой/100 га

Үетэн (>20%) аль (<30%) - алаг өвст бүтэцтэй

Цайвар ширээт цагаан туруу

Саман өргөг

Крыльын хөвгөн

**2. Үетэн багассан төлөв байдал**

Ургас: 244-326 кг/га  
Бэлчээрийн давс: 41-45 жонин толгой/100 га

Үетэн (<20%) - аль (>30%) - ширэг улаажит бүтэцтэй

Саман өргөг

Крыльын хөвгөн

**3. Ширэг улааж ихэссэн төлөв байдал**

Ургас: 787-888 кг/га  
Бэлчээрийн давс: 35-45 жонин толгой/100 га

Ширэг (>30%) доройтын төвгөр ургамалд зонхилсон бүтэцтэй

Ширэг улааж

Аль

**4. Шарилж доройтсон төлөв байдал**

Ургас: 787-888 кг/га  
Бэлчээрийн давс: 35-45 жонин толгой/100 га

Адамсын шарилж (>30%) улаажит бүтэцтэй

Адамсын шарилж

**Ш1, Ш2 бэлчээрийн зохисгүй ашиглалт, хуурайшилт**

Нарийн өвсний сүргэлийг дэмжих үүрэгтэй. Эргийн хуваарьтай ашиглалтыг нөвдүүлэх, өөрөөр хялбар бэлчээрээс 5-7 хэсэгт хувааж, шүүн олоо боогох, эсвэл байгалийн таних тамдаг ашиглаж зохионо ашиглах, үүний тулд байнгын харилцаа зайлшгүй чухал. Эргийн хуваарьтай ашиглалтыг нөвдүүлснээр бэлчээрийн ачаагааг 10-25 хувиар бууруулах боломжтой. 2. Хоёр тамбайг салгаж нөвдүүлэх, үүний тулд 1. Бэлчээрээ А, Б гэж 2 хувааж эхний жилийн хавар А хэсгийг эзлэж ашиглах, зуны сүүл 5 хэсгийг ашиглах. 2. Хоёр дахь жилийн хавар Б хэсгийг туруулах ашиглах, зуны сүүлээр А хэсгийг ашиглана. Харилцаатай мангалга маш чухал.

Алах шаардмалтай арга хэмжээнүүд: А. Ашигласнаас чөлөөтөн сүргээж, бага ачаагаар ашиглах хувиар; Б. Гурван жил дараахан ургамалын хугацаанд ашигласнаас чөлөөтөн, энэ хугацаанд шарилжны бүрэлдлийг хэдхэн шатаах замаар бууруулах, мөн сүргэлийг эргэмжүүлэх үүрэгтэй шав тунгаах, өтөг бууц шатаах, жортоо нэрвэгчтэй тэмцэх. 2. Ачаагааг боломжин дотоос 15 хувиар багтар тооцон 2 жил дараахан ургамал ургамалын хугацаанд ашиглах. 3. Алин гурван жилийн ургамалын ургамалын хугацаанд ашигласнаас чөлөөтөн. 4. Малын толгой боломжтой дотоос 15 хувиар багтар тооцон ажин 2 жил дараахан ургамалын ургамалын хугацаанд ашиглах. 5. Төрсний үс чийгний гөрмийг сайжруулах замаар ургамалын сүргэлийг дэмжих зорилгоор а. Харс хаваж б. Газрын намуугийн хөндлөн чиглэлд 20-30 см зайтай шав гаргах арга хэмжээ авна.

### Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хавсралт № 04

Гэрээний энэхүү хавсралт нь гэрээний биелэлтийг, өөрөөр хэлбэл гэрээт ашиглагчид бэлчээрийг хэрхэн зүй зохистой ашиглаж буйг үнэлэх суурь мэдээлэл болох бөгөөд гэрээт бэлчээрийн газрын төлөв байдлын лавлагаа түвшний экологийн бүлэг бүрээр гаргасан мэдээллийг Төлөв байдал, шилжилтийн загвар дээр үндэслэн тодорхойлох бөгөөд суурь түвшний мэдээллийг гэрээ байгуулсан даруйд фото мониторингийн аргаар тодорхойлно. Цаашид тухайн тогтсон цэг дээр, тогтсон хугацаанд давтан үнэлгээ хийж мэдээллийг санд оруулан боловсруулалт хийж ашиглана.

**Хүснэгт .** Гэрээний биелэлтийг үнэлэх суурь мэдээлэл, ..... малчдын оролцоотой БНХМБ-ын Хаваржааны бэлчээрийн дүн:

Аймгийн нэр:	.....					
Сумын нэр:	.....					
Малчдын оролцоотой БНХМБ-ын нэр:	.....					
Ашигладаг улирлын нэрийг бичнэ үү	.....					
Байгалийн бүс, бүслүүр (дугуйлна үү)	Ойт хээр					
	2022	2023	2024	2025	2026	
Нийт бүрхцийн %	86.3					
Үетэн %	0					
Улалж %	77					
Шарилж %	0					
Агь %	3					
Алаг өвс %	6					
Хагд %	11					
Халцгай газар %	3					
Бусад %	0					
Ургац, кг/га	325.3					
Нийт малын тоо, мян.толгой	59527					
Нийт малын тоо, хонин толгойд шилжүүлснээр	122624					
Боломжит даац, хт/100га	16362					
Даацаас хэтэрсэн малын тоо	-106261					
Бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загварын дугаар	2					
Төлөв байдлын нэр	Шарилж ихэссэн					
Орчны ерөнхий зураг						
Эгц дээрээс авсан зураг						

**Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хавсралт № 05**  
 Малчдын оролцоотой БНХМБ-ын сүргийн эргэлтийн төлөвлөгөө

Сүргийн зохистой бүтцийг бий болгохын тулд тухайн төрлийн малын сүргийн эргэлтийг зөв зохион байгуулах шаардлагатай байдаг.

Сүргийн эргэлт гэдэг нь тодорхой хугацаанд тухайлбал сар, улирал, жилийн дотор таны эзэмшилд байгаа малын орлого, зарлагыг буюу мал сүргийн нас, хүйсийн бүтцэд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг тусган харуулсан тооцоо байх юм. Малчин та мал сүрэгтээ эхлээд төлөвлөгөөт сүргийн эргэлт хийх замаар гүйцэтгэлийг нь тодорхой хугацааны дараа тооцож ажиллах боломжтой.

Сүргийн эргэлтийн төлөвлөгөө нь мал хээлтүүлэх, төл хүлээн авах болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөнүүдтэй нягт уялдсан байх шаардлагатай. Сүргийн эргэлтийн төлөвлөгөөгөөр зөвхөн сүргийн зохистой бүтцийг хангаад зогсохгүй түүгээр дамжуулан малын үүлдэр угсааг сайжруулах, малын төрөл хоорондын харьцааг тохиромжтой байлгах, нэг малаас үйлдвэрлэх бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах боломжийг давхар үүсгэдэг.

**Малчдын бүлгийн сүргийн эргэлт тооцооны загвар хүснэгт**

Малын төрөл, нас, хүйс	Оны эхэнд байсан малын тоо	Орлого				Зарлага			Оны эцэст байсан малын тоо
		Нас дэвшиж ирсэн	Худалдан авсан	Шилжиж ирсэн	Шинэ оны төл	Нас дэвшиж явсан	Худалдсан	Шилжүүлсэн	

Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжил арга зүйн зөвлөмжийн дагуу бэлтгэнэ.

Загвар-9: Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээ (Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх)

№

**БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ГЭРЭЭ**

Энэ гэрээг..... аймгийн ..... сумын Засаг даргын ..... оны ..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар захирамж, газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дугаар заалт, Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг тус тус үндэслэн нэг талаас өмчлөгчийг төлөөлөн сумын Засаг дарга ..... овогтой ..... (цаашид ашиглуулагч гэх), нөгөө талаас иргэн..... овогтой ....., ..... регистрийн дугаартай ..... хуулийн этгээд (аль нэгийн доогуур зурах) (цаашид ашиглагч гэх) нар эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээрийг зохистой ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. Гэрээний зорилго**

1.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаа, түүнтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. Өмчлөл

- 2.1. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар бэлчээр нь төрийн нийтийн өмч байна.
- 2.2. Ашиглуулагч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ энэхүү гэрээнд заасан хэмжээ, байршил бүхий бэлчээрийг ашиглагчид ашиглуулах боломжоор хангана.
- 2.3. Энэхүү гэрээнд заасан бэлчээрийн газар нь бусдын эзэмшил, ашиглалтад олгосон бэлчээр, газартай давхцаагүй болохыг ашиглуулагч батлав.

### ГУРАВ. Бэлчээрийн зориулалт, хэмжээ, байршил, бэлчээрийн даац

- 3.1. Ашиглалтад олгосон бэлчээрийг зөвхөн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зориулалтаар гэрээнд заасан нөхцөлийн дагуу ашиглуулна.
- 3.2. Ашиглах бэлчээрийн талбай нь ..... га байна.
- 3.3. Бэлчээрийн талбайн хиллэх газар, зааг /эргэлтийн цэгийн солбицол/  
.....

### ДӨРӨВ. Бэлчээрийг ашиглуулах хугацаа

- 4.1. Бэлчээрийг 20... оны сарын ..... өдрөөс эхлэн ..... жилийн хугацаатай ашиглуулна.
- 4.2. Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно.

### ТАВ. Бэлчээр ашиглагчийн эрх, үүрэг

#### 5.1. Бэлчээр ашиглагч нь дараах эрхтэй.

- 5.1.1. Бэлчээрийг гэрээнд заасан зориулалтаар ашиглах.
- 5.1.2. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх төлөвлөлт боловсруулах.
- 5.1.3. Бусад байгууллагатай хамтран ажиллаж эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр аливаа хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж хэрэгжүүлэх.
- 5.1.4. Гэрээний хугацааг сунгах хүсэлт гаргах.
- 5.1.5. Бэлчээрт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр шаардах.
- 5.1.6. Гэрээнд заасан бэлчээрт бусад этгээд бэлчээрийг дур мэдэн ашигласан бол энэ талаарх үйл ажиллагааг зогсоох шаардлага тавих.
- 5.1.7. ....
- 5.1.8. ....

#### 5.2. Бэлчээр ашиглагч нь дараах үүрэгтэй.

- 5.2.1. Гэрээ болон сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам дагаж мөрдөх.
- 5.2.2. Ашиглаж буй бэлчээрийн даацад малын тоог тохируулах.
- 5.2.3. Гишүүдийн буруутай үйл ажиллагаанаас бэлчээрт учруулсан хохирлыг өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах.
- 5.2.4. Бусдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх.
- 5.2.5. Бэлчээрт байгаа худаг, уст цэгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
- 5.2.6. Бэлчээр нутгаа бэлчээрийн хортон мэрэгчдээс хамгаалах, байгальд халгүй аргаар тэмцэх арга хэмжээ авах.
- 5.2.7. Мал сүргээ эрүүлжүүлэх арга хэмжээ авах.
- 5.2.8. Энэхүү гэрээ болон холбогдох хуульд заасан бусад үүргийг биелүүлэх.
- 5.2.9. ....

### ЗУРГАА. Ашиглуулагчийн эрх, үүрэг

#### 6.1. Ашиглуулагч нь дараах эрхтэй.

- 6.1.1. Бэлчээр ашиглалтын байдалд тогтмол хяналт тавих.

- 6.1.2. Буруутай этгээдээр бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах, зөрчлийг арилгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах.
- 6.1.3. Зохих зөвшөөрөлгүй орж ирсэн гадны малчдыг нүүлгэх, хуульд заасан бусад арга хэмжээ авах.
- 6.1.4. Бэлчээрийг гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашиглаж бэлчээрийн төлөв байдлыг доройтуулсан нь мэргэжлийн байгууллагын мэргэжилтний дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд хохирлыг арилгуулах арга хэмжээ авах.
- 6.1.5. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх төлөвлөлтийн биелэлтэд хяналт тавих.
- 6.1.6. Хэрэв холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх.

- 6.1.7. ....
- 6.1.8. ....

**6.2. Ашиглуулагч нь дараах үүрэгтэй.**

- 6.2.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийн төсөлд гэрээгээр олгосон бэлчээрийг тусгах.
- 6.2.2. Гэрээгээр олгосон бэлчээрийн хэмжээ заагийг тэмдэгжүүлэх, газрын улсын бүртгэлд бүртгүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах.
- 6.2.3. Ашиглалтад олгосон бэлчээрийг бусдад давхар олгохгүй байх нөхцөлөөр хангаж ашиглагчийн газар ашиглах хууль ёсны эрхийг хамгаалах.
- 6.2.4. ....
- 6.2.5. ....

**ДОЛОО. Гэрээг цуцлах**

- 7.1. Энэхүү гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно.
- 7.2. Бэлчээрийг зориулалтын дагуу ашиглаагүй, хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан нь тогтоогдсон.
- 7.3. Энэхүү гэрээний 5.2.2-т заасны дагуу малын тоог хэтрүүлэн ашиглаж бэлчээрийн төлөв байдлыг доройтуулсан нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон.
- 7.4. Ашиглагч нь холбогдох хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй, гэрээний нөхцөлийг удаа дараа ноцтойгоор зөрчсөн.
- 7.5. ....
- 7.6. ....

**НАЙМ. Давагдашгүй хүчин зүйл**

- 8.1. Талуудын хүсэл сонирхлоос гадуур, урьдчилан мэдэх боломжгүй зуд, ган, үер үс зэрэг бусад байгалийн аюултай үзэгдэл, гал түймэр, мал амьтны гоц халдварт өвчин,эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгаа гэх мэт нөхцөл байдлын улмаас талууд гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд тусгасан нөхцөлүүдийн талаар талууд харилцан үүрэг хүлээхгүй.

**ЕС. Хариуцлага**

- 9.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол холбогдох хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээнэ.

**АРАВ. Бэлчээр ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх**

10.1. Гэрээний талаар гарсан маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэнэ. Эс тохиролцвол бэлчээрийн болон холбогдох хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

#### АРВАН НЭГ. Бусад

11.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

11.2. Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг мөн.

11.3. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

11.4. Ашиглуулагч нь Монгол Улсын хуульд заасан үндэслэлээр албан үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, өөр этгээдээр солигдсон нь энэ гэрээг цуцлах, дуусгавар болгох, түүний нөхцөлийг өөрчлөх үндэслэл болохгүй.

11.5. Гэрээнд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

11.6. Энэхүү гэрээг нийт .... эх хувь үйлдэж, талууд 20.... оны ....-р сарын ....-ны өдөр ..... сумын ..... -нд гарын үсэг зурав. Тал тус бүр энэ гэрээний нэг хувийг өөртөө хадгалав.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ашиглуулагчийг төлөөлж сумын Засаг дарга .....овогтой  
.....  
Гарын үсэг .....

Иргэн..... овогтой  
.....,  
регистрийн дугаартай .....  
хуулийн этгээд  
Гарын үсэг .....

#### 3.1.4. Бэлчээрийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд оролцогч Талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой болгож, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлуудыг гэрээнд тусгах тухай:

Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдох хууль тогтоомжийн хүрээнд болон ажлын даалгаврын удирдамжийн дагуу малчдын хамтын байгууллагын оролцоотой бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын гэрээнд зайлшгүй тусгахаар дараах нөхцөл, асуудлуудыг судалж үзсэн. Үүнд:

#### Талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх талаар:

Өмчлөгчийг төлөөлж гэрээ байгуулах эрх бүхий этгээд сумын Засаг дарга, ашиглагч этгээд болох малчдын хамтын байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тусгахдаа тэдгээрийн эдлэх эрхийг мөн адил тусгах шаардлагатай. Иймд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нэр бүрчлэн нийтлэг байдлаар тусгахаас гадна тухайн сумын онцлогт тохирсон нөхцөлүүдийг талууд харилцан тохиролцох боломжтой гэрээний төслийг боловсрууллаа.

#### Засаг даргын эдлэх эрх:

- Бэлчээр ашиглалтын байдалд тогтмол хяналт тавих,
- Байгаль, цаг уурын байдал хүндэрсэн үед отор нүүдэл зохион байгуулах арга хэмжээ авах,

- Буруутай этгээдээр бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах (сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам баталсан нөхцөлд илүү хялбар), зөрчлийг арилгах талаар холбогдох хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах,
- Зохих зөвшөөрөлгүйгээр ашиглалтын газарт орж ирсэн гадны малчдыг нүүлгэх, хуульд заасан бусад арга хэмжээ авах,
- Бэлчээрийн төлөв байдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах санал гаргах, энэ нь доройтсон тохиолдолд хохирлыг арилгуулах арга хэмжээ авах,
- Тухайн бэлчээрт байх малын тоог хонин толгойгоор жил бүрээр нь төлөвлөхөд удирдлагаар хангах, улмаар оролцох, бэлчээр төлөвлөлтийн биелэлтэд тогтмол хяналт тавих,
- Бэлчээрийг даацад нь тохируулан тогтвортой ашиглаж байгаа болон шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд тухайн малчдын байгууллагад тэргүүн ээлжид тусламж дэмжлэг үзүүлэх.
- Холбогдох хууль тогтоомж, уг гэрээг зөрчсөн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх,
- Бусад гэж гэрээний нөхцөлийг нээлттэй орхих нь зүйтэй. Учир нь талууд өөрийн сумын онцлогт тохируулан эдлэх эрхийг тохиролцох боломжтой.

#### Засаг даргын хүлээх үүрэг:

- Ашиглалтад олгох бэлчээрийн зургийг гэрээний хавсралтаар гаргаж, тухайн гэрээний салшгүй хэсэг болох нөхцөлийг тусгаж, тэрхүү зураглал бүхий бэлчээрийг ашиглагчид хүлээлгэн өгөх,
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийн төсөлд гэрээгээр олгосон бэлчээрийг тусгах арга хэмжээ авах,
- Гэрээгээр олгосон бэлчээрийн хэмжээ заагийг тэмдэгжүүлэх, газрын улсын бүртгэлд бүртгүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах,
- Ашиглалтад олгосон бэлчээрийг бусдад давхар олгохгүй байх боломжоор хангаж малчдын хамтын байгууллагын газар ашиглах хууль ёсны эрхийг хамгаалах,
- Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалахтай холбоотой аливаа асуудлаар бэлчээр ашиглагч - малчдын хамтын байгууллагад дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан арга, хэлбэрээр ашиглагчид бэлчээрийн дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
- Бусад

#### Бэлчээр ашиглагч болох малчдын хамтын байгууллагын эдлэх эрх:

- Бэлчээрийг гэрээнд заасны дагуу бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтаар ашиглах, үр шимийг хүртэх,
- Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөлт боловсруулах.
- Ашиглалтад олгогдсон бэлчээрээ хамгаалах, сайжруулах чиглэлээр дотоод, гадаадын байгууллагатай хамтран ажиллах,
- Бэлчээрийн зохистой үйл ажиллагааны чиглэлээр аливаа хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх, хэрэгжүүлэх,
- Гэрээний хугацааг сунгах хүсэлт гаргах,
- Тухайн ашиглалтад олгогдсон бэлчээрт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр шаардах, бэлчээр ашиглуулагчид энэ талаар мэдээлэх, санал, хүсэлт, гомдол гаргах, шийдвэрлүүлэх,



- Гэрээнд заасан бэлчээрт бусад этгээд бэлчээрийг дур мэдэн ашигласан бол энэ талаарх үйл ажиллагааг зогсоох шаардлага тавих, бэлчээр ашиглуулагчид энэ талаар мэдээлэх, санал, хүсэлт, гомдол гаргах, шийдвэрлүүлэх,
- Бэлчээр зохион байгуулалтын талаар багийн иргэдийн Нийтийн Хурлаар шийдвэрлүүлэхээр өргөдөл, санал, хүсэлт гаргах.
- Бусад

Бэлчээр ашиглагч болох малчдын хамтын байгууллагын хүлээх үүрэг:

- Гэрээ болон сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам, бэлчээр зохион байгуулалтын жил бүрийн төлөвлөлтөө дагаж мөрдөх, хэрэгжүүлэх,
- Ашиглаж буй бэлчээрийн даацад малын тоог тохируулах,
- Гишүүн малчин өрхийн буруутай үйл ажиллагаанаас бэлчээрт учруулсан хохирлыг малчдын хамтын байгууллага нь өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах,
- Бусдын ашиглалтад олгосон бэлчээрт отор нүүдэл хийх, мал тууварлах, дамжин өнгөрөхдөө бусдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх ба отор нүүдэл болон тууврын малыг саадгүй дамжин өнгөрөх нөхцөл боломжоор хангах.
- Бэлчээрт байгаа худаг, уст цэгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах,
- Усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
- Бэлчээр нутгаа бэлчээрийн хортон мэрэгчдээс хамгаалах, байгальд халгүй аргаар тэмцэх арга хэмжээ авах,
- Мал сүргээ эрүүлжүүлэх арга хэмжээ авах,
- Гэрээгээр ашиглаж буй бэлчээрээ сайжруулах талаар тогтмол санаачилгатай ажиллах,
- Энэхүү гэрээ болон холбогдох хуульд заасан бусад үүргийг биелүүлэх.
- Бусад

Сумдын мэргэжлийн алба, тасгийн мэргэжилтний үүрэг, оролцоо:

- Мал, амьтан идэшлэх өвс, үс бүхий эдэлбэр газрыг бэлчээр гэдэг. Бэлчээрийн хууль зүйн орчинд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй хууль, журмууд тодорхой байрыг эзэлдэг учраас бэлчээр ашиглуулах гэрээнд тодорхой байдлаар тусган биелэлтийг дүгнэж байх нь чухал юм.
- Манай улсын нийт нутаг дэвсгэрийн 73.4 хувийг Хөдөө аж ахуйн газар бөгөөд үүний 96.1 хувийг буюу 110.4 сая га нь бэлчээрийн газар эзэлж байгаа юм. Гэвч бэлчээрийн талбай жил ирэх тусам багассаар байна. Монгол малчны мал маллах болон бэлчээрийг ашиглах уламжлалт арга, технологи алдагдсанаас даац нь хэтэрч, хариуцлагагүй уул уурхайн ашиглалтаас үүдэж доройтож өөрчлөгдсөн 65 хувийн арваад хувь нь дахин сэргэхээргүй байдалд орж цөлжжээ.
- Иймээс манай орны мал, сүргийн тэжээлийн хэрэгцээний 90 гаруй, зэрлэг өвсөн идэштэний 100 хувийг тэжээлээр хангадаг бэлчээрийг зохистой ариг гамтай ашиглах, цэвэр, эрүүл байлгахыг анхаарч **Малын генетик нөөцийн тухай хуулийн .3.б.-д** бэлчээр, үс, хужир марааг зөв зохистой ашиглах, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3-т бэлчээрийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, малчин, амьтан маллагч нь хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж

устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах; Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийхээр заасан байна.

- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, шаардлагатай уялдан мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, байгальд ээлтэй байх харилцаанд малчдын оролцоо, үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж байна.
- Бидний судалгаа хийж буй Дорнод болон Сүхбаатар аймгуудад малын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа боловч ашиг шимийг нь төдийлөн гүйцэд ашиглаж чадахгүй байгааг өмнөх тайланд дурдсан билээ.
- Иймээс тухайн байгаль экологийн нөхцөлд тохирсон төрөл үүлдрийн малыг, чанарыг нь сайжруулан, тоог бэлчээрийн даацад тохируулан маллахын зэрэгцээ ашиг шимийг бүрэн гүйцэд ашиглахад анхаарах хэрэгтэй.
- **Малын генетик нөөцийн тухай хуулийн** 8.4.1-д тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн үүлдэр, омгийн хээлтүүлэгчийг ашиглах, малыг сонгон үржүүлэхдээ ашиг шимийн чиглэлийг дур мэдэн өөрчлөхгүй, эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр үүлдрийн малыг сайжруулагчаар ашиглахгүй байх; 14 дүгээр зүйлд баталгаажсан үүлдэр, омгийн малыг нутагшсан болон уугуул орчинд нь үржүүлж хамгаалах, малын үүлдэрлэг байдлыг алдагдуулахгүй байх; .бүс нутгийн онцлогийг харгалзан өвөлжих, хаваржих бэлчээрийн малд зориулж хадлан тэжээл бэлтгэх, ус, хашаа байраар хангах, малыг байгалийн эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхээр заасан байна.
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6.5 болон 9.8.1-д Зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээнд мал, амьтнаа тогтоосон хугацаанд бэлэн байлгаж, бүрэн хамруулахаар заажээ.
- Бид эдгээр хуулиудаас гадна ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги”, ХХААХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тушаалаар батлагдсан “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар” зэрэгт тусгагдсан зайлшгүй хэрэгжүүлэх заалтуудыг гэрээнд тодорхой хэмжээгээр тусган оруулсан болно.
- Малчдын оролцоотой БНМХБ-тай байгуулсан гэрээг дүгнэж, шийдвэрлэхэд тухайн сумдын хөдөө аж ахуйн болон мал эмнэлэгийн тасгийн мэргэжилтнүүд оролцож ажиллах нь чухал байна.
- **Бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын гэрээний хариуцлагын талаар:**
- Талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг тус бүрд хүлээлгэх хариуцлагыг талууд гэрээгээр тохиролцох эрх зүйн үндэслэлтэй ч түүний хэрэгжилт хангалтгүй байдалд хүрэх магадлал их байх нь практикт түгээмэл. Иймд хуульд заасан үндэслэлээр гэрээний хариуцлагыг тооцох боломж бүхий гэрээг байгуулах асуудлыг чухлаар авч үзэх шаардлагатай юм.
- 2017 онд Зөрчлийн тухай хууль батлагдсанаар газрын тухай хууль зөрчигсдөд, тэр дундаа бэлчээрийн газрын зохисгүй ашиглалтад хууль зүйн тодорхой хариуцлага хүлээлгэх эрх зүйн таатай орчин бүрдсэн гэж үзэж болно. Энэ талаар

малчдын хамтын байгууллагын оролцоотой бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хариуцлагын талаарх судалгааны нэгэн чухал хэсэг болохыг тодотгох нь ач холбогдолтой.

- Уг хуульд “нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил” гэсэн нэртэй 8 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд газрын тухай хууль зөрчсөн зөрчилд хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар хуульчилсан ба бэлчээрийн газар ашиглалтыг шууд болон шууд бус зохицуулсан зохицуулалтын агуулгыг авч үзье.
- Хуульд бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалсан газарт зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно<sup>34</sup> гэж заасны дагуу гэрээгээр ашиглалтад олгогдсон бэлчээрийн газар (хуулийн зохицуулалтаар ашиглалтад байгаа газар гэж үзэж болох юм)-т нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг хэрэглэж болно, ийм тохиолдолд өөр сумдын болон өөр гэрээтэй малчид тухайн гэрээгээр ашиглаж буй бэлчээрт нэвтрэн орж малаа идээшлүүлэх, дайран өнгөрөхдөө олон хоног саатах гэх мэт практикийн хүндрэлүүд байдаг асуудлаар бэлчээр ашиглагчид хуулийн хүрээнд шаардлага тавих эрх үүсэх үндэслэлтэй.
- Ашиглалтад байгаа бэлчээрийн газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих талаар гэрээнд тусгах боломжтой гэж дүгнэн гэрээний загварын бэлчээр ашиглагчийн эрх гэсэн нөхцөлд тусгав.
- Зөрчлийн тухай хуульд бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын талаар шууд хуульчилсан ач холбогдол бүхий хэм хэмжээ бол **“Бэлчээрийг зохистой ашиглах, эсхүл хамгаалах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”** юм. Энэхүү хэм хэмжээний бэлчээрийг зохистой ашиглах, эсхүл хамгаалах журам зөрчсөн бол гэдгийг нэгдүгээрт, тухайн орон нутагт, ялангуяа сумын хэмжээнд (нүүдлийн уламжлалт байдлаар сум хоорондын хэмжээнд ч байж болно) бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын журам батлах, тэрхүү журмыг зөрчвөл зөрчилд нь хариуцлага хүлээлгэх хууль зүйн агуулгатай, хоёрдугаарт гэрээний үүргээ биелүүлэх журам зөрчсөн бол гэдгээр ч ойлгох боломжтой юм, учир нь хуулийн энэ заалтыг тайлбарласан Монгол Улсын Дээд Шүүхээс тайлбарласан албан ёсны тайлбар бүхий тогтоол одоогоор гараагүй байна. Иймд бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын гэрээнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтаар бэлчээрийн газар ашиглалтын гэрээг зөрчсөн зөрчилд нь хууль зүйн хариуцлага хүлээлгэж болохоор байна гэж дүгнэн шинээр боловсруулсан гэрээний загварт Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг гэрээний үндэслэл хэсэгт тусгав.
- Практикт бэлчээрийн газар ашиглалттай холбоотой тулгамдсан асуудлуудын нэг бол хадлангийн талбайн хадланг хурааж дуусаагүй цаг хугацаанд болон тариалангийн газарт мал оруулах, бэлчээрлүүлсэнтэй холбогдсон маргаан нийтлэг, ийм маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэсэн ч тохиолдол бий.
- Энэ асуудлын талаар зөрчлийн тухай хуульд “газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн **хадлангийн талбайд хадлан авч дуустал мал бэлчээх, эсхүл тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн албан ёсны**

<sup>34</sup> Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1

зөвшөөрөлгүйгээр тухайн газарт мал, амьтан оруулах, бэлчээхийг хориглосон заалтыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж хуульчилсан онцлогтой.

- Тэрчлэн зөрчлийн тухай хуулийн “Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил” гэсэн нэртэй 13 дугаар бүлгийн “тариалангийн тухай хууль зөрчих” гэсэн 13.1 дүгээр зүйлийн 13.1.6.6-д Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд “бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байлгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж хуульчилсан.
- Зөрчлийн тухай хуульд бэлчээрийн газар гэж шүүд заагаагүй ч газар ашиглагч хэмээн шүүд бус хуульчилсан бас нэгэн чухал хэм хэмжээ бол газрын тухай хуульд заасныг зөрчиж газар ашиглагч газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно<sup>35</sup> гэжээ.
- Энэ заалтаар бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээнд Засаг дарга бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтын дагуу уг бэлчээрийн газрыг ашиглахыг шаардах эрхтэй болохыг гэрээнд тусгасан тохиолдолд малчдын хамтын байгууллагад хариуцлага хүлээлгэх боломж үүсэх тул гэрээний загварт Засаг даргын эдлэх эрхэд тусгасан болно.
- **Хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах талаар:**
- Хадлангийн талбайг зохистой ашиглах хамгаалах талаар Газрын тухай хуулийн 53 дугаар зүйлд хуульчилсан ба уг зохицуулалтаар хадлангийн талбайг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сумын Засаг дарга уг талбайг нь эзэмшүүлж болохоор байна.

### **3.1.5. Бэлчээрийн газрын төлөв байдалтай уялдсан ашиглалт, богино хугацааны сэлгээний хуваарь, урт хугацааны мониторингийн төлөвлөгөө, бэлчээрийн даац, болон үүр амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг тооцсон сүргийн эргэлтийн төлөвлөгөө зэргийг төр - малчид - хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах үүрэг, хариуцлагыг тусгах талаар:**

Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээнд бэлчээрийн газрын төлөв, зохистой ашиглалт, богино хугацааны сэлгээний хуваарь, урт хугацааны мониторингийн төлөвлөгөө, бэлчээрийн даац, сүргийн эргэлт зэргийг гэрээний хавсралтад бэлчээрийн төлөвлөлт боловсруулан тусгаж, түүнийгээ дагаж мөрдөхийн тулд энэхүү хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна гэсэн нөхцөлийг үндсэн гэрээндээ тусгах боломжтой.

Иймд бэлчээрийн төлөвлөлтийн загварыг дараах байдлаар боловсруулав.

Бэлчээр ашиглагч болох малчдын хамтын байгууллага, баг, сумын хэмжээнд бэлчээр зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж “Сумын газар зохион байгуулалтын

<sup>35</sup> Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.1

тухайн жилийн төлөвлөгөө"-нд тусгуулж хэрэгжүүлж байх нь газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Бэлчээрийн газрын ашиглалт хамгаалалтыг сайжруулахад авч хэрэгжүүлж буй технологи нийт нутаг дэвсгэрт нэлээд түгээмэл шинжтэй боловч аймаг сум бүрийн уламжлал, онцлог байдал, малын төрөл, газар зүй, байгаль, цаг уурын өвөрмөц байдлаас хамааран өөрийн онцлогтой.

Бэлчээр ашиглагч болох малчдын хамтын байгууллага нь бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд бүлгийн бэлчээрийн хил зааг, малчдын дөрвөн улирлын байршил, нүүж суух хугацаа, доройтсон бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээх, сэлгэж ашиглах хуваарь, ургамал ургалтын хугацаанд чөлөөлж өнжөөх, хадлангийн талбайг хамгаалах, тордож сайжруулах, тэжээл бэлтгэх, худаг ус шинээр гаргах, засварлах, бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх, малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэрлэг чанарыг сайжруулах зэрэг бүхий л чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгаж тухайн ажлуудыг хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах зардал зэргийг тооцож, боловсруулна.

Бэлчээр ашиглагч болох малчдын хамтын байгууллагын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дах заалтуудыг үндэслэн Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн гаргасан саналыг нэгтгэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд суулгаж, батлуулах ажлыг сумын Бэлчээр ашиглагчдын холбоо, баг, сумын Засаг дарга нар, холбогдох мэргэжилтнүүд хариуцан хэрэгжүүлнэ. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын ИТХурал хэлэлцэж баталснаар төлөвлөгөө сумын түвшинд эцэслэн баталгаажна.

Ихээхэн талхлагдсан бэлчээрийг улс, орон нутгийн болон гадаад, дотоодын төслийн хөрөнгө оруулалтаар сэргээхээс гадна бэлчээрийг сэлгэж ашиглалтаас чөлөөлөх байдлаар нөхөн сэргээх нь хамгийн тохиромжтой арга юм. Иймээс талхагдал, доройтол, элэгдэл, эвдрэлд орсон бэлчээрийн төрх, төлөв байдал, байршлыг тодорхойлж сайжруулалтын оновчтой аргуудыг тухайн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх нь чухал юм.

#### **Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах.**

Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг сумын Засаг даргын захирамжийн дагуу сумын газрын даамал, бэлчээрийн менежментийн ажлын хэсэг, малчдын бүлэг, хэсэг-ийн ахлагч, малчидтай хамтран хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд

*Олон нийтэд сурталчлах, үйл ажиллагааг зохион байгуулах:* Батлагдсан төлөвлөгөөг Иргэн, Аж ахуйн нэгж, малчид, малчдын бүлэг, хэсэг-т танилцуулах, сурталчлах ажлыг БИНХ, сум багийн өдөрлөг, малчдын хэсэг, бүлгийн хурал, малчдын уулзалт зөвлөгөөн, малчдад нэгдсэн болон хэсэгчилсэн сургалтуудаар дамжуулан зохион байгуулах.

*Орчин үеийн техник технологи сошиал мэдээ мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан түгээн дэлгэрүүлэх:* Сумын болон багийн төвүүд дээр мэдээ мэдээллийн самбар байрлуулах, малчдын хэсэг, бүлгийн өнжөөж амраах, сэлгэж ашиглах бэлчээрийн талбайд таних тэмдэг, сануулга, самбар байрлуулах зэрэг.

*Төлөвлөгөө хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах:* Сумын Засаг дарга төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор захирамж шийдвэрийг гаргаж нийтээр дагаж мөрдүүлэх.

Тухайлбал малчид, малчдын бүлэг, хэсэг-ийн саналыг үндэслэн бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах, улирлын бэлчээрийг ашиглах хуваарь, өнжөөж амрах бэлчээрт мал оруулах гаргах хугацаа, өвөлжөө хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, сумын отрын нөөц нутаг ашиглах, өвөлжилтийн бэлтгэл хангуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон захирамж шийдвэр гаргах зэрэг болно.

Тэжээлийн агуулахын байр барих, булаг хаших, худаг засварлах, хөв цөөрөм байгуулах, усан хангамж нэмэгдүүлэх зэрэг бэлчээрийн газрыг хамгаалах үйл ажиллагааг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, сайн дурын байгууллага, малчид, малчдын хамтын байгууллага болон БНХМБ-тай хамтран хэрэгжүүлсэн тохиолдолд сумын засаг захиргаа, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөлтэй хамтран ажиллаж үйл ажиллагааг дэмжих асуудлыг сумын хэмжээнд дагаж мөрдөх журамд болон байгалийн нөөц баялаг ашиглалт, хамгаалалтын гэрээнд тусгаж хариуцах эзэн, арчилгаа, засвар үйлчилгээ хийх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой болгон ажиллах зүйтэй гэж зөвлөж байна.

### **3.1.6. Малчдын оролцоотой БНХМБ-тай бэлчээрийн нөөц ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамж, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулсан талаар:**

Малчдын оролцоотой БНХМБ-тай байгуулсан “Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамж болон Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтүүдийг загвар 10 болон 11-т үзүүлэв.

**Загвар-10 . Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамжийн төсөл:**

#### **Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэх удирдамж**

##### **Нэг. Зорилго**

..... аймгийн ..... сумын малчдын оролцоотой БНХМБ-ын “Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээ”-ээр хүлээсэн үүргийн биелэлтийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргахад оршино. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээг дүгнэхдээ сумын Засаг даргын ..... оны ..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар захирамж, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дугаар заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.6, 8.4.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3, 9 дүгээр зүйлийн 9.8, 15 дугаар зүйлийн 15.2, 21 дугаар зүйлийн 21.3, Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-ыг удирдлага болгоно.

##### **Хоёр. Гэрээ дүгнэх хугацаа**

Гэрээний биелэлтийг 20.. оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс .. дүгээр сарын .. -ны өдрийн хооронд дүгнэж гэрээ дүгнэсэн илтгэх хуудас, тайланг .. дугаар сарын ...-ны өдрийн дотор гаргана.

### Гурав. Гэрээ дүгнэх аргачлал

1. Гэрээний биелэлтийг энэ удирдамжийн хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу үнэлж дүнг нэгтгэнэ.
2. Гэрээний биелэлтийг батлагдсан үзүүлэлт тус бүрээр дүгнэнэ. Үүнд:
  - ✓ 90 - 100 оноо Бүрэн хангалттай
  - ✓ 80 - 89.9 оноо Хангалттай
  - ✓ 70 - 79.9 оноо Ажил сайжруулах
  - ✓ 69.9-с доош Хангалтгүй
3. Үнэлгээ өгөхдөө тухайн БАХ-ийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан тайланг үндэслэн шалгана.
4. Бэлчээр эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, бүртгэл, газрын төлбөрийн болон малын тоо толгойн албан татварын төлөлтийн асуудлыг шалгах.

Загвар-11. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтүүд. /Удирдамжийн хавсралт/

### Бэлчээр ашиглалт, хамгаалалтын гэрээний хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтүүд

Малчдын хамтын байгууллагын оноосон нэр .....

Бүлэг, хэсгийн ахлагчийн нэр .....

№	Гэрээ дүгнэх үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Бүлэг, хэсгийн хурлын тэмдэглэлүүд	5	
2	Ашиглаж буй бэлчээрийн талбайн хэмжээ, гэрээнд заасантай харьцуулбал	5	
3	Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	5	
4	Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн хил заагийг бусдад тодорхой харуулах тэмдэглэгээтэй эсэх	5	
5	Ашиглалтад байгаа бэлчээрт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавьсан эсэх	5	
6	“Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалын дагуу тогтоосноор гэрээт бэлчээрийн зуны дээд ургац .... кг/га -аас өөрчлөгдсөн эсэх	5	
7	Бэлчээрийн фотомониторингийн дүн, шинжилгээний дүгнэлт	5	
8	Бэлчээрийн даацын тохируулалт, хонин толгойгоор	10	
9	Бэлчээрт байгаа худаг, уст цэгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамгаалах арга хэмжээ авсан байдал	10	
10	Бэлчээрийг сайжруулах, хортон мэрэгчдээс хамгаалах, байгальд халгүй аргаар тэмцэх	10	



	арга хэмжээ авсан байдал		
11	“Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө”-ний дагуу тухайн бүсэд зөвшөөрөгдсөн үүлдрийн малыг өсгөн үржүүлж буй эсэх	10	
12	Сүргийн зохистой бүтцийг мөрдөж буй байдал	5	
13	Мал сүргийг эрүүлжүүлэх, халдварт болон бусад төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хувь	5	
14	“Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх зааврын дагуу малын нэмэгдэл тэжээлийн нөөцийг бэлтгэсэн байдал, хувиар	5	
15	Дулаан хашаа хороогоор хангагдсан эсэх	5	
16	Гэрээний сунгалт хийгдсэн эсэх	5	
		100	

### 3.1.7. Малын тоо толгойн албан татварын орлогыг бэлчээр ашиглалтын журам болон гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, дүгнэхэд ашиглах тухай зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварын хууль гарсантай холбогдуулан хураасан орлогыг зарцуулах чиглэлийг Төсвийн тухай хуулийн 60.2.8-р хуульчилсан байна. Үүнд:

1. Бэлчээрийн менежментийг сайжруулах;
2. Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
3. Малын эрүүл мэндийг хамгаалах;
4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
5. Малын чанарыг сайжруулах;
6. Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
7. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
8. Малын тэжээлийн ургамал тариалах;
9. Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
10. Байгаль орчныг хамгаалах;
11. Хортон мэрэгчидтэй тэмцэх;
12. Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

Малын тоо толгойн албан татвараар Орон нутгийн хөгжлийн санд хуримтлагдсан дээрх орлогыг бэлчээрийг хамгаалах, инженерийн хийцтэй худаг гаргах, булаг, шандыг хамгаалах зэрэг менежментийг сайжруулах чиглэлээр зарцуулахаас гадна бэлчээр ашиглалтын журам болон малчдын оролцоотой БНХМБ-тай байгуулсан бэлчээр ашиглах гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг дүгнэх зэрэг арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрт зориулан зарцуулах боломжтой гэж зөвлөж байна.

Бэлчээрийн газрыг хамгаалахад чиглэсэн дээр дурдсан үйл ажиллагааг аймаг, сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагдажуулах журмын болон гэрээний шинэчилсэн загварын төсөлд тусгасан болно.




3.1.8. Гэрээт ажлын үр дүн болох малчдын оролцоотой БНХМБ-ын тооллого, бүртгэл, гэрээний шинэ загварыг төслийн нэгж, орон нутгийн болон хамтрагч талуудад танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан талаар:

### 3.1.8.1. Төслийн нэгж болон хамтрагч талуудын уулзалт, хэлэлцүүлэг:



Зөвлөхийн гэрээний ажлын даалгаврын дагуу дараах ажлуудыг гүйцэтгэж зорилтот хоёр аймгийн удирдлага, төслийн нэгжийн уулзалт болон хамтрагч талуудын уулзалт-хэлэлцүүлэгт танилцуулан саналыг сонсож, явцын тайлан, зөвлөмжид тусган ажилласан байна.

-Дорнод, Сүхбаатар аймгийн бүх сумын хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөл, хоршооны тооллого, бүртгэл хийж, бүртгэлийн мэдээллийн санг шинэчлэн гаргаж, төслийн нэгжид тайлагнасан.









-Дээрх хоёр аймгийн бүх сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой БНХМБ-ын ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор бэлчээр ашиглуулах, нөхөрлөлийн ойн санг эзэмшүүлэх, ан амьтан хамгаалах зэрэг гэрээний хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж ажилласан байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг даван туулах боломж, нөхцөлийг хангасан, малчдын оролцоотой БНХМБ-ын хэлбэрээр ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын менежментийг хэрэгжүүлэх хамтын менежментийн гэрээний загварыг боловсруулах, албажуулах ажлын зөвлөмжийг гаргаж, төслийн нэгжид танилцуулсан байна.

**ҮР ДҮН-2**

Ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, гэрээний хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийх

**ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ**

Дорнод, Сүхбаатар аймаг

**Дун шинжилгээ хийсэн гэрээний төрлүүд**

- Хөдөө аж ахуйн зориулалтаар газар ашиглах гэрээнд
- Бэлчээр ашиглуулах гэрээнд
- Нөхөрлөлийн ойн санг эзэмших гэрээнд
- БНХМН-ийн байгаль, ан амьтан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээнд
- Хамтын ажиллагааны гэрээнд
- Ус ашиглах гэрээнд

### 3.1.8.2. Төслийн нэгжтэй хийсэн уулзалт, хэлэлцүүлэг:

Дорнод, Сүхбаатар аймгийн 27 сумын хэмжээнд хийсэн малчдын оролцоотой БНХМБ /нөхөрлөл, бүлэг, хэсэг, хөдөө аж ахуй хоршоо/-ын тооллого, бүртгэл, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, сумын Засаг даргатай байгуулсан гэрээ болон эрх зүйн холбогдолтой баримт бичигтэй танилцаж судлан үзсэний үндсэн дээр дээрх хоёр аймгийн сумдад байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх болон мал аж ахуйн үйлдвэрлэл явуулах зорилгоор байгуулсан нөхөрлөл, бүлэг, хэсгийн гэрээний загварыг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн хүрээнд шинэчлэн боловсруулж Бодлого судлалын төвтэй хамтран төслийн нэгж, НҮБ-ын холбогдох ажилтан нарт танилцуулж, санал бодлоо солилцож, чиглэл авч ажилласан болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:**

### **ГЭРЭЭНИЙ ШИНЭЧИЛСЭН ЗАГВАРЫГ ОРОН НУТАГТ ТАНИЛЦУУЛАХ, ШИНЭ ЗАГВАРЫН ДАГУУ БНХМБ-ЫГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ЧАДАВХЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ**

---

**4.1. Төсөл хэрэгжиж байгаа Сүхбаатар, Дорнод аймагт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн талаар:**

#### **Нэг. Сүхбаатар аймаг:**

1. Үр дүн 3-ын хүрээнд: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг даван туулах боломж, нөхцөлийг хангах зорилгоор малчдын оролцоотой байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага (бүлэг, нөхөрлөл)-ын хамтын менежментийн гэрээ (Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын гэрээ, Нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ)-ний шинэчлэн боловсруулсан загварын төслийг албан бичгээр Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт биечлэн хүргүүлж, удирдлага, мэргэжилтэн нарт нь танилцуулж санал авах ажлыг зохион байгуулав. Мөн АДАПТ төслийн Сүхбаатар аймгийн зохицуулагч О.Дүүрэнбилэг, зөвлөх Г.Ариунболд, ажилтан Э.Дуламсүрэн, төслийн хөдөө аж ахуйн зөвлөх н.Ганзориг нартай уулзаж гэрээний шинэчилсэн загвар, малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл шинээр байгуулах шаардлага, хэрэгцээний талаар санал солилцож ажиллав.
2. Дээрх хоёр гэрээний шинэчилсэн загварын төсөлд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 205 тоот, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/400 тоот, Хүнс, хөдөө аж ахуйн газар 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 1/177 тоот албан бичгээр гэрээний төсөлд нэмэлт санал байхгүй гэж мэдэгдсэн.
3. Үр дүн 4-ийн хүрээнд: Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Түвшинширээ сумдын удирдлага, мэргэжилтэн болон төслийн зүгээс хашиж хамгаалсан бүлгийн эх орчимд намаржиж буй малчдын төлөөлөлд гэрээний шинэчлэн боловсруулсан загварын төслийг танилцуулж хэлэлцүүлэн саналыг нь сонсох, шаардлагатай тохиолдолд шинээр малчдын бүлэг байгуулах талаар чиглэл, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Үүнд:

-Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс, Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн Н.Гантөмөр нартай уулзаж, зөвлөх багийн зүгээс бэлтгэсэн бэлчээрийн болон ойн нөхөрлөлийн гэрээний төслийг танилцуулж, санал солилцсон. Мөн энэ онд АДАПТ төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тус сумын 2 дугаар багийн нутаг болох Баруун-Урт голын ай савд 8 га газарт татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хамгаалах зорилгоор барьсан хашааг сумын орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь ойжуулалтын ажлын хамт хариуцан ажиллахаар төлөвлөж байгааг мэдэгдсэн. Харин зөвлөх багийн зүгээс "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд

ойжуулах газрыг мэргэжлийн талаас нь хариуцан ажиллах чадамж бүхий “ойн нөхөрлөл” байгуулах асуудлыг судлан үзэхийг зөвлөж, холбогдох хуулийн үндэслэл, эрх зүйн орчин, гэрээний загвар зэргийг танилцуулж ажилласан болно.

-Дарьганга сумын Засаг дарга Д.Болдбаатар, орлогч дарга М.Эрдэнэбаатар, 1 дүгээр багийн Засаг дарга Ч.Дорж, хөдөө аж ахуйн мэргэжилтэн Э.Хүрэлбаатар, газрын даамал Б.Сүхчүлүүн нартай уулзаж “Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын гэрээ”, “Нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ”-ний гэрээний шинэчилсэн загварын төслийг танилцуулж бүлэг, нөхөрлөл болон гэрээ байгуулах хуулийн үндэслэл, албажуулах үе шат, дарааллын талаар зөвлөмж, танилцуулах материал өгч ажилласан. Сумын удирдлага, мэргэжилтэн нар гэрээний төсөл, заавар, зөвлөмжтэй танилцаад энэ оны 9 дүгээр сард АДАПТ төслийн хөрөнгө оруулалтаар тус сумын 1 дүгээр багийн “Хөөврийн булаг”-ийн эхийг хашиж хамгаалж өгсөн явдалд малчид ихээхэн талархалтай байгааг илэрхийлээд булгийн эхээс малаа усалдаг тэр орчимд амьдардаг 18 малчин өрхийг зохион байгуулалтад оруулж цаашид малчдын бүлэг байгуулах хүсэлтийг илэрхийлж, энэ хүсэлтээ албан бичгээр мэдэгдэхээр тогтсон. Ингээд багийн Засаг даргын хамт Хөөврийн булгийн эхийг хамгаалж барьсан хашаатай танилцаж, булгийн эхээс малаа усалж буй 11 малчидтай уулзаж санал бодлыг нь сонсож, малчдын бүлэг байгуулах талаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэсэн.

-Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Ренчинмядаг, Үнэгт буюу 3 дугаар багийн Засаг дарга Н.Базаррагчаа, Өлзийт буюу 2 дугаар багийн Засаг дарга Д.Баттулга, Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн Ш.Бат-Эрдэнэ нартай уулзаж “Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын гэрээ”, “Нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ”-ний шинэчилсэн загварыг танилцуулан санал авч, малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл болон гэрээ байгуулах хуулийн үндэслэл, албажуулах үе шатны талаар зөвлөмж өгч, холбогдох заавар, зөвлөмжийг тараан өгсөн. Сумын удирдлага, мэргэжилтэн нар гэрээний төсөл, заавар, зөвлөмжтэй танилцаад энэ оны 9 дүгээр сард АДАПТ төслийн хөрөнгө оруулалтаар тус сумын Үнэгт багийн “Замтын булаг”-ийн эхийг хашиж хамгаалж өгсөн явдалд талархал илэрхийлээд булгийн эхээс малаа усалдаг, нэг нутаг бэлчээртэй 20 гаруй малчин өрхийг зохион байгуулалтад оруулж цаашид малчдын бүлэг байгуулахаар төлөвлөж байгаа тул энэ ажилд мэргэжлийн байгууллагын хувьд мэргэжил арга зүйн хувьд туслалцаа үзүүлэхийг хүсэж, хүсэлтээ албан бичгээр мэдэгдэхээр тогтсон.

Ингээд багийн Засаг дарга, хөдөө аж ахуйн мэргэжилтэн нарын хамт Замтын булгийн эхийг хамгаалж барьсан хашаатай танилцаж, ойролцоо нутаглаж буй 12 малчидтай малчин З.Батсүхийн хотонд уулзаж санал бодлыг нь сонсож, малчдын бүлэг байгуулах, гэрээ хийх талаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэсэн.

### **Хоёр. Дорнод аймаг:**

1. Үр дүн 3-ын хүрээнд: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг даван туулах боломж, нөхцөлийг хангах зорилгоор малчдын оролцоотой байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага (бүлэг, нөхөрөл)-ын хамтын менежментийн гэрээ (“Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын гэрээ”, “Нөхөрлөлд ойн

сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ”) -ний шинэчлэн боловсруулсан загварын төслийг албан бичгээр Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлж, удирдлага, мэргэжилтэн нарт нь танилцуулж санал авах ажлыг зохион байгуулсан.

2. Дээрх хоёр гэрээний шинэчилсэн загварын төсөлд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 445 тоот албан бичгээр “Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын гэрээ”-ний төсөлд дараах 4 саналыг ирүүлсэн байна. Үүнд:

- 1.Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшигч нь зөвхөн өөрийн өрхийн хэрэгцээнд мал аж ахуйн чиглэлээр эзэмших үүрэгтэй,

- 2.Газар эзэмшигч, бэлчээр ашиглагч нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өвөлжөө, хаваржааны газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад түрээслэхгүй, ашиглуулахгүй, шилжүүлэхгүй, худалдахгүй байх,

- 3.Дээрх заалтыг зөрчсөн тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг үл маргах журмаар цуцлах,

- 4.Өөрийн эзэмшил, ашиглалтын бэлчээрийн газарт зөвшөөрөлгүй отор нүүдлийн мал дур мэдэн оруулахгүй байх, зөвшөөрөлгүй отор нүүдлийн мал орж ирсэн тохиолдолд зохих албан тушаалтанд мэдэгдэж байх зэрэг саналыг гэрээний шинэчилсэн загварын төсөлд тусгуулахаар ирүүлсэн байна.

Харин аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 477 тоот албан бичгээр “гэрээний төсөл”-д тусгах санал байхгүй болно гэсэн хариу ирүүлсэн байна.

3. Үр дүн 4-ийн хүрээнд: Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн, Чойбалсан, Халхгол зэрэг 4 суманд энэ ондоо багтааж АДАПТ төслийн санхүүжилтээр Татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх 4 газрыг хашаалж хамгаалах ажлыг хийхээр төлөвлөж, эхлүүлээд байгаа юм байна. Энэ талаар аймгийн АДАПТ төслийн зохицуулагч Ч.Нэргүйтэй уулзаж тодруулга авахад: Хэрлэн, Баянтүмэн сумдын Засаг даргын Тамгын газар ойжуулалт хийх газрыг хамгаалах зориулалтаар барих хашааг өөрсдөө хариуцан ажиллах чиглэлтэй байгаа бол Чойбалсан сумын хувьд бэлчээр ашиглагч хэсэг /БАХ/-ийн гишүүн малчинд хариуцуулах, Халхгол сумын хувьд хашааг барьж дууссаны дараа малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөлийн аль нэгэнд хариуцуулахаар төлөвлөж байгааг мэдэгдсэн. Ингээд Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн Ц.Хүрэлчулуунтай уулзаж гэрээний шинэчлэн боловсруулсан загварын төслийг танилцуулж саналыг нь сонсох, шаардлагатай тохиолдолд малчдын бүлгийн бэлчээр ашиглах гэрээг энэхүү гэрээний загварын дагуу шинэчлэн байгуулах, гэрээнд хашиж хамгаалсан хашааг арчлан тордож хамгаалж байх талаар талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой оруулж өгөх чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Тус сумын хувьд гэвэл Хэрлэн голын ай сав газарт татмын ойн нөхөн сэргээлт ойжуулалт хийх 400 метр газрыг энэ онд хашаалан хамгаалахаар төлөвлөсөн бөгөөд хашааг барьж дууссаны дараа Энгэр шанд багийн бэлчээр ашиглагчдын хэсгийн ахлагч З.Ганбаатарт хариуцуулахаар урьдчилсан байдлаар ярьж тохирсон байна.

-Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Бямбадорж, газрын даамал Л.Отгон-Иш, 5 дугаар Засаг дарга П.Бямбажав нартай уулзаж “Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын гэрээ”, “Нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ”-ний шинэчилсэн загварыг танилцуулан санал авч, малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл болон гэрээ байгуулах хуулийн үндэслэл, албажуулах үе шатны талаар зөвлөмж өгч, холбогдох заавар, зөвлөмжийг тарааж өгсөн. Сумын удирдлага, мэргэжилтэн нар гэрээний төсөл, заавар, зөвлөмжтэй танилцаад энэ оны 9 дүгээр сард АДАПТ төслийн хөрөнгө оруулалтаар тус сумын 1 дүгээр буюу Заяат багийн “Мухарын булаг”, 5 дугаар багийн “Зүүн ар булаг” гэсэн 2 бүлгийн эхийг хашиж хамгаалж, хүлээлгэн өгсөн явдалд талархал илэрхийлээд өмнө нь хоёр багийн нэг нутаг бэлчээртэй малчин өрхүүд нэгдэн нийлж малчдын бүлэг байгуулсан байсан бөгөөд одоо хоёр бүлгийн эхийн ойролцоо нутагладаг малчдын бүлгийн гишүүн хоёр малчин гэрээгээр хариуцан хамгаалж байхаар зохион байгуулсан байна.Үүнд: “Мухарын булаг”-ийн эхийг “Заяат” бэлчээр ашиглагчдын хэсгийн гишүүн малчин, “Зүүн ар булаг”-ийн эхийг “Улз” бэлчээр ашиглагчдын хэсгийн гишүүн малчин Л.Төмөрбаатар, Г.Энхтайван нар тус тус хариуцаж ажиллахаар тохирсон байна.



## ДҮГНЭЛТ

### ҮР ДҮН 1-ИЙН ХҮРЭЭНД:

**Нэг.** Дорнод аймгийн 14, Сүхбаатар аймгийн 13, нийт 27 сумын хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөл, хоршооны тооллого, бүртгэл хийхэд:

- **Дорнод аймгийн** 9 суманд 2427 малчин өрхийн оролцоотой бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 123 бүлэг, 7 суманд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 нөхөрлөл, 13 суманд малчдын оролцоотой хөдөө аж ахуйн чиглэлийн 54 хоршоо тоологдож бүртгэгдсэн байна.
- **Малчдын бүлгүүд нь:** нийт 3230 малчидтай 67.1 хувь нь эрэгтэй, 32.9 хувь нь эмэгтэй бөгөөд бүлэг, хэсгийн ахлагч нарын 63 хувь нь эрэгтэй, 37 хувь нь эмэгтэй байна. Дорнод аймагт нэг сая толгой мал бүхий малчдын бүлэг, хэсгүүд 3.3 сая га бэлчээрийг ашиглахаар гэрээ байгуулсан байна.
- **Нөхөрлөл нь:** нийт 40 нөхөрлөл нь 40 ахлагч, 709 гишүүнтэй, тэдгээрийн 53 хувь нь эрэгтэй, 47 хувь нь эмэгтэй байна. Ахлагчдын 51 хувь эрэгтэй, 49 хувь нь эмэгтэй, дундаж нас 55 байна. Нөхөрлөлүүд нь Удирдах зөвлөлийн 137 Хяналтын зөвлөлийн 107 гишүүнтэй бөгөөд 48 идэвхтэн байгаль хамгаалагчтай ажиллаж байна.
- **Хоршоо:** ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын гишүүдийн тоо 2310 хүрсэн байна. Малчдын оролцоотой 54 хоршоо нь 32.9 сая төгрөгийн дүрмийн сантай, 614,8 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.
- **Сүхбаатар аймгийн** 8 суманд 1465 малчин өрхийн оролцоотой, бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 43 бүлэг, 4 суманд байгаль орчин, бэлчээрийн чиглэлийн нийт 5 нөхөрлөл, 11 суманд хөдөө аж ахуйн чиглэлийн 33 хоршоо тоологдож бүртгэгдсэн байна.
- **Малчдын бүлэг:** Нийт 5028 гишүүдийн 2554 буюу 50.2 хувь нь эрэгтэй, 2474 буюу 49.8 хувь нь эмэгтэй, бүлэг, хэсгийн ахлагчдын 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэй байна. Сүхбаатар аймгийн бэлчээр ашиглагч бүлэг, хэсгүүд 0,79 сая толгой мал сүрэгтэй, 1,5 сая га бэлчээрийг 5 жилийн хугацаатайгаар ашиглахаар гэрээ байгуулан ажиллаж байна.
- **Нөхөрлөл:** Нийт 5 нөхөрлөл, 5 ахлагч, 71 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.
- **Хоршоо:** 11 суманд 2859 гишүүнтэй 33 хоршоо хөдөө аж ахуйн чиглэлээр 83.0 сая төгрөгийн дүрмийн сантай, 181,0 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.
- Судалгааны явцад малчдын оролцоотой бүлгүүд нь тухайн орон нутагт ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжиж байх явцад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаад төсөл хөтөлбөр хэрэгжиж дуусах үед дагаад үйл ажиллагаа нь идэвхгүй байдалд орж байгаа нийтлэг дутагдал байна. Иймд бүлэг, хэсгийн үйл ажиллагааг тогтвортой идэвхтэй үйл ажиллагаатай байх тал дээр залгаад аймаг, сум, багийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.
- Нөхөрлөлийн үйл ажиллагааны хувьд гэвэл байгалийн баялаг буюу ой мод, усны ашиглалт сайтай Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун зэрэг сумдын нөхөрлөлүүд

тухайн гэрээгээр ашиглаж байгаа газрынхаа байгалийн баялгийг харж хамгаалах, түүнээсээ ашиг хүртэх боломжтой учраас идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжтой. Харин Сүхбаатар аймгийн хувьд ямар нэгэн байгалийн баялгаас ашиг хүртэх гэхээс илүү хамгаалах тал нь илүү давамгайл байдаг онцлог тал байна. Иймд Дорнод аймгийн Халхгол сумын нуур хамгаалах, Сүхбаатар аймгийн Дарьганга, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт сумдын амьтан, ургамал хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөлүүдэд мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад анхаарах нь зүйтэй.

- Зорилтот хоёр аймгийн ихэнх сумдад хөдөө аж ахуйн чиглэлийн /малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх гэх мэт/ хоршоо байгуулагдан зөвхөн улирлын чанартай /ноолуур, ноос, мах бэлтгэх үед/ ажилладаг байна. Иймд малчдад хоршооны хууль, эрх зүйн орчны талаарх тухай ойлголт, мэдээллийг тодорхой үе шаттай олгох, эргэлтийн хөрөнгийн зориулалттай, хүү багатай зээл олгох зэргээр чадавхжуулах шаардлагатай байна.

**Хоёр.** Төсөл хэрэгжиж буй Дорнод, Сүхбаатар аймгийн нийт 27 сумын малчдын оролцоотой БНХМБ-ын тооллого, бүртгэлийг үндэслэн байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын үйл ажиллагааны чиглэлийн байдлаар 3 ангилан бүртгэсэн. Үүнд:

1. Бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүлэг хэсэг:

- Дорнод аймгийн нийт 14 сумаас 9 суманд буюу 64,3 хувьд нь малчдын оролцоотой, бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 123 бүлэг, хэсгээс 122 бүлэг нь бэлчээр ашиглах гэрээ байгуулсан бөгөөд үүнээс 21 гэрээ нь газрын мэдээллийн санд бүртгэлтэй байна.
- Сүхбаатар аймгийн нийт 13 сумаас 8 суманд буюу 61,5 хувьд малчдын оролцоотой, бэлчээрийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 43 бүлэг, хэсгээс 28 бүлэг нь бэлчээр ашиглах гэрээ байгуулж, бүгд газрын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

2. Байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр /ой, ус, амьтан гэх мэт/ үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөл:

- Дорнод аймгийн 7 суманд малчдын оролцоотой, байгаль орчны менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 нөхөрлөл бүртгэгдсэнээс 38 нөхөрлөл, Сүхбаатар аймгийн 4 суманд малчдын оролцоотой, байгаль орчны менежментийн чиглэлээр /амьтан, ургамал хамгаалах/ үйл ажиллагаа явуулдаг 5 нөхөрлөл нь сумын Засаг даргатай тус тус гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

3. Малчдын оролцоотой гишүүнчлэл бүхий хөдөө аж ахуйн чиглэлийн хоршоо:

- Дорнод аймгийн 13 суманд малчдын оролцоотой, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 54, Сүхбаатар аймгийн 11 суманд 33 хоршоо нь аймгийн ХХААГ-т бүртгэлтэй ажилладаг байна.

**Гурав.** Малчдын оролцоотой БНХМБ-ын гэрээний хэрэгжилт, сайн туршлага, сургамжийн хувьд:

- Ногоон алт, малын эрүүл мэнд, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд байгуулсан бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгүүд нь бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж, улмаар газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд бүртгүүлсэн болон Дорнод аймгийн Хөлөнбуйр, Сэргэлэн, Халхгол, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Түвшинширээ сумдад ЗЗББУХ төслийн хүрээнд малчдын үүсгэл санаачилгаар байгуулсан бэлчээр ашиглагч малчдын бүлгүүд нь “Бэлчээрийн менежментийн 2019-2021 оны төлөвлөгөө”-г сум, багийн удирдлага, мэргэжилтэн, малчдын оролцоотой боловсруулж, хэрэгжүүлж ажиллаж байгаа бол Ногоон алт төслийн хүрээнд Дорнод аймгийн 5, Сүхбаатар аймгийн 5 суманд байгуулагдсан бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор малчдын дундын сан байгуулсан туршлагыг бусад аймаг, сумдын малчдын оролцоотой бүлэг, хэсэгт нэвтрүүлэх сайн туршлага гэж үзэж байна.

**Дөрөв.** Малчдын оролцоотой БНХМБ-ын нэгдсэн бүртгэлийг одоо ашиглагдаж буй холбогдох мэдээллийн сан, бүртгэлтэй харьцуулсны үндсэн дээр мэдээллийн санг шинэчлэн гаргасан талаарх дүгнэлт:

Дорнод, Сүхбаатар аймгийн одоо ашиглагдаж буй малчдын оролцоотой БНХМБ-ын мэдээллийн санг шинэчлэн гаргасан талаар

Дорнод аймгийн 14, Сүхбаатар аймгийн 13, нийт 27 сумын хэмжээнд ус, ой, газар (хадлан, бэлчээр)-ын нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөл, хөдөө аж ахуйн хоршооны тооллого, бүртгэл, судалгааг аймаг, сумдын ХАА, БО, Газрын харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн нартай хамтран хийлээ. Дээрх судалгааны бүртгэл мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /ГЗБГЗЗГ/, Улсын бүртгэлийн ерөнхий газар /УБЕГ/, Байгаль орчны яам, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо зэрэг газруудын мэдээллийн сангуудтай харьцуулан БНХМБ-ын мэдээллийн санг шинэчилсэн байдлаар гаргасан болно. Сум аймгийн холбогдох алба, мэргэжилтэн нарт сургалт, мэдээлэл өгч мэдээллийн санг жил бүр шинэчлэн баяжуулах чадавхыг сайжруулах ажлыг төслийн хүрээнд үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### **ҮР ДҮН 2-ЫН ХҮРЭЭНД:**

**Тав.** Байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалтын гэрээг байгуулахад баримтлах хэм хэмжээг шинээр боловсруулах гэрээний загварт тусгах нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

- Байгаль орчны үнэлгээ хийхийн тулд гэрээнд анх ашиглалтад олгогдох бэлчээрт мэргэжлийн байгууллагын хийсэн дүгнэлтийг хавсаргах боломжтой.

Дорнод болон Сүхбаатар аймгийн бэлчээрийн даац ялангуяа өвөл, хаврын улиралд ихээхэн хэтэрсэн үзүүлэлттэй тул эдгээр аймгуудад малын тоог багасган, чанаржуулах, сүргийн эргэлтийн төлөвлөлтийг бэлчээрийн бодит даацад тохируулах, үр дүнг тооцох, үнэлэх асуудлыг гэрээний шинэчилсэн загварт тусгасан.

- Дорнод, Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ-ын гэрээнд байгалийн гамшигт үзэгдэл, онцгой байдлын нөхцөл байдал үүсэх тохиолдолд талууд хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөлүүдийг түлхүү тусгасан боловч тухайн форс мажор

үүсэх үед хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан байдал үндсэндээ гэрээнд байхгүй тул шинээр боловсруулах гэрээний загварт энэ талаар нэмж тусгаж өгсөн.

**Зургаа. Малчдын оролцоотой БНХМБ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны түвшнээр нь ангиланүнэлсэн талаар:**

Дорнод аймгийн БНХМБ-ын үйл ажиллагаа:

Малчдын бүлгүүд нь нийт 3230 малчидтай 67.1 хувь нь эрэгтэй, 32.9 хувь нь эмэгтэй бөгөөд бүлэг, хэсгийн ахлагч нарын 63 хувь нь эрэгтэй, 37 хувь нь эмэгтэй байна. Дорнод аймагт нэг сая толгой мал бүхий малчдын бүлэг, хэсгүүд 5.5 сая га бэлчээрийг ашиглахаар гэрээ байгуулсан. **Малчдын бүлгүүдийн 39 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.**

Нийт 40 нөхөрлөл нь 40 ахлагч, 709 гишүүнтэй, тэдгээрийн 53 хувь нь эрэгтэй, 47 хувь нь эмэгтэй байна. Ахлагчдын 51 хувь эрэгтэй, 49 хувь нь эмэгтэй, дундаж нас 55 байна. Нөхөрлөлүүд нь Удирдах зөвлөлийн 137 Хяналтын зөвлөлийн 107 гишүүнтэй бөгөөд 48 идэвхтэн байгаль хамгаалагчтай ажиллаж байна. Эдгээрээс 38 нөхөрлөл сумын Засаг даргатай гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна. **Нөхөрлөлүүдийн 72 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.**

ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын гишүүдийн тоо 2310 хүрсэн байна. Малчдын оролцоотой 54 хоршоо нь 32,9 сая төгрөгийн дүрмийн сантай, 614,8 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

**Хоршоодын 29 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.**

Сүхбаатар аймгийн БНХМБ-ын үйл ажиллагаа:

Тооллогод хамрагдсан малчдын бүлэг, хэсгүүд нь нийт 5028 гишүүдийн 2554 буюу 50.2 хувь нь эрэгтэй, 2474 буюу 49.8 хувь нь эмэгтэй, бүлэг, хэсгийн ахлагчдын 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэй байна. Сүхбаатар аймгийн бэлчээр ашиглагч бүлэг, хэсгүүд 0,75 сая толгой мал сүрэгтэй, 1,7 сая га бэлчээрийг 5 жилийн хугацаатайгаар ашиглахаар гэрээ байгуулан ажиллаж байна. **Малчдын бүлгүүдийн 52 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна.**

Нийт 5 нөхөрлөл, 5 ахлагч, 71 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 5 нөхөрлөл нь сумын засаг даргатай гэрээ байгуулж, аймгийн БОАЖГ-ын мэдээллийн санд бүртгүүлсэн байна. **Нөхөрлөлүүдийн 60 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна.**

11 суманд 2859 гишүүнтэй 33 хоршоо хөдөө аж ахуйн чиглэлээр 118,3 сая төгрөгийн дүрмийн сантай, 181,0 сая төгрөгийн зээл, тусламжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. **Хоршоодын 24 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.**

**Долоо.** Дорнод, Сүхбаатар аймгийн малчдын оролцоотой БНХМБ-ын гэрээний талуудын үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, сунгах, цуцлах талаар дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн болно. Үүнд:

1. Засаг даргын эрх хэмжээг гэрээнд зааж өгөхдөө ихэвчлэн эдлэх эрхийг түлхүү тусгасан байдал ажиглагдав. Иймд Засаг даргын бэлчээр ашиглалтад хүлээх үүргийг бас уялдуулан тусгах хэрэгтэй ба түүний албан үүрэгтэй нь холбогдуулан тус суманд хэрэгжүүлэх бэлчээрийн харилцаанд баримтлах бодлогын түвшинд тусгах нь илүү ач холбогдолтой.
2. Бэлчээрийг гэрээгээр ашиглах хугацааны хувьд гэрээнүүдэд хийсэн судалгаанаас дүгнэхэд янз бүр байгаа нь тухайн баялгийн объектын ангилал, холбогдох хуулийн зохицуулалттай хамааралтай Газрын хуульд заасан газар эзэмших, ашиглах эрхийн хугацааг жишиг болгохоос гадна тухайн гэрээний талууд харилцан тохиролцож бэлчээр ашиглалтын хугацаа, хугацааг сунгах талаарх нөхцөлийг тодорхой тусгах шаардлага байна.
3. Бэлчээр ашиглалтын гэрээнд хариуцлагын нөхцөлийн талаар тусгахдаа хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөлүүдийг тусгасан, зарим гэрээнд хариуцлагын талаар огт тусгаагүй гэх мэт харилцан адилгүй байна. Иймд тухайн гэрээнд холбогдох хуульд (зөрчлийн тухай хууль) заасан үндэслэлээр хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх боломжтой тул шинээр загвар болгон боловсруулах гэрээний төсөлд тусгах нь зүйтэй гэж дүгнэв.
4. Газрын даамлын эрх, үүргийг тусгайлан заах боломжгүй боловч газрын даамалд тухайн гэрээгээр ашиглалтад олгогдсон бэлчээрийн газрын зургийг газрын бүртгэлд оруулах асуудлыг гэрээнд тусгах шаардлагатай байна.
5. Газрын тухай хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг дарга шийдвэрлэх ба шийдвэрийг эс хүлээн зөвшөөрвөл дээд шатны Засаг дарга шийдвэрлэх зохицуулалтад тулгуурлана. Хэрэв бэлчээр ашиглалтын гэрээтэй холбогдон маргаан гарвал нэн тэргүүнд маргалдагч талууд харилцан тохиролцох, эс тохиролцвол Газрын тухай хуульд заасан үндэслэлээр шийдвэрлэх боломжийг тусгах нь зүйтэй.

### **ҮР ДҮН 3-ЫН ХҮРЭЭНД:**

Гэрээний шинэчилсэн загварын хоёр төслийг төслийн нэгж болон Сүхбаатар, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт албан бичгээр хүргүүлж санал авсан бол Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Түвшинширээ, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул зэрэг сумдын удирдлага, малчдын төлөөлөл нийт 46 хүнд танилцуулж, санал авах, албажуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх ажлыг гүйцэтгэсэн байна.

### **ҮР ДҮН 4-ИЙН ХҮРЭЭНД:**

Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллага /БНХМБ/-ын хэлбэрээр гэрээний шинэ загварын дагуу Сүхбаатар аймгийн Дарьганга сумын 1 дүгээр багийн “Хөөврийн булаг” орчмын 18 малчин өрх, Түвшинширээ сумын 3 дугаар багийн “Замтын булаг” орчмын 20 малчин өрхийг тус тус оролцуулсан хоёр малчдын бүлэг шинээр байгуулах хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсны гадна Дорнод аймгийн Баян-Уул сумын “Заяат” болон “Улз”, Чойбалсан сумын “Энгэр шанд” бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар зөвлөх багийн зүгээс мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахаар тогтсон болно.

Төслийн хөрөнгө оруулалтаар бүлгийн эх болон ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хамгаалсан хашааг цаашид хариуцан ажиллах малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөлийг газар дээр нь тодорхой болгож, гэрээний шинэчилсэн загварын талуудын хүлээх эрх, үүргийн хэсэгт барьсан хашааг хамгаалах, арчлан тордох, ашиглах асуудлыг тусгаж өгөх талаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Түвшинширээ, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул сумдын ЗДТГ-ын удирдлага, мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт зөвлөгөө өгч, бэлчээр ашиглалтын болон ойн нөхөрлөлийн гэрээний загвар, гарын авлага материалыг танилцуулж хэлэлцүүлэн хүлээлгэн өгсөн.

**ТАЙЛАНГИЙН ХОЛБОГДОЛТОЙ ФОТО ЗУРАГ:**

**ДОРНОД АЙМАГ. 2022.05.16-17.**



Семинарын нээлтийн үйл ажиллагаа.







Семинарын үйл ажиллагааны явц.







Семинарын үеэр бүлгээр ажилласан нь.





Аймгийн Засаг даргын орлогч болон ХХААГ-тай уулзалт хийсэн нь.







Баянтүмэн сумын “Хотонт” нөхөрлөлийн үйл ажиллагаатай танилцсан нь.





“Хотонт” нөхөрлөлийн ахлагч, гишүүдтэй уулзаж санал солилцов.





СҮХБААТАР АЙМАГ. 2022.05.19-20.



Семинарын үйл ажиллагааны явц.





Бүлгийн ажлын явцыг танилцуулав.







**СҮХБААТАР АЙМАГ. 2022.10.02-05.**



Сүхбаатар аймгийн төслийн ажилтан нартай хийсэн уулзалт



Дарьганга сумын Засаг даргатай хийсэн уулзалт





Дарьганга сумын Засаг даргын Тамгын газрын уулзалт



Дарьганга сумын Үүд багийн Хөөврийн булгийн эх



Хөөврийн булгийн эхийг хашиж хамгаалсан байдал







Хөөврийн булаг орчмын малчидтай хийсэн уулзалт







Түвшинширээ сумын Үнэгт багийн Замтын булаг







Замтын булаг орчмын малчидтай хийсэн уулзалт





Малчдын оролцоотой бүлэг байгуулах талаар сургалт хийв





**ДОРНОД АЙМАГ. 2022.10.06-08.**



**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын бэлчээр хариуцсан мэргэжилтэн хийсэн уулзалт**





Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газарт хийсэн уулзалт

